# ИНТЕРНЭТИЙН ТҮГЭЭМЖИЙН ТАЛААРХ ЮНЕСКО-ГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Интернэтийн хөгжлийн үнэлгээний хүрээ



Algo-r(h)i(y)thms, 2018. ON AIR инстоляц бүтээлийн харагдац, Томас Сарасеногийн карт-бланш үзэсгэлэн, Палаис де Токио, Парис хот, 2018.

Ребекка Ламарче-Ваделийн цуглуулга. Зураачийн зөвшөөрөлтэй. Эстер Шиппер, Берлин; Ягаан зун - Орчин цагийн урлаг, Генуя хот.

© Андреа Россетти, 2018

# ИНТЕРНЭТИЙН ТҮГЭЭМЖИЙН ТАЛААРХ ЮНЕСКО-ГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Интернэтийн хөгжлийн үнэлгээний хүрээ

Дэвид Сутер
Анри ван дэ Спи

Энэхүү гарын авлагыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас 2022 онд эрхлэн хэвлүүлэв. Франц улс, Парис хот 07 SP, 7 Фоунтенуа талбай

© UNESCO, 2022
ISBN 978-92-3-000178-0

Энэхүү хэвлэлийг attribution-ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA 3.0 IGO) тусгай зөвшөөрлийн дагуу нээлттэй хандалттайгаар байршуулав http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/ Хэрэглэгчид тус хэвлэлийн агуулгыг ашиглахдаа ЮНЕСКО-гийн Нээлттэй хандалтын сангийн ашиглалтын нөхцөлийг http://www.unesco.org/open-access/terms-use-ccbya-en хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Анхны гарчиг: UNESCO's Internet Universality Indicators: A Framework for Assessing Internet Development Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас 2019 онд хэвлэв.

Энэхүү хэвлэлд ашигласан тодорхойлолт болон баримт мэдээлэл нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн хууль эрх зүйн байдал, түүний эрх бүхий байгууллага, удирдлага эсхүл хилийн хязгаарыг тогтоох талаар ЮНЕСКО-гийн зүгээс ямар нэгэн байр суурийг илэрхийлээгүй болно.

Энэхүү хэвлэлд илэрхийлсэн санаа, үзэл бодол нь зохиогчдынх бөгөөд зохиогчид нь ЮНЕСКО-д харьяалагдах албагүй, тухайн байгууллагад үүрэг хүлээдэггүй болно.

ЮНЕСКО-гийн төслийн зохицуулагч: Шанхонг Ху, Жоселин Гүйлармаү
Цахим шуудан: internet.indicators@unesco.org
Веб сайт: http://en.unesco.org/internetuniversality

Хавтасны зураг: © Андреа Россетти, 2018
График дизайн, хавтасны дизайн, чимэглэл зургууд, өрөлт: ЮНЕСКО
Дижитал Эра ТББ монгол хэлнээ хөрвүүлэв.
Эхийг бэлтгэсэн: Тэнгис, Э.Мөнхзул
Орчуулгыг найруулсан: С.Уянга, Н.Мөнхцэцэг
Хянасан: Л.Ариунзул
Монгол Улсад хэвлэв.



# Өмнөх үг

Та цахим орчны нарийн учрын талаар илүү мэдмээр байна уу? Интернэт хүний эрхэд нийцэж буй эсэхийг шалгах, нээлттэй, хүртээмжтэй байдлыг тодорхойлох, интернэт засаглал дахь янз бүрийн бүлэг, нийгмийн оролцоог үнэлдэг интернэтийн зураглалтай болохыг хүсэж байна уу? Хэрэв тийм бол танд ЮНЕСКО-гийн Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлт хэрэгтэй.

XXI зуунд цахим технологи нь мэдээлэлд хандах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, харилцаа холбоо, технологийн инновац төдийгүй олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах зэрэг урьд өмнө байгаагүй өргөн боломжийг нээж байна. Үүний зэрэгцээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хувь хүний нууц, сэтгүүлчдийн аюулгүй байдал, ил тод байдал, сахилга хариуцлагатай холбоотой асуудал, түүнчлэн онлайн худал мэдээлэл, тэгш бус байдал, жендерийн бусад ялгаварлах үзэл зэрэг олон асуудал үүсэж байна.

Иймд ЮНЕСКО-гоос өөрийн гишүүн орнууд, сонирхогч талуудыг дэмжих зорилгоор интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлт (ИТБШҮ)-ийг боловсруулсан болно. Эдгээр шалгуур үзүүлэлт нь хүн бүрд үндэснийхээ интернэт орчныг сайн дураараа үнэлэх, тоон ялгаатай байдлыг арилгах, интернэтийг сайжруулах боломжийг олгодог.

ИТБШҮ нь ЮНЕСКО-гийн үгээр болон зургаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг сурталчлан, мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоон бүтээх амин чухал үзэл санаатай холбогддог. Энэхүү шинэ, онцлог бүхий аргачлал нь 2030 он гэхэд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд интернэтийн гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх юм.

Тус үнэлгээний хүрээ нь хүний эрхэд суурилсан, хүн бүрд нээлттэй бөгөөд хүртээмжтэй, олон талт сонирхогч талуудын оролцоо бүхий интернэтийг дэмжих эрх олон талт оролцооны (ROAM) зарчмын дагуу интернэтийг практик талаас үнэлж дүгнэх замаар 2015 онд ЮНЕСКО-гоос баталсан интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд тусална. Эдгээр шалгуур үзүүлэлтэд тулгуурласан судалгааны үр дүнд ялгавартай байдлыг тодорхойлж, улмаар зорилтот түвшинд хүргэж сайжруулах зөвлөмжийг өгөх боломжтой.

Шалгуур үзүүлэлтийг цахим болон цахим бус байдлаар олон улсын, шинэлэг, нээлттэй бөгөөд олон талт сонирхлын бүлгүүдийн хэлэлцүүлгээр боловсруулж, 2017 оны 3 дугаар сараас 2018 оны 9 дүгээр сар хүртэл дэлхийн бүх бүс нутгийн 36 улсад 46 зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулсан. Шалгуур үзүүлэлтийг боловсруулахад 66 гишүүн орон хувь нэмрээ оруулж, 2000 гаруй мэргэжилтэн ЮНЕСКО-той хамтран ажилласан. Түүнчлэн зориулалтын платформоор[1] 300 гаруй санал хүсэлтийг хүлээн авсан байна.

Энэхүү шинэ аргачлал нь мэдэгдэхүйц нөлөөлж байна. 2018 оны 7 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Интернэт дэх хүний эрхийг дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх тухай тогтоолд уг аргачлалыг онцлон тэмдэглэсэн. ИТБШҮ-ийн хүрээний эцсийн хувилбар нь 6 ангиллын 109 гол үзүүлэлт, 25 сэдэв, 124 асуулт бүхий 303 шалгуур үзүүлэлтээс бүрддэг. Эрх, нээлттэй байдал, хүртээмж, олон талт оролцооны 4 ангиллаас гадна жендерийн тэгш байдал, хүүхэд залуучуудын хэрэгцээ, тогтвортой хөгжил, итгэлцэл ба аюулгүй байдал төдийгүй интернэтийн эрх зүй болон ёс зүйтэй холбоотой зангилаа асуудлын 79 шалгуур үзүүлэлттэй.

ИТБШҮ-ийн хүрээ нь интернэт болон мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн нийтлэг үүрэг, түүний өөрчлөх чадварыг үнэлснээр Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрийн зорилтуудад хүрэхэд тодорхой хувь нэмэр оруулдаг. ЮНЕСКО-гийн үйл ажиллагаатай холбоотой бусад олон асуудлаас энэхүү хүрээ нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын 16.10 зорилт болох олон нийтийг мэдээлэл олж авах боломжоор хангах, үндсэн эрх чөлөөг хамгаалах гол асуудлыг хамардаг. Ингэснээр шалгуур үзүүлэлт нь ядуурлыг арилгах, цаг уурын өөрчлөлттэй тэмцэхээс эхлээд жендерийн тэгш байдлыг хангах зэрэг тогтвортой хөгжлийн бусад зорилгод чухал нөлөө үзүүлэх гол зорилтуудад хүрэхэд хувь нэмрээ оруулах юм.

Интернэтийн шалгуур үзүүлэлт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжилтэй холбоотой өргөн хүрээний асуудлыг үнэлдэг тул ЮНЕСКО-гийн Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжлийн үзүүлэлт, Сэтгүүлчдийн аюулгүй байдлын үзүүлэлт, Хэвлэл мэдээллийн жендерийн мэдрэмжтэй үзүүлэлтийг шинэчлэн өргөжүүлдэг.

[1] ЮНЕСКО-гийн Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн платформ https://en.unesco.org/internetuniversality

2018 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-гийн Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөрийн Засгийн газар хоорондын зөвлөлийн 31 дүгээр чуулганаар “интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээг сайшааж”, “уг аргачлалыг гишүүн орнууд сайн дурын үндсэн дээр хэрэгцээт эх сурвалж болгон ашиглахыг зөвшөөрсөн”[2] билээ.

Олон улсад энэхүү аргачлалыг ашиглахын үнэ цэн, ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байна. Иймд бид түүнийг ашиглаж, хэрэгжүүлэхийг, ялангуяа төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, техник технологи, боловсрол, сэтгүүл зүй болон мэдээллийн хэрэгслийн хоорондын хамтын ажиллагааг дэмждэг. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд дээрх салбарууд хамтран сайн дурын үндсэн дээр үндэснийхээ интернэтийн хөгжлийн үнэлгээг хийж, улмаар өөрсдийн дүгнэлтээ нотолгоонд суурилсан бодлогод тусгах боломжтой.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг боловсруулахад хувь нэмэр оруулсан бүх талуудад, ялангуяа Шведийн хаант улс, Интернэтийн нийгэмлэг (ISOC), Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага (ICANN), Бразилын сүлжээний мэдээллийн төв (NIC.br), Латин Америк болон Карибын тэнгисийн сүлжээний мэдээллийн төв (LACNIC)-д гүн талархал илэрхийлье.

Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлт нь хүний эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн нууцлал, нийгмийн амьдралд оролцох эрхийг хүндэтгэн дээдэлсэн бүх нийтийн интернэтийн үнэт зүйлсийг бэхжүүлэхэд тусална хэмээн найдаж байна. Интернэт нь ил тод, технологийн хувьд хүртээмжтэй бөгөөд зохистой үнэтэй байж, хүмүүсийг холбодог, олон талт байдлыг хамардаг, нас, хүйс, арьсны өнгө, соёл, нийгмийн давхаргаас үл хамааран бүх хүнийг дэмждэг нэгэн цогц зүйл байх ёстой. Энэ бол бидний хүсэж буй интернэт бөгөөд бид үүнийг ашиглан тогтвортой хөгжилд хүрэх хэрэгтэй.

Та бүхнийг интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг улс орныхоо судалгаа шинжилгээ, харилцаа холбоо, хөгжилд нутагшуулан ашиглахыг уриалж байна.

Хамтран ажиллаж, цахим эрин зуунд хэнийг ч ардаа орхилгүй хамтдаа урагшилцгаая.

Моэз Чакчоук
ЮНЕСКО-гийн Харилцаа холбоо, мэдээлэл хариуцсан
ерөнхий захирлын туслах

[2] ЮНЕСКО-гийн Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөрийн Засгийн газар хоорондын зөвлөлийн 31 дүгээр чуулганаас гаргасан шийдвэр, 2018 оны 11 дүгээр сарын 21-22, ЮНЕСКО. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000266235

# Талархал

ЮНЕСКО-гоос Шведийн Олон улсын хөгжлийн агентлаг (SIDA, Swedish International Development Agency), Интернэтийн нийгэмлэг (ISOC, Internet Society), Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага (ICANN, Internet Corporation for Assigned Names and Numbers), Бразилын сүлжээний мэдээллийн төв (NIC.br, Brazilian Network Information Center), Латин Америк болон Карибын тэнгисийн сүлжээний мэдээллийн төв (LACNIC, Latin America and Caribbean Network Information Centre)-д энэхүү төсөлд чухал дэмжлэг үзүүлсэнд гүн талархал илэрхийлье.

Төслийн хэлэлцүүлэгт оролцож, дэмжин ажилласан гишүүн орнуудаа талархал илэрхийлж, Эрх чөлөөний онлайн эвсэл, Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөрийн зөвлөлийн оруулсан хувь нэмрийг онцлон тэмдэглэж байна.

Онлайн хэлэлцүүлгийн болон хувь нэмрээ оруулсан нийт оролцогч, зөвлөлдөх уулзалтын илтгэгч оролцогчид төдийгүй манай сургалт семинарыг зохион байгуулж, биднийг арга хэмжээнд урьсан үндэсний, бүс нутгийн, олон улсын платформуудад гүн талархал илэрхийлье.

Олон улсын 15 шинжээч, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас бүрдсэн олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх багт төслийг хэрэгжүүлэх явцад зөвлөмж, удирдамж өгч ажилласанд талархал илэрхийлж байна.

ЮНЕСКО-гийн хэмжээнд багаар хамтран ажилласан Харилцаа холбоо ба мэдээллийн салбар, Соёлын салбар, Боловсролын салбар, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбар, Жендерийн тэгш байдлын хэлтэс, ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн (UIS, UNESCO’s Institute for Statistics), ЮНЕСКО-гийн Боловсролын мэдээллийн технологийн хүрээлэн (IITE, UNESCO Institute for Information Technologies in Education) болон Монтевидео, Бангкок, Бээжинд байрлах ЮНЕСКО-гийн салбарын нийт ажилтанд шалгуур үзүүлэлтийг боловсруулахад жинтэй хувь нэмэр оруулсанд гүн талархал илэрхийлье.

Бразил, Эквадор, Нигери, Пакистан, Сенегал, Тайланд зэрэг улсад шалгуур үзүүлэлтийг урьдчилан туршиж, удирдан чиглүүлсэн Александр Барбоса, Жоао Брант, Энрико Каландро, Маваки Чанго, Алисон Гиллвалд, Татьяна Жерайссати, Садаф Хан, Вакас Наим, Хассан Накви, Фола Одуфува, Пиронгронг Рамасоота, Талал Раза, Фабио Сенне, Артит Сuриявонгкул нарт чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Бидэнд шалгуур үзүүлэлтийн хүрээг боловсруулахад тусалсан Дэвшилтэт харилцаа холбооны нийгэмлэг (APC, Association for Progressive Communications) тэргүүтэй МХХТ-ийн хөгжлийн холбоод (ictDA, ict Development Associates), LIRNEasia, Африкийн МХХТ-ийн судалгааны байгууллага (RIA, Research ICT Africa)-аас бүрдсэн судалгааны консорциумын мэргэжлийн хамтын ажиллагаанд талархсанаа илэрхийлж байна. Үндсэн зохиогчид болох Дэвид Сутер Анри ван де Спи болон энэхүү төслийн хүрээнд дэлхийн хэмжээний хэлэлцүүлэг, зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулахад ЮНЕСКО-г дэмжин ажилласан консорциумыг гайхалтай удирдан зохион байгуулсан Анриэтте Эстерхюсенд гүн талархал илэрхийлье.

Өмнөх үг 3
Талархал 5
Товчилсон болон хураангуйлсан үгс 8
Хураангуй 11

1

**ИНТЕРНЭТИЙН ТҮГЭЭМЭЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ЮНЕСКО-ГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 15**

Интернэтийн хөгжил 17
Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлал 18
Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгцээ шаардлага 19
Шалгуур үзүүлэлтийн хүрээ боловсруулах арга зүй, үйл явц 20

2

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ 23**

Танилцуулга 25
Хүрээний бүтэц 25

3

**НӨХЦӨЛ БАЙДЛААС ХАМААРАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 29**

Эдийн засгийн үзүүлэлт 31
Хүн ам зүйн үзүүлэлт 32
Хөгжлийн үзүүлэлт 32
Тэгш байдлын үзүүлэлт 33
Засаглалын үзүүлэлт 33
Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн (ICT) хөгжлийн үзүүлэлт 34

4

**R-ЭРХ 35**

Сэдэв A • Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ 38
Сэдэв B • Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө 39
Сэдэв C • Мэдээлэл олж авах эрх 40
Сэдэв D • Эвлэлдэн нэгдэх, эрх чөлөө, нийгмийн амьдралд оролцох эрх 42
Сэдэв E • Хувийн халдашгүй байх эрх 43
Сэдэв F • Эдийн засаг, нийгэм, соёлын эрх 45

5

**O- НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ 47**

Сэдэв A • Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ 50
Сэдэв B • Нээлттэй стандарт 51
Сэдэв C • Нээлттэй зах зээл 52
Сэдэв D • Нээлттэй контент 53
Сэдэв E • Нээлттэй өгөгдөл ба нээлттэй засаг 55

# Агуулга


## 6

**А- БҮХ НИЙТЭД ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙХ** **57**

Сэдэв A • Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо 60

Сэдэв B • Холболт ба хэрэглээ 61

Сэдэв C • Хямд үнэтэй байх 62

Сэдэв D • Эрх тэгш хүртэмж 63

Сэдэв E • Орон нутгийн агуулга, хэл 64

Сэдэв F • Чадавх / Ур чадвар 65

## 7

**М- ОЛОН ТАЛТ СОНИРХЛЫН БҮЛГҮҮДИЙН ОРОЛЦОО** **67**

Сэдэв A • Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ 70

Сэдэв B • Үндэсний интернэт засаглал 71

Сэдэв C • Олон улсын болон бүс нутгийн интернэт засаглал 72

## 8

**Х-ЗАНГИЛАА АСУУДЛУУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ** **73**

Сэдэв A • Жендер 75

Сэдэв Б • Хүүхдүүд 77

Сэдэв C • Тогтвортой хөгжил 78

Сэдэв D • Итгэлцэл ба аюулгүй байдал 80

Сэдэв E • Интернэтийн эрх зүйн болон

ёс зүйн асуудал 81

## 9

**ЭХ СУРВАЛЖ БАТАЛГААЖУУЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ** **83**

Судалгааны арга зүйн эх сурвалж 84

Шалгуур үзүүлэлтийн эх сурвалж 84

## 10

**ИНТЕРНЭТИЙН ТҮГЭЭМЭЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ЮНЕСКО-ГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ** **105**

Удиртгал 107

Шалгуур үзүүлэлтийн хэрэгжүүлэх 108

Ирээдүйг төсөөлөх нь 123

ЮНЕСКО-той хамтран ажиллах 124

Хавсралт 1. Олон талд сонирхлын бүлгийн зөвлөх багийн гишүүд 125

Хавсралт 2. Зөвлөлдөх арга хэмжээ 126

Хавсралт 3. Цахим санал зөвлөгөө өгөгчид 134

Хавсралт 4. Интернэтийн түгээмэл байдлын гол шалгуур үзүүлэлт 145

Эшлэл 154

# Товчилсон болон хураангуйлсан үгс

| | |
|---|---|
| **APC**<br>**ДХХН** | Association for Progressive Communications<br>Дэвшилтэт харилцаа холбооны нийгэмлэг |
| **API**<br>**ХПИ** | Application Programming Interface(s)<br>Хэрэглээний програмчлалын интерфэйс(үүд) |
| **APNIC**<br>**АНДБНИХББ** | Regional Internet address Registry for the Asia-Pacific<br>Ази Номхон Далайн бүс нутгийн интернэт хаягийн бүртгэлийн байгууллага |
| **ccTLDs** | Country Code Top-Level Domain<br>Олон улсын код дээд түвшний домэйн |
| **CEDAW**<br>**ЭЯГБХУТК** | Convention on the Elimination of Discrimination against Women<br>Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц |
| **CERT**<br>**КХХҮБ** | Computer Emergency Response Team<br>Компьютерын халдлагад хариу үзүүлэх баг |
| **CRC**<br>**ХЭТК** | Convention on the Rights of the Child<br>Хүүхдийн эрхийн тухай конвенц |
| **DNSSEC**<br>**ДНСАБӨ** | Domain Name System Security Extensions<br>Домэйн нэрийн системийн аюулгүй байдлын өргөтгөл |
| **FOSS**<br>**ЧНЭПХ** | Free and Open-Source Software<br>Чөлөөт ба нээлттэй эхийн программ хангамж |
| **GAC**<br>**ЗГЗХ** | ICANN's Governmental Advisory Committee<br>Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага (ICANN)-ын Засгийн газрын зөвлөх хороо |
| **GDP**<br>**ДНБ** | Gross Domestic Product<br>Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| **GNI**<br>**ҮНО** | Gross National Income<br>Үндэсний нийт орлого |
| **GSMA**<br>**ОУҮУОХ** | Groupe Spйciale Mobile Association<br>Олон улсын үүрэн утасны операторуудын холбоо |
| **gTLDs** | Generic Top-Level Domains<br>Ерөнхий дээд түвшний домэйн |
| **HDI**<br>**ХХИ** | Human Development Index (UNDP)<br>Хүний хөгжлийн индекс (НҮБХХ) |
| **ICANN**<br>**ОУИНХБ** | Internet Corporation for Assigned Names and Numbers<br>Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага |
| **ICCPR**<br>**ИБУТЭТОУП** | International Covenant on Civil and Political Rights<br>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт |
| **ICERD**<br>**АҮАҮБХУТОУК** | Conventions on the Elimination of All Forms of Racial Discrimination<br>Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц |
| **ICESCR**<br>**ЭЗНСЭТП** | Economic Social and Cultural Rights<br>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт |
| **ICT**<br>**МХХТ** | Information and Communications Technology (or technologies)<br>Мэдээлэл, харилцаа холбооны технологи (буюу технологиуд) |
| **IDN ccTLDs** | Internationalized Country Code Top-Level Domain<br>Үндэсний буюу улс үндэстний эх хэл дээр бичигддэг домэйн |
| **IGF**<br>**ИЗФ** | Internet Governance Forum<br>Интернэт засаглалын форум |

| | |
|---|---|
| **IPDC**<br>**ХXXОУХ** | International Programme for the Development of Communication (UNESCO)<br>Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөр (ЮНЕСКО) |
| **IPv4** | Internet Protocol Version 4<br>Интернэт протокол хувилбар 4 |
| **IPv6** | Internet Protocol Version 6<br>Интернэт протокол хувилбар 6 |
| **ISPs**<br>**ИҮЭ** | Internet Service Provider<br>Интернэтийн үйлчилгээ эрхлэгч |
| **ITU**<br>**ОУЦХБ** | International Telecommunication Union<br>Олон улсын цахилгаан холбооны байгууллага |
| **IXPs**<br>**ИХХ** | Internet Exchange Points<br>Интернэтийн харилцан холболт |
| **LDCs**<br>**НБХО** | Least Developed Countries<br>Нэн буурай хөгжилтэй орнууд |
| **MDIs**<br>**ХМХҮ** | Media Development Indicators<br>Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлт |
| **NGOs**<br>**ТББ** | Non-Profit Organization<br>Ашгийн төлөө бус байгууллага |
| **OECD**<br>**ЭЗХАХБ** | Organisation for Economic Cooperation and Development<br>Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага |
| **OER**<br>**БНН** | Open Educational Resources<br>Боловсролын нээлттэй нөөц |
| **RIA**<br>**АМХХТСБ** | Research ICT Africa<br>Африкийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн судалгааны байгууллага |
| **ROAM**<br>**ЭНБХБОТО** | Rights, Openness, Accessibility, Multistakeholder (UNESCO)<br>Эрх, нээлттэй байдал, хүртээмжтэй байдал, олон талт сонирхлын бүлэг (ЮНЕСКО) |
| **SDGs**<br>**ТХХ** | Sustainable Development Goals (United Nations)<br>Тогтвортой хөгжлийн зорилго (НҮБ) |
| **SIDA**<br>**ШОУХА** | Swedish International Development Agency<br>Шведийн олон улсын хөгжлийн агентлаг |
| **SIDS**<br>**АЖХБО** | Small Island Developing States<br>Арлын жижиг хөгжиж буй орнууд |
| **SMEs**<br>**ЖДҮ** | Micro, Small and Medium-Sized Enterprises<br>Жижиг, дунд үйлдвэр |
| **STEM**<br>**ШУТИМ** | Science, Technology, Engineering, and Mathematics<br>Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик |
| **UDHR**<br>**ХЭТТ** | Universal Declaration of Human Rights<br>Хүний эрхийн түгээмэл тунхаглал |
| **UIS**<br>**ЮНЕСКОСХ** | UNESCO Institute for Statistics<br>ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн |
| **UN DESA**<br>**НҮБЭЗНГ** | United Nations Department of Economic and Social Affairs<br>НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газар |
| **UN HRC**<br>**НҮБХЭЗ** | United Nations Human Rights Council<br>НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл |
| **UNCTAD**<br>**НҮБХХБХ** | United Nations Conference on Trade and Development<br>НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал |

| | |
|---|---|
| **UNDP**<br>**НҮБХХ** | United Nations Development Programme<br>НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр |
| **UNESCO**<br>**ЮНЕСКО** | United Nations Educational, Scientific and Cultural Organization<br>НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага |
| **UNGA**<br>**НҮБЕА** | United Nations General Assembly<br>Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблей |
| **UNODC**<br>**НҮБГХМБТГ** | United Nations Office on Drugs and Crime<br>НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар |
| **VPNs** | Virtual Private Network(s)<br>Хувийн виртуал сүлжээ |
| **WHO**<br>**ДЭМБ** | World Health Organisation<br>Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| **WSIS**<br>**МНДДХУ** | World Summit on the Information Society<br>Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалт |

# Хураангуй

Интернэт нь дэлхийн өнцөг булан бүрд мэдээлэл хүргэх, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгож, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийг тасралтгүй өөрчлөгч харилцаа холбооны гол хэрэгсэл болон асар хурдацтай хөгжиж байна. Шинэ санаа, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний дэлхийн зах зээл болж чадсан интернэт нь хүний эрхийг хангахыг дэмжихийн зэрэгцээ шинэ шинэ эрсдэлийг дагуулах болжээ. Интернэтийн ашиг тусыг бүх нийтэд хүртээмжтэй болгохын тулд эн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлын нэг бол хөгжингүй, хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнууд, хот болон хөдөө орон нутгийн хоорондын болон хүмүүсийн орлого, боловсрол, мэдлэг чадвар, жендерийн цахим ялгавартай байдал юм. Интернэтийн технологи, үйлчилгээ, зах зээл тасралтгүй өөрчлөгдөн хөгжихийн хэрээр түүний боломж, дагуулах эрсдэл нь улам бүр төвөгтэй болж, илүү хүчтэй илэрч, ирээдүйд илүү ихээр нөлөөлөх боллоо.

Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-д оновчтой хувь нэмэр оруулахад интернэтийн үр ашигтай хэрэглээ, түүний хөгжил, үр нөлөөг ойлгож, үнэлэх нь маш чухал. ЮНЕСКО нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл болон мэдлэгийн хүртээмжтэй байдал, соёл болон хэлний ялгаатай байдлыг хүндэтгэх, бүх нийтийн чанартай боловсролд суурилсан мэдлэгийн нийгмийг хөгжүүлэхэд интернэтийн гүйцэтгэх үүрэг, чадавхыг онцолж, уг хөтөлбөрийг удаан хугацаанд хэрэгжүүлж ирсэн билээ. Тухайлбал, тус байгууллага 2003, 2005 оны Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалт (МНДДХУ), Интернэт засаглалын форум (ИЗФ), Тогтвортой хөгжлийн өргөн зурвасын комисс (ТХӨЗК) болон интернэт болон түүний үр нөлөөнд анхаарал хандуулдаг бусад форумд чухал үүрэг гүйцэтгэдэг. Интернэт тасралтгүй хөгжихийн хэрээр ЮНЕСКО-гоос интернэтийн хөгжлийг ойлгоход туслах үүднээс интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлалыг боловсруулсан болно.

## Интернэтийн түгээмэл байдал

Интернэт бол зөвхөн цахим технологи биш юм. Энэ бол эдийн засаг, нийгмийн харилцан үйлчлэл, харилцаа холбооны сүлжээ. Иймээс интернэт нь хүний эрхийг хангах, хувь хүн болон нийгмийг чадавхжуулах, тогтвортой хөгжлийг хурдасгах боломжийг олгодог. Нөгөөтээгүүр энэ нь нийгэм, эдийн засаг, хөгжилд эерэг ба сөргөөр нөлөөлөх замаар тогтсон хэм хэмжээний асуудлыг үүсгэдэг. Интернэтийн олон асуудлыг төрийн бодлогын хүрээнд авч үзэх нь тэгш байдал, хүртээмжтэй байдал, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүй, соёлын олон талт байдал, чанартай боловсрол, хүний эрхийн хамгаалал зэрэгт чухал нөлөөтэй юм. ЮНЕСКО нь эдгээр нөлөөлөлд ихээхэн анхаарч, тэдгээрийг Интернэтийн түгээмэл байдлын олон талт шатлалын дагуу судлан сайжруулж ирсэн билээ.

Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлалыг хоёр жилийн турш боловсруулсны дараа 2015 онд ЮНЕСКО-гийн Ерөнхий хурлаар баталсан. Энэхүү үзэл баримтлал нь интернэтийн өсөлт, хөгжлийн үндсэн тулгуур болсон 4 зарчмыг онцолсон алсын харааг тодорхойлсон. Энэ нь интернэт нь хүмүүсийн харилцаанд илүү давамгайлж байгаа тул эдгээр зарчмыг улам бэхжүүлэх шаардлагатайг харуулж байна. Интернэтийг ийм байдлаар ойлгох нь ЮНЕСКО-гийн дэлхий дахинд гүйцэтгэх үүрэг, түүний гишүүн орнуудаа үзүүлэх дэмжлэгтэй хамааралтай экосистемийн төрөл бүрийн талуудыг нэгтгэхэд тусалдаг.

Интернэтийн түгээмэл байдлын үндсэн тулгуур хэмээн тодорхойлсон 4 зарчмыг R-O-A-M (эрх, нээлттэй байдал, хүртээмжтэй байдал, олон талт оролцоо) зарчим гэх бөгөөд эдгээр нь Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд нийцтэй байдлаар интернэтийг хөгжүүлэх үндэс суурь болно. Эдгээр зарчим нь:

**R** - Интернэт нь хүний **эрхэд** суурилдаг;

**O** - **Нээлттэй**;

**A** - Бүх нийтэд **хүртээмжтэй** байх ёстой;

**M** - Олон талт сонирхлын бүлгийн **оролцоогоор дэмжигддэг** байна.

Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлалыг илүү ойлгох, хэрэгжүүлэх боломжийг олгохын тулд ЮНЕСКО нь 4 зарчмын шалгуур үзүүлэлтийг боловсруулахад 2 жил зарцуулсан. Эдгээр шалгуур үзүүлэлт нь үндэсний түвшинд интернэтийн түгээмэл байдал эмпирик үнэлгээ хийх боломжийг олгодог. Судалгаанд эдгээр шинэ шалгуур үзүүлэлтийг ашигласнаар засгийн газар болон бусад сонирхогч талуудад ололт амжилт, алдаа дутагдлыг тодорхойлоход туслах нотлох баримтыг цуглуулах боломжтой. Шалгуур үзүүлэлтийн хүрээг орон нутгийн интернэтийн орчныг сайжруулах үүднээс үндэсний хэрэглээнд зориулсан бөгөөд улс орнуудыг өөр хооронд нь харьцуулан эрэмбэлэхэд зориулаагүй болно.

Энэхүү баримт бичигт тодорхойлсон Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг судалгааны үйл явц, олон улсын шинжээчдийн зөвлөгөө, улс орнуудад хийсэн туршилтад тулгуурлан гаргасан. ЮНЕСКО энэхүү ажлыг Дэвшилтэт харилцаа холбооны нийгэмлэг тэргүүтэй МХХТ-ийн хөгжлийн холбоод, LIRNEasia, Африкийн МХХТ-ийн судалгааны байгууллагаас бүрдсэн судалгааны консорциумын дэмжлэгтэйгээр хамтран гүйцэтгэсэн.

Хэлэлцүүлгийн эхний үе шатанд Интернэтийн түгээмэл байдлын өргөн хүрээний сэдвүүд, тэдгээрийг шалгуур үзүүлэлтийн хүрээнд багтаах талаар авч хэлэлцсэн. 2017 оны 6 дугаар сараас 10 дугаар сарын хооронд цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, нийт 198 оролцогчийг хамруулсан байна. Түүнчлэн 2017 оны 3 дугаар сараас 10 дугаар сарын хооронд зохион байгуулагдсан олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээний 26 арга хэмжээний үеэр зөвлөлдөх хэлэлцүүлэг, сургалт семинарыг зохион байгуулжээ.

2017 оны 12 дугаар сараас 2018 оны 3 дугаар сарын хооронд хэлэлцүүлгийн 2 дахь үе шатыг ижил төстэй зарчмаар зохион байгуулж, шалгуур үзүүлэлтийн хүрээ болон шалгуур үзүүлэлтийн төсөлд санал авсан. Үүнд 138 оролцогчийг хамруулж, олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээний 16 арга хэмжээнд нэмэлт зөвлөлдөх хэлэлцүүлэг болон сургалт семинарыг зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийн 3 дахь үе шатанд өмнөх 2 хэлэлцүүлгээр боловсруулсан шалгуур үзүүлэлтийг улам боловсронгуй болгож, тэдгээрийг Бразил, Эквадор, Нигери, Пакистан гэсэн 4 улсад судалгаа явуулж, урьдчилсан туршилт хийсэн. Улмаар Бразил, Сенегал, Тайланд гэсэн 3 улсад хэсэгчлэн турших байдлаар сайжруулж, шалгуур үзүүлэлтийг эцэслэн энэхүү баримт бичигт оруулсан болно.

Төсөлд Олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх баг, ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага зөвлөгөө өгч, Шведийн Олон улсын хөгжлийн агентлаг, Интернэтийн нийгэмлэг болон Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэхүү хамтын үйл ажиллагааны үр дүнд дэлхий даяар болон сонирхогч талуудын гол ойлголт, туршлагад тулгуурлан орчин үеийн, цогц бөгөөд бодит байдалд туршигдсан судалгааны аргачлалыг боловсруулсан.

# Шалгуур үзүүлэлтийн хүрээ

Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээг ROAM дөрвөн зарчимтай уялдуулан бүтэцлэж, жендер, хүүхдийн хэрэгцээ шаардлага, тогтвортой хөгжил, итгэлцэл, аюулгүй байдал, интернэтийн эрх зүйн болон ёс зүйн зангилаа асуудлын шалгуур үзүүлэлтийг нэмж оруулсан. Эдгээр нь ROAMX шалгуур үзүүлэлтийн хүрээг бүрдүүлдэг.

ROAMX шалгуур үзүүлэлтээс гадна уг хүрээ нь тухайн улсын хүн ам зүй, нийгмийн болон эдийн засгийн онцлогтой холбоотой нөхцөл байдлаас хамаарах хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг багтаадаг. Эдгээр нөхцөл байдлаас хамаарах шалгуур үзүүлэлт нь хэрэглэгчдэд өөр өөр улс орны хувьд өөрсдийн дүгнэлтийг хамгийн тохиромжтой байдлаар ойлгоход нь туслах зорилготой.

# Сэдэв, асуулт, шалгуур үзүүлэлт

ROAMX ангилал тус бүр хэд хэдэн сэдэвт хуваагддаг. Сэдэв нь шалгуур үзүүлэлтийг ашиглан судалгаа, үнэлгээ хийх үндсэн бүтцийг бүрдүүлдэг. Сэдэв тус бүр хэд хэдэн асуулттай, асуулт тус бүр нэг эсхүл олон шалгуур үзүүлэлттэй байна.

# Шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх

Ямар ч улсын хувьд бүх шалгуур үзүүлэлтэд шаардлагатай нотлох баримт байхгүй байж болно. Гэвч шалгуур үзүүлэлтийн тоо, цар хүрээ нь өгөгдлийн хязгаарлалтаас үл хамааран судлаачдад бодит үнэлгээ хийхэд хангалттай хэмжээний өгөгдөл цуглуулах боломжийг олгохуйц байх ёстой. Цаашилбал, шалгуур үзүүлэлтийг тайлбарлах, холбогдох мэдээллийг цуглуулахад туслах үүднээс уг хүрээ нь тоон болон чанарын нотлох баримтын ерөнхий эх сурвалж, холбогдох суурь баримт бичиг, олон улсын тогтоосон үзүүлэлт болон чухал байж болох бусад шалгуур үзүүлэлтийн хүрээг багтаадаг.

ЮНЕСКО нь сонирхогч талууд уг шалгуур үзүүлэлтийн хүрээг бүхэлд нь ашиглана хэмээн үзэж байгаа хэдий ч энэ нь судалгааны багагүй хугацаа, ихээхэн туршлага шаардахыг хүлээн зөвшөөрдөг. Иймд үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс сонгож авсан шалгуур үзүүлэлт бүхий хураангуйлсан сонгох багцыг мөн тодорхойлсон (Хавсралт 4) болно.

Энэхүү баримт бичигт хавсаргасан судлаачдад зориулсан гарын авлага (10 дугаар хэсэг) нь техникийн удирдамж болон судалгааны зөвлөгөөг агуулдаг.

Интернэт асар хурдацтай өөрчлөгдөн хөгжиж байгаа тул цаашид ЮНЕСКО энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээг хэрэгжүүлж эхэлснээс хойш 5 жил тутам хянаж, зохион байгуулсан болон бүрэн хийсэн үнэлгээний үр дүн, сургамж, туршлагыг авч үзэх юм.

Энэхүү чанарын судалгааны аргачлал нь интернэттэй холбоотой асуудлыг үндэснийхээ түвшинд тодорхойлох сонирхолтой аливаа гишүүн оронд чухал ач холбогдолтой. Үндэсний түвшинд хийсэн Интернэтийн түгээмэл байдлын үнэлгээний үр дүн нь тухайн улсыг тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд интернэтийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх нотолгоонд суурилсан бодлогод нөлөөлж болно.



# 1

# ИНТЕРНЭТИЙН ТҮГЭЭМЭЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ЮНЕСКО-ГИЙН **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨСӨЛ**

“Info Lady” Шати нь хөдөөгийн тосгоны хэсэг эмэгтэйчүүдэд видео үзүүлж байна. Бангладеш улсад “Info Lady” гэгдэх эмэгтэйчүүд нь мэдээлэл авах шаардлагатай хэдий ч интернэтэд хандах боломжгүй хүмүүст интернэтийн үйлчилгээг хүргэдэг. Тэд 3 сарын сургалтад хамрагдсаны дараа өдөр бүр ягаан, цэнхэр дүрэмт хувцсаа өмсөн алслагдсан тосгон руу дугуйгаар очиж, тосгоны оршин суугчдад хилийн чанадад ажилладаг хамаатан садантайгаа холбогдох боломжийг олгодог.

© G.M.B. Akash/Panos Pictures



# ИНТЕРНЭТИЙН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

# Интернэтийн хөгжил

Өдгөө интернэт нь харилцаа холбооны салбарын харьцангуй шинэ хөгжил хэвээр байна. Энэ нь анх эрдэмтэн, судлаачдын жижиг бүлгүүдийг холбосон найдвартай сүлжээ байсан бол өнөөдөр цогцоор нь танин мэдэхэд төвөгтэй, олон хэмжээст харилцаа холбооны хэрэгсэл болон хөгжжээ. Интернэт нь хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн экосистемийг ихээр нэмэгдүүлж, шинэ санаа, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний дэлхийн зах зээлийг улам бүр өргөжүүлэн тэлсээр байна. Нэг талаар хүний эрхийг хангахын зэрэгцээ нөгөөтээгүүр эрх эдлэхтэй холбоотой шинэ эрсдэлийг бий болгох болжээ. Интернэтийн нарийн төвөгтэй шинж нь мэдээллийн хүртээмж, үзэл бодлоо илэрхийлэх боломж төдийгүй төр, хувийн хэвшлийн талаарх бидний ойлголт, тэдгээрийг тодорхойлоход хүндрэл үүсгэх нь бий. Тогтвортой хөгжилд хүрэх үндэс суурь ньинтернэтийн хөгжил бөгөөд шинээр бүрэлдэж буй мэдлэгийн нийгэмд интернэтийн үзүүлэх нөлөөг ойлгох, үнэлэх нь чухал болж байна

Өөрчлөлт нь инновацыг хурдасгах интернэтийн нээлттэй бүтэцтэй холбоотой байдаг. Технологи, нэвтрэх төхөөрөмж, үйлчилгээний шинэ хөгжил нь төр, хувийн хэвшил, иргэний нийгэмд шинэ боломжуудыг тасралтгүй бий болгосоор байна. Эдгээрээс хамгийн чухал нь World Wide Web буюу дэлхий дахины сүлжээ, хөдөлгөөнт интернэт, ухаалаг утасны хөгжил, олон нийтийн сүлжээний өсөлт зэрэг болно. Өргөн зурвасын сүлжээний тасралтгүй өсөлт нь интернэтийн урсгалыг ихээр нэмэгдүүлж, үүлэн тооцооллын технологийн хөгжлийг хурдасгаж, видео урсгалын үйлчилгээний өсөлтийг нэмэгдүүлж байна. Цаашид интернэтэд суурилсан инновац, юмсын интернэт (Internet of Things), хиймэл оюун ухаан болон алгоритмд суурилсан шийдвэр гаргалт зэрэг нь интернэтийн мөн чанар, түүний нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, ялангуяа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-д үзүүлэх нөлөөллийг өөрчилсөөр байх болно. Интернэтийн талаарх бидний ойлголт нь улам бүр хөгжин өөрчлөгдөж буй технологи, үйлчилгээ, тэдгээрийн харилцан хамаарлын хамт өргөжин хөгжих ёстой.

ТХЗ-д хэнийг ч орхигдуулж болохгүйг онцолсон. Хүртээмжтэй байдал нь интернэт бий болсон үеэс дэлхийн хэмжээний чухал асуудал байсаар ирсэн. Зарим бүс нутаг, улс орон, нийгмийн бүлэг, хувь хүн интернэтийн боломжийг ашиглахын тулд бусдаас илүү байр суурьтай байх нь бий. Хөгжингүй, хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудын хооронд, хот ба хөдөөгийн хооронд, хүмүүсийн орлого ба боловсролын ялгаа, эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн хооронд цахим ялгавартай байдал ажиглагдсаар байна. Залуучуудын интернэтийн оролцоо нь ахмад настнуудаас ерөнхийдөө өндөр байдаг бол нийгмийн зарим бүлгүүд, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо бага байдаг. ЮНЕСКО нь интернэтийг бүх нийтэд хэрэглэх боломжтой байлгах, хүртээмжтэй байлгах нөхцөл байдлыг бусад оролцогч талуудын хамтаар авч хэлэлцдэг.

Интернэтийн цар хүрээ улам өргөжихийн хэрээр бодлого боловсруулагч, техникийн нийгэмлэгүүд зөвхөн боломж төдийгүй холбогдох эрсдэлийг шийдвэрлэх шаардлагатай тулгарч байна. Энд өргөн утгаар нь авч үзэж буй кибер аюулгүй байдал нь сүлжээний бүрэн бүтэн байдал, интернэт хэрэглэгчдийг залилан болон бусад төрлийн гэмт хэргээс хамгаалах тухай юм. Интернэтийн хэлэлцүүлэг, мэтгэлцээний үеэр ихээхэн анхаарал татдаг бусад асуудалд хувийн нууцлал, мэдээллийн хамгаалалт, хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхалтыг өдөөх, хувийн орон зайд халдах, олон нийтийн сүлжээг бусдыг төөрөгдүүлэх болон мэдээлэл тараах зорилгоор ашиглах, хүүхэд хамгаалал зэрэг орно. Хууль эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээг агуулсан эдгээр асуудал нь интернэт орчны чухал хэсэг юм.

ЮНЕСКО үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл ба мэдлэгийг бүх нийтэд хүртээмжтэй болгох, хэл соёлын ялгааг хүндэтгэх, бүх нийтийн чанартай боловсролд суурилсан мэдлэгийн нийгмийг хөгжүүлэх зорилгын хүрээнд интернэтийн боломж, чадавхыг онцолж, олон жилийн турш уг хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн[1]. Тус байгууллага нь мэдээллийн технологийн хөгжил, интернэтийн үр нөлөөг тодорхойлсон, тэр дундаа интернэт болон интернэт засаглалд олон талт сонирхлын бүлгүүдийн хандлагыг бэхжүүлсэн Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалтад (МНДДХУ/WSIS, 2003 ба 2005) голлох үүрэг гүйцэтгэж[2], олон жилийн турш МНДДХУ-ын төдийгүй Интернэт засаглалын форумд чухал үүрэгтэйгээр оролцож ирсэн. Түүнчлэн тус байгууллага нь интернэт хөгжлийн талаар цуврал бага хурал, бусад арга хэмжээг зохион байгуулж, интернэтийн нөлөөлийн талаар олон тайланг нийтэлж, дүн шинжилгээ хийдэг. Иймд интернэт нь ЮНЕСКО-гийн харилцаа холбоо, мэдээллийн салбарт төдийгүй боловсрол, соёл, байгаль, нийгмийн шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд голлох байр суурийг эзэлдэг.[3]

ЮНЕСКО нь интернэтийг дэд бүтэц, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн нэгдэл гэдгээс хавьгүй өргөн хүрээнд авч үздэг. Иймээс интернэтийг эдийн засаг, нийгмийн харилцан үйлчлэл, харилцаа холбооны сүлжээ бөгөөд хүний эрхийг хангах, хувь хүн, олон нийтийг чадваржуулах, тогтвортой хөгжлийг дэмжих технологиос хол давсан асар их нөөц бололцоотой гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Интернэт нь эдийн засаг, нийгэм, хөгжилд эерэг болон сөргөөр нөлөөлдөг эдийн засаг, нийгмийн тогтсон хэм хэмжээний асуудал, сорилтыг бий болгодог. Иймд үүнийг төрийн бодлогод тусгаж, практикт шийдвэрлэх нь тэгш байдал, хүртээмж, хүний эрхийн хамгаалал төдийгүй

хэвлэл мэдээлэл, соёлын ялгаатай байдал, бүх нийтийн чанартай боловсрол болон ЮНЕСКО-гийн бусад асуудалд нөлөөлдөг. Интернэт орчны эдгээр асуудлыг Интернэтийн түгээмэл байдлыг олон талт байдлаар дамжуулан судалж, сайжруулах боломжтой.

# Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлал

2013 онд ЮНЕСКО-гоос мэдлэгийн нийгмийг байгуулах, тогтвортой хөгжилд хүрэхийн тулд хүн төрөлхтний бүтээсэн энэхүү боломжийг бүрэн ашиглах үндсэн суурь болох интернэтийн боломжийг тодорхойлох зорилгоор Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлалыг гаргасан.[4]

ЮНЕСКО нь гишүүн орнууд болон интернэтийн оролцогч талуудтай хамтран хийсэн өргөн хүрээтэй судалгаа шинжилгээ, зөвлөлдөх уулзалтын үр дүнд Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлалыг боловсруулсан. Үүнд, 2015 оны 3 дугаар сард Парис хотноо зохион байгуулсан CONNECTing the Dots[5] олон талт оролцогчдын бага хурал, мэдлэгийн нийгмийг дэмжих голлох шинжээчдийн тайлан, нийтлэл зэргийг дурдаж болно.[6]

2015[1] онд ЮНЕСКО-гийн Ерөнхий Хурлаар сайшаан баталсан Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлал нь интернэт ба түүний тогтвортой хөгжилтэй холбогдох асуудлыг үр дүнтэй, шуурхай шийдвэрлэхэд тусалдаг. Түүнчлэн интернэтийн өсөлт, хөгжлийн үндсэн тулгуур болох 4 зарчмыг онцолж, интернэт нь хүмүүсийн амьдралын бүх хүрээг өргөнөөр хамарч байгаа энэ цаг үед тэдгээр зарчмыг бэхжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Интернэтийг ийм байдлаар ойлгох нь дэлхий даяар ЮНЕСКО-гийн экосистемийн олон талыг нэгтгэхэд тусалж, улмаар технологи, төрийн бодлого, хүний эрх, тогтвортой хөгжлийн нэгдлийг бүрдүүлдэг. R-O-A-M гэгдэх Интернэтийн түгээмэл байдлын 4 зарчмыг Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг дэмжих интернэтийг хөгжүүлэх үндэс суурь гэж үздэг. Эдгээр зарчим нь:

**R** – Интернэт нь хүний **эрхэд** суурилсан;

**O** – **Нээлттэй** байна;

**A** – Бүх нийтэд **хүртээмжтэй**;

**M** – Олон талт сонирхлын **бүлгүүдийн оролцоогоор** дэмжигдсэн.

Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлал нь интернэтийн хөгжлийг цогцоор нь авч үзэх, тэр дундаа дээрх 4 зарчим хоорондын харилцан хамаарлыг ойлгохын чухлыг онцолдог. Интернэтийн энэхүү цогц арга барил нь НҮБ-ын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэлэлцүүлгийг илүү үр өгөөжтэй болгодог.[7]

Энэхүү баримт бичигт тусгасан Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлал, шалгуур үзүүлэлтийн хүрээ нь эн тэргүүнд интернэтэд хамааралтай хэдий ч хурдацтай хөгжиж буй цахим орчны илүү өргөн хүрээтэй бусад асуудалд ч хамааралтай, хэрэгжүүлэх боломжтой байна. Мэдээллийн технологи, үйлчилгээ хурдацтай өөрчлөгдөж, хиймэл оюун ухаан, дэвшилтэт робот техник зэрэг шинэ технологиуд бий болохын хэрээр боломжийг өргөжүүлэх, тэдгээрээс үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн технологийн тогтолцоонд тогтмол хяналт тавих шаардлага урган гарч байна. Дээрх 4 зарчим, тэдгээрийн гол санаа нь хүн төрөлхтний хөгжил, цахим хөгжлийн талаарх ойлголтыг илүү өргөн хүрээнд өгдөг.

# Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгцээ шаардлага

1

Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлалын шинжилгээг улс орны түвшинд илүү тодорхой хийх боломжийг олгох үүднээс шалгуур үзүүлэлтийн хүрээг боловсруулсан. Уг хүрээ нь нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломжийг олгох замаар улс орныхоо интернэтийн орчныг сайн дураар үнэлж дүгнэхийг хүсэж буй засгийн газар, бусад оролцогч талуудад туслах зорилготой.

Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурал болон Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөр (ХХХОУХ)-ийн Засгийн газар хоорондын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу боловсруулсан[1]. Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулахтай холбоотой цаашдын чиг үүрэгт ЮНЕСКО-гийн 2017 оны Ерөнхий бага хурлаас баталсан 39 C/5 хөтөлбөр ордог. 2016 онд ХХХОУХ-ийн албанаас арга хэмжээний нэг хэсэг болгон Шведийн Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгээр дэлхийн хэмжээний хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулахад туслах зорилгоор итгэлцлийн төслийн санхүүжилтийг баталсан. Түүнчлэн уг арга хэмжээг Интернэтийн нийгэмлэг болон Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага дэмжин ажилласан.

Шалгуур үзүүлэлт нь 2008 онд ХХХОУХ-өөс баталсан Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлттэй төстэй бөгөөд засгийн газар, сонирхогч бусад талууд (дурын салбар эсхүл бүлэг) үндэсний хэмжээний үнэлгээ хийхэд тэдгээр нөөцийг ашиглах боломжтой. 2018 оны дунд үе гэхэд олон улс оронд 30 орчим Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтийг боловсруулсан болон боловсруулж байгаа нь үндэсний хэвлэл мэдээллийн орчны талаарх мэдлэг, ойлголтыг баяжуулж байна. Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтийн хүрээ нь ач холбогдолтой хэвээр байгаа ч Интернэтийн түгээмэл байдлын хүрээ нь экосистемийн зураглал болон ЮНЕСКО-гийн онцгойлон анхаардаг олон асуудалд нөлөөлж буй харилцаа холбооны экосистемийн хувьсан өөрчлөгдөж буй бусад хэмжигдэхүүний зураглалыг гаргах нэмэлт аргачлал болно.

Энэхүү баримт бичигт буй Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг ЮНЕСКО-гийн хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны шалгуур үзүүлэлтийн хүрээний өмнөх туршлагад үндэслэн боловсруулсан. 2008 онд ХХХОУХ-ийн 26 дугаар чуулганаас баталж, улмаар хэд хэдэн гишүүн улсад ашигласан Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтээс гадна сонирхогч гишүүн улс, бусад сонирхогч талууд улс орныхоо харилцаа холбооны орчныг үнэлэх, түүний чанарыг сайжруулах бодлогыг боловсруулахад сайн дурын үндсэн дээр үнэлгээ хийхдээ ашигладаг шалгуур үзүүлэлт байдаг. Тухайлбал:

- ХХХОУХ нь 2013 онд сэтгүүлчдийн аюулгүй байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг баталсан.[10]
- Хэвлэл мэдээлэл дэх жендерийн мэдрэмжтэй байдлын үзүүлэлтийг 2012 онд баталсан. [11]
- Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролтой холбоотой үзүүлэлтийг гаргасан. [12]

Энэхүү баримт бичигт тодорхойлсон хүрээнд дээрх баримт бичгүүдийг ашиглаж, шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдуулсан. Уг баримт бичигт тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн хүрээ нь НҮБ болон бусад оролцогч талуудын ТХЗ-ын хэрэгжилт, биелэлтийг хянах, хэмжих хүчин чармайлт, тухайлбал, Хөгжлийн төлөөх МХХТ-ийг хэмжих хамтын түншлэлийн байгуулсан ТХЗ-ын Ажлын хэсгийн ажлыг багтаасан болно.[13]

[1] Интернэтийг ЮНЕСКО-гийн байр сууринаас үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах боломжийг 2014 оны 11 дүгээр сард болсон ЮНЕСКО-гийн Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөр (ХХХОУХ)-ийн Засгийн газар хоорондын зөвлөлийн 29-р чуулганаар зарлав. Үүнд, "Хэвлэл мэдээллийн хөгжилд хамаарах шалгуур үзүүлэлтийг боловсруулж, хэрэгжүүлэх замаар стандартын дагуу үргэлжлүүлэн ажиллаж", “Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтийн туршлагад тулгуурлана” гэж заажээ. 2015 онд болсон "CONNECTing the Dots" бага хурлын үр дүнгийн баримт бичигт Ерөнхий бага хурлаар дэмжигдсэн Интернэтийн түгээмэл байдлын үзэл баримтлалыг танилцуулж, цаашид хууль, бодлого, зохицуулалтын хүрээ, холбогдох шалгуур үзүүлэлтийг оролцуулан интернэтийн ашиглалтын талаар судалгаа хийхийг уриалав.

# Шалгуур үзүүлэлтийн хүрээ боловсруулах арга зүй, үйл явц

2017 оны 4 дүгээр сард Дэвшилтэт харилцаа холбооны нийгэмлэг (ДХХН) тэргүүтэй консорциумыг олон улсын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар шалгуур үзүүлэлтийг ЮНЕСКО-той хамтран боловсруулах ажлын гүйцэтгэгчээр томилсон. Тус консорциумд ДХХН-ээс гадна МХХТ-ийн хөгжлийн холбоод, LIRNEasia, Африкийн МХХТ-ийн судалгааны байгууллага зэрэг бүс нутгийн мэдээллийн технологийн судалгааны байгууллагууд орсон. Төслийн судалгаанд хатагтай Анри ван де Спи дэмжлэг үзүүлж, МХХТ-ийн хөгжлийн холбоодын доктор Дэвид Сотер төслийн удирдагчаар, хатагтай Анриетт Эстерхуйсен төслийн багийн зохицуулагчаар ажилласан.

ЮНЕСКО-гоос төслийн хэрэгжилтэд зөвлөгөө өгөх зорилгоор бүс нутаг, сонирхогч талуудын интернэтийн төрөл бүрийн чиглэлээр ажилладаг олон улсын 15 шинжээчээс бүрдсэн Олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх багийг томилсон (Хавсралт 1-ийг үзнэ үү). ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас зөвлөгөө авч ажилласан. Уг төслийг судалгаа, зөвлөгөө, баталгаажуулалт гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Төслийн эхний үе шатанд интернэтийн түгээмэл байдлын өргөн хүрээний сэдвүүд, тэдгээрийг шалгуур үзүүлэлтийн хүрээнд багтаах арга замыг авч үзсэн. Энэ үе шат нь дараах хоёр хэсэгтэй. Үүнд:

a. Засгийн газар хоорондын байгууллага, олон улсын төрийн бус байгууллага, бусад оролцогч талын боловсруулсан эсхүл баталсан хүчин төгөлдөр шалгуур үзүүлэлт, индексийн судалгаа;
b. Интернэттэй холбоотой төрөл бүрийн оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлэг, зөвлөгөөн. Гишүүн орнуудын засгийн газар, олон улсын байгууллага, интернэтэд онцгой ач холбогдол өгдөг холбоодыг хэлэлцүүлэгт тусгайлан урьсан байна.

Хэлэлцүүлгийг дараах хоёр хэсэгтэйгээр зохион байгуулав. Үүнд:

a. 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалтаар НҮБ-ын албан ёсны 6 хэлээр онлайн хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг эхлүүлж, 2017 оны 10 дугаар сарын 31 хүртэл нээлттэй явуулав. Хэлэлцүүлэгт 198 оролцогч оролцсон (Хавсралт 3-ыг үзнэ үү)[2].
b. 2017 оны 3 дугаар сарын 29-нөөс 10 дугаар сарын 31-ний хооронд дэлхийн 22 улсад[3] зохион байгуулагдсан интернэтийн асуудлаарх олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээний 26 арга хэмжээний үеэр зөвлөлдөх уулзалт, семинарыг зохион байгуулсан (Хавсралт 2-ыг үзнэ үү).

Эхний үе шатанд Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрээ, багц шалгуур үзүүлэлтийн төслийн баримт бичгийг бэлтгэж, 2017 оны 12 дугаар сард цахимаар болон хэвлэмэл байдлаар нийтэлсэн. Үүнд, ЮНЕСКО-гийн шалгуур үзүүлэлтийн өмнөх туршлагад үндэслэн дор дурдсан үндсэн 6 шалгуурыг гаргав. Үүнд:

- Шалгуур үзүүлэлтийг найдвартай боловсруулах үүднээс хэмжих өгөгдөлд чанарын хувьд найдвартай байхаар сонгох;
- Тухайн сонгосон шалгуур үзүүлэлтийг боломжтой бол тоон, шаардлагатай бол чанарын шинжээр авч үзэх;
- Шалгуур үзүүлэлтийг тус тусад нь шалган баталгаажуулах боломжтой байх;
- Шалгуур үзүүлэлтийг боломжтой бөгөөд хамааралтай бол хүйс, насны бүлэг, газар нутаг[4] болон хүн амын бусад шинж чанараар ангилах;
- Ихэнх улс оронд зохистой цаг хугацаа, зардлаар шаардлагатай өгөгдөл, мэдээллийг цуглуулах боломжтой байх.

Хоёр дахь үе шатны хэлэлцүүлгийг 2017 оны 12 дугаар сарын 1-нээс 2018 оны 5 дугаар сарын 18-ны хооронд зохион байгуулж, нийт оролцогчдод энэхүү хүрээ, шалгуур үзүүлэлтийн төсөлд санал өгөх боломжийг олгосон. Гишүүн орнуудын засгийн газар нь интернэтийг онцгойлон анхаардаг олон улсын байгууллага, холбоодыг оролцохыг дахин урьсан.

Хоёр дахь хэлэлцүүлэгт оролцогчид дараах 3 асуултыг авч хэлэлцсэн байна. Үүнд:

1. *Энэхүү хүрээнд оруулах шаардлагатай гэж үзэж буй* ***нэмэлт сэдэв, асуулт, шалгуур үзүүлэлт*** *бий эсэх?*
2. *Энэхүү хүрээнд* ***санал болгосон сэдэв, асуулт, шалгуур үзүүлэлтийг*** *энэ хэвээр оруулах талаар ямар нэг санал байгаа эсэх?*
3. *Санал болгож буй асуулт, шалгуур үзүүлэлтийн талаар өөрийн туршлагад үндэслэн ямар* ***эх сурвалж, баталгаажуулалтын*** *аргыг санал болгох вэ?*

[2] Энэхүү үйл ажиллагаар 2014 онд ноён Эндрю Пуддефаттын удирдсан, Интернэтийн нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр зохион байнуулсан ажилд тулгуурлан гүйцэтгэлээ. http://www.unesco.org/new/ fileadmin/MULTIMEDIA/HQ/CI/CI/pdf/news/defining_internet_indicators_draft.pdf
[3] Аргентин, Австри, Бельги, Хятад, Колумби, Эстони, Франц, Герман, Индонез, Ямайка, Иордан, Кени, Панам, Перу, Португал, ОХУ, Өмнөд Африк, Швед, Швейцар, Тайланд, Арабын Нэгдсэн Эмират Улс, Вьетнам
[4] Жишээ нь хот, хөдөөгийн ялгавартай байдал гэх мэт.

Хэлэлцүүлгийн 2 дахь үе шатыг эхний үе шатын нэгэн адил зохион байгуулсан. Үүнд:

a. НҮБ-ын албан ёсны 6 хэлээр зохион байгуулсан онлайн хэлэлцүүлэгт 138 оролцогч оролцсон (Хавсралт 3-ыг үзнэ үү).
b. 2017 оны 12 дугаар сарын 1-нээс 2018 оны 5 дугаар сарын 18-ны хооронд дэлхийн 13 оронд зохион байгуулагдсан олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээний 15 арга хэмжээний үеэр зөвлөлдөх уулзалт, семинарыг зохион байгуулсан[5]. Үүнд, Ази, Номхон далай, Африк, Латин Америк ба Карибын тэнгис, Арабын орнуудын бүс нутгийн зөвлөлдөх арга хэмжээнүүд орно (Хавсралт 2-ыг үзнэ үү).

Дээрх хэлэлцүүлгийн үр дүнд шалгуур үзүүлэлтийн төслийн баримт бичгийг шинэчлэн боловсруулсан. Хэлэлцүүлгийн 3 дахь үе шатанд 2018 оны 5 дугаар сард Бразил, Эквадор, Нигери, Пакистан гэсэн 4 улсад шинэчилсэн шалгуур үзүүлэлтийн төсөл хэрэгжих өндөр түвшний үнэлгээг хийсэн. Тухайн хүрээнд орсон шалгуур үзүүлэлт тус бүрийг үнэлэхийн тулд нотлох баримт олж авах боломжтой эсэхийг үнэлж, туршилтын орнуудад уг хүрээг хэрэгжүүлэх арга замыг авч хэлэлцэв.

2018 оны 7 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд Бразил, Сенегал, Тайланд зэрэг улсад бодит нотолгоог илрүүлэх шалгуур үзүүлэлтийн хэсэгчилсэн туршилтыг хийв.

2018 оны 11 дүгээр сарын 21-нд зохион байгуулагдсан ЮНЕСКО-ийн XXXОУХ-ийн Засгийн газар хоорондын зөвлөлийн 31 дүгээр чуулганаар “Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээг сайшаан хүлээн авч”, "энэхүү аргачлалыг гишүүн орнууд сайн дурын үндсэн дээр хэрэглэхийг зөвшөөрсөн”[6]. Түүнчлэн уг зөвлөлөөс "сонирхогч гишүүн орнууд болон оролцогч бусад талыг сайн дурын үндсэн дээр Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтээр үндэсний хэмжээнд интернэтийн хөгжлийг үнэлэх, дэмжих", "судалгааны үр дүнг нотолгоонд суурилсан бодлогын хэлэлцүүлэг, зөвлөмжид хэрэглэхийг" уриалав.

[5] Бразил, Канад, Египет, Франц, Гана, Итали, Перу, Шри Ланка, Швейцар, Тайланд, Тунис, Их Британи, АНУ
[6] 2018 оны 11 дүгээр сарын 21-22-нд болсон XXXОУХ-ийн Зөвлөлийн 31 дүгээр чуулганаас гаргасан шийдвэр, ЮНЕСКО-гийн төв байр. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000266235

# ҮЙЛ ЯВЦ, ҮЕ ШАТ

**2017/03 сар**
**Эхлэл**

**2017/11 сар**
**Эхний тайлан**

**2018/11 сар**
**Эцсийн тайлан**

**2018/11 сар**
ЮНЕСКО, ХХХОУХ-ийн Засгийн газар хоорондын зөвлөлөөс шалгуур үзүүлэлтийг батлав.

## 1-Р ҮЕ ШАТ

**ӨРГӨН ХҮРЭЭНИЙ СЭДЭВТ ТӨВЛӨРӨХ**

2017/03-2017/10

Интернэтийн түгээмэл байдал өргөн хүрээний сэдвээрх судалгаа, олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөлдөх уулзалт.

## 2-Р ҮЕ ШАТ

**ТОДОРХОЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТӨВЛӨРӨХ**

2017/11- 2018/03

Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн төслийн судалгаа, олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөлдөх уулзалт.

## 3-Р ҮЕ ШАТ

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН УРЬДЧИЛСАН ТУРШИЛТ, ТУРШИЛТЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ**

2018/04-2018/11

Бразил, Эквадор, Нигери, Пакистанд хийсэн урьдчилсан үнэлгээ (2018/05). Бразил, Сенегал, Тайландад хийсэн хэсэгчилсэн үнэлгээ (2018/07-2018/09)



# 2

# ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН **ХҮРЭЭ**

2015 онд Канадын Нунавут мужийн Саникилуак хотын оршин суугчид орон нутагт түшиглэсэн өвөрмөц өв уламжлал, түүх, соёлын зан үйлийг баримтжуулах цахим зураглалын үйл ажиллагаанд хамрагдсан. Энэхүү төсөл нь нутгийн уугуул иргэд, зураглаачид болон Google компанийн хамтын ажиллагааны хүрээнд өөрсдийгөө Канадын “анхдагч үндэстэн” Метис буюу Инуит хэмээн үздэг ө 1.4 сая хүний газар нутгийн зураглалыг гаргах, тэдний нийгмийн бүлэг, нэгдмэл шинжийг тусган чадваржуулах зорилготой.

© Google Канад




# ROAM-X ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

# Танилцуулга

Энэхүү баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтийн хүрээ нь засгийн газар болон оролцогч бусад талуудад өөрсдийн интернэт орчныг үнэлэх, ROAM зарчимтай уялдуулах хэсгийг тодорхойлж, холбогдох бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг сайжруулахад туслах зорилготой. Түүнчлэн судалгааны дүнд холбогдох бодлогыг боловсронгүй болгоход тусалдаг. Шалгуур үзүүлэлт нь интернэтийн бүх орчинд тохиромжтой хэдий ч хэрэглээ нь тухайн улс орны нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байна.

Энэхүү хүрээ нь үндэсний чадамжийг үнэлэх үндэслэл болох эсхүл улс орнуудыг өөр хооронд нь харьцуулах зорилготой биш юм. Уг хүрээг төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний болон боловсролын байгууллага, интернэтийн хөгжил, хандалт ба эрхийн асуудлаар ажилладаг бусад олон талт сонирхлын бүлэг зэрэг олон янзын оролцогч талууд ашиглах боломжтойгоор боловсруулсан болно.

## Хүрээний бүтэц

Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээ нь ROAM дөрвөн зарчимтай уялдан бүтэцлэгдэж, жендер, хүүхдийн хэрэгцээ шаардлага, тогтвортой хөгжил, итгэлцэл ба аюулгүй байдал, интернэтийн хууль эрх зүй ба ёс зүйн зангилаа асуудлын шалгуур үзүүлэлтийг нэмж оруулсан болно. Эдгээр нь нэгдэж, ROAMX шалгуур үзүүлэлтийн хүрээг бүрдүүлдэг.

ROAMX шалгуур үзүүлэлтээс гадна уг хүрээ нь тухайн улсын хүн ам зүй, нийгмийн болон эдийн засгийн онцлогтой холбоотой нөхцөл байдлаас хамаарах хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг багтааж, хэрэглэгчдэд өөрийн орны нөхцөл байдлын талаар олж мэдсэн зүйлээ ойлгоход нь туслах зорилготой.

**Ангилал**. Энэхүү хүрээ нь бүхэлдээ ROAM дөрвөн зарчмыг зангилаа асуудлын шалгуур үзүүлэлт (X) гэсэн ангиллын хамтаар нийт 5 ангиллаас бүрдэнэ.

**Сэдэв**. ROAMX шалгуур үзүүлэлт тус бүр хэд хэдэн сэдэвт хуваагдана. R болон A ангилал нь 6 сэдэв, O болон X ангилал нь 5 сэдэв, M ангилал нь 3 сэдэвтэй.

**Асуулт**. Сэдвийн хүрээнд хэд хэдэн асуултыг тодорхойлох ба асуулт нь үндэсний гүйцэтгэлийг үнэлэх, нотлох баримт цуглуулах, шалгах тодорхой асуудлыг шийдвэрлэнэ. ЮНЕСКО нь асуулт, шалгуур үзүүлэлтийг бусад хүрээний туршлагад үндэслэн хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтаас гарсан санал, зөвлөмжид тулгуурлан дор дурдсан 6 шалгуураар сонгосон. Үүнд.

- Асуулт тус бүр, холбогдох шалгуур үзүүлэлт нь тодорхой нэг асуудлыг шийдвэрлэдэг байх;
- Шалгуур үзүүлэлтийг найдвартай боловсруулахын тулд хэмжих өгөгдөлд чанарын хувьд хангалттай найдвартай байхаар сонгох;
- Тухайн сонгосон шалгуур үзүүлэлтийг боломжтой бол тоон, шаардлагатай бол чанарын шинжийг авч үзэх;
- Шалгуур үзүүлэлтийг тус тусад нь шалган баталгаажуулах боломжтой байх;
- Шалгуур үзүүлэлтийг боломжтой бөгөөд хамааралтай бол хүйс, насны бүлэг, газар нутаг болон хүн амын бусад шинж чанараар ангилах;
- Ихэнх улс зохистой цаг хугацаа, зардлаар шаардлагатай өгөгдөл, мэдээллийг цуглуулах боломжтой байх.

**Шалгуур үзүүлэлт**. Асуулт бүрд нэг эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх ба шалгуур үзүүлэлт нь тухайн асуултыг үнэлэх нотлох үндэслэл болно. Шалгуур үзүүлэлтийг дор дурдсан 3 ангилалд хуваана. Үүнд:

- Тоон шалгуур үзүүлэлт. Албан ёсны статистик болон бусад мэдээллийн эх сурвалжаас авсан тоон үзүүлэлт, тухайлбал, өрхийн болон мэргэжлийн бусад тоон судалгаа, тэдгээрийг ашиглах боломжтой интернэт бизнесийн цуглуулсан хувийн хэвшлийн мэдээлэл, шаардлагатай бол найдвартай параметр болон индексэд суурилсан тооцоолол байна.
- Зохион байгуулалтын шалгуур үзүүлэлт. Үндсэн хууль болон эрх зүйн баримт бичигт тодорхой зарчмыг тусгах, хэрэгжүүлэгч агентлаг болон бусад байгууллагыг байгуулах, ажиллуулах зэрэг үзүүлэлт байна.
- Чанарын шалгуур үзүүлэлт. Төрийн байгууллага, олон улсын байгууллага, эрдэмтэн судлаач, бусад эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллага, хэвлэл мэдээллийн эх сурвалж, фокус бүлэг зэрэгт чанарын судалгааны

аргыг ашиглан мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэсэн судалгааны мэдээлэл, үнэлгээний явцад мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, үнэлгээний хэсэг болгон зохион байгуулсан зөвлөлдөх үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр зэрэг орно.

**Эх сурвалж**. Энэхүү баримт бичгийн 9 дүгээр бүлэгт бүх ангилал, сэдвийн бүх асуулт, шалгуур үзүүлэлтийг шалгах эх сурвалж, аргачлалыг тусгасан. Энэ нь улс орнуудын өгөгдөл болон мэдээллийн эх сурвалжийн хүртээмж, бэлэн байдал ихээхэн ялгаатай байдгийг хүлээн зөвшөөрч, шалгуур үзүүлэлтийг ашиглахад судлаачдад туслах зорилготой. Сэдэв тус бүрийн хувьд тоон болон чанарын нотлох баримтын ерөнхий эх сурвалжийн жагсаалт, холбогдох суурь баримт бичиг, тогтоосон олон улсын индекс болон ач холбогдолтой байж болох бусад шалгуур үзүүлэлтийн хүрээг зааж өгсөн болно.

Бүх шалгуур үзүүлэлтийн нотлох баримтгүй байж болох тул зарим улс оронд зарим асуулт, шалгуур үзүүлэлтийг хангалттай үнэлэхэд хүндрэл гарч болно. Ийм асуудлыг шалгуур үзүүлэлтийн хүрээнд боломжит эх сурвалжийг багтаах замаар шийдвэрлэнэ. Энэ нь өгөгдлийн хязгаарлалтаас үл хамааран интернэтийн орчныг бүхэлд нь бодитой үнэлэх хангалттай нотолгоотой байх ёстой.

ЮНЕСКО-гоос шалгуур үзүүлэлтийн хүрээг бүхэлд нь ашиглана хэмээн үздэг ч үүнд судалгааны багагүй хугацаа, ихээхэн туршлага шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг. Иймд хураангуйлсан, илүү төвлөрсөн, сонгомол үндсэн багц шалгуур үзүүлэлтийг ашиглаж болно. Ийм үзүүлэлтийг одоор тэмдэглэх бөгөөд 4-8 дугаар бүлэгт бүрэн хүрээг харуулав (Хавсралт 4-өөс харж болно). Шалгуур үзүүлэлтийн хүрээг бүхэлд нь эсхүл үндсэн шалгуур үзүүлэлтийн аль нэгийг ашиглах нь судлаачдад ЮНЕСКО-гийн ROAM зарчмын үүднээс интернэтийн орчныг цогцоор нь ойлгоход туслах тоон болон чанарын хэмжүүрийн нэгдлийг бий болгох боломжийг олгоно.

ЮНЕСКО-гоос олон түвшний боломжит нөөц, туршлага бүхий үнэлгээний багууд энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээг ашиглана хэмээн үзэж байна. Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтийн туршлагаас харахад, олон янзын үзэл санаа, туршлага бүхий судлаачдын цомхон баг нь ялангуяа удирдах зөвлөлийн төлөөллийн дэмжлэгтэй үед боломжит бүх нотлох баримт дээр илүү үр дүнтэй ажилладаг байна. Ийм баг харьцангуй богино хугацаанд цахим болон хэвлэмэл тайлан, өгөгдлийн багц, засгийн газрын байгууллага, хувийн компани болон бусад байгууллагаас мэдээлэл авах хүсэлт гаргах, гол мэдээлэгчтэй ярилцлага хийх, багийн гишүүдийн туршлага ба санал бодлыг хуваалцах хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг олон төрлийн эх сурвалжийг ашиглах, төрөл бүрийн арга барилаар хамтран ажиллаж чаддаг.

Гарын авлагад (10 дугаар бүлэг) судлаачид шалгуур үзүүлэлтийг үр ашигтай хэрэглэх талаарх техникийн заавар, зөвлөгөөг тусгаж, дор дурдсан үйл ажиллагааг авч үзсэн. Үүнд:

- Боломжит эх сурвалж, эх баримт бичгийг тодорхойлох;
- Төр, хувийн хэвшил, үндэсний болон олон улсын эх сурвалжаас мэдээлэл цуглуулах;
- Өгөгдлийн чанар, үнэн зөв, найдвартай, цаг үеэ олсон байдлыг оролцуулан тоон нотлох баримтыг үнэлэх;
- Хүн амын  бүлэг хоорондын өгөгдлийг ангилан задлах;
- Холбогдох судалгаа, шинжилгээний арга техникийг оролцуулан чанарын нотлох баримтыг үнэлэх;
- Судалгааны үр дүнгээр тайлан бэлтгэх.

# R
## Эрх

# O
## Нээлттэй байдал

| | R — Эрх | O — Нээлттэй байдал |
|---|---|---|
| **СЭДЭВ A** | Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ | Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ |
| **СЭДЭВ B** | Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө | Нээлттэй стандарт |
| **СЭДЭВ C** | Мэдээлэл олж авах эрх | Нээлттэй зах зээл |
| **СЭДЭВ D** | Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, нийгмийн амьдралд оролцох эрх | Нээлттэй контент |
| **СЭДЭВ E** | Хувийн халдашгүй байх эрх | Нээлттэй өгөгдөл, ба нээлттэй засаглал |
| **СЭДЭВ F** | Эдийн засаг, нийгэм, соёлын эрх | |

| А<br>Бүх нийтэд хүртээмжтэй байх | М<br>Олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоо | Х<br>Зангилаа асуудлууд |
| --- | --- | --- |
| Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ | Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ | Жендер |
| Холболт ба хэрэглээ | Үндэсний интернэт засаглал | Хүүхдүүд |
| Хямд үнэтэй байх | Олон улсын, бүс нутгийн интернэт засаглал | Тогтвортой хөгжил |
| Эрх тэгш хүртээмжтэй байдал | | Итгэлцэл, аюулгүй байдал |
| Орон нутгийн агуулга, хэл | | Интернэтийн хууль эрх зүйн болон ёс зүйн асуудлууд |
| Чадамж/ур чадвар | | |



# 3

# НӨХЦӨЛ БАЙДЛААС ХАМААРАХ **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Оюутан (зүүн гар талаас) Савера, Фузия, Заруда, Садиа, Гулназ нар 2012 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Пакистаны Пенжаб мужийн Бичиг үсгийн хөгжил (DIL, Developments in Literacy) байгууллагын дэмжлэгтэйгээр Равалпинди хотын ойролцоох Багга Шейхан сургуулийн компьютерын өрөөнд боловсролын төсөл дээр ажиллаж байна. Хэвлэл мэдээлэл болон мэдээллийн бичиг үсгийн боловсрол нь хүмүүсийг сониуч байх, эрэл хайгуул хийх, шүүмжлэлтэй хандах, мэдээлэл болон хэвлэл мэдээллийн агуулгыг ухаалгаар ашиглах, хувь нэмрээ оруулах боломжийг олгодог.

© Kristian Buus/STARS, CC BY-NC-ND 2.0




# НӨХЦӨЛ БАЙДЛААС ХАМААРАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Санал болгож буй шалгуур үзүүлэлтийн хүрээ нь ROAMX таван ангиллаас гадна нөхцөл байдлаас хамаарах хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг агуулдаг. Эдгээр нь ROAMX ангиллын шалгуур үзүүлэлтийн үр дүнг тайлбарлахад чухал үүрэгтэй суурь мэдээллээр хангадаг. Шалгуур үзүүлэлтийг олон улсын байгууллагуудаас эмхэтгэн гаргасан өгөгдлийн багц эсхүл индексээс гаргаж авсан бөгөөд тэдгээрийг тухайн байгууллагын веб сайт, нийтлэлээс авах боломжтой. Нөхцөл байдлаас хамаарах шалгуур үзүүлэлтийг дараах 6 бүлэгт хуваана. Үүнд:Эдийн засгийн шалгуур үзүүлэлт;

1. Хүн ам зүйн шалгуур үзүүлэлт;
2. Хөгжлийн шалгуур үзүүлэлт;
3. Тэгш байдлын шалгуур үзүүлэлт;
4. Засаглалын шалгуур үзүүлэлт;
5. Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн хөгжлийн шалгуур үзүүлэлт.

Шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн эх сурвалжийг дор нэгтгэн оруулав. Эдгээр шалгуур үзүүлэлтийн тоон утгаас гадна шалгуур үзүүлэлтийн хүрээг ашиглаж буй тохиолдолд тухайн улсын гүйцэтгэлийг харьцуулж болохуйц улс орнуудтай харьцуулах, гүйцэтгэлийн чиг хандлагыг өргөн хүрээнд үнэлэх нь чухал ач холбогдолтой.

Эдгээр өгөгдлийн багцын ихэнх нь дийлэнх улсыг хамардаг хэдий ч бүх улсыг багтаадаггүй. Зарим тохиолдолд зарим улсын талаарх мэдээллийг түүхэн өгөгдөл эсхүл харьцуулж болохуйц улсуудын мэдээлэлд үндэслэн тооцдог болохыг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь буурай хөгжилтэй орнуудад тохиолдох магадлал өндөр. Түүнчлэн онлайн эх сурвалжид тэр бүр тодорхой байдаггүй өгөгдөл мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэг бүхий олон улсын байгууллагаас авч болно.

# 1. Эдийн засгийн шалгуур үзүүлэлт

Эдгээр шалгуур үзүүлэлт нь тухайн улсын эдийн засгийн ерөнхий байдал, чадамжтай холбоотой. Шалгуур үзүүлэлт A (GNI p.c. буюу нэг хүнд ногдох үндэсний нийт орлого) нь дундаж орлогын нийтлэг прокси үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлтийг тухайн орлогын хуваарилалттай холбоотой нөхцөл байдлаас хамаарах 4.A шалгуур үзүүлэлтийн хамт авч үзэх шаардлагатай. Шалгуур үзүүлэлт B (GNI growth rate буюу үндэсний нийт орлогын өсөлтийн хэмжээ) нь эдийн засгийн өсөлт, шинэ техник технологийн хөрөнгө оруулалтын хандлагыг хэмждэг. Үйлчилгээнд хамаарах эдийн засагт эзлэх хувь (шалгуур үзүүлэлт C) чухал ач холбогдолтой байдаг нь үйлчилгээний салбар нь олборлох үйлдвэр, түүхий эд, бусад үйлдвэрлэлийн салбараас илүү инновац болон МХХТ-д хөрөнгө оруулалтыг ихээр татдагтай холбоотой.

Үнэлгээг хийхдээ далайд гарцгүй, жижиг арал (жижиг арлын хөгжиж буй орныг оролцуулан) эсхүл буурай хөгжилтэй орон зэрэг үндэсний эдийн засгийн чадамжид нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.[14]

### A. Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (худалдан авах чадварын паритет)

Энэ шалгуур үзүүлэлтийн гол эх сурвалж нь Дэлхийн банкнаас гаргадаг нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (ҮНО)-ын багц өгөгдөл болно.[15]

### B. Сүүлийн арван жилийн ҮНО-ын өсөлтийн хэмжээ

Энэ шалгуур үзүүлэлтийн гол эх сурвалж нь Дэлхийн банкнаас гаргадаг нэг хүнд ногдох ҮНО-ын багц өгөгдөл болно.[16]

### C. Үйлчилгээнд хамаарах ДНБ-д эзлэх хувь

Тус шалгуур үзүүлэлтийн гол эх сурвалж нь Дэлхийн банкнаас гаргадаг ДНБ-ий салбарын тархалтын багц өгөгдөл болно.[17]

# 2. Хүн ам зүйн шалгуур үзүүлэлт

Эдгээр шалгуур үзүүлэлт нь тухайн улсын хүн ам зүйтэй холбоотой. Шалгуур үзүүлэлт A (хүн амын тоо) нь тухайн улс бусад үйлчилгээнээс илүүтэйгээр интернэтийн үйлчилгээний цар хүрээ, эдийн засгийн өсөлтийг бий болгоход нөлөөлдөг. Шалгуур үзүүлэлт B (дундаж наслалт) нь тухайн улсын хөгжлийн түвшинг илэрхийлэх чухал үзүүлэлт юм[1]. Шалгуур үзүүлэлт C (насны үзүүлэлт) ба D (хэлний ялгаатай байдал) нь интернэт хандалт, ашиглалтын тархалтыг тайлбарлахад чухал ач холбогдолтой. Шалгуур үзүүлэлт E (хотжилт) нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтын үнэ болон хурд, улмаар интернэтийн үйлчилгээний улс орон, нутаг дэвсгэрийн хэмжээнд үзүүлэх нөлөөлөл, хот ба хөдөөгийн ялгавартай байдалтай хамааралтай.

Зарим улс оронд онцгой хамааралтай байж болох, судалгааны явцад анхаарах ёстой хүн ам зүйн бусад хүчин зүйлд угсаатны болон соёлын олон янз байдал, шилжилт хөдөлгөөний цар хүрээ (дүрвэгсдийг оруулан) зэргийг авч үзнэ.

A. **Нийт хүн амын тоо, өсөлтийн чиг хандлага**. Энэ шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газрын Хүн амын хэлтэсээс гаргасан хүн амын тоо, өсөлтийн чиг хандлагын багц өгөгдөл болно.[18]

B. **Хүн амын дундаж наслалт, хүйсээр ангилсан**. Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас гаргадаг хүн амын дундаж наслалтын багц өгөгдөл болно.[19] Дундаж наслалтын өгөгдлийг Хүний хөгжлийн индекс (ХХИ)-ээс харж болно.[20]

C. **Хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн насны болон өндөр настны эзлэх хувь.** Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газрын Хүн амын хэлтэсээс гаргадаг хүн амын тоог насны бүлгээр гаргасан багц өгөгдөл болно.[21]

D. **Хэлний ялгаатай байдал.** Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Этнологи (дэлхийн бүх амьд хэлний лавлагаа)-оос гаргадаг хэлний ялгаатай байдлын индекс (улс орнуудын тойм мэдээлэл бүхий) болно.[22]

E. **Хотжилтын зэрэг.** Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газрын Хүн амын хэлтэсээс гаргадаг хот, хөдөөгийн хүн ам зүйн багц өгөгдөл болно.[23]

# 3. Хөгжлийн шалгуур үзүүлэлт

Хөгжлийн шалгуур үзүүлэлт нь тухайн улсын хөгжлийн ерөнхий түвшинтэй уялдаж, мэдээлэл, харилцаа холбоо, технологи (МХХТ)-ийн үйлчилгээний хүртээмж, ашиглалттай нягт холбоотой.[24] Шалгуур үзүүлэлт A (НҮБХХ-ийн Хүний хөгжлийн индекс) нь дундаж наслалт, боловсрол, нэг хүнд ноогдох ҮНО зэрэг шалгуур үзүүлэлтээс бүрдсэн, хөгжлийн ерөнхий шалгуур үзүүлэлт байдлаар өргөн хэрэглэгддэг нийлмэл индекс юм. Шалгуур үзүүлэлт B (боловсролын байдал), шалгуур үзүүлэлт C (бичиг үсэгт тайлагдсан байдал) нь интернэт ашиглах чадварт шууд нөлөөлдөг хувь хүний чадавхтай, шалгуур үзүүлэлт D (цахилгаан эрчим хүчний хүртээмж) нь интернэтийн хэрэглээг хөнгөвчлөх нэмэлт дэд бүтэцтэй тус тус холбоотой.

Зарим улс оронд хамааралтай байж болох, судалгааны явцад анхаарах ёстой бусад хүчин зүйлд зөрчил мөргөлдөөн, байгалийн гамшиг зэрэгтэй холбоотой хүмүүнлэгийн асуудлыг авч үзнэ.

A. **НҮБХХ-ийн Хүний хөгжлийн индекс (ХХИ).** Энэ шалгуур үзүүлэлтэд санал болгох үндсэн эх сурвалж бол НҮБХХ-өөс боловсруулж, жил тутам хүний хөгжлийн тайландаа оруулдаг хүний хөгжлийн индекс болно.[25]

B. **Бага, дунд, дээд боловсролын зохих насны бүлгийн суралцсан дундаж жил, эзлэх хувь (хүйсээр ангилсан байдлаар).** Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгээс цуглуулдаг өгөгдлийн багц болно.[26] Суралцсан дундаж жилийг хүний хөгжлийн индекст оруулсан байдаг.[27]

C. **Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдсан байдлын түвшин, хүйсээр ангилсан байдлаар (шаардлагатай тохиолдолд хэлээр).** Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Дэлхийн банкны цуглуулдаг мэдээлэл байна.[28]

[1] Энэ нь Хүний Хөгжлийн Индексийн нэг бүрэлдэхүүн хэсэг болно. Нөхцөл байдлаас хамаарах шалгуур үзүүлэлт 3A.

**D. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь**. Энэ шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Дэлхийн банкны Тогтвортой эрчим хүчний бүх нийтийн мэдээллийн сан болно.[29]

# 4. Тэгш байдлын шалгуур үзүүлэлт

Эдгээр шалгуур үзүүлэлт нь интернэтийн хүртээмж, ашиглалтын цар хүрээ, боломж нөхцөлийг тодорхойлоход чухал хүчин зүйл болдог нийгмийн тэгш ба тэгш бус байдлын түвшинтэй холбоотой. Хүн амын баялаг, орлогын тархалтыг хэмждэг шалгуур үзүүлэлт A (Жини коэффициент) нь нийгмийн тэгш бус байдлыг тодорхойлоход хамгийн өргөн хэрэглэгддэг шалгуур үзүүлэлт юм. Шалгуур үзүүлэлт B (хүйсийн тэгш бус байдал) нь эрүүл мэнд, эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтээс бүрдсэн нийлмэл үзүүлэлт болно.

**A. Жини коэффициент**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Дэлхийн банкнаас гаргадаг Жини индекс болно.[30]

**B. Хүйсийн тэгш бус байдлын индекс**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь НҮБХХ-өөс гаргадаг Жендерийн тэгш бус байдлын индекс болно.[31]

# 5. Засаглалын шалгуур үзүүлэлт

Эдгээр шалгуур үзүүлэлт нь засаглалын чанарын асуудалтай холбоотой. Шалгуур үзүүлэлт A (Дэлхийн засаглалын үзүүлэлт) нь засаглалын ерөнхий чанартай хамааралтай бөгөөд засаглалын олон талтай холбоотой төрөл бүрийн дэд үзүүлэлтийг багтаадаг. Дэлхийн банкнаас C шалгуур үзүүлэлтийг (Бизнес эрхлэлтийн индекс) бизнес эхлүүлэх, эрхлэх олон талт асуудалтай холбоотой 10 шалгуур үзүүлэлтээр тооцож гаргадаг. Энэ нь технологийн шинэчлэлийн давуу талыг ашиглахыг эрмэлздэг, технологи ба зах зээлийн хурдацтай өөрчлөлтөд мэдрэмтгий интернэт болон онлайн бизнесийг хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтой.

**A. Дэлхийн засаглалын шалгуур үзүүлэлт**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Дэлхийн банкнаас боловсруулдаг Дэлхийн засаглалын шалгуур үзүүлэлт болно.[32]

**B. Эрх зүйт ёсны индекс**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь World Justice Project байгууллагаас боловсруулдаг Эрх зүйт ёсны индекс болно.[33]

**C. Бизнес эрхлэлтийн индекс**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэлтийн индекс болно.[34]

# 6. МХХТ-ийн хөгжлийн шалгуур үзүүлэлт

Эдгээр шалгуур үзүүлэлт нь МХХТ-ийн бэлэн байдал, чадавхын ерөнхий түвшинтэй холбоотой бөгөөд Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн МХХТ-ийн орчны ерөнхий үнэлгээг гаргадаг. Шалгуур үзүүлэлт A (МХХТ-ийн хөгжлийн индекс) нь МХХТ-ийн хүртээмж, ашиглалт, ур чадвартай холбоотой статистик үзүүлэлтийг, шалгуур үзүүлэлт B (Хөдөлгөөнт холболтын индекс) нь дэд бүтэц, боломж нөхцөл, хөдөлгөөнт холболтод хэрэглэгчийн бэлэн байдал, нөхцөл байдлын өгөгдлийг тус тус нэгтгэдэг. Шалгуур үзүүлэлт C (Сүлжээний бэлэн байдлын индекс) нь үндэсний МХХТ-ийн орчин, олон талт сонирхлын бүлгүүдийн МХХТ ашиглах бэлэн байдал, тэдгээрийн бодит хэрэглээг илүү өргөн хүрээтэй авч үздэг бол шалгуур үзүүлэлт D нь цахим худалдаатай холбоотой.

**A. МХХТ-ийн хөгжлийн индекс**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ/ITU)-аас бэлтгэн гаргадаг МХХТ-ийн хөгжлийн индекс болно[35] (уг индекст багтсан зарим шалгуур үзүүлэлтийг A ангилалд оруулсан болно).

**B. Хөдөлгөөнт холболтын индекс**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн үндсэн эх сурвалж нь Олон улсын үүрэн утасны операторуудын холбоо (ОУҮУОХ/GSMA)-ноос гаргадаг Хөдөлгөөнт холболтын индекс болно[36] (уг индекст багтсан зарим шалгуур үзүүлэлтийг A ангилалд оруулсан болно).

**C. Дэлхийн эдийн засгийн форумын Сүлжээний бэлэн байдлын индекс**

Энэхүү шалгуур үзүүлэлтэд санал болгож буй үндсэн эх сурвалж нь Дэлхийн эдийн засгийн форумаас боловсруулсан Сүлжээний бэлэн байдлын индекс болно[37] (уг индекст багтсан зарим шалгуур үзүүлэлтийг A ангилалд оруулсан болно).

**D. НҮБХХБХ-ын Цахим худалдааны индекс**

Энэхүү шалгуур үзүүлэлтэд санал болгож буй үндсэн эх сурвалж нь НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлаас гаргасан B2C (бизнесээс хэрэглэгчид) Цахим худалдааны индекс болно.[38]



# 4

# АНГИЛАЛ R
## Эрх

Хтан Табин тосгоны Khayae ФМ радиогийн сурвалжлагч нь дэлгүүрийн худалдагчтай ярилцлага хийж байна. Khayae ФМ нь Мьянмарын анхны олон нийтийн радио станц юм. Уг радио станц нь ард иргэдэд олон нийтийн радио хүргэх туршилтын хөтөлбөрийн хүрээнд өдөрт 2 цагийн нэвтрүүлэг цацдаг.

© Chris Peken

# R
## Эрх



Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
Мэдээлэл олж авах эрх
Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ
Эдийн засаг, нийгэм, соёлын эрх
Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, нийгмийн амьдралд оролцох эрх
Хувийн халдашгүй байх эрх

Хүний эрхийн үндсэн зарчим нь интернэт, тогтвортой хөгжлийн аль алиных нь амин чухал хэсэг болно. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрт "бүх нийтээр хүний эрх, нэр төр, хуульт ёс, шударга ёс, тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байхыг дээдлэх; арьсны өнгө, үндэс угсаа, соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх; хүний чадавхыг бүрэн дүүрэн ашиглах, хамтын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах тэгш боломжтой" байх тухай тусгасан.[39] Хэрэв интернэтийн орчин уг зарчмыг баримталж чадахгүй бол дээрх хөгжлийн хөтөлбөртэй нийцэхгүй. Хүний эрхийн үндсэн зарчмыг олон улсын хамтын нийгэмлэгүүд Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)[40] болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)[41], Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт (ЭЗНСЭТП)[42], Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (АҮАҮБХУТОУК)[43], Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭЯГБХУТК)[44], Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭТК)[45] зэрэг олон улсын эрхийн гэрээ, хэлэлцээрт тусгасан байдаг.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл[46], Ерөнхий Ассамблей[47] нь "хүний оффлайн орчинд эдэлдэг эрхийг онлайн орчинд нэгэн адил хамгаалах ёстой" хэмээн баталсан. Хүний эрхийн зөвлөлийн тогтоолд хүний эрхийн тухай олон улсын гэрээг онлайн орчинд хэрэгжүүлэх талаар тусгасан байдаг.

Эдгээр олон улсын гэрээнд "ардчилсан нийгэмд үндэсний аюулгүй байдал, […] нийтийн хэв журам сахиулах, нийгмийн эрүүл мэнд, ёс суртахуун, ба бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах хуульд заасан эрхээс бусад эрхэд ямар нэгэн хязгаарлалт тавьж болохгүй" хэмээн онцолсон байдаг.[1] Ялангуяа Хүний эрхийн зөвлөлөөс аливаа хязгаарлалтыг хууль ёсны болгох, хөндөгдсөн эрхийг зөрчсөнд тооцохгүйн тулд хууль эрх зүйн орчин, тэнцвэртэй байдал, бие даасан хяналтын чухлыг онцлон авч үздэг.

Интернэтийн түгээмэл байдал нь интернэтийн өсөлт, хэрэглээ ба хүний эрх хоорондын уялдаа холбоог чухалчлан авч үздэг. Чөлөөт интернэт нь дээр дурдсан олон улсын гэрээ хэлцэлд заасан хүний эрхийг хүндэтгэх, хүмүүст эрхээ бүрэн эдлэх, хэрэгжүүлэх боломжийг олгодог. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хувийн халдашгүй байдал, соёлын оролцоо, жендерийн тэгш байдал, боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон халамжтай холбоотой аюулгүй байдал, эрх зэрэг хүний эрх болон интернэтийн харилцан хамаарлыг бүрэн хамардаг.

Шалгуур үзүүлэлтийн хүрээний уг ангилал нь 6 сэдэвтэй, сэдэв тус бүр асуулт болон шалгуур үзүүлэлтээс бүрдэнэ. Үүнд:

- Сэдэв A нь хүний эрхийн талаарх ерөнхий бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо, тэдгээрийн интернэттэй хамаарах уялдаа холбоо;
- Сэдэв B нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө;
- Сэдэв C нь мэдээлэлд хандах эрх;
- Сэдэв D нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, нийгмийн амьдралд оролцох эрх;
- Сэдэв E нь хувийн халдашгүй байх эрх, түүнтэй хамааралтай асуудал.
- Сэдэв F нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг тус тус багтаана.

Энэ ангилалд хамаарах эрхийн талаарх ойлголт, үнэлгээг дээр дурдсан эрхийн бүх гэрээнд багтаасан байх шаардлагатай. Үнэлгээ нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийн асуудалд онцгой анхаарч, тэдгээрийг жендер ба хүүхдийн асуудалтай холбоотой X ангилалтай уялдуулах шаардлагатай. Ялангуяа уугуул иргэд, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цагаач, дүрвэгсдийн бүлэг зэрэг нийгмийн бүлэгт онцгойлон анхаарна.

Үндэсний үнэлгээг хийхдээ Хүний эрхийн тухай Америкийн конвенц[48], Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн харти[49], Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенц[50] зэрэг эрхийн тухай бүс нутгийн гэрээ хэлэлцээрт анхаарал хандуулж, оффлайн ба онлайн эрхийг хэрэгжүүлэх уялдаа холбоог нэг нэгнээс нь ялгахаас илүүтэйгээр хамтад нь цогцоор нь авч үзэх шаардлагатай.

[1] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ICCPR) 22.2 дугаар зүйл. Үүнийг улс орнууд бүх эрхэд хязгаарлалт тавихыг зөвшөөрсөн хэмээн ойлгож болохгүй. Иймд, жишээлбэл, эрүүдэн шүүх, боолчлолоос ангид байх эрхийг үндэслэлтэй бол хязгаарлаж болно гэсэн тайлбар байх ёсгүй.

# Сэдэв А • Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ

Хүний эрхийн үндсэн зарчмыг олон улсын хамтын нийгэмлэгүүд Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)[51], Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)[52], Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт (ЭЗНСЭТП)[53], Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (АҮАҮБХУТОУК)[54], Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭЯГБХУТК)[55], Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭТК)[56] зэрэг олон улсын эрхийн гэрээ, хэлэлцээрт тусгажээ.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл[57], Ерөнхий Ассамблей[58] нь “хүний оффлайн орчинд эдэлдэг эрхийг онлайн орчинд нэгэн адил хамгаалах ёстой” хэмээн баталсан. Түүнээс гадна Хүний эрхийн зөвлөл “Интернэт дэх хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх тухай” хэд хэдэн тогтоол баталсан нь эдгээр болон нэмэлт асуулт, шалгуур үзүүлэлтэд чиглэсэн.[59]

### RA.1 Эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлэлцээр, хууль тогтоомж, стандарт, хууль ёсны зарчимд нийцсэн хүний эрхийг хангах, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бий эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

▶ Эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ, хууль тогтоомж, стандартад нийцсэн үндсэн хууль, эрх зүйн орчин, түүний дотор хяналтын зохицуулалт бий эсэх, тэдгээрийг засгийн газар болон эрх бүхий байгууллага даган мөрдүүлж байгааг нотлох баримт.[2]

### RA.2 Хүний оффлайн орчинд эдэлдэг эрхийг онлайн орчинд нэгэн адил хамгаалах ёстойг зөвшөөрсөн хууль эрх зүйн орчин бий эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

▶ Хувь хүн онлайн ба оффлайн орчинд ижил эрхтэй байх зарчмыг хууль болон практикт хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж байгааг нотлох баримт.

### RA.3 Интернэт ашиглах, урвуулан ашигласнаас үүдэлтэй эрхийн зөрчлөөс хувь хүнийг хамгаалах эрх зүйн орчин бий эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

▶ Эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ, хууль тогтоомж, стандарттай нийцсэн кибер гэмт хэрэг, интернэттэй холбоотой гэмт хэрэг, эрхийн зөрчлөөс хамгаалах хууль эрх зүйн орчин болон журамласан эрх мэдэл[3].

### RA.4 Төрийн болон төрийн бус байгууллага онлайн болон оффлайн байдлаар эрх зөрчих тохиолдолд хувь хүн үр дүнтэй арга хэмжээ авах боломжтой эсэх?[4]

**Шалгуур үзүүлэлт:**

▶ Зохих ёсны журмын дагуух хууль эрх зүйн орчин, үр дүнтэй арга хэмжээ;

▶ Хүний эрхийн үндэсний байгууллага, түүний үр дүнтэй үйл ажиллагаа;

▶ Хууль, шүүхийн шийдвэрийн нотлох баримт.

---

[2] “Үндсэн үзүүлэлт”-ийг гурвалжин тэмдгээр тэмдэглэв. Бүрэн үнэлгээ хийхэд нөөц хүрэлцэхгүй тохиолдолд үндсэн үзүүлэлтүүдийн дэд багцыг интернэтийн түгээмэл байдлын талаар цогц үнэлгээ хийхэд ашиглаж болно. Эдгээр үндсэн үзүүлэлтийг Хавсралт 4-өөс харж болно.

[3] Цахим гэмт хэргийн тодорхойлолт өөр өөр байдаг. Үнэлгээ нь үндэсний хууль эрх зүйн орчин болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас гаргасан олон улсын гэрээ хэлэлцээртэй уялдах ёстой (9-р бүлгийг үзнэ үү).

[4] Энд хэрэглэсэн "зөрчил" гэсэн нэр томьёо нь төрийн байгууллагын хүний эрхийг зөрчсөн, төрийн бус этгээдийн хүний эрхийг зөрчсөн үйлдлийг аль алинд нь хамаарахыг анхаарна уу.

**RA.5 Шүүгч, шинжээч, хуулийн бусад мэргэжилтэнг интернэт ба хүний эрхтэй холбоотой асуудлаар бэлтгэдэг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбогдох сургалтын бэлэн байдал, сургалтад хамрагдсан эсхүл сургалтыг дүүргэсэн холбогдох ажилтны эзлэх хувь.

# Сэдэв B • Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол Түгээмэл тунхаглалд багтсан хүний эрхийн нэг бөгөөд үүнд интернэт нь харилцаа холбооны хэрэгсэл болсноор ихээхэн нөлөөлөх болсон билээ. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 19(2) дугаар зүйлд хувь хүн "бүх төрлийн мэдээлэл, санаа бодлоо үгээр, бичгээр эсхүл хэвлэмэл хэлбэрээр дурын хэлбэрээр, өөрийн сонгосон дурын хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөтэй байна" хэмээн тодорхойлсон.[60] Түүнчлэн эрхийн тухай бүс нутгийн гэрээнд холбогдох заалтыг тусгасан байдаг.

ИБУТЭТОУП-ын 19(3)-т эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд хуулиар тогтоосон эсхүл зайлшгүй шаардлагатай тохиолдолд (а) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх үүднээс; [эсхүл] (б) үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үүднээс тодорхой хязгаарлалт хийж болохыг тусгасан.[61] Бусад олон улсын гэрээнд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэн ядалт (АӨЯГБХУТОУХ), хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн зураг (ХЭТК) зэрэг мэдээллийг хязгаарладаг. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 34 дүгээр (2011) ерөнхий тайлбарт ийм төрлийн хязгаарлалтыг хуулиар тогтоож, заасан тодорхой зорилгын үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд зохих зарчимтай байх ёстойг онцлон тэмдэглэжээ.[62] Түүнчлэн хууль эрх зүйн орчин ба онлайн, оффлайн хэрэгжилтийн хооронд байж болох ялгааг харгалзан үзэх нь зүйтэй.

Асуулт B.1, B.2, B.3, B.4 нь тухайн улс орны үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах хууль эрх зүйн болон зохицуулалтын ерөнхий тогтолцоотой,[63] асуулт B.5 ба B.6 нь хувь хүн үзэл бодлоо илэрхийлж чадаж байгаа эсэхтэй, асуулт B.7 ба B.8 нь үзэл бодлоо илэрхийлэх шийтгэл болон өөрийгөө цаглан хянахтай (хувийн цензуртэй) холбоотой. А ангиллын D сэдвийн асуулт, шалгуур үзүүлэлт нь энэ сэдэвт мөн хамааралтай болно.

**RB.1 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хуулиар баталгаажуулж, практикт дээдлэн хүндэлж, өргөн хүрээнд хэрэгжүүлдэг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд нийцүүлэн Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулж, түүнийг засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага дээдлэн хүндэлж, мөрдөж байгааг нотлох баримт;[64]
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд нийцүүлэн Үндсэн хууль болон бусад хуулиарбаталгаажуулсан байдал;
- Онлайн болон оффлайнаар үзэл бодлоо илэрхийлэх хэм хэмжээ, олон янз байдлын талаарх баталгаат, эрх бүхий эх сурвалжийн үнэлгээ.

**RB.2 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан аливаа хязгаарлалтыг дэлгэрэнгүй тодорхойлж, эрхийн талаарх олон улсын гэрээ, хууль, стандартын дагуу ил тод хэрэгжүүлдэг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцүүлэн тогтоосон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн хязгаарлалт, тэдгээрийг засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага хүлээн зөвшөөрдөг тухай нотолгоо.

**RB.3 Онлайн контентод урьдчилсан болон дараах хяналт шалгалт[5] (цензур)-ыг ямар үндэслэлээр, хэрхэн ил тодхийдэг вэ?**

---

[5] Хэвлэхээс өмнө (өмнө) болон хэвлэгдсэний дараа (ex post) хэрэгжүүлдэг цензур

**Шалгуур үзүүлэлт:**

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан хууль эрх зүй ба зохицуулалтын орчин;
- Онлайн контентын урьдчилсан болон дараах цензурын тоон ба чанарын нотлох баримт.

**RB.4 Платформ, онлайн үйлчилгээ эрхлэгчид болон тэдний хэрэглэгчдийн нийтэлсэн контентын төлөө ямар нөхцөлд хуулиар хариуцлага хүлээдэг вэ?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Зуучлалын хариуцлага, агуулга/контент зохицуулалтын эрх зүйн орчин нь эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцдэг эсэх, хэрэгжилтийг нотлох баримт.

**RB.5 Хүн амын хэдэн хувь нь онлайн контент үүсгэдэг вэ?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Нийгмийн сүлжээ, бичил блог, блог хөтлөх үйлчилгээ ашигладаг хүн амын эзлэх хувь.

**RB.6 Хувь хүн, сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл/онлайн этгээдийг цахим орчинд мэдээлэл тараасных нь төлөө дур мэдэн баривчлах, яллах, айлган сүрдүүлдэг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбогдох хуулийн заалт, тогтсон дэг журам;
- Онлайнаар үзэл бодлоо илэрхийлсних нь төлөө дур мэдэн баривчилсан, ялласан тухай нотлох баримт.

**RB.7 Хувь хүн, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл/онлайн этгээд засгийн газар болон бусад онлайн этгээдийн дарамтаас зайлсхийхийн тулд өөрсдийгөө хянадаг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Сэтгүүлч, блогчин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл/онлайн этгээд өөрсдийгөө хянаж хязгаарладгийг нотлох баримт;
- Онлайн хүчирхийлэл, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд хүчирхийллийн улмаас өөрийгөө хянаж хязгаарладгийг нотлох баримт.

# Сэдэв C • Мэдээлэл олж авах эрх

Мэдээлэл олж авах эрх нь бусдын хэвлэн нийтэлсэн болон олон нийтэд нээлттэй мэдээлэл, санааг олж авах/хандах эрх юм. Энэ талаар Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 19(2) дүгээр зүйлд заасан бөгөөд “хил хязгаар харгалзахгүйгээр […] бүх төрлийн мэдээлэл, санааг […] сонголтоор […] дурын хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрэлхийлэх эрх чөлөө багтана” хэмээн тусгасан.[65] ИБУТЭТОУП-ын 9(3) дүгээр зүйл (дээр дурдсан) болон эрхийн тухай олон улсын болон бүс нутгийн хуулийн холбогдох заалт нь мэдээлэлд хандах, тухайлбал, “дайныг сурталчлах” болон “үндэсний дайсагналцал, хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзэл, арьс өнгө болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хориглох (ИБУТЭТОУП-ын 20 дугаар зүйл) тухай, садар самууныг харуулсан үзүүлбэр, түүнийг сурталчилсан материалд хүүхдийг ашиглахыг хориглосон (ХЭТК-ийн 34 дүгээр зүйл).

Хүний эрхийн хорооноос үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний нэгэн адил эдгээр эрхийн аливаа хязгаарлалтад хууль эрх зүйн орчин, зайлшгүй шаардлага, тэнцвэртэй байдал ач холбогдолтойг онцолсон.[66]

Үүнийг засгийн газраас болон олон нийтээс санхүүжүүлсэн мэдээлэлд хандах чадавхтай холбоотой арга хэмжээнээс ялгах шаардлагатай бөгөөд эдгээрийг O ангиллын C ба D сэдэвт авч үзнэ.

Энэ сэдвийн асуулт C.1 нь мэдээлэл олж авах эрх зүйн ерөнхий зохицуулалттай, асуулт C.2 нь засгийн газраас цахим мэдээлэл хэрэглэгчдийг хянаж хязгаарладагэсэхтэй холбоотой. Асуулт C.3 нь тухайн улсын хэмжээнд нээлттэй байдаг контентын олон талт болон бие даасан байдалтай, асуулт C.4 нь төрийн байгууллага болон бусад оролцогч

талын дарамт шахалттай хамааралтай. A ангиллын D сэдвийн асуулт, шалгуур үзүүлэлт нь энэ сэдэвт хамааралтай болно.

4

### RC.1 Мэдээлэл олж авах эрхийг хуулиар баталгаажуулж, практикт мөрддөг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Эрхийн тухай олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцсэн мэдээлэл олж авах эрхэд хамаарах үндсэн хуулийн болон хууль ёсны баталгаа, засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага хүлээн зөвшөөрч, мөрдүүлж байгааг нотлох баримт;
- Контентод онлайн болон оффлайнаар хандахад тавьсан хязгаарлалтын зорилго, хамрах хүрээ.

### RC.2. Засгийн газар интернэтийг бүхэлд нь болон тодорхой онлайн үйлчилгээ, программ хангамж, веб сайтад нэвтрэх эрхийг хаадаг, хяналт тавьдаг эсэх, үүнийг ямар үндэслэлээр, хэр ил тод байдлаар хэрэгжүүлдэг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Ил тод байдал, хяналтын зохицуулалтыг оролцуулан интернэтийн хандалтыг хаадаг, хянадаг эрх зүйн орчин;
- Хандалтыг хаах, хяналт тавихтай холбоотой засгийн газар, шүүхийн шийдвэр, бусад баталгаатай, эрх бүхий эх сурвалжаас авсан нотлох баримт;
- Интернэт холболтыг салгах, бусад хязгаарлалт хийх тохиолдол, шинж, үндэслэл;
- Сүүлийн 3 жилийн хугацаанд контентод хандах эрхэд тавьсан хязгаарлалт, домэйн нэрийг хүчингүй болгосон тохиолдол, бусад хөндлөнгийн оролцооны тоо, чиг хандлага.

### RC.3 Олон нийтэд ач холбогдол бүхий мэдээллийн эх сурвалж, олон янзын үзэл бодол онлайн хэлбэрээр байдаг эсэх?[6]

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон улсын, үндэсний болон орон нутгийн, онлайн болон оффлайн мэдээтэй холбоотой мэдээллийн үйлчилгээний тоо, олон талт байдал.

### RC.4 Хувь хүн, сэтгүүлч болон бусад онлайн/хэвлэл мэдээллийн хэрэгслийн этгээд мэдээлэлд нэвтэрснийхээ төлөө баривчлагдах, яллагдах, айлган сүрдүүлэгдэж байсан эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хуулийн заалт, практикийн хамрах хүрээ, мөн чанар;
- Зөвшөөрөгдөх хязгаарлалтын нөхцөл байдал, шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор олон улсын гэрээний дагуу хууль бус контентыг олж авсан үндэслэлээр саатуулагдан, мөрдөгдсөн хэргийн тоо.[7]

---

[6] Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтэд уг асуудлыг илүү өргөн хүрээнд тусгасан.
[7] Дээрх танилцуулгыг харна уу.

# Сэдэв D • Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, нийгмийн амьдралд оролцох эрх

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь интернэт нөлөөлж болох хүний нэг эрх юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 21 дүгээр зүйлд тайван жагсаал цуглаан хийх эрх, 22 дугаар зүйлд бусадтай эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг тус тус заасан.

Энэ сэдвийн асуулт D.1 нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тухай ерөнхий хууль эрх зүйн орчинтой, асуулт D.2 нь иргэний нийгмийн байгууллагын онлайнаар үр дүнтэй зохион байгуулагдах чадвартай холбоотой.

ИБУТЭТОУП-ын 25 дугаар зүйлд “Иргэн бүр төрийн үйл хэрэгт шууд болон сайн дураараа сонгосон төлөөллөөрөө дамжуулан оролцох эрх, боломжтой” бөгөөд “тэгш эрхийн ерөнхий нөхцөлтэйгөөр эх орондоо төрийн алба хаших” тухай заасан.

Асуулт D.3 ба D.4 нь засгийн газраас иргэдэд уг эрхийг онлайн ба оффлайн орчинд эдлэх боломжийг хангахтай холбоотой.

### RD.1 Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хуулиар баталгаажуулж, амьдралд хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Эрхийн тухай олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцсэн хууль эрх зүйн орчин, түүнийг төрийн болон эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрч, мөрддөг болохыг нотлох баримт.

### RD.2 Төрийн бус байгууллага онлайнаар чөлөөтэй үйл ажиллагаа явуулж чаддаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Онлайн зохион байгуулалтыг нотлох баримт, ийм байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс зүй бусаар оролцоогүйг нотлох баримт.

### RD.3 Төрийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцохыг дэмжсэн цахим засаглал ба/буюу цахим оролцооны талаарх төрийн бодлого байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Цахим засаглал, цахим оролцооны талаар төрөөс баримталж буй бодлого, тухайлбал, интернэтийг олон нийтийн хэлэлцүүлэгт ашиглах байдал;
- НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газраас гаргадаг Цахим засгийн газрын хөгжлийн индексийн онлайн үйлчилгээний индексийн үнэлгээ;
- НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газраас гаргадаг цахим оролцооны индекс дэх байр/зэрэглэл.

### RD.4 Хувь хүнд цахим засгийн газрын өргөн хүрээний үйл ажиллагаанд онлайн болон оффлайн хэлбэрээр аюулгүй оролцох боломжийг олгодог төрийн веб сайт/аппликэйшн байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Веб сайт, аппликэйшнээр дамжуулан авах боломжтой төрийн цахим үйлчилгээний тоо;
- Төрийн цахим үйлчилгээ хэрэглэгчийн тоо (хүйсээр, шаардлагатай бол хэлээр ангилсан байдлаар);
- Цахим засгийн газрын веб сайт дээрх үйлчилгээний ил тод нөхцөл, кибер аюулгүй байдлын арга хэмжээ ба өгөгдлийн нууцлалаар (жишээ нь https) хамгаалсан байдал, төрөл бүрийн хайлтын хөтөч программ болон үйлдлийн системээр нэвтрэх боломж;
- Төрийн веб сайт, үйлчилгээний кибер аюулгүй байдлын талаарх тайлан.

4

# Сэдэв E • Хувийн халдашгүй байх эрх

Интернэтээс ихээхэн хамааралтай хүний өөр нэг эрх бол хувийн халдашгүй байх эрх юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 17 дугаар зүйлд "Хэний ч хувийн нууц, гэр бүл, орон байр, захидал харилцааны нууц болон нэр төр, алдар хүндэд нь дур мэдэн хууль бусаар халдахыг хориглоно", "Хүн бүр ийм хууль бус оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй" хэмээн заасан. Түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭТК)-ын 16 дугаар зүйлд хүүхдэд зориулж эдгээр эрхийг нэмж тусгасан байдаг.

Интернэт нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, мэдээлэл олж авах хүний эрхийг ерөнхийд нь өргөжүүлсэн хэмээн үздэг ч засгийн газраас тандах, гуравдагч этгээд мөрдөх, арилжааны зорилгоор хувийн мэдээллийг ашиглах, гэмт хэргийн зорилгоор хууль бусаар мэдээлэл олж авах, ашиглах зэрэг хувийн нууцад учирч болзошгүй аюул заналхийлэл, асуудал улам бүр нэмэгдсээр байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей цахим эрин үед хувийн халдашгүй байх эрхийн тухай баталсан хэд хэдэн тогтоолд ерөнхий зарчмаас гадна тандалт, нууцлал, нэр нууцлах зэрэг асуудлыг тусгасан.[67]

Асуулт E.1, E.2, E.3 нь нууцлал, мэдээллийн хамгаалалт, тандалтын талаарх хууль эрх зүйн зохицуулалттай холбоотой. Энэ хүрээнд мэдээллийн хамгаалалтыг өгөгдөл цуглуулах, шинжлэх, ашиглах, хадгалах, дамжуулах, хуваалцахтай холбон авч үзнэ. Асуулт E.4, E.5, E.6 нь хувь хүний онцлог шинж чанартай холбоотой эрхтэй хамааралтай. Асуулт E.7, E.8 нь арилжааны болон хувь хүний багц мэдээллийг эзэмшиж буй төр болон бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаатай холбоотой.

### RE.1 Хувийн халдашгүй байх эрхийг хуулиар баталж, практикт мөрдөж байгаа эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Нууц, хувийн халдашгүй байх эрхийн үндсэн хуулийн заалт болон хууль ёсны тодорхойлолт, түүнийг засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага хүлээн зөвшөөрснийг нотлох баримт;
- Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага болон түүнтэй адилтгах байгууллагад мэдээлэгдсэн нууцад халдсан зөрчлийн тоо, хүн амд ээлэх хувь;
- Нууцлалын зөрчлийн талаарх хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн эх сурвалжаас авсан нотлох баримт.

### RE.2 Засгийн газар, хувийн хэвшил болон бусад байгууллагын мэдээлэл олж авах, хохирол барагдуулах эрхийг оролцуулан хувь хүний мэдээллийн хамгаалалтыг хуулиар баталгаажуулж, практикт хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хяналтын механизм, хохирол барагдуулах арга зэрэг мэдээлэл хамгаалах хууль эрх зүйн орчин, засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага тэдгээрийг хүлээн зөвшөөрч, мөрдүүлж байгааг нотлох баримт;
- Хувийн мэдээллийг арилжааны зорилгоор ашиглах, хяналтын механизм, хохирол барагдуулах арга буюу олон улсын мэдээлэл дамжуулалт/аюулгүй байдлын талаарх хууль эрх зүйн орчин;
- Мэдээлэл хамгаалах бие даасан байгууллага болон түүнтэй адилтгах байгууллага байдаг эсэх, түүний эрх мэдэл.

### RE.3 Хэрэглэгчийн мэдээллийг хууль ёсны дагуу авах хууль сахиулах болон бусад байгууллагын эрх мэдлийг зайлшгүй шаардлагатай, зохистой бөгөөд эрхийн тухай олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцсэн байдлаар хязгаарладаг эсэх?[68]

**Шалгуур үзүүлэлт:**

- Бие даасан хяналт, ил тод байдал зэрэг мэдээллийг хуулийн дагуу саатуулах эрх зүйн орчин байгаа эсэх, засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагын хэрэгжилтийг нотлох баримт.

### RE.4 Утасны болон интернэтийн үйлчилгээний бүртгэл зэрэг таних, бүртгэхэд тавигдах шаардлага нь зайлшгүй шаардлагатай, зохистой бөгөөд эрхийн тухай олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцсэн эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Танилт, бүртгэлийн шаардлагын үндсэн шинж, тохиромжтой байдал (хэрэв байгаа бол баталгаажуулалтыг оролцуулан).

### RE.5 Өгөгдлийн нууцлал, онлайн нууцлалыг эрхийн тухай олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцүүлэн хуулиар хамгаалж, практикт хэрэгжүүлдэг эсэх?[69]

**Шалгуур үзүүлэлт:**

- Эрхийн тухай олон улсын гэрээ хэлцэлд нийцсэн хууль эрх зүйн орчин, түүнийг засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага хүлээн зөвшөөрч байгааг нотлох баримт.

### RE.6 Хувь хүн ИБУТЭТОУП-ын 17 дугаар зүйлд заасан хувийн нууцаа хуулиар хамгаалуулах эрхээ хамгаалах үүднээс цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалах, өөртэйгөө холбоотой мэдээллийг онлайнаар удирдах, залруулах хууль ёсны эрхтэй эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Нууцлал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль болон хууль эрх зүйн орчин, тэдгээрийг засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага хүлээн зөвшөөрдөг тухай нотлох баримт.

### RE.7 Интернэт хэрэглэгчдийн мэдээллийг төрийн байгууллагад өгөх талаарх интернэтийн бизнес эрхлэгчдэд тавьж буй засгийн газрын шаардлага нь зайлшгүй шаардлагатай, зохистой, ил тод бөгөөд олон улсын болон бүс нутгийн эрхийн тухай гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандарттай нийцсэн эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хэрэглэгчийн мэдээллийг засгийн газарт өгөх талаарх хууль эрх зүйн болон зохицуулалтын заалт.

### RE.8 Өгөгдөл хадгалах байршил, хадгалах хугацаатай холбоотой заалтууд нь өгөгдлийг хамгаалах олон улсын стандарт, хууль сахиулах байгууллагын хууль ёсны шаардлагад нийцсэн эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Өгөгдөл хадгалалт, хил дамнасан өгөгдлийн урсгалтай холбоотой хууль эрх зүйн болон зохицуулалтын заалт, засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага тэдгээрийн хэрэгжилтийг хангаж буйг нотлох баримт.

# Сэдэв F • Эдийн засаг, нийгэм, соёлын эрх

4

НҮБ-ын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрт тусгагдсан олон зорилтот эдийн засаг, нийгмийн хөгжилд интернэтийг асар их ач холбогдолтой гэж үздэг.[70] Интернэтийн үзүүлэх хөгжлийн нөлөөллийг, ялангуяа тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөллийг Х ангиллын С сэдэвт онцгойлон авч үзсэн болно.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт (ЭЗНСЭТП)-д тодорхойлж, тусгасан байдаг.[71] Энэ сэдэв нь ерөнхийдөө ЭЗНСЭТП-д багтсан эрхийг интернэтийн нийтлэг байдалтай нэгтгэхтэй холбоотой бөгөөд үүнийг Х ангиллын С сэдэвтэй (Тогтвортой хөгжил) хамт авч үзэх шаардлагатай.

ЭЗНСЭТП-ын 6-14 дүгээр зүйлд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хангамж, гэр бүлийн амьдрал, өлсгөлөнгөөс ангид аж төрөх, эрүүл мэнд, боловсрол зэрэг амьжиргааны хүрэлцээтэй түвшинтэй холбоотой эрхийг үе шаттайгаар хэрэгжүүлэх тухай заасан. Асуулт F.1 нь эдийн засаг, нийгмийн бодлогын гурван чиглэл болох хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролын үндэсний стратегид интернэтийг нэгтгэхтэй холбоотой.

ЭЗНСЭТП-ын 15 дугаар зүйлд хүн бүр соёлын амьдралд оролцох эрхтэйг хүлээн зөвшөөрдөг. Асуулт F.2 нь тухайн улс орны төрөл бүрийн нийгэм, угсаатны гарал бүхий хүмүүс уг эрхийг онлайнаар эдлэж буй эсэхийг авч үздэг.

### RF.1 Засгийн газрын бодлогод интернэтийг хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролтой холбоотой сртатегиуд[8], ялангуяа ЭЗНСЭТП-ын эрхийг тусгасан эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролын салбарын стратегид а) интернэт, б) ЭЗНСЭТП-ын эрхийг хүлээн зөвшөөрснийг нотлох баримт;
- Засгийн газраас хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролд интернэтийн үзүүлэх нөлөөллийн талаар хийсэн судалгаа;
- ЭЗНСЭТП-ын эрхийн хэрэгжилтийн тухай улсын тайланг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарт хүргүүлсэн байдал, тухайн тайлангийн агуулга.

### RF.2 Нийт иргэд, бусад хувь хүн интернэтийн давуу талыг ашиглан соёлын үйл ажиллагаанд оролцох боломжтой эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон янзын нийгэм/үндэстний хоорондын интернэтийн хүртээмж, ашиглалтын ялгааны цар хүрээ, мөн чанар;
- Цахим орчинд буй соёлын өвийн талаарх төрийн бодлого байдаг эсэх;
- Бүтээлээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн хуулийн болон бусад хууль ёсны баталгаа.

[8] Эдгээрийг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг төлөөлөх бүлгээр сонгосон болно.





# 5

# АНГИЛАЛ О
# **Нээлттэй байдал**

Мексикийн Оаксакад Орон нутгийн харилцаа холбооны нийгэмлэгийн сүлжээ нь хөдөө орон нутагт хямд үнээр үүрэн холбоо, интернэтийн үйлчилгээ үзүүлдэг. Rhizomatica ашгийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй уг төсөл нь бие даасан, өмчлөгдсөн харилцаа холбооны дэд бүтцийг байгуулан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болон хүсэлтэй байгаа иргэдэд тусалдаг.

© Luisa Civardi

O

# Нээлттэй байдал



Интернэтийн түгээмэл байдлын хоёр дахь зарчим бол интернэт нь хүн бүрд хамгийн тохиромжтой, ач холбогдолтой гэж үзсэн арга замаар өөрийн нөөц, боломжийг хөгжүүлэх, бүгдэд нээлттэй байх явдал юм. Нээлттэй байдлын ангилал нь интернэт болон интернэтэд суурилсан үйлчилгээний техник технологийн асуудал, зах зээл, контент, ил тод байдал, итгэлцэл зэрэгтэй холбоотой. Тухайлбал, нээлттэй программ хангамж ба хөгжүүлэлт, нээлттэй засгийн газар, нээлттэй өгөгдөл, боловсролын нээлттэй нөөц зэргийг хамарна. Интернэтийн түгээмэл байдал нь нээлттэй байдлаараа дамжуулан үл зохицох технологид суурилсан тодорхой үйлчилгээний хэрэглэгчдэд хүргэдэг хязгаарлагдмал хүрээний мэдээллийг хязгаарлахаас илүүтэйгээр түүний цогц шинж чанар нь дэлхийн хэмжээнд мэдээлэл солилцох боломжийг бий болгодог интернэтийн бүрэн бүтэн байдлыг хүлээн зөвшөөрдөг.

Энэхүү ангилал нь дор дурдсан 5 сэдэвт хуваагдана. Үүнд:

- Сэдэв A нь ерөнхий бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо;.
- Сэдэв B нь нээлттэй стандарт;
- Сэдэв C нь нээлттэй зах зээл;.
- Сэдэв D нь нээлттэй контент;.
- Сэдэв E нь нээлттэй өгөгдөлтэй тус тус холбоотой.

Нээлттэй стандарт, харилцан ажиллах чадвар, хэрэглээний программчлалын интерфэйс, нээлттэй эхийн программ хангамж нь интернэтийн техникийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж, интернэтийг илүү хурдацтай хөгжүүлэх, үйлчилгээний шинэчлэл хийх боломжийг олгосон. Нээлттэй зах зээл нь интернэтийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж, тусгай зөвшөөрлийг хязгаарлах эсхүл үйлчилгээнд чиглэсэн хамгаалалтыг хязгаарлах замаар эдгээрийг үгүйсгэхийн оронд шинэлэг, өрсөлдөх чадвартай бизнест оролцохболомжийг олгодог. Жишээлбэл, Линукс үйлдлийн систем нь мэдээллийн технологийн өргөн хүрээний экосистемийг бий болгоход ихээхэн хувь нэмэр оруулсан бол W3C[1] стандартууд нь хэрэглэгчдэд ашиглах боломжтой/хүртээмжтэй веб орчинг бий болгосон билээ.

Шинэ технологид нээлттэй байх, зах зээлд нэвтрэх нь чухал боловч инновац шиг интернэтийг нийгэм, эдийн засгийн нэгээхэн хэсгээс хөгжлийн гол чиглэлд шилжих боломжийг олгох хангалттай нөхцөл биш юм.

Интернэт болон интернэтэд суурилсан үйлчилгээний бүрэн бүтэн байдалд итгэх итгэл болоод аюулгүй байдал нь интернэтийг үр дүнтэй, бүх нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн ажиллуулахад зайлшгүй шаардлагатай. Эдгээр нь интернэтийн нээлттэй байдлын нэг хэсэг болох ил тод байдлын түвшинтэй холбоотой. Энэ ангиллыг үнэлэхдээ X ангиллын D сэдэвт анхаарлаа хандуулах хэрэгтэй.

[1] Дэлхий дахины сүлжээний консорциум

# Сэдэв А • Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ

Нотолгоонд суурилсан, ил тод, алсыг харсан бодлого боловсруулах үйл ажиллагааг дэмжихэд олон талын оролцоот засаглалын бүтцийг оролцуулан зохистой бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо зайлшгүй шаардлагатай. Ингэснээр интернэтийг нээлттэй, олон нийтийн, бүх нийтийн нөөц болгох юм. Бодлогын арга хэмжээ нь интернэтийг нээлттэй бөгөөд дундын платформ дээр ажиллуулж, харилцан үйлчлэлээр дамжуулан хамтын ажиллагаа болон өрсөлдөөнийг бий болгох, хүний эрхийг эрхэмлэн дээдэлсэн аюулгүй орчинд контент, программ хангамжийг хэрэглэгчдэд хүргэхэд чиглэсэн байна.

Асуулт А.1, А.2 нь интернэт болон интернэтэд суурилсан үйлчилгээний бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоотой, асуулт А.3 нь улс орны хэмжээнд онлайнаар инновац хийх чадавхын түвшинтэй холбоотой.

### OA.1 Нээлттэй, ил тод байдлын талаарх олон улсын хэм хэмжээнд нийцсэн интернэтийг хөгжүүлэх болон бодлого боловсруулах ерөнхий бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоотой эсэх?[2]

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбогдох олон улсын хэм хэмжээнд нийцсэн ерөнхий тогтолцоо;[72]
- Цахим худалдаа, тоон гарын үсэг, кибер аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо.

*Энэхүү асуулт болон шалгуур үзүүлэлтийг М ангиллын А сэдэвт оруулсан болно.*

### OA.2 Хувийн хэвшил, шинжлэх ухаан, иргэний нийгмийн хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин нь интернэтийн инновацыг дэмждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн шинэ бизнес, инновацыг бий болгоход хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчныг нотлох баримт;[3]
- Бизнес, МХХТ-ийн бизнесийн зохицуулалтын орчин, тэр дундаа интернэтэд суурилсан бизнесийн туршлагын талаарх ойлголт.

### OA.3 Байгууллага, хувь хүн интернэт болон интернэтэд холбогдсон үйлчилгээ нээхэд хязгаарлалт тавьдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэт болон интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэх, аж ахуйн нэгж үүсгэн байгуулахад мөрдөх хууль эрх зүйн орчны шаардлага.

---

[2] Эдгээр хэм хэмжээг интернэттэй холбоотой олон улсын байгууллагын гэрээ хэлцэлд тодорхойлж, интернэтийн технологи, үйлчилгээтэй нийцүүлэн өөрчилдөг.
[3] "Үндсэн үзүүлэлт"-ийг гурвалжин тэмдгээр тэмдэглэв. Бүрэн үнэлгээ хийхэд нөөц хүрэлцэхгүй тохиолдолд үндсэн үзүүлэлтүүдийн дэд багцыг интернэтийн түгээмэл байдлын талаар цогц үнэлгээ хийхэд ашиглаж болно. Эдгээр үндсэн үзүүлэлтийг Хавсралт 4-өөс харж болно.

# Сэдэв В • Нээлттэй стандарт



Интернэтийн хөгжил нь түүний өсөлт, аюулгүй байдлыг хангах стандарт, протоколыг хэрэгжүүлэхэд холбогдох бүх талын оролцоог шаарддаг. Нээлттэй стандарт нь харилцан уялдаатай байх, ингэснээр инновац, интернэтийн үйлчилгээний олон талт байдлыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Засаг захиргааны байгууллага нь худалдан авалт хийх, төрийн үйлчилгээ үзүүлэх замаар нээлттэй стандартыг дэмжих боломжтой.

Асуулт В.1 ба В.2 нь нээлттэй стандартын хууль эрх зүйн зохицуулалтын ерөнхий тогтолцоотой, асуулт В.3 нь чөлөөт болон нээлттэй эхийн программ хангамжтай холбоотой. Асуулт В.4 нь дэлхийн аюулгүй интернэтийн ирээдүйн хөгжилд чухал үүрэгтэй гэгдэх IPv6 болон DNSSEC интернэт протокол/стандартын нэвтрэлттэй холбоотой. Олон улсын стандарт тогтоох үйл явц дахь үндэсний оролцоог М ангиллын С сэдэвт оруулсан болно.

### ОВ.1 Хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо нь боломжит бүх технологийг ашиглан хөрөнгө оруулалт, инновацыг дэмждэг ба хязгаарладаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Төрийн үйлчилгээний худалдан авалт зэрэг онлайн инновацад чиглэсэн төрийн бодлого, хэрэгжилтийг нотлох баримт;
- Интернэтийн гарааны бизнесийг эхлүүлж, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгааг нотлох баримт.

### ОВ.2 Үндэсний стандарт тогтоох процесс, ил тод байдлыг оролцуулан олон улсын стандартад нийцүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Стандартын үйл явцын хууль эрх зүйн зохицуулалт;
- Холбогдох талуудын стандартын үйл явцын талаарх ойлголт;
- Стандарт тогтоох үйл явцад хамааралтай М ангиллын шалгуур үзүүлэлт.

### ОВ.3 Төрөөс чөлөөт болон нээлттэй эхийн программ хангамжийг оролцуулан оюуны өмчийн лицензийн олон төрлийг дэмждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Чөлөөт болон нээлттэй эхийн программ хангамж болон бусад төрлийн лицензийн талаарх төрийн бодлого;
- Төрийн байгууллагад төрөл бүрийн лицензийн сонголттой программ хангамжийг ашиглаж буй байдал.

### ОВ.4 Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд интернэт болон төрийн цахим үйлчилгээг хэрэглэхэд хялбар байлгах стандартыг сурталчилж, хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрэглэхэд хялбар байдлыг хангах талаарх төрийн бодлого, үйл ажиллагаа;
- Хүртээмжтэй байдлын бодлого, үйл ажиллагааны талаарх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ойлголт.

### ОВ.5 Улсын хэмжээнд интернэтийн протокол, стандартыг хэр өргөн хүрээнд хэрэгжүүлдэг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- IPv4 болон IPv63[4] нэвтрүүлэлтийн талаарх өгөгдөл;
- Домэйн нэрийн системийн аюулгүй байдлын өргөтгөлийн[5] нэвтрүүлэлтийн талаарх өгөгдөл;
- Олон улсын кибер аюулгүй байдлын стандарт, шилдэг туршлагыг нэвтрүүлсэн талаарх нотлох баримт.

[4] Интернэт протокол хувилбар 3 ба 4

[5] Domain Name System Security Extensions.

# Сэдэв С • Нээлттэй зах зээл

Сүлжээ, харилцаа холбооны үйлчилгээний нээлттэй зах зээл нь хэрэглэгчийн сонголтод нөлөөлөх, инновацыг хөхиүлэн дэмжих, эцсийн хэрэглэгчид хүрэх үнийг хямдруулах, үйлчилгээний чанарыг сайжруулах төдийгүй интернэтийг хөгжүүлэх үр ашигтай, хямд, шинэлэг орчныг бүрдүүлэх, зах зээлийн төвлөрлөөс үүдэн хэрэглэгчийн сонголт, боломжийг багасгахад хүргэж болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэж байна. Сүлжээ, харилцаа холбооны үйлчилгээний өрсөлдөөнийг хянах зорилгоор олон оронд бие даасан зохицуулах байгууллага ажилладаг.

Асуулт С.1, С.2, С.3 нь харилцаа холбооны сүлжээ, интернэтийн домэйн нэрийн зах зээлийг зохицуулах эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоотой, асуулт С.4 ба С.5 нь олон улсын онлайн үйлчилгээний хүртээмж зэрэг сүлжээ болон үйлчилгээ нийлүүлэгчдийн хоорондын өрсөлдөөнтэй холбоотой. Эдгээр асуулт нь R ангиллын B (Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө) болон C (Мэдээлэл олж авах эрх) сэдэвт мөн хамааралтай.

Харилцаа холбооны сүлжээний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд өрсөлдөгч үйлчилгээ хоорондын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Жишээлбэл, техникийн харилцан үйлдэлцэл гэх мэт. Асуулт 7 нь дотоодын интернэтийн урсгалын интернэтийн харилцан холболт, түүний гүйцэтгэлтэй холбоотой.

### OC.1 Харилцаа холбооны зах зээлд олон улсын хэм хэмжээ, стандартад нийцсэн бие даасан зохицуулалт байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Бие даасан зохицуулах байгууллага болон эрх бүхий байгууллага байдаг эсэх;
- Харилцаа холбооны бизнес эрхлэгч, хэрэглэгчдийн холбоо болон бусад байгууллагын зохицуулалтын чанарын талаарх ойлголт зэрэг зохицуулалтын гүйцэтгэлийг нотлох баримт.

### OC.2 Чухал ач холбогдолтой нөөцөд (спектрийг оролцуулан) тусгай зөвшөөрөл олгох болон хуваарилах үйл ажиллагаа нь ил тод, уян хатан, технологи болон үйлчилгээнээс хамааралгүй, хязгаарлалтгүй, сонголтгүй эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Спектрийн хүртээмжийн боломжийг оролцуулан спектрийн зохицуулалтын арга хэмжээ;
- Холбогдох талуудын чухал ач холбогдолтой нөөцөд зөвшөөрөл олгох, хуваарилах зохицуулалтын чанарын талаарх ойлголт.

### OC.3 Домэйн нэрийн системийн бие даасан менежменттэй эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Домэйн нэр бүртгэгчийн хараат бус байдал, домэйн нэрийн бүртгэлийн талаарх хууль эрх зүйн зохицуулалт;
- Тухайн улсаас ccTLDs (Олон улсын код дээд түвшний домэйн) ангилалд бүртгэгдсэн домэйн нэрийн эзлэх хувь.

### OC.4 Харилцаа холбооны хандалтын сүлжээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хангалттай үр дүнтэй өрсөлдөөнтэй эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Суурин болон хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн тоо;
- Суурин болон хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь;
- Сүлжээний бэлэн байдлын индексийн дэд индекс болох интернэт, телефон утасны салбарын зэрэглэл.

### OC.5 Интернэт хэрэглэгч нь домэйн нэр бүртгэгч, интернэт болон, онлайн үйлчилгээ эрхлэгч зэрэг төрөл бүрийн интернэтийн үйлчилгээ эрхлэгчдээс сонгох боломжтой эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Домэйн нэр бүртгэгчдийн тоо[6], зах зээлд эзлэх хувь хэмжээ;
- Интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн тоо, зах зээлд эзлэх хувь хэмжээ;
- Тухайн улсын гадна байрладаг онлайн үйлчилгээ эрхлэгчид (жишээлбэл, хайлт, нийгмийн сүлжээ, бичил блог, мэдээний хандалт, цахим худалдааны платформ гэх мэт) тавьдаг (хэрэв байдаг бол) хязгаарлалт;
- Интернэтийн хэрэглээний үндсэн чиглэлээр (жишээлбэл хайлт, нийгмийн сүлжээ, бичил блог, мэдээний хандалт, цахим худалдааны платформ зэрэг) онлайн үйлчилгээ эрхлэгч хоорондын зах зээлийн хүртээмж, ашиглалтын цар хүрээ, дотоодын зах зээлийн хувь хэмжээ.

### OC.6 Олон нийт интернэт ашиглах боломжоор хангахын тулд өөрсдийн сүлжээг байгуулах боломжтой эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон нийтийн сүлжээ байгуулах эрх олгох хууль эрх зүйн орчин[7].

### OC.7 Интернэтийн харилцан холболт, интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн хооронд өгөгдлийг шууд солилцох, хандалтыг үр дүнтэй болгох интернэт урсгалын солилцооны бусад зохицуулалт байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтийн харилцан холболт, түүний үр дүнтэй удирдлага;
- Интернэтийн харилцан холболт ашиглаж буй дотоодын интернэт урсгалын эзлэх хувь, чиг хандлага;
- Үндэсний, бүс нутгийн болон олон улсын серверт хандахад хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээний хүлээлтийн түвшин;
- Олон улсын контентын дотоод хадгалалтын үйлчилгээ.

# Сэдэв D • Нээлттэй контент

Нээлттэй контентын сэдэв нь олон нийтэд нээлттэй мэдээлэл, онлайнаар ашиглах боломжтой дотоод болон гадаад эх сурвалжийн мэдээлэл зэрэг бүх төрлийн контентыг хүртээмжтэй болгохтой холбоотой. Хууль эрх зүйн шаардлага, тусгай зөвшөөрлийн хязгаарлалт нь контентын нээлттэй байдлын түвшинг өөрчилж, контентыг ашиглахад тавигдах шаардлага, болон түүний түгээлтийг хязгаарлаж болно. Нээлттэй контентын арга нь олон улсын оюуны өмчийн гэрээнд нийцсэн нээлттэй лицензийн зохицуулалтын дагуу эцсийн хэрэглэгчдэд хүргэх контентын хүртээмжийг дээд зэргээр нэмэгдүүлэхийг эрмэлздэг. Жишээлбэл, Creative Commons лиценз нь контент бүтээгчдэд өөрсдийн контентод тохирсон гэж үзсэн лицензийн нөхцөлийг тогтоох боломжийг олгодог. Өдгөө боловсролын нээлттэй нөөцөөр дамжуулан боловсролын контентыг ашиглахад онцгойлон анхаарч байна.

Энэ сэдэв нь R ангиллын C сэдэв (Мэдээлэл олж авах эрх)-тэй холбоотой тул хамтад нь авч үзэх шаардлагатай. Асуулт D.1 ба D.2 нь мэдлэг мэдээлэл олж авах, олон улсын оюуны өмчийн гэрээний хэрэгжилтийн талаарх засгийн газрын ерөнхий бодлоготой, асуулт D.3 ба D.4 нь олон нийтийн мэдээллийн нээлттэй байдал, боловсролын нээлттэй нөөцтэй холбоотой. Асуулт D.5 ба D.6 нь сүлжээний нээлттэй зарчим, хувийн виртуал сүлжээний зохицуулалтын асуудлыг хамарна.

### OD.1 Төрөөс боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт баримтлах бодлогоор дамжуулан мэдлэг, нээлттэй контентын хүртээмжийг хөхиүлэн дэмждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Мэдлэг, ялангуяа төсвийн хөрөнгөөр бий болгосон мэдээлэл, олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн бусад мэдээлэлд хандах талаарх төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаа, түүний үндсэн шинж;
- Мэдлэгийн хүртээмжтэй холбоотой төрийн бодлого, үйл ажиллагааны талаарх оролцогч талуудын төсөөлөл, тэдгээрийн нөлөөлөл.

---

[6] Домэйн нэр бүртгэгч нь эцсийн хэрэглэгчийн нэрийн өмнөөс домэйн нэрийг бүртгэдэг байгууллага юм. Ихэнх оронд энэ зах зээлд өрсөлдөөн их байдаг. Үүнийг домэйн нэрийг удирдаж, бүртгэгчдийг итгэмжилдэг үндэсний тусгай домэйн нэрийн бүртгэлтэй андуурч болохгүй.
[7] Улс орон бүрд олон нийтийн сүлжээний тодорхойлолт харилцан адилгүй байдаг.

### OD.2 Оюуны өмчийг хамгаалах зохицуулалт нь зохиогчийн эрх эзэмшигч болон мэдээлэл хэрэглэгчийн ашиг сонирхлыг инновац, бүтээлч байдлыг дэмжих замаар тэнцвэржүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Зохиогчийн эрхийн бүтээлд хандах, шударгаар ашиглах зохицуулалт[8] зэрэг зохиогчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн зохицуулалтын мөн чанар;
- Creative Commons лиценз зэрэг оюуны өмчийн бусад зохицуулалт, хэрэглээний талаарх төрийн бодлого, үйл ажиллагаа.

### OD.3 Төрөөс олон нийтийн болон олон нийтийн хөрөнгөөр санхүүждэг мэдээлэлд хандах, хуваалцах боломжийг олгодог эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Төрийн байгууллага, бүх нийтийн боловсролын системд контентыг үнэ төлбөргүй дахин ашиглахыг дэмжих тусгай зөвшөөрлийн сонголтын цар хүрээ;
- Дээр дурдсан контентын хандалт, ашиглалтын хэмжээг нотлох баримт.

*Цахим засаглал ба цахим оролцооны талаарх төрийн бодлого (R ангилал: Асуулт D.3, D.4), олон нийтийн мэдээлэлд хандахад ашигладаг нийтийн хандалтын арга хэрэгсэлтэй холбоотой шалгуур үзүүлэлтийн (A ангилал: Асуулт A.5) нотлох баримтыг анхаарч үзэх хэрэгтэй.*

### OD.4 Төрөөс боловсролын нээлттэй нөөцийг ашиглахыг дэмжиж, эрдэм шинжилгээний болон судалгааны эх сурвалжийг нээлттэй ашиглах боломжийг олгодог эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Боловсролын нээлттэй нөөцийн талаарх боловсролын бодлого;
- Дээд боловсролын байгууллага, суралцагч нь эрдэм шинжилгээний болон судалгааны эх сурвалжийг ашиглах талаарх зохицуулалт.

### OD.5 Төрөөс интернэтийн үйлчилгээ эрхлэгчээс сүлжээний урсгалыг тодорхой төрлийн контент болон тодорхой эх сурвалжийн агуулгаар ялгахгүйгээр ил тод, шударга, төвийг сахисан байдлаар удирдахыг шаарддаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Сүлжээний ялгаваргүй байдал, онлайн ба сүлжээний үйлчилгээний өрсөлдөөнтэй холбоотой зохицуулалт, арга хэмжээ.

### OD.6 Төрөөс иргэдэд өөрсдийн сонгосон протокол, хэрэгсэл, түүний дотор хувийн виртуал сүлжээ (VPN) ашиглан контент нийтлэх, хандах боломжийг олгодог эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Эцсийн хэрэглэгч хувийн виртуал сүлжээ (VPN) зэрэг боломжит бүх хэрэгслээр дамжуулан контент нийтлэх, хандах эрхийн талаарх хууль эрх зүйн орчин, арга хэмжээ.

[8] Хууль эрх зүйн олон янзын уламжлалыг харгалзан энэ үзүүлэлтийн "зохистой хэрэглээ" гэсэн ойлголтыг холбогдох хууль тогтоомж, үндсэний зохицуулалтын тогтолцооны хүрээнд тайлбарлах шаардлагатай. Учир нь тайлбар, шүүмжлэл, зөвлөмж, судалгааны тохиолдол гэх мэт зохиогчийн эрхэд хамаарах, үл хамаарах зүйл байж болно.

# Сэдэв Е • Нээлттэй өгөгдөл ба нээлттэй засаг

Нээлттэй өгөгдлийн бодлого нь засгийн газраас (зарим тохиолдолд бусад оролцогч тал) цуглуулсан өгөгдлийг олон нийтэд нээлттэй болгоход чиглэж, улмаар тэдгээрийг хувь хүн, бизнес эрхлэгч (дотоодын болон гадаадын аль аль нь) болон иргэний нийгмийн байгууллага дүн шинжилгээ хийх, тавьсан зорилгоо биелүүлэхэд ашиглах боломжийг олгодог. Нээлттэй өгөгдлийн бодлого нь мэдлэгийн хүртээмж, бизнесийн инновац, үйлчилгээ үзүүлэх боломж, төрөл бүрийн эх сурвалжаас авсан өгөгдлийг нэгтгэх замаар өгөгдлийн шинжилгээг хийх, олон талт сонирхлын бүлгийн илүү нарийн шинжилгээний үр дүнд бодлого боловсруулах үйл ажиллагааг сайжруулах зэрэг давуу талтай. Өгөгдөл хамгаалах зохицуулалт нь нээлттэй өгөгдлийн багцыг хувь хүний нууцлалыг алдагдуулахгүй байхаар зохицуулах чухал үүрэгтэй.

Асуулт Е.1 нь нээлттэй мэдээллийн хууль эрх зүйн орчны тухай, асуулт Е.2, Е.3, Е.4 нь засгийн газрын хэрэгжилттэй, асуулт Е.5 ба Е.6 нь мэдээллийн ашиглалт, түүний хөгжилд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой.

### E.1 Олон нийтийн болон олон нийтээс санхүүжсэн мэдээлэлд нээлттэй хандах зохих нууцлалын хамгаалалт бүхий хууль тогтоомжийг баталж, хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон улсын хэм хэмжээ[73], нууцлалын шаардлагад нийцсэн нээлттэй мэдээлэлд нэвтрэх хууль эрх зүйн орчин бий эсэх;
- Хууль эрх зүйн орчны хэрэгжилтийг нотлох баримт;
- Нээлттэй мэдээллийн хэрэглэх боломжтой нөөц, онлайнаар ашиглаж байгаа нотолгоо.

### E.2 Төрийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага нь албан ёсны бүх хэлээр, голлох бүх веб хөтчөөр хандах боломжтой веб сайттай эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Веб сайтыг зохих хэл, веб хөтчийн хандалтаар хангах төрийн бодлого, үр дүнтэй хэрэгжилтийг нотлох баримт;
- Веб сайттай төрийн үйлчилгээний эзлэх хувь (НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газраас гаргадаг онлайн үйлчилгээний индекс дэх зэрэглэл);
- Засгийн газрын веб сайтын чанар (хэлний хүртээмж, агуулгын хамрах хүрээ, гар утасны хувилбар гэх мэт);
- Арван хоёр сарын хугацаанд төрийн цахим үйлчилгээ авсан насанд хүрэгчдийн эзлэх хувь, нэгтгэсэн болон ангилсан байдлаар[9].

### E.3 Засгийн газар, олон нийтийн бусад оролцогч тал нь эх өгөгдлийг компьютероор унших боломжийг оролцуулан нийтийн эзэмшилд байгаа нэр нууцалсан нийтийн өгөгдлийн багцад[10] онлайнаар хялбар хандах боломжоор хангадаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Нэр нууцлах зохицуулалт зэрэг нийтийн мэдээллийн санд хандах тухай хууль эрх зүйн орчин, засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагаас хэрэгжүүлсэн нотлох баримт;
- Засгийн газраас олон нийтийн хандалтын хэрэгслээр дамжуулан хандах боломжтой нээлттэй өгөгдлийн багцын тоо, хүрээ/олон талт байдал;
- Тухайн улс доторх болон гадна байгаа хэрэглэгчдийн хандсан нээлттэй өгөгдлийн ашиглалтын мэдээлэл.

---

[9] Хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдлыг онцгойлон авч үзэв.
[10] Үүнд, нийтийн мэдээлэлд хувийн мэдээллийг оруулж болохгүй гэж ойлгоно.

### OE.4 Хувь хүн, байгууллага нь олон нийтэд нээлттэй өгөгдлийг ашиглах, хуваалцах боломжтой эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Нийтийн мэдээлэлд нэвтрэх хууль эрх зүйн орчин, нууцлалтай холбоотой дурын хязгаарлалтын шинж чанар.

### OE.5 Оролцогч талууд нээлттэй өгөгдлийг тогтвортой хөгжилд эергээр нөлөөлөхөөр ашигладаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Засгийн газрын нээлттэй өгөгдөлд хандах хүсэлтийн тоо;
- Тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс сонгосон салбарт (хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хувийн хэвшил гэх мэт) нээлттэй өгөгдөл ашиглаж буйг нотлох баримт.



# 6

## АНГИЛАЛ А
## **Бүх нийтэд хүртээмжтэй байх**

Камеруны Гбити хотын нэгэн сургуулийн сурагчид өөрсдийн хийсэн гар утсаараа тоглож байна. Төв Африкийн Бүгд Найрамдах Улстай хиллэдэг, хөрш орноосоо 150 метр үргэлжлэх тогтоол усаар тусгаарлагдсан Гбити бол Мбororогийн дүрвэгсдийн Камерунд нэвтэрдэг гурван гарцын нэг юм. Гбити бол алслагдсан газар. Ойрын телефон утас нь 18 километрийн зайд байрлах бөгөөд сүлжээ нь ажилладаг эсэх нь ямар ч баталгаагүй.

© UNHCR/Frederic Noy

# A
# Бүх нийтэд хүртээмжтэй байх



Интернэтийн түгээмэл байдлын гол цөм бол хүн бүрийн интернэтэд нэвтрэх чадамж юм. Интернэт болон интернэтэд суурилсан үйлчилгээний хүртээмж нь өмнөх харилцаа холбооны бүх хэрэгслээс илүү хурдацтай өсөн нэмэгдэж, ялангуяа World Wide Web өргөн хэрэглээ бий болж, сүүлийн үеийн гар утсанд хөдөлгөөнт интернэт нэвтэрч, ухаалаг гар утас ашиглах боломжтой болсон.

Гэвч интернэтэд нэвтрэх боломж тэгш бус хэвээр байна. Одоогоос 10 гаруй жилийн өмнө болсон Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалтаас өмнө бүс нутаг, улс үндэстэн, нийгмийн бүлэг хооронд болон доторх цахим ялгавартай байдал НҮБ-ын харьяа байгууллага, сонирхогч бусад талын анхаарлыг татсаар ирсэн билээ[74]. Эдгээр байгууллагын нэг болох Дэлхийн банкны үзэж байгаагаар сүүлийн үед эдийн засгийн хөгжил, боловсролоор илт давуу улс орнууд интернэтийн ашиг тусыг хүртэж байгаа нь тэгш бус байдлыг багасгах бус, эсрэгээр улам нэмэгдүүлж байгаа ажээ[75].

Бүх нийтэд хүртээмжтэй байх зарчим нь нийгэм, эдийн засаг, техник технологийн олон талтай. Энэ нь зөвхөн сүлжээ, холболт бус, зохистой үнэ, агуулга, чадамж зэрэг илүү өргөн хүрээний асуудлыг хамардаг. Бүх нийтэд хүртээмжтэй байдал нь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд, баян ба ядуу, хот ба хөдөөгийн иргэд, ялгаатай хэлний бүлэг, үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй болон ялгаварлан гадуурхагдсан хүмүүсийн орлого, нийгмийн нөөцийн хуваарилалттай нягт уялдаатай.

Бүх нийтэд хүртээмжтэй байдлын техникийн хэмжүүрт интернэт холболтын хангалттай дэд бүтэц болон интернэтийн өргөн зурвасын үйлчилгээнд ашигладаг төхөөрөмжийн хүчин чадал зэргийг авч үзнэ. Нийгэм, эдийн засгийн хэмжүүрт хямд үнэ, холбогдох контент, түүнчлэн тухайн хэлээрх контент, хүмүүсийн хэрэгцээндээ нийцүүлэн интернэтийг үр дүнтэй ашиглах чадвар зэрэг орно. Эдгээр нь тухайн улсын нийгмийн бүх давхаргын иргэдэд хямд үнээр интернэт ашиглах нөхцөлийг бүрдүүлэх хууль эрх зүйн болон зохицуулалтын арга хэмжээ шаардлагатайг харуулдаг. Ялангуяа өнөөгийн болон ирээдүйн эрэлт хэрэгцээний эдийн засгийн болон техник технологийн ялгаатай байдлыг шийдвэрлэхийн тулд бүх нийтийн хүртээмжийн бодлого, тогтвортой бизнесийн загварыг нэвтрүүлэх нь тун чухал.

Цахим ялгавартай байдлыг шийдвэрлэх хүчин чармайлт нь дангаараа хэрэгждэггүй, харин нас, хүйс, боловсрол, бичиг үсэг, хэл соёл, хөгжлийн бэрхшээл зэрэг хүчин зүйлд тулгуурлан нийгмийн бусад бүтцийн тэгш бус байдлыг арилгах хүчин чармайлтын хамтаар хэрэгждэг. Эдгээр нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болно.

Хандалт, нэвтрэлтийн өгөгдлийг бүрэн боловсруулах, төрийн бодлогод тусгах, амьдралд нэвтрүүлэхийн тул тэдгээрийг ангилан задлах шаардлагатай. Энэ ангилалд багтах олон шалгуур үзүүлэлтэд “нэгтгэсэн болон ангилсан” гэсэн хэллэг хэрэглэсэн бөгөөд энэ нь онцгой ач холбогдолтойг илэрхийлнэ. Энэ хэллэгийг хэрэглэсэн тохиолдолд эмэгтэйчүүд, хүүхдийн интернэтийн хүртээмжтэй байдалд онцгой анхаарч, эдгээр асуудлыг X ангилалд хамаарах сэдэв төдийгүй орон нутаг, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлын хамтаар авч үзэх шаардлагатай.

Энэхүү ангилал нь дор дурдсан 6 сэдэвтэй. Үүнд:

- Сэдэв A нь бүх нийтэд хүртээмжтэй байх, холбогдох асуудлын хууль эрх зүйн зохицуулалт;
- Сэдэв B нь техникийн болон газар зүйн холболт;.
- Сэдэв C нь сүлжээ, үйлчилгээний хямд үнэ;
- Сэдэв D нь тэгш хүртээмжтэй байдал;
- Сэдэв E нь агуулга, хэлний асуудал;
- Сэдэв F нь ур чадвар, чадамжтай тус тус холбоотой.

Уг ангиллын олон асуулт, шалгуур үзүүлэлт нь тоон үзүүлэлтийг ашигладаг. Үүнд, олон улсын өгөгдлийн багц нь орон нутгаас цуглуулсан эмпирик өгөгдлийг тооцоололд ашигладаг болохыг тэмдэглэх нь зүйтэй. Боломжтой бол өгөгдлийг олон улсын өгөгдлийн багцаас бус, тухайн улсаас шууд авах нь зүйтэй.

Тоон өгөгдөл харьцангуй хурдан хуучирдаг тул сүлжээ, тоног төхөөрөмж, үйлчилгээнд нэвтрэх, ашиглахад гарч буй ажиглагдахуйц өөрчлөлтийг харгалзан бэлэн байгаа өгөгдлийг тайлбарлахад анхаарах шаардлагатай. Ялангуяа тоон цуврал бэлэн байгаа тохиолдолд үнэлгээнд тоон өгөгдлийн чиг хандлага, тэдгээрийн өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэх хэрэгтэй. Энэ нь сүлжээ, холболт, хямд үнэ зэрэг сэдэвт маш чухал.

# Сэдэв А • Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо

Энэ сэдэвт хүн бүрд хүртээмжтэй байх боломжоор хангадаг харилцаа холбооны хүртээмжийн талаарх хууль эрх зүй, зохицуулалт, дэд бүтцийн тогтолцоог авч үзнэ.

Асуулт А.1 нь хандалтын хэмжигдэхүүний чанартай холбоотой. Асуулт А.2, А.3, А.4 нь хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцооны асуудал буюу хүртээмжийн талаарх хууль эрх зүйн заалт, зохицуулах эрх бүхий байгууллага, бүх нийтийн хүртээмжийн бодлого зэргийг хамарна. Асуулт А.5 нь төлбөрийн чадваргүй эсхүл хувиараа хандах боломжгүй хүмүүсийн нэвтрэх боломжтой холбоотой.

### A A.1 Интернэтийн хандалт, ашиглалтын талаарх статистик мэдээллийг үндэсний статистикийн систем ба эрх бүхий бусад байгууллагаас системтэйгээр тогтмол цуглуулдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Өрхийн судалгаа зэрэг олон эх үүсвэрээс нэгтгэсэн болон ангилсан статистикийн мэдээллийг цуглуулах зохицуулалт;[1]
- Өрхийн бие даасан судалгаа болон интернэтийн нэгдсэн хандалт, ашиглалттай холбоотой бусад нотлох баримт.

### A A.2 Интернэт болон онлайн үйлчилгээнд нэвтрэхтэй холбоотой үндсэн хуулийн болон бусад хуулийн заалт байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтэд холбогдох талаарх хууль эрх зүйн болон зохицуулалтын баримт бичгүүд.

### A A.3 Харилцаа холбоо, интернэтийн бүх нийтийн хүртээмжийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн болон зохицуулалтын байгууллага байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Бүх нийтийн хүртээмжийн талаарх хууль эрх зүйн болон зохицуулалтын байгууллага байдаг эсэх, бүх нийтийн үүргийн сан, механизмыг ашиглаж буй нотлох баримт;
- Бүх нийтийн хүртээмжийн зохицуулалтын хэрэгжилтийн талаарх сонирхлын бүлгүүдийн төсөөлөл.

### A A.4 Төрөөс бүх нийтийг найдвартай, хямд өргөн зурвасын сүлжээгээр хангах бодлого, хөтөлбөртэй эсэх, энэ нь үр дүнтэй хэрэгждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Бүх нийтийн хүртээмжийн талаарх стратеги, түүний хэрэгжилтийг нотлох баримт;
- Бүх нийтийн хүртээмжид чиглэсэн ахиц дэвшлийг нотлох статистик баримт, нэгтгэсэн болон ангилсан байдлаар[2].

*Цахилгаан эрчим хүчний боломжтой хамааралтайгаар нөхцөл байдлаас хамаарах 3.D шалгуур үзүүлэлтийн өгөгдөл/нотолгоог авч үзэх шаардлагатай.*

### A A.5 Интернэт ашиглах боломжгүй болон хувиараа хандах боломжгүй хүмүүст интернэтэд нэвтрэх боломжийг олгодог олон нийтэд зориулсан газар байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон нийтийн хандалтыг бүх нийтийн хүртээмжийн стратегид тусгасан байдал;
- Интернэт ашиглах боломжтой, олон нийтэд нээлттэй теле төв, номын сан болон бусад газрын тоо, хувиараа нэвтрэх боломжгүй хүн амын ээлэх хувьтай харьцуулсан хувь.

---

[1] “Үндсэн үзүүлэлт”-ийг гурвалжин тэмдгээр тэмдэглэв. Бүрэн үнэлгээ хийхэд нөөц хүрэлцэхгүй тохиолдолд үндсэн үзүүлэлтүүдийн дэд багцыг интернэтийн түгээмэл байдлын талаар цогц үнэлгээ хийхэд ашиглаж болно. Эдгээр үндсэн үзүүлэлтийг Хавсралт 4-өөс харж болно.
[2] Нас, хүйс, газар нутаг, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдал зэрэг тодорхой хамаарлыг авч үзнэ.

# Сэдэв B • Холболт ба хэрэглээ

Бүх нийтэд хүртээмжтэй байхын үндэс бол хүмүүсийг интернэтэд нэвтрэх, ашиглах боломжийг олгох хангалттай хүчин чадалтай, найдвартай сүлжээтэй байх явдал юм.

Асуулт B.1 нь сүлжээний бодит хүртээмжтэй, асуулт B.2, B.3, B.4 нь практикт ашигладаг сүлжээ, сүлжээнд нэвтрэх, ашиглахад учирч буй саад бэрхшээлтэй холбоотой. Асуулт B.5 нь тухайн улсын дотоодын интернэтийн урсгалын цар хүрээг хамарна.

### AB.1 Хүн амын хэдэн хувь нь интернэтийг ямар давтамжтайгаар ашигладаг вэ? Энэ хувь нэмэгдэж байгаа эсэх?[3]

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтэд нэвтэрсэн хүмүүсийн эзлэх хувь, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- Интернэтэд холбогдсон айл өрхийн эзлэх хувь;[76]
- 100 хүнд ногдох интернэт хэрэглэгчийн тоо, хэрэглээний давтамж, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;[77]
- 100 хүнд ногдох олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тоо (нийгмийн сүлжээ, бичил блог, мессеж, хэрэглэгчийн үүсгэсэн видео урсгал)[4], нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- 100 хүнд ногдох олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн веб сайтад (өмнө тодорхойлсон) хандсан тоо.

### AB.2 Улсын хэмжээнд нийт бүс нутагт өргөн зурвасын сүлжээг ашиглах боломжтой эсэх?[5]

**Шалгуур үзүүлэлт:**

- Өргөн зурвасын суурин сүлжээнд хамрагдсан хүн амын хувь, түүний дотор зурвасын өргөн, хот, хөдөө, бүс нутгаар ангилсан хувь;
- Холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээнд хамрагдсан хүн амын хувь, ашигладаг технологи/зурвасын өргөн[6] (хөдөлгөөнт үүрэн холбооны сүлжээний хувьтай харьцуулсан) болон бүс нутгаар ангилсан хувь;
- Интернэт хэрэглэгчдэд ногдох олон улсын интернэтийн зурвасын өргөн;[78]
- Интернэт хэрэглэгчдэд ногдох дотоодын интернэтийн зурвасын өргөн, бүс нутгаар ангилсан байдлаар;
- Хөдөлгөөнт интернэтийн урсгалын татаж авах хурд.

### AB.3 Хүн амын хэдэн хувь нь харилцаа холбоо/өргөн зурвасын үйлчилгээг ашигладаг вэ? Энэ нь нэмэгдэж байгаа эсэх?[7]

**Шалгуур үзүүлэлт:**

- Гар утас эзэмшдэг хувь хүмүүсийн эзлэх хувь, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;[79]
- 100 хүнд ногдох өргөн зурвасын суурин сүлжээний хэрэглэгчийн тоо, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;[80]
- 100 хүнд ногдох үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээний хэрэглэгчийн тоо, зурвасын өргөн, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;[81]
- Тухайн улсын хэмжээнд 100 хүн амд ногдох IP хаягийн тоо.

---

[3] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.
[4] Олон нийтийн хэвлэл мэдээллийн нөлөөлөл, хамрах хүрээ нь улс орнуудад харилцан адилгүй байдгийг анхаарна уу.
[5] Өргөн зурвасын тодорхойлолт нь байгууллага, газар нутгийн харьяаллаас хамааран харилцан адилгүй байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Зарим тохиолдолд зурвасын хэмжээ 256 кбит/с ба түүнээс дээш байхад заримд нь 10 Мбит/с хүртэл их байна. Иймээс боломжтой бол өргөн зурвасын өөр өөр түвшнийг анхаарч үзэх нь чухал.
[6] 2G, 3G, 4G гэх мэт.
[7] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.

### AB.4 Интернэт хэрэглэгч болон хэрэглэгч бус хүмүүст интернэтэд нэвтрэхэд ямар саад бэрхшээл тулгардаг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Өрхийн судалгаа ба/буюу бусад эх үүсвэрээс авсан интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгардаг саад бэрхшээлийн талаарх ойлголт (хэрэглэгч болон хэрэглэгч бус хүмүүс), нэгтгэсэн болон ангилсан байдлаар[8].

### AB.5 Тухайн улсын дотоодын интернэтийн урсгалын хэмжээг дэлхийн интернэтийн урсгалын өсөлттэй харьцуулахад хэр хурдацтай өсөж байна вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Суурин өргөн зурвасын интернэтийн урсгалын хэмжээг эксабайтаар (шууд видео дамжуулалтыг тооцсон болон эс тооцсон байдлаар), хувь хүн, интернэт хэрэглэгч болон чиг хандлагаар;[82]
- Хөдөлгөөнт өргөн зурвасын интернэтийн урсгалын хэмжээг эксабайтаар (шууд видео дамжуулалтыг тооцсон болон эс тооцсон байдлаар), хувь хүн, интернэт хэрэглэгч болон чиг хандлагаар.[83]

### AB.6 Хувь хүн, иргэний нийгмийн байгууллага контент ба үйлчилгээнд хандах, үзэл бодлоо илэрхийлэхэд интернэт ашиглах боломжийг олгодог зохистой үнэтэй онлайн үйлчилгээ байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хямд үнэтэй блог, веб хостингийн үйлчилгээ;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, блог хөтлөх үйлчилгээг ашигладаг хүн амын эзлэх хувь.

# Сэдэв С • Хямд үнэтэй байх

Хүмүүст интернэтэд холбогдох, ашиглах боломжийг олгоход зөвхөн интернэтийн холболт хангалттай бус. Интернэтэд холбогдох нь интернэтийн үнэ уян хатан хямд байхаас мөн хамаардаг. Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ)[84], Цахим хөгжлийн өргөн зурвасын хороо (Broadband Commission for Digital Developmen)[85], Хямд үнэтэй интернэтийн холбоо (Alliance for Affordable Internet)[86] зэрэг байгууллага интернэтийг хямд үнээр хангах зорилтыг баталсан.

Асуулт C.1 ба C.2 нь хямд үнэтэй тоног төхөөрөмж болон өргөн зурвасын ашиглалттай холбоотой. Асуулт C.3 нь хүн амын орлого багатай хэсэгт интернэтэд нэвтрэх боломжийг олгох бодлого, хэрэглээний асуудлыг авч үзсэн.

### AC.1 Хүн амын бүх хэсэг интернэтэд холбогдох боломжтой гар утсыг хямд үнээр авах боломжтой эсэх?9

**Шалгуур үзүүлэлт:**

- Зардал: а) хямд гар утас, б) ухаалаг гар утас, в) нэг хүнд ногдох сарын үндэсний нийт орлого (ҮНО)-д эзлэх хувь;
- Интернэт хэрэглэгч болон хэрэглэгч бус хүмүүсийн хямд үнийн талаарх ойлголт, нэгтгэсэн болон ангилсан байдлаар.

### AC.2 Хүн амын бүх хэсэгт өргөн зурвасын[88] интернэт, хэрэглээ нь хямд үнэтэй эсэх?[10]

**Шалгуур үзүүлэлт:**

- Анхан шатны[89] суурин өргөн зурвасын холболт ба ашиглалтын сарын зардал, нэг хүнд ногдох сарын ҮНО-д эзлэх хувь;
- Анхан шатны[90] хөдөлгөөнт өргөн зурвасын холболт ба ашиглалтын сарын зардал, нэг хүнд ногдох сарын ҮНО-д эзлэх хувь;
- Боломжтой болон бусад тохиолдолд тэг-үнэлгээтэй болон хямд өртөгтэй хандалт.

---

[8] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.
[9] Төгсгөлийн зүүлтийг харна уу. Үнэлгээнд улс орнуудын болон цаг хугацааны хувьд "суурь түвшин"-ий тодорхойлолт өөр өөр байдгийг анхаарах шаардлагатай. Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.
[10] Төгсгөлийн зүүлтийг харна уу. Үнэлгээнд улс орнуудын болон цаг хугацааны хувьд "өргөн зурвасын" болон "суурь түвшин" гэсэн тодорхойлолт нь өөр өөр байдгийг анхаарах хэрэгтэй.

**AC.3 Хүн амын бага орлоготой болон эмзэг бүлгийн хүмүүсийн хандалт, ашиглалтын зардлыг бууруулахад чиглэсэн бүх нийтэд хүртээмжтэй хандалт/үйлчилгээний зохицуулалт байдаг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Бүх нийтэд хүртээмжтэй байх бодлого, зохицуулалтаар практикт хямд үнэтэй байх асуудлыг зохицуулж байгааг нотлох баримт;[91]
- Бага болон хувьсах орлоготой нийгмийн давхаргад тохирсон үнийн багц.

# Сэдэв D • Эрх тэгш хүртээмж

Олон улс орны баримт, нотолгооноос харахад тухайн улс үндэстний хүн амын дунд газар зүйн байрлал, хүйс, нас, яс үндэс, хөгжлийн бэрхшээл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан цахим хэрэглээний ялгаа их байдаг ажээ. Ихэнх тохиолдолд энэ нь бүхэлдээ нийгмийн бүтцийн тэгш бус байдлаас үүсдэг бөгөөд бусад бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг авахад ч харилцан адилгүй байдагтай ижил юм.

Энэ сэдвийн асуултууд нь газар зүйн байрлал, хүйс, нас, яс үндэс, хөгжлийн бэрхшээлээс үүдсэн цахим ялгаатай байдалтай холбоотой. Эдгээр асуултыг өмнөх B сэдэвт авч үзсэн сүлжээ, холболт, ашиглалтын ерөнхий үр дүнг интернэтийн хэрэглэгч болон хэрэглэгч бус хүмүүсийн тодорхойлсон интернэтэд хандах, ашиглахад тулгардаг саад бэрхшээлийг X ангиллын хүйс болон хүүхэдтэй холбоотой асуудлын хамтаар үнэлнэ. Асуулт D.2 нь X ангиллын A сэдэвт (Хүйс) мөн багтсан болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг бүлэг хооронд ашиглахад онцгой анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, хүн ам зүйн болон нийгэм-эдийн засгийн бусад хүчин зүйлсийн хоорондын уялдаа холбоог задлан ангилах замаар тодорхойлно.

**AD.1 Бүс нутаг хооронд, хот ба хөдөөгийн хооронд өргөн зурвасын хүртээмж, ашиглалтын хувьд мэдэгдэхүйц ялгаатай эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Хот, хөдөөгийн өргөн зурвасын сүлжээний газар зүйн хамрах хүрээ, зурвасын өргөнөөр;
- Холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч болон интернэт хэрэглэгчийн тоо, боломжтой бол хот ба хөдөө, бүс нутгаар ангилсан байдлаар.

**AD.2 Уугуул иргэдийг оролцуулан хүн амын доторх төрөл бүрийн угсаатны бүлгийн өргөн зурвасын сүлжээнд нэвтрэх болон ашиглахад мэдэгдэхүйц ялгаатай эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо болон интернэт хэрэглэгчийн тоо, уугуул иргэдийг оролцуулан угсаатны бүлгээр ангилсан байдлаар.

**AD.3 Засгийн газраас олон бүлэг, тэдгээрийг төлөөлж буй байгууллагатай интернэтийн ойлголт болон хэрэглээний талаар судалгаа авсан ба/буюу санал солилцон зөвлөлддөг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбогдох судалгаа болон хүн амын олон янз бүлэгт чиглэсэн эсхүл ангилсан зохицуулалт;
- Өрхийн судалгаа болон бусад эх сурвалжаас авсан интернэтийн талаарх ойлголт, хүн амын төрөл бүрийн бүлгээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар.

**AD.4 Интернэтэд нэвтрэх, ашиглахад жендерийн цахим ялгаварлал байдаг эсэх, хэрэв тийм бол энэ нь нэмэгдэж, буурч, эсхүл тогтвортой байгаа эсэх? (Энэ асуулт, шалгуур үзүүлэлт нь X ангиллын A сэдэвт орсон болно)**

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэт ашигладаг хүмүүсийн хувь, хүйсээр нь ангилж, эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн орлого болон боловсролын түвшнээр харьцуулан ангилсан байдлаар;[11]

[11] Энэ нь жендерийн цахим ялгааг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд хоорондын тэгш бус байдалтай харьцуулах боломжийг олгодог.

- Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасыг хэрэглэгч насанд хүрсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувь, хүйсээр нь ангилж, орлого болон боловсролын түвшин дэх жендерийн зөрүүгээр харьцуулсан байдлаар;
- Интернэт хэрэглээний хэв маягийн талаарх судалгааны өгөгдөл, хүйсээр ангилсан байдлаар;
- Интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгарч буй саад бэрхшээл, интернэтийн хандалт ба ашиглалтын үнэ цэнийн талаарх ойлголт, хүйсээр ангилсан байдлаар.

### AD.5 Бүх насны бүлгийн насанд хүрэгчид интернэтийг ижил хэмжээгээр ашигладаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэт ашигладаг төрөл бүрийн насны бүлгийн насанд хүрэгчдийн эзлэх хувь, хэрэглээний давтамж ба төрлийг[12] хүйсээр ангилсан байдлаар;
- Интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгардаг саад бэрхшээлийн талаарх ойлголт, эцсийн хэрэглэгчдийн интернэтэд нэвтрэх, ашиглах үнэ цэнийн талаарх ойлголт, (боломжтой бол) нас болон хүйсээр ангилсан байдлаар.

### AD.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс интернэтийг үр дүнтэй ашиглах боломжтой эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс интернэтэд нэвтрэх, ашиглахыг дэмждэг хууль эрх зүйн болон зохицуулалтын заалт;
- Засгийн газрын веб сайт, төрийн цахим үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хандах боломж;
- Интернэт ашиглаж буй иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь, насны бүлэг ба хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ангилсан байдлаар;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгардаг саад бэрхшээл, тэдний интернэтэд нэвтрэх, ашиглах үнэ цэнийн талаарх ойлголт.

# Сэдэв E • Орон нутгийн агуулга, хэл

Хүмүүс амьдралын чанар болон амьжиргаагаа сайжруулах, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор интернэтийг ашиглахад тухайн орон нутагт бүтээсэн болоод орон нутгийн асуудалтай холбоотой контент зайлшгүй шаардлагатай байдаг. Гэвч орон нутгийн агуулгыг тодорхойлох, үнэлэх асуудал тодорхой бус, асуудалтай хэвээр байна. Ер нь орон нутагт хамааралтай гэж үзсэн агуулгыг төрөл бүрийн аргаар тодорхойлдог бөгөөд хэл нь боломжит нэг шалгуур үзүүлэлт болдог.

Энд хувь хүний нийтэлсэн нийгмийн сүлжээний контентыг веб сайт дээрх контентоос ялгаатай авч үзнэ.

Асуулт E.1 ба E.2 нь тухай улсад болон тухайн улсын талаарх дотоодод бүтээсэн контент байдаг эсэхтэй холбоотой бөгөөд онлайн контент үүсгэж буй хувь хүмүүсийн эзлэх хувьтай уялдуулан үнэлнэ (R ангиллын Асуулт B.5).

Орон нутгийн хүн амын хэлээрх контент байдаг эсэх нь, ялангуяа үндэсний цөөнхийн хэлээрх контент нь интернэт ашиглах үнэ цэнэд чухал ач холбогдолтой.

Асуулт E.3, E.4 нь орон нутгийн хэлээрх контентын хүртээмжтэй холбоотой бөгөөд нөхцөл байдлаас хамаарах 2.D шалгуур үзүүлэлтийн хамт үнэлэх хэрэгтэй.

### AE.1 Улсын хэмжээнд хэдэн интернэт домэйн нэр болон сервер байдаг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- 1000 хүнд ногдох бүртгэгдсэн домэйн нэрийн тоо (ccTLDs. gTLDs[92] болон IDNccTLDs нэрийг оролцуулан) болон боломжтой бол чиг хандлага;
- Нэг сая хүн амд ногдох аюулгүй веб серверийн тоо, боломжтой бол чиг хандлага.

[12] "Ашиглалтын төрөл" гэж интернэт хэрэглэгчдийн нийгмийн сүлжээ ашиглах, веб мэдээ үзэх, тоглоом тоглох, цахим шуудан шалгах зэрэг олон төрлийн онлайн үйл ажиллагааг хэлнэ.

### AE.2 Орон нутагт бүтээсэн контентыг оролцуулан тухайн улсын талаарх онлайн контент агуулгын хэмжээ өсөн нэмэгдэж байгаа эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Википедиа болон түүнтэй төстэй эх сурвалжид[13] байгаа тухайн улстай холбоотой нийтлэл/үгийн тоог бусад улс оронтой харьцуулсан харьцуулалт, эх үүсвэрийн (тухайн улсад үүсгэсэн хувь) хамт.

### AE.3 Хувь хүн орон нутгийн болон уугуул иргэдийн бичиг, хэлээрх онлайнаар хандах боломжтой домэйн болон онлайн үйлчилгээ байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэт домэйн нэр болон веб сайтыг орон нутгийн бичгээр ашиглах боломж;
- Томоохон онлайн платформыг орон нутгийн хэлээр ашиглах боломж;
- Орон нутгийн хэлээр гар утасны программ ашиглах боломж;
- Хүн амын доторх хэрэглэгчдийн томоохон бүлгийн бүх хэлээр төрийн веб сайтын контентыг ашиглах боломж;
- Тэргүүлэгч онлайн үйлчилгээнд хувь хүний үүсгэсэн болон уншсан контентын эзлэх хувь, үндсэн хэл бүрээр хүн амд эзлэх хувьтай харьцуулсан харьцуулалт.

### AE.4 Орон нутагт бүтээсэн контентыг оролцуулан орон нутгийн болон уугуул иргэдийн хэлээрх интернэт контентын хэмжээ[14] ихсэж, өсөн нэмэгдэж байгаа эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Голлох онлайн үйлчилгээнд үндсэн хэл, бичгийг ашиглах боломжтой хүн амын эзлэх хувь;
- Хүн амын дунд олон хэрэглэгчийн бүлэгтэй бүх хэлээрх төрийн веб сайтын агуулгын хүртээмж.

# Сэдэв F • Чадавх/Ур чадвар

Интернэтийг үр дүнтэй ашиглах, интернэтэд холбогдсон үйлчилгээг авахад хэрэглэгчдээс тодорхой чадавх, ур чадвар шаарддаг. Энэ нь интернэтийг арилжааны болон бусад зорилгоор ашиглах нь хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагын хувьд тун чухал. НҮБ-ын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрт “Хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байр, бизнес эрхлэхэд шаардлагатай холбогдох техникийн болон мэргэжлийн ур чадвар” эзэмшсэн хүмүүсийн тоог мэдэгдэхүйц нэмэгдүүлэхээр заасан билээ. Энэ зорилтод хүрэхэд хэвлэл мэдээлэл, мэдээллийн бичиг үсэгт тайлагдсан байдал чухал ач холбогдолтойг нийтээр хүлээн зөвшөөрсөн. Үүнд, бичиг үсгийн суурь мэдлэг (үүнийг өмнө авч үзсэн нөхцөл байдлаас хамаарах шалгуур үзүүлэлтэд оруулсан болно), онлайн үйлчилгээ ба программ хангамжийг үр дүнтэй ашиглах чадавх, төрөл бүрийн түвшний техникийн ур чадвар багтана.

ЮНЕСКО нь хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын бүлэг шалгуур үзүүлэлтийг[93] боловсруулан гаргаж, энэ сэдэвт хэсэгчлэн тусгасан нь цаашид гүнзгийрүүлэн судлахад үнэ цэнтэй эх сурвалж болно. Түүнчлэн ЮНЕСКО-гоос “Багшийн МХХТ–ийн цогц чадамжийн хүрээ”[94] баримт бичгийг эрхлэн гаргасан.

Асуулт F.1 нь боловсролын сургалтын хөтөлбөр, асуулт F.2 нь нийгэмд хэвлэл мэдээлэл, боловсролыг сурталчлан таниулах засгийн газрын үйл ажиллагаатай, асуулт F.3 нь төрөл бүрийн түвшний МХХТ-ийн ур чадварын тархалттай холбоотой. Х ангиллын бизнесийн орчны интернэт тархалтын талаарх С.7 асуултад анхаарал хандуулах хэрэгтэй.

### AF.1 ЕБС, дээд боловсролын сургалтын хөтөлбөрт МХХТ, хэвлэл мэдээлэл, бичиг үсгийн сургалтыг оруулж, үр дүнтэй бөгөөд аюулгүй хэрэглээнд чиглүүлж, хөтөлбөрийг практикт хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Сургуулийн сургалтын хөтөлбөр, тэр дундаа хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол, соёл хоорондын яриа, МХХТ-ийн ур чадвар олгох сургалтын талаарх бодлого;
- Бага, дунд, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн баримт бичгүүд;

[13] Хөгжлийн төлөөх МХХТ-ийг хэмжих түншлэлээс Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалтын дагуу Википедиагийн нийтлэлийн тоог шалгуур үзүүлэлт болгон сонгосон. Википедиагийн өгөгдлийг чөлөөтэй авах боломжтой бөгөөд энэ нь хяналт, үнэлгээний үйл ажиллагааг хөнгөвчилдөг. Гэвч тэдгээрийг ашиглахдаа Википедиагийн хандалт, хэрэглээ нь улс орнуудын эдийн засаг, хэлний бүлгүүдийн хооронд харилцан адилгүй байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Бусад лавлах эх сурвалжийг авч үзэх шаардлагатай.

[14] Үүнд бичвэр, аудио, видео контентыг авч үзэх шаардлагатай.

- МХХТ-ийн сургалттай эсхүл сургалтад МХХТ ашигладаг бага, дунд сургуулийн багш нарын эзлэх хувь;
- Интернэтэд холбогдсон сургуулиудын эзлэх хувь;
- Сургууль дээрээсээ интернэтэд холбогдох боломжтой суралцагчдын эзлэх хувь.

### AF.2 Төр болон бусад сонирхлын бүлгүүдээс насанд хүрэгчдэд зориулсан хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын хөтөлбөр (цахим хэлбэрийг оруулан) байдаг эсэх, хэрэв байдаг бол тэдгээрийг хэр зэрэг ашигладаг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын хөтөлбөр, түүний хэрэглээний статистик, хүйсээр ангилсан байдлаар;
- Хэрэглэгчдийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын талаарх ойлголт.

### AF.3 Хүн амын болон ажиллах хүчний хэдэн хувь нь МХХТ–ийг ашиглах чадвартай вэ?[15]

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтийн тодорхой ур чадвартай хэрэглэгчдийн эзлэх хувь, ур чадварын түвшингээр (анхан, дунд, ахисан), нэгтгэсэн болон ангилсан[95] байдлаар;
- Ажлын байранд МХХТ ашигладаг боловсон хүчний эзлэх хувь, ур чадварын түвшин ба төрлөөр (анхан, дунд, ахисан), нэгтгэсэн болон ангилсан байдлаар
- ШУТИМ (STEM)[16] болон МХХТ-ийн сургалтад хамрагдсан их дээд сургуулийн оюутнуудын эзлэх хувь, хүйсээр ангилж, дэлхийн дундажтай харьцуулсан байдлаар.

[15] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.
[16] Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик



# 7

# АНГИЛАЛ M
# **Олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоо**

2015 оны 11 дүгээр сард Бразилийн Жоао Песоа хотод Интернэт засаглалын форум (ИЗФ)-ын 10 дахь удаагийн хурлыг зохион байгуулсан. ИЗФ нь интернэт засаглалын асуудлаарх бодлогын яриа хэлэлцээний олон талт сонирхлын бүлгүүдийн форум юм. Энэ нь интернэт засаглалын талаарх мэтгэлцээнд оролцогч бүх талыг засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм, тэр дундаа техникийн болон эрдэм шинжилгээний нийгэмлэгийг төлөөлж байгаа эсэхээс үл хамааран тэгш эрхтэй, нээлттэй, оролцоотой үйл явцаар нэгтгэдэг.

© Ricardo Matsukawa/IGF Secretariat

# M

# Олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоо



Интернэтийн хөгжил нь олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоогоор тодорхойлогддог. 2005 онд болсон Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалт (МНДДХУ)-ын хоёрдугаар чуулганаар баталсан Мэдээллийн нийгмийн Тунисын хөтөлбөр нь “Хүн төвтэй, хүртээмжтэй, хөгжилд чиглэсэн мэдээллийн нийгмийг амжилттай байгуулахад олон талт оролцоо чухал" гэдгийг хүлээн зөвшөөрч, “Мянганы хөгжлийн зорилтуудыг багтаасан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэм тус болох үүднээс интернэтийг өргөжүүлэх, хөгжүүлэх талаар зөвшилцөх, хамтран ажиллах зорилгоор олон талт үйл явцыг үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд хөгжүүлэх”-ийг дэмжсэн билээ.[96]

2015 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей МНДДХУ-ын 10 жилийн үр дүнгийн тайландаа “олон талт хамтын ажиллагаа, оролцооны үнэ цэн, зарчмыг ... төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллага, техникийн болон боловсролын байгууллага, холбогдох бүх талын үр дүнтэй оролцоо, түншлэл, хамтын ажиллагаа нь өөрсдийн үүрэг хариуцлагын хүрээнд, ялангуяа хөгжиж буй орнуудаас тэнцвэртэй төлөөлөлтэй байх нь мэдээллийн нийгмийг хөгжүүлэхэд амин чухал байсаар ирсэн бөгөөд одоо ч хэвээр байна[97]” хэмээн хүлээн зөвшөөрснөө дахин нотолсон.

Интернэтийн хөгжил, засаглалд олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоо нь засгийн газар, засгийн газрын агентлаг, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм, интернэтийн техникийн болон мэргэжлийн нийгэмлэг, эрдэм шинжилгээний байгууллагыг нэгтгэдэг. Олон талт сонирхлын бүлгүүдийн оролцооны зорилго нь интернэтийн ашиг сонирхолтой бүх талыг шийдвэр гаргахад оролцуулж шийдвэр гаргалтын оролцоо ба чанарыг дээшлүүлж, нээлттэй бөгөөд ил тод шийдвэр гаргаснаар түүний нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд үзүүлэх нөлөөллийг сайжруулахад оршино. Тунисын хөтөлбөрөөр интернэт засаглалын "тодорхойлолт"-ыг “Төр, хувийн хэвшил, иргэний нийгэм нь үүрэг хариуцлагынхаа хүрээнд интернэтийн хэрэглээ, хөгжлийг зохицуулах нийтлэг зарчим, хэм хэмжээ, дүрэм, шийдвэр гаргах журам, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх явдал юм” хэмээн тодорхойлжээ.

МНДДХУ-ын дагуу НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын үүсгэн байгуулсан Интернэт засаглалын форумын гол зарчим нь олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоо байсаар ирсэн бөгөөд интернэттэй холбоотой үндэсний, бүс нутгийн, олон улсын бусад форумд өргөнөөр ашиглах болсон. Энэ нь өргөн далайцтай болж чадсан билээ. НҮБ-ын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрт бүх улс орон, ялангуяа хөгжиж буй орнуудын[98] тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдлэг, туршлага, технологи, санхүүгийн нөөцийг дайчлах, хуваалцах "олон талт түншлэл"-ийг бий болгохыг уриалсан билээ. Сонирхогч талуудын үр дүнтэй оролцоо, юу хийж чадах нь тэдний итгэл үнэмшил, ашиг сонирхол, мэдлэгийн цар хүрээ, интернэттэй холбоотой үйл ажиллагаанд хүлээх эрх мэдэл хийгээд үүрэг хариуцлагын түвшин, зөвлөлдөх болон шийдвэр гаргалтын мөн чанар зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогддог.

Энэ ангиллын шалгуур үзүүлэлтийг дор дурдсан 3 сэдэвт авч үзнэ. Үүнд:

- Сэдэв A нь засаглал дахь оролцооны хууль эрх зүйн болон зохицуулалтын ерөнхий тогтолцоотой холбоотой.
- Сэдэв B нь үндэсний интернэт засаглалтай холбоотой.
- Сэдэв C нь олон улсын болон бүс нутгийн интернэт засаглалтай холбоотой.

Олон талт оролцоог үнэлэхдээ институцийн зохицуулалт болон түүний үр нөлөөгөөр олон талт оролцооны практик үр дүнг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд, оролцоо нь зөвхөн интернэтийн хөгжилд шууд хамааралтай төдийгүй нийгмийн бүх талын ашиг сонирхлыг багтаасан, бодитоор тэнцвэржүүлсэн эсэхийг үнэлэх нь зүйтэй.

# Сэдэв А • Бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээ

Энэхүү сэдэв нь интернэт болон интернэт засаглалыг тусгайлан авч үзэхээс илүүтэй засаглалын үндэсний хэмжээний өргөн хүрээтэй хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог авч үзнэ. Энэ нь интернэттэй холбоотой бодлого, шийдвэрийн хүрээнд цогц орчныг бүрдүүлдэг. Гэвч үнэлгээний нотлох баримт нь засаглалын үйл явц онлайнаар хэрэгжиж байгаа эсэхтэй зарим талаараа холбоотой байдаг нь засгийн газар интернэтийн боломжийг хэр зэрэг ашиглаж байгааг харуулдаг.

### MA.1 Интернэтийг хөгжүүлэх, бодлого боловсруулах олон улсын хэм хэмжээнд нийцсэн хууль эрх зүйн болон зохицуулалтын орчинтой эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбогдох олон улсын жишигт нийцсэн зохицуулалт, орчинтой эсэх;[99]
- Цахим худалдаа, тоон гарын үсэг, кибер аюулгүй байдал, өгөгдлийн хамгаалалт, хэрэглэгчийг хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин[1].

### MA.2 Төрөөс үндэсний бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог дэмждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газраас гаргадаг Цахим оролцооны индекс дэх утга, эзлэх байр;
- Олон нийтийн хэлэлцүүлэг шаардсан бодлого, хууль эрх зүйн зохицуулалт болон онлайнаар зөвлөгөө өгөх хууль эрх зүйн болон практик зохицуулалт;
- Онлайнаар оролцох боломжтой засгийн газрын зөвлөлдөх үйл явц, боломжийн тоо, хамрах хүрээ;
- Интернэттэй хамааралгүй онлайн зөвлөгөө өгөх үйл явцад төрөл бүрийн сонирхлын бүлгийн оролцоог нотлох баримт;
- Интернэттэй холбоотой бодлого боловсруулах үйл явцад төрөл бүрийн сонирхлын бүлгийн оролцоог нотлох баримт.

### MA.3 Засгийн газар нь иргэд болон сонирхлын бүлгийн өмнө хариуцлага хүлээдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Засгийн газрын хүлээх үүрэг хариуцлагын тухай үндсэн хуулийн болон институцийн зохицуулалт, тэдгээр нь практикт хэрэгжиж байгаа эсэх талаар эрх бүхий баталгаат эх сурвалжаас авсан нотлох баримт.

[1] “Үндсэн үзүүлэлт”-ийг гурвалжин тэмдгээр тэмдэглэв. Бүрэн үнэлгээ хийхэд нөөц хүрэлцэхгүй тохиолдолд үндсэн үзүүлэлтүүдийн дэд багцыг интернэтийн түгээмэл байдлын талаар цогц үнэлгээ хийхэд ашиглаж болно. Эдгээр үндсэн үзүүлэлтийг Хавсралт 4-өөс харж болно.

7

# Сэдэв B • Үндэсний интернэт засаглал

Энэ сэдэв нь үндэсний түвшинд интернэттэй холбоотой бодлого боловсруулахад оролцогч талуудын төрөл бүрийн бүлгийн оролцоотой холбоотой. Асуулт B.1 нь бодлого боловсруулагч оролцогчдын хамтын ажиллагааг хамарна. Асуулт B.2 ба B.3 нь сүүлийн жилүүдэд өргөнөөр хэрэгжиж байгаа интернэт засаглалын форумын үндэсний форматаар засгийн газрын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах институцийн тогтолцоотой холбоотой.

**MB.1 Интернэттэй холбоотой бодлого болон засаглалын асуудлыг хариуцдаг, оролцдог мэргэжлийн хүмүүс (интернэтийн мэргэжилтнийг оруулан), хэрэглэгч болон бусад сонирхлын бүлгийн идэвхтэй ажиллаж буй холбоо байдаг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбогдох холбоод, тэдгээрийн үйл ажиллагааны түвшин, гишүүнчлэлийн өгөгдөл, хүйсээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар.

**MB.2 Төрөөс үндэсний интернэтийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулахад сонирхлын бүлгүүдийг идэвхтэй оролцуулдаг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтийн хөгжил, ашиглалттай холбоотой үндэсний бодлого боловсруулах институц, үйл явцад олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөлдөх уулзалт болон оролцооны зохицуулалт байдаг эсэх;
- Идэвхтэй оролцож буй төрийн бус сонирхогч талын тоо, бүлэг, хүйсээр ангилсан байдлаар.

**MB.3 Интернэт засаглалын үндэсний форум ба/буюу бусад олон талт сонирхлын бүлгүүдийн форум нь идэвхтэй оролцоотой сонирхлын бүх бүлэгт нээлттэй байдаг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэт засаглалтай холбоотой үндэсний интернэт засаглалын форум ба/буюу бусад олон талт сонирхлын бүлгийн форум байдаг эсэх;
- Үндэсний ИЗФ эсхүл бусад форумын оролцогчдын өгөгдөл, хүйс ба сонирхлын бүлгээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар, ялангуяа зайнаас оролцох зохицуулалтыг оролцуулан сонгосон бүлгийн (жишээлбэл, боловсролын яам, ЖДҮ, хүүхдийн асуудлаар ажилладаг ТББ, үйлдвэрчний эвлэл гэх мэт) оролцоо.

**MB.4 Үндэсний домэйн нэрийн бүртгэл нь шийдвэр гаргах үйл ажиллагаандаа сонирхогч бүх талыг оролцуулдаг эсэх?**

**Шалгуур үзүүлэлт:**

- Домэйн нэрийн бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм журам.

# Сэдэв С • Олон улсын болон бүс нутгийн интернэт засаглал

Энэ сэдэв нь интернэт засаглалтай холбоотой олон улсын форумд тухайн улсын төрөл бүрийн сонирхлын бүлгийн оролцоотой холбоотой. Асуулт С.1 нь засгийн газраас олон улсын үйл ажиллагаанд олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоог хэр зэрэг дэмжиж байгааг авч үзнэ. Асуулт С.2 ба С.3 нь интернэтийн хөгжил, ашиглалтын талаар авч үздэг олон улсын голлох хоёр хамтын ажиллагаа болох Интернэт засаглалын форум (ИЗФ) болон Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага (ОУИНХБ) дахь засгийн газар, бусад сонирхлын бүлгийн идэвхтэй оролцоотой холбоотой. Интернэтийн өргөн хүрээний хамтын ажиллагааны оролцоог үнэлэх боломжгүй тул интернэт засаглалын ерөнхий орчны олон талт байдлыг тусгах зорилгоор Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ), дэлхийн болон бүс нутгийн ИЗФ, ОУИНХБ-ыг сонгосон.

### МС.1 Төрөөс олон улсын интернэт засаглалын талаарх бодлого боловсруулахад сонирхлын бүлгүүдийг идэвхтэй оролцуулдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Төрөөс олон улсын хурал уулзалтад олон талт сонирхлын бүлгүүдийг бэлтгэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлж байгааг нотлох баримт.

### МС.2 Тухайн улсын засгийн газар, бусад сонирхлын бүлгүүд МХХТ болон интернэттэй холбоотой олон улсын томоохон форумд идэвхтэй оролцдог эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Засгийн газраас МХХТ болон интернэттэй холбоотой олон улсын форумд ирүүлсэн мэдүүлгийн тоо;
- Харилцаа холбоо, интернэттэй холбоотой олон улсын стандарт тогтоох үйл явцад засгийн газар болон бусад сонирхлын бүлгүүдийн оролцсон байдал;
- Дэлхийн болон бүс нутгийн ИЗФ-д оролцсон төрөл бүрийн сонирхлын бүлгийн оролцогчийн тоо, нэг сая хүнд ногдох тоо, сонирхлын бүлэг ба хүйсээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- ОУЦХБ-д оролцох албан ёсны төлөөлөгчдийн бүрэлдэхүүн дэх төрийн бус сонирхлын бүлгүүдийн оролцоо, сонирхлын бүлэг ба хүйсээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар.

### МС.3 Засгийн газар, бусад сонирхогч талууд ОУИНХБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- ОУИНХБ-ын Засгийн газрын зөвлөх хорооны гишүүнчлэл, идэвхтэй оролцоо;
- ОУИНХБ-ын сонгуулийн хэсэг, ажлын хэсэг болон бусад форумын гишүүнчлэл, идэвхтэй оролцоо.




8

# АНГИЛАЛ X
# **Зангилаа асуудлуудын шалгуур үзүүлэлт**

12 настай Мансур 2017 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Йордан улсын Мафрак мужийн Сирийн хилийн ойролцоох Сирийн дүрвэгсдэд зориулсан Заатари хуаран дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн Макани төвийн гадаа “Сидра дээрх үүлс” баримтат кино үзэж байна. Энэхүү богино хэмжээний кинонд 80,000 хүн амын талаас илүү хувийг хүүхдүүд бүрдүүлдэг хуаранд амьдардаг өсвөр насны Сидра охины амьдралын нэгэн өдрийг харуулдаг.

© UNICEF/Herwig

# X

# Зангилаа асуудал



Энэхүү ангилал нь дор дурдсан 5 сэдэвтэй. Үүнд:

- Сэдэв A нь жендерийн тэгш байдал.
- Сэдэв B нь хүүхдүүд
- Сэдэв C нь тогтвортой хөгжил
- Сэдэв D нь итгэлцэл ба аюулгүй байдал
- Сэдэв E нь интернэтийн хууль эрх зүйн болон ёс зүйн асуудалтай тус тус холбоотой.

Сэдэв A ба B нь дурын үнэлгээнд онцгой анхаарах шаардлагатай асуудлыг авч үзнэ. Эдгээр сэдэв нь интернэтийн хандалт, нэвтрүүлэлт, ашиглалттай холбоотой асуудал бэрхшээлтэй тулгардаг бүлгүүдэд чиглэсэн нийгмийн бүтцийн тэгш бус байдал зэрэгт анхаарсан. Интернэтийн хүртээмжтэй байдлын үнэлгээг ROAM ангиллын шалгуур үзүүлэлтээр, ялангуяа хүйс болон насны бүлгээр ангилсан шалгуур үзүүлэлтээр бүрэн хийх шаардлагатай. A ба B сэдвийн шалгуур үзүүлэлтийг нэмэлт болон дагалдах байдлаар оруулж, цаашдын шинжилгээ, түүний дотор дотоод хамаарлыг судлан шинжлэх үндэслэл болгоно.

Сэдэв C нь тогтвортой хөгжлийн асуудал, тухайлбал, НҮБ-ын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрт тусгагдсан тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)[100] болон хөгжлийн тодорхой салбарт интернэтийн үзүүлж буй нөлөөлөлтэй холбоотой.

Сэдэв D нь итгэлцэл, аюулгүй байдалтай холбоотой. Сүлжээний аюулгүй байдлыг бодитоор үр дүнтэй хангаж чадахгүй тохиолдолд хэрэглэгчийн эрх, өгөгдөл болон бүрэн бүтэн байдал алдагдаж, сүлжээнд итгэх итгэл үнэмшил багасаж, улмаар бүх нийтийн хүртээмжийг хангахад итгэл буурах болно.

Сэдэв E нь интернэтийн хууль эрх зүй болон ёс зүйн асуудалтай холбоотой. Сүүлийн жилүүдэд интернэтийн хэрэглээнд гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, хуурамч ташаа мэдээллийг санаатайгаар тараах зэрэг эрхийн зөрчил, хөгжлийг боомилсон асуудал ихээр гарах болсон. Эдгээр асуудал нь хүний эрхийг хангах, хөгжлийг түргэтгэхэд интернэтийг үр өгөөжтэй ашиглахыг шаарддаг тул тухайн улсын интернэт орчны хөгжлийн ерөнхий үнэлгээг харгалзан үзэх шаардлагатай.

# Сэдэв A • Жендер

МХХТ нь жендерийн хувьд тодорхой, боловсруулж, ашиглаж буй нөхцөл байдлаас хамаардаг. Олон оронд эмэгтэйчүүд интернэтэд нэвтрэх, ашиглахад олон саад бэрхшээлтэй тулгардаг. Үүнд, үнэ өртөг, сүлжээний түгээлт, чанар, хүртээмж зэрэг үйл ажиллагааны саад бэрхшээл, мөн холбогдох агуулга, боловсролын хүртээмж болон мэдлэг чадвартай холбоотой бүтцийн саад бэрхшээл, шаардлагатай ур чадвар болон орлого, ажил мэргэжлийн байдал, онлайн хүчирхийлэл, жендерт суурилсан хүчирхийлэл ба заналхийллийн үр дагавар, интернэтэд нэвтрэх болон ашиглах ур чадварт нөлөөлөх хэвшмэл ойлголт болон соёлын хэм хэмжээ зэрэг нийтлэг асуудлууд орно[101].

"Жендерийн цахим ялгавартай байдал" гэсэн нэр томьёог мэдээллийн нийгэмд, ялангуяа МХХТ болон интернэтэд нэвтрэх, ашиглахад эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн оролцооны ялгааг үнэлэхэд хэрэглэдэг. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалт (МНДДХУ)-ын 10 жилийн үр дүнгийн тайландаа жендерийн цахим ялгавартай байдлыг шийдвэрлэх нь нэн тэргүүний зорилт хэмээн тодорхойлсон.[102] Хэдийгээр өдгөө энэ асуудалд ихээхэн анхаарал хандуулж байгаа ч ОУЦХБ-аас гаргасан судалгаагаар дэлхийн хэмжээнд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд интернэт ашиглах ялгавартай байдал буурахгүй хэвээр байна.[103] Түүнчлэн үнэлгээнд нас ба хүйсийн хамаарал болон хүн ам зүйн бусад шинж чанарыг тусгах шаардлагатай.

ЮНЕСКО-гоос энэхүү хүрээнд орсон шалгуур үзүүлэлтийг ашиглан хийсэн аливаа үнэлгээнд жендерийн талаарх тодорхой дүн шинжилгээ байх ёстой хэмээн үздэг. Энэ нь бүх 5 ангиллын шалгуур үзүүлэлтийн (ROAMX) өгөгдөлд үндэслэсэн байх шаардлагатай. Эрэгтэйчүүдтэй харьцуулсан эмэгтэйчүүдийн талаарх өгөгдлийг гаргахын тулд ROAM ангиллын олон шалгуур үзүүлэлтийг тоон болон чанараар нь ангилан авч үзнэ. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс гаргадаг Жендерийн тэгш бус байдлын индекс болон энэхүү хүрээнд орсон нөхцөл байдлаас хамаарах шалгуур үзүүлэлтийг дүн шинжилгээнд тусгах нь зүйтэй.

Энэ хэсэгт орсон асуулт, шалгуур үзүүлэлт нь жендерийн ялгаатай байдалтай хамааралтай хэд хэдэн асуудлыг авч үзсэн бөгөөд энэ нь бусад ангилалд багтсан асуулт, шалгуур үзүүлэлтэд мөн тусгагдсан болно.

Асуулт А.1 нь жендер, МХХТ/интернэтийн талаар баримталж буй төрийн бодлоготой холбоотой. Асуулт А.2, А.3, А.4 нь жендерийн цахим ялгавартай байдлыг хамарсан (Асуулт А.2 нь А ангиллын D сэдэв (Эрх тэгш хүртээмж)-т багтсан болно). А.5, А.6, А.7 асуултыг жендерээс хамааралтай дарамт, хүчирхийлэл, сургалт ба хөдөлмөр эрхлэлт, нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндтэй холбогдох мэдээлэл зэрэг эмэгтэйчүүдийн интернэт хэрэглээг хэмжих нэмэлт хэмжигдэхүүний хамтаар авч үзнэ.

### XА.1 Интернэтийг хөгжүүлэх үндэсний бодлого, стратегид эмэгтэйчүүд ба охидын эрх ашиг, хэрэгцээг тодорхой тусгаж, үр дүнтэй хяналт тавьдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- ▶ Үндэсний стратегид тусгасан а) Эмэгтэйчүүдийн интернэтийн хэрэгцээ шаардлага, б) Эмэгтэйчүүдийн эрх мэдэл, жендерийн тэгш байдлыг дэмжих интернэтийн боломж;[1]
- ▶ МХХТ/Интернэттэй холбоотой бодлого боловсруулах төрийн удирдах албан тушаалд ажилладаг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо;
- ▶ МХХТ-ийн хүртээмж, ашиглалтын талаарх боломжит өгөгдөл, хүйсээр ангилсан байдлаар;
- ▶ Интернэтийн хандалт, ашиглалтын стратегид тусгагдсан эмэгтэйчүүдийн оролцоог хянах үндэсний тогтолцоо.

### XА.2 Интернэтэд нэвтрэх, ашиглахад жендерийн цахим ялгаа байдаг эсэх, хэрэв байгаа бол энэ ялгаа нэмэгдэж байгаа, тогтвортой эсхүл буурч байгаа эсэх? (Энэ асуулт, түүний зарим шалгуур үзүүлэлт нь А ангиллын D сэдэвт орсон болно)

**Шалгуур үзүүлэлт:**

- ▶ Интернэт ашигладаг хувь хүмүүсийн эзлэх хувь, хүйс, орлого болон боловсролын түвшин, хүйсээр харьцуулан ангилсан байдлаар;
- ▶ Гар утасны өргөн зурвасын үйлчилгээнд бүртгэлтэй насанд хүрсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувь, хүйс, орлого болон боловсролын түвшин, хүйсээр харьцуулан ангилсан байдлаар;
- ▶ Интернэтийн талаарх мэдлэг, интернэтийн хэрэглээний хэв маягийн талаарх судалгааны өгөгдөл, хүйсээр ангилсан байдлаар;
- ▶ Интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгардаг саад бэрхшээл, интернэтийн хандалт, ашиглалтын үнэ цэнийн талаарх ойлголт, хүйсээр ангилсан байдлаар.

### XА.3 Интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгарч буй нийгэм, соёлын саад бэрхшээл нь эмэгтэйчүүдийн интернэтэд нэвтрэх, ашиглах чадварт нөлөөлж байгаа эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- ▶ Интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгардаг саад бэрхшээл, интернэтийн хандалт болон ашиглалтын үнэ цэнийн талаарх ойлголт, хүйсээр ангилсан байдлаар.

### XА.4 Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд онлайн үйлчилгээг ижил түвшинд ашигладаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- ▶ Нийгмийн сүлжээг ашигладаг интернэт хэрэглэгчдийн хувь, хүйсээр ангилсан байдлаар;
- ▶ Мобайл санхүүгийн болон онлайн банкны үйлчилгээг ашигладаг насанд хүрэгчдийн эзлэх хувь, хүйсээр ангилсан байдлаар;
- ▶ Төрийн цахим үйлчилгээг ашигладаг насанд хүрэгчдийн эзлэх хувь, хүйсээр ангилсан байдлаар;
- ▶ Цахим худалдааны үйлчилгээг ашигладаг насанд хүрэгчдийн эзлэх хувь, хүйсээр ангилсан байдлаар.

### XА.5 Хууль, хууль сахиулах болон шүүхийн үйл ажиллагаа нь охид, эмэгтэйчүүдийг цахим орчинд үйлдэгддэг жендерт суурилсан дарамт, хүчирхийллээс хамгаалдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- ▶ Холбогдох хууль эрх зүйн орчин, шүүхийн процесс;
- ▶ Охид, эмэгтэйчүүд цахим орчинд үйлдэгддэг жендерт суурилсан дарамт, хүчирхийлэлд өртсөн тохиолдол;

[1] “Үндсэн үзүүлэлт”-ийг гурвалжин тэмдгээр тэмдэглэв. Бүрэн үнэлгээ хийхэд нөөц хүрэлцэхгүй тохиолдолд үндсэн үзүүлэлтүүдийн дэд багцыг интернэтийн түгээмэл байдлын талаар цогц үнэлгээ хийхэд ашиглаж болно. Эдгээр үндсэн үзүүлэлтийг Хавсралт 4-өөс харж болно.

- Цахим орчинд үйлдэгддэг жендерт суурилсан дарамт хүчирхийллээс охид, эмэгтэйчүүдийг хамгаалах хууль сахиулах болон шүүхийн байгууллагын үйл ажиллагааг нотлох баримт;
- Цахим орчинд үйлдэгддэг жендерт суурилсан дарамт хүчирхийллээс эмэгтэйчүүдийг хамгаалах болон хохирогч эмэгтэйчүүдэд туслах зорилготой онлайн үйлчилгээ.

### XA.6 Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (ШУТИМ)-ийн сургалт, хөдөлмөр эрхлэлт, интернэтийн манлайлалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь чухал бөгөөд өсөн нэмэгдэж байгаа эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Дээд боловсролын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн сургалтад хамрагдаж, төгссөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь;
- ШУТИМ-ийн чиглэлээр ажилладаг эмэгтэйчүүдийн эзлэх хувь, ур чадварын түвшингээр;
- Үндэсний түвшинд интернэт, харилцаа холбооны бизнесийн удирдах албан тушаалд ажилладаг эмэгтэйчүүдийн эзлэх хувь.

### XA.7 Нөхөн үржихүй болон бэлгийн эрүүл мэндийн талаарх үнэн зөв мэдээллийг онлайнаар чөлөөтэй авах боломжтой эсэх?[2]

**Шалгуур үзүүлэлт:**

- Нөхөн үржихүй болон бэлгийн эрүүл мэндийн талаарх онлайн мэдээллийн хязгаарлалт, хандахад хялбар байдал (хэлийг оролцуулан) болон хэрэглэх цар хүрээ.

# Сэдэв B • Хүүхдүүд

Хүүхдийн эрхийн тухай конвенцод “Хүүхдэд хамаарах хуульд зааснаас бусад тохиолдолд 18 нас хүрээгүй хүнийг насанд хүрээгүй хүүхэд гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг[104]. Энэ нь эдгээр шалгуур үзүүлэлтэд санал болгож буй хүүхэд насны тодорхойлолт юм. Ихэнх улс оронд насыг өөр өөрөөр авч үздэг тул насны тодорхойлолтод зарим өөрчлөлтийг хийх шаардлага гарч болно.

Хүүхдүүд бага наснаасаа интернэтэд холбогдох нь улам бүр ихсэж байна. Интернэт нь хүүхдэд хэрэгцээтэй бөгөөд бусад арга хэрэгслээр хялбархан олж авах боломжгүй мэдээллийг авах, нийгмийн амьдралд оролцох, өөрийн хүсэл зорилго, итгэл үнэмшил, хэрэгцээ шаардлагаа илэрхийлэх зэрэг олон боломжийг олгодог. Үүний зэрэгцээ интернэтээс үүдэлтэй сөрөг үр дагавар буюу тэдний сайн сайхан байдалд заналхийлж, сэтгэлийг нь түгшээх, донтуулах, бэлгийн дарамт үзүүлэх, дээрэлхэх, залилан мэхлэх сурталчилгаа зэрэг агуулгад өртөх зэргээр хүүхдийн эрх ашгийг зөрчих нь түгээмэл. “Дэлхийн хүүхдүүд онлайнаар” (Global Kids Online) зэрэг санаачилга, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг байгууллага хүүхдийг дээрх асуудлаас хамгаалахын зэрэгцээ интернэтэд нэвтрэх, ашиглах боломжийг олгох, сурталчлах арга замыг эрэлхийлэн ажиллаж байна.

Асуулт B.1, B.2, B.3 нь хүүхдийн интернэтийн хэрэглээ, асуулт B.4, B.5, B.6, B.7 нь төрийн бодлого (B.4), боловсрол (B.5 ба B.6), хүүхэд хамгаалалтай (B.6) тус тус холбоотой.

Хууль эрх зүйн орчин, тоон болон чанарын үр дүнтэй холбоотой асуултыг багтаасан энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн эрх ашгийг харгалзан үзэх шаардлагатай. Хувийн халдашгүй байх эрх, мэдээлэл хүртэх эрх зэрэг нь хүүхдийн асуудалд онцгой нөлөө, шаардлагыг тавьдаг. Бодлогыг авч үзэхдээ зөвхөн хүүхэдтэй шууд холбоотой бодлогыг бус, илүү олон талын асуудлыг (өргөн зурвасаар нэвтрэх, цахим эдийн засаг гэх мэт) шийдвэрлэх өргөн хүрээний бодлогод тусгагдсан эсэхийг авч үзэх нь чухал юм.

### XB.1 Төрөөс хүүхдийн интернэт хэрэглээний талаар тэднээс судалгаа авдаг эсхүл тэдэнтэй ба/буюу эцэг эхчүүдтэй (эсхүл хүүхдийн байгууллага) зөвлөлдөг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хүүхдүүд болон холбогдох байгууллагад хандсан шууд судалгаа, зөвлөгөөний арга хэмжээний нотлох баримт.

[2] Энд онцгойлон эмэгтэйчүүдэд хамааралтай агуулгыг жишээ болгон оруулсан болно.

### XB.2 5-18 насны хүүхдийн хэдэн хувь нь интернэт ашигладаг вэ?[3]

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтийг ашигладаг хүүхдийн эзлэх хувь, хэрэглээний давтамж болон төрлийг оролцуулан хүйс, насны бүлгээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар[4].

### XB.3 Хүүхдүүд интернэтийг хэрхэн хүлээн авч, ашигладаг вэ?[5]

**Шалгуур үзүүлэлт:**

- Судалгааны үр дүнгээс авсан хүүхдүүдийн интернэтийн талаарх ойлголт, түүнийг ашиглах үр ашиг, тулгардаг саад бэрхшээл, айдас, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- Хүүхдийн интернэт хэрэглээний талаарх өгөгдлийг бусад насны бүлэгтэй (байршил, давтамж, хэрэглээний төрөл[6] гэх мэт) харьцуулсан байдал, нэгтгэсэн болон ангилсан байдлаар.

### XB.4 Онлайн орчинд хүүхдийн эрх ашгийг дэмжих, хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин, тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хүүхдийн эрхийн тухай конвенцод нийцсэн бодлогын тогтолцоо, эрх зүйн хамгаалалт байдаг эсэх, түүнийг засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага хэрэгжүүлж байгааг нотлох баримт.

### XB.5 Бага, дунд сургуулиуд интернэт, өргөн зурвасын сүлжээнд холбогдсон эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Өргөн зурвасын сүлжээ болон интернэтэд холбогдсон сургуулиудын эзлэх хувь, шатлал (бага/дунд), төрөл (төрийн/хувийн) болон байршлаар (хөдөө/хот) ангилсан байдлаар;
- Сургуулийн компьютер-төхөөрөмжид ногдох суралцагчийн тоо, шатлал (бага/дунд), төрөл (төрийн/хувийн) болон байршлаар (хөдөө/хот) ангилсан байдлаар.

### XB.6 Засгийн газар, боловсролын байгууллага нь хүүхдийн интернэтийг үр ашигтай, аюулгүй ашиглахад чиглэсэн хэвлэл мэдээллийн цахим хэмжүүр болон мэдээллийн боловсролыг дэмждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хүүхдүүдэд цахим бичиг үсгийг таниулан сурталчлах, интернэтийн аюулгүй байдал болон хэрэглээний хариуцлагыг дээшлүүлэх засгийн газрын хөтөлбөр;
- Интернэтийг үр дүнтэй, аюулгүй ашиглах зэрэг цахим бичиг үсгийн талаарх сургалтын хөтөлбөрийн нотолгоо;
- Хүүхдийн интернэтийн хэрэглээг дэмжих онлайн үйлчилгээ, тэр дундаа хүүхдэд хүртээмжтэй хүүхэд хамгааллын үйлчилгээ;
- Хүүхдийн интернэтийн хэрэглээг дэмжих онлайн үйлчилгээ, тэр дундаа хүүхдэд хүртээмжтэй хүүхэд хамгааллын үйлчилгээний өгөгдлийн ашиглалт.

# Сэдэв С • Тогтвортой хөгжил

Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ), тэр дундаа интернэт нь энэ зууны эхэнд болсон Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалт (МНДДХУ)-аас хойш нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан. Хөгжилд интернэтийн үзүүлэх нөлөөг ойлгох нь үндэсний интернэт орчны аливаа үнэлгээний чухал хэмжүүр болно.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр нь 2015 оноос 2030 он хүртэлх 15 жилийн хөгжлийн талаарх олон улсын үйл ажиллагааны дэлхийн цар хүрээг тодорхойлж, хөгжлийн 17 зорилтыг дэвшүүлсэн[105]. Хөтөлбөр нь “Мэдээлэл, харилцаа холбооны технологийн тархалт, дэлхий даяарх харилцан уялдаа

[3] Хүний эрхийн конвенцын 1 дүгээр зүйлд “Хүүхдэд хамаарах хуульд зааснаас бусад тохиолдолд 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” хэмээн тодорхойлсон.
4 "Ашиглалтын төрөл" гэж интернэт хэрэглэгчдийн цахим сүлжээ ашиглах, веб мэдээ үзэх, тоглоом тоглох, цахим шуудан шалгах зэрэг төрөл бүрийн онлайн үйл ажиллагааг хэлнэ.
[5] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
[6] "Ашиглалтын төрөл" гэж интернэт хэрэглэгчдийн цахим сүлжээ ашиглах, веб мэдээ үзэх, тоглоом тоглох, цахим шуудан шалгах зэрэг төрөл бүрийн онлайн үйл ажиллагааг хэлнэ.

холбоо нь хүн төрөлхтний хөгжлийг хурдасгах, цахим хуваагдлыг арилгах, мэдлэгийн нийгмийг хөгжүүлэх асар их нөөцтэй” хэмээн тэмдэглэсэн ба үүний дагуу Зорилго 9(с) нь олон улсын хамтын нийгэмлэгийг “Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хүртээмжийг эрс нэмэгдүүлж, 2020 он гэхэд буурай хөгжилтэй орнуудад интернэтийг бүх нийтэд хүртээмжтэй, боломжийн үнээр хангахын төлөө ажиллах”-ыг уриалсан.

Асуулт C.1, C.2, C.3 нь интернэт болон Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн талаарх төрийн бодлоготой, асуулт C.4, C.5, C.6, C.7 нь хөгжлийн салбаруудад интернэтийн үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой.

### XC.1 Тогтвортой хөгжлийн үндэсний болон салбарын хөгжлийн бодлого, стратеги нь МХХТ, өргөн зурвасын сүлжээ болон интернэттэй үр дүнтэй уялдаж чаддаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- МХХТ, өргөн зурвасын сүлжээ болон интернэтийг хөгжүүлэх сүүлийн үеийн цогц бодлоготой байж, тэдгээрт тусгасан ирээдүйн хөгжлийн хүчин зүйлс;
- НҮБ-ын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр болон тогтвортой хөгжлийн зорилтуудыг хянах, хэрэгжүүлэхэд чиглэсэн өргөн зурвасын болон интернэтийн шинээр боловсруулсан болон шинэчилсэн бодлого, стратеги;
- Эдийн засаг, нийгмийн сонгосон салбарын (хувийн хэвшил, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд гэх мэт) шинээр боловсруулсан болон шинэчилсэн өргөн зурвасын болон интернэтийн бодлого, стратеги.

### XC.2 Засгийн газар нь цахим хог хаягдлын менежментийн талаарх бодлоготой эсэх, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Цахим хог хаягдлын талаарх үндэсний бодлого, төр болон хувийн хэвшил уг асуудлыг шийдвэрлэж байгааг нотлох баримт;
- Цахим хог хаягдлын хуримтлалын үзүүлэлт.

### XC.3 Интернэтийн хөгжил, түүний нийгэмд үзүүлэх нөлөөллийг хянах, үнэлэх хангалттай зохицуулалттай эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Үндэсний статистикийн газартай эсэх;
- Өрхийн судалгаа оролцуулан интернэтийн нэвтрэлт, ашиглалтын статистикийн хяналт зохицуулалт;
- Интернэт болон түүний тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой бодлогыг тогтмол хянаж, шинэчлэх зохицуулалт.

### XC.4 Засгийн газарт мэдээллийн технологийн шинэ хөгжлийг шийдвэрлэх, олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоог хангасан урт хугацааны стратегитай эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Мэдээллийн технологийн шинэ хөгжил, түүний дотор хиймэл оюун ухааны стратегийн форум болон түүнтэй адилтгах форум, бүрэлдэхүүн.

### XC.5 Насанд хүрэгчдийн хэдэн хувь нь томоохон онлайн үйлчилгээг ашигладаг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Төрийн цахим үйлчилгээг ашигладаг насанд хүрэгчдийн хувь, тодорхой ангиллаар, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- а) Онлайн банк, б) мобайл санхүүгийн үйлчилгээ ашигладаг насанд хүрэгчдийн эзлэх хувь, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- Онлайн сургалтын үйлчилгээг ашигладаг насанд хүрэгчдийн эзлэх хувь;
- Онлайн эрүүл мэндийн үйлчилгээг ашигладаг насанд хүрэгчдийн эзлэх хувь;
- Онлайн худалдааны үйлчилгээг ашигладаг насанд хүрэгчдийн эзлэх хувь.

### XC.6 Олон нийтийн үйлчилгээний байгууллагын хэдэн хувь нь интернэтэд холбогдсон бэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтэд холбогдсон бага сургуулиудын эзлэх хувь;
- Интернэтэд холбогдсон номын сангуудын эзлэх хувь;
- Интернэтэд холбогдсон эмнэлгүүдийн эзлэх хувь.

### XC.7 Бизнесийнхэн, тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хэдэн хувь нь интернэт болон цахим худалдааг ашигладаг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Цахим худалдаагаар дамжсан бизнес хоорондын үйл ажиллагааны эзлэх хувь;
- Интернэт ашигладаг ЖДҮ-ийн эзлэх хувь, хандалтын төрлөөр;
- ЖДҮ-ийн онлайн худалдааны (болон экспортын) эзлэх хувь;
- Нийт үйл ажиллагаанд бизнес хоорондын болон бизнесээс хэрэглэгч хоорондын үйл ажиллагааны эзлэх хувь, хэмжээ;
- ЖДҮ эрхлэгчдийн интернэт хэрэглээний үнэ цэнийн талаарх ойлголт.

# Сэдэв D • Итгэлцэл ба аюулгүй байдал

Интернэт болон интернэтийн үйлчилгээний бүрэн бүтэн байдалд итгэх итгэл, түүний аюулгүй байдал нь интернэтийг бүх нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн үр дүнтэй ажиллахад зайлшгүй чухал юм. Итгэлцэл болон аюулгүй байдалтай холбоотой эрсдэл, айдас түгшүүр нь ялангуяа нийгмийн эмзэг бүлэгт түлхүү тохиолддог.

Кибер аюулгүй байдал гэдэг нь интернэт, онлайн үйлчилгээ, үйлчилгээг хүртэгсдийг эрсдлээс хамгаалах байдал гэж нийтээр ойлгодог бөгөөд интернэтийн түгээмэл байдлыг хангахад улам бүр чухал асуудал болж, сонирхогч бүх талын анхаарлын төвд байдаг.[7] Сүлжээний аюулгүй байдлын хамгаалалт хангалтгүй байх нь хэрэглэгчийн эрх, өгөгдөл мэдээллийн бүрэн бүтэн байдалд эргэлзээ төрүүлж, сүлжээнд итгэх итгэлийг багасгаж, хүртээмжийг бууруулдаг. Эдгээр шалгуур үзүүлэлтээс харахад кибер аюулгүй байдал гэдэг нэр томьёо нь аж ахуйн нэгж, хувь хүнд заналхийлж буй кибер гэмт хэрэг[8] чухал дэд бүтэц болон мэдээллийн санд учрах аюул заналхийллийг хамрах ба эдгээр нь засгийн газар, төрийн бус байгууллага, гэмт хэрэгтэн, хувь хүн зэрэг олон төрлийн эх сурвалжаас үүдэлтэй байж болно. Олон улс орны засгийн газраас компьютерын халдлагад хариу үзүүлэх баг (КХХБ/CERT) байгуулах зэргээр эдгээр эрсдэлтэй тэмцэх стратегийг боловсруулсан.

Асуулт D.1 ба D.2 нь сүлжээ ба түүний хэрэглэгчдэд нөлөөлдөг кибер аюулгүй байдлын хууль эрх зүйн зохицуулалттай, асуулт D.3 нь итгэлцэл, аюулгүй байдлыг улс орны хэмжээнд үүсгэдэг асуудалтай, асуулт D.4 ба D.5 нь сүлжээний аюулгүй байдлын талаарх хувь хүн, аж ахуйн нэгжийн ойлголт, хариу арга хэмжээтэй холбоотой. Кибер аюулгүй байдлын зэрэгцээ хувь хүнд учрах дарамт, ташаа мэдээлэлтэй холбоотой асуудлыг E сэдэвт дор авч үзсэн болно.

### XD.1 Үндэсний компьютерын халдлагад хариу үзүүлэх баг (КХХБ) болон түүнтэй адилтгах бүтцийг оролцуулан олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн, олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоог хангасан үндэсний кибер аюулгүй байдлын стратегитай эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон улсын эрх, хэм хэмжээнд нийцсэн, олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоог хангасан кибер аюулгүй байдлын стратегитай эсэх;
- Үндэсний КХХБ болон түүнтэй адилтгах бүтэц, түүний үр дүнтэй байдлыг нотлох баримт.

---

[7] Кибер аюулгүй байдлын тодорхойлолт нь өөр өөр байж болох тул судлаачид уг үзэл баримтлалд ямар тайлбар өгч байгаагаа илэрхийлэх ёстой.
[8] Кибер гэмт хэргийн тодорхойлолтууд өөр өөр байж болно. Үнэлгээ нь дотоодын хууль эрх зүйн орчин болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC) зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрийг баримтална.

### XD.2 Цахим гэмт хэрэг болон компьютерын системтэй холбоотой бусад гэмт хэргийг мөрдөн шалгах олон улсын болон бүс нутгийн эрхийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцсэн тогтолцоотой эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Цахим гэмт хэрэг болон бусад гэмт хэргийг мөрдөн шалгах эрх зүйн орчин, онлайн нотлох баримт.

### XD.3 Цахим худалдааны хэрэглэгчдийг зохих хамгаалалтаар хангадаг онлайн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн зохицуулалтын орчин бий эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагаас хэрэгжүүлж, аж ахуйн нэгжийн даган мөрдөх хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийг нотлох баримт;
- Онлайн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой гомдол, шүүхийн болон иргэний хэргийн тоо (болон чиг хандлага);
- Онлайн залилан, гэмт хэргээс сэргийлэх хамгаалалтын талаарх ойлголт.

### XD.4 Сүүлийн 3 жилийн хугацаанд тухайн улсад кибер аюулгүй байдлын томоохон зөрчил гарсан эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Мэдээлэгдсэн зөрчлийн тохиолдол ба шинж чанар, өртсөн хувь хүн болон аж ахуйн нэгжийн тоо;
- Хэрэглэгч, бизнес эрхлэгч, бусад сонирхогч талын интернэтийн аюулгүй байдлын талаарх ойлголт;
- Үндэсний түвшний домэйн нэрийн фишинг, спам, боттой хамааралтай өгөгдөл.

### XD.5 Хувь хүн, аж ахуйн нэгж кибер аюулгүй байдлын талаар хангалттай мэдлэгтэй байж, аюулгүй байдал болон хувийн нууцад учирч болох эрсдэлийг бууруулах арга хэмжээ авдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагаас хэрэгжүүлдэг кибер аюулгүй байдлын мэдлэг олгох хөтөлбөр байдаг эсэх;
- Төрийн болон бизнесийн байгууллагын кибер аюулгүй байдлын мэргэшсэн ажилтны тоо;
- Хувь хүний эзэмшиж буй өгөгдлийг хамгаалах зэрэг кибер халдлагын эсрэг авах хариу арга хэмжээний төлөвлөгөө, бизнес эрхлэгчдийн ойлголтыг нотлох баримт;
- Нэг сая хүнд ногдох аюулгүй интернэт серверийн тоо, одоогийн байдлаар болон өмнөх жилүүдийн байдлаар;
- Хамгийн сүүлийн үеийн вирусний эсрэг программаар хамгаалагдсан интернэт хэрэглэгчдийн эзлэх хувь;
- Хувь хүн, аж ахуйн нэгжийн ашигладаг нууцлалын үйлчилгээ.

Нууцлал, нэрээ нууцлахтай холбоотой хууль болон хэрэглээнд хамаарах R ангиллын E.5 асуултын өгөгдөл/нотлох баримтыг анхаарч, эшлэл хийх хэрэгтэй.

# Сэдэв E • Интернэтийн эрх зүйн болон ёс зүйн асуудал

Интернэтийг хувь хэрэглэгчдэд сөргөөр нөлөөлөх эсхүл интернэтэд итгэх итгэл, найдварыг алдагдуулах байдлаар ашиглаж байгаад ихээхэн анхаарах болжээ. Үүнд, гэмт хэрэг, залилан, хувийн мэдээллийг хулгай; дарамт, бэлгийн хүчирхийлэл; хүчирхийллийг өдөөсөн үзэн ядалт, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, хөгжлийн бэрхшээл болон бусад хувийн шинж чанартай холбоотойгоор ялгаварлан гадуурхах; интернэтийг “хуурамч мэдээ” тараах, ташаа мэдээлэл, гуйвуулга (хуурамч баримт бичиг, эвлүүлэг зураг гэх мэт) болон суртал ухуулгын зорилгоор ашиглах[106] зэрэг орно. Эдгээр асуудал, тэдгээрийн учир шалтгааныг Интернэтийн түгээмэл байдлын хүрээнд авч үзэх шаардлагатай.

Энэ хүрээнд гарч буй олон асуудал нь хууль эрх зүй болон ёс зүйн үр дагавартай байдаг. Онлайн болон оффлайн гэмт

хэрэг, дарамт, ялгаварлан гадуурхалтай холбоотой үндэсний хууль эрх зүйн орчин нь улс орнуудад өөр өөр байдаг нь дайн мөргөлдөөний дараах эвлэрэл зэрэг улс орны онцлог шинж чанартай холбоотой.

Асуулт E.1, E.2 нь засгийн газар болон олон талт сонирхлын бүлгүүд интернэтийн эдгээр асуудлыг хэрхэн авч үздэгтэй холбоотой. Асуулт E.3 нь хувь хүмүүсийн интернэтийн талаарх ерөнхий ойлголттой, асуулт E.4, E.5, E.6 нь тодорхой асуудлын талаарх ойлголттой холбоотой. Эдгээр асуултад ангилсан, чиг хандлагын өгөгдөл онцгой ач холбогдолтой.

### XE.1 Олон улсын болон бүс нутгийн эрхийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцсэн интернэтийн ашиглалтаас үүдэлтэй хууль эрх зүй, ёс зүйн асуудлыг шийдвэрлэх үндэсний бодлогын тогтолцоо бий эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Үзэн ядалт, ялгаварлан гадуурхал, хүчирхийллийг өөгшүүлэх зэрэг асуудал болон бусад ёс зүйн сорилт, онлайн болон оффлайн орчныг зохицуулах олон улсын болон бүс нутгийн эрхийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцсэн үндэсний бодлого, хууль эрх зүйн тогтолцоо, үнэлгээ байдаг эсэх.

### XE.2 Интернэтийн ёс зүйн асуудалтай холбоотой олон талт сонирхлын бүлэг болон хувийн хэвшлийн өөрийгөө зохицуулах байгууллага байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбогдох олон талт сонирхлын бүлэг болон өөрийгөө зохицуулах байгууллага байдаг эсэх.

### XE.3 Тухайн улсын хэмжээнд интернэтийн ашиг тус, эрсдэл, нөлөөллийг хүмүүс хэрхэн хүлээж авдаг вэ?

Шалгуур үзүүлэлт:

- Өрхийн судалгаа болон санал асуулгын үр дүнгээр гарсан интернэтийн ашиг тус, эрсдэл, нөлөөллийн талаарх ойлголт, хүйсээр ангилсан байдлаар.

### XE.4 Интернэт хэрэглэгчид интернэтийг бүрэн ашиглахад саад болж буй бусад хэрэглэгчийн зүгээс ирсэн дарамт, хүчирхийллийн талаар мэдээлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Онлайн үйлчилгээ эрхлэгчийгийг мэдээлэх зохицуулалт зэрэг онлайн дарамт, хүчирхийллийн талаар мэдээлэх механизмтай эсэх;
- Интернэт хэрэглэгчдэд, ялангуяа хүн ам зүй болон нийгмийн тодорхой бүлэгт (эмэгтэйчүүд, үндэстэн ястан, үндэстний цөөнх, нийгмийн идэвхтнийг оролцуулан) ирсэн дарамт шахалт эсхүл хүчирхийллийн талаар өгсөн мэдээлэл.

### XE.5 Тухайн улсын интернэт хэрэглэгчид дотоодын хууль тогтоомжид кибер гэмт хэрэг болон интернэттэй холбоотой гэмт хэрэг гэж тодорхойлсон үйлдэлтэй тулгардаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Дотоодын хууль тогтоомжид заасан кибер гэмт хэрэг, интернэттэй холбоотой гэмт хэргийн тодорхойлолт;
- Дотоодын хууль тогтоомжид кибер гэмт хэрэг гэж тодорхойлсон үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан тоо, чиг хандлага;
- Өрхийн судалгаа, санал асуулга болон бусад эх сурвалжаас авсан интернэт болон интернэтийн контентын талаарх ойлголт.

### XE.6 Онлайн мэдээллийн эх сурвалжийн агуулгыг засгийн газар, гадаадын засгийн газар, арилжааны болон намын ашиг сонирхлоор тодорхойлдог болон удирддаг гэдэгт хувь хүн итгэдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Онлайн мэдээллийн чанар, найдвартай байдлыг хангах, мэдээллийг гуйвуулсан, хуурамч мэдээллийн тархалт ба нөлөөллийн үнэлгээний талаарх засгийн болон сонирхогч бусад тал мэдээллийг баталгаатай, эрх бүхий эх сурвалжаас авсан нотолгоо;
- Өрхийн судалгаа, санал асуулгын үр дүнгээс авсан интернэт болон интернэтийн агуулгын талаарх ойлголт.




# 9

# Эх сурвалж баталгаажуулах арга хэрэгсэл

2017 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр, Йордан улс. Сирийн хилийн ойролцоох Мафрак муж дахь Сирийн дүрвэгсдэд зориулсан Заатари хуаранд байрлах нарны цахилгаан үүсгүүрийн киоскт гар утас, цэнэглэгч, адаптер болон бусад электрон тоног төхөөрөмжийг байрлуулжээ. Киоск нь интернэтэд холбогдож, таблет болон компьютероор тоноглогдсон. Түүнчлэн уг киоск нь гар утас болон бусад цахилгаан хэрэгслийг цэнэглэх станц, хуарангийн хүүхэд залуучуудад зориулсан цахим сургалтын төв байдлаар ажилладаг ажээ.

© UNICEF/Herwig

Энэ бүлэгт судалгааны арга зүй, ёс зүйн талаарх зааварчилгааны эх сурвалжийн товч жагсаалтыг оруулав.

Гуравдугаар бүлэгт авч үзсэн нөхцөл байдлаас хамаарах шалгуур үзүүлэлтийн эх сурвалжийг тухайн бүлэгт болон харгалзах төгсгөлийн зүүлтээр оруулсан болно.

Уг бүлэгт энэхүү баримт бичгийн 4-өөс 8 дугаар бүлэгт тусгагдсан ROAM ангилал тус бүрийн шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд ашиглаж болох нийтлэг эх сурвалж, баталгаажуулах аргачлалыг оруулсан болно. Улс орон бүрд судалгааны явцад нэмэлт эх сурвалж гарч болох тул дараах мэдээллийг иж бүрэн лавлах эх сурвалж бус, харин зааварчилгаа хэмээн үзэх нь зохимжтой.

Олон улсын эх сурвалжид нэн буурай хөгжилтэй болон бага орлоготой улс орнуудаас илүүтэйгээр гол төлөв өндөр хөгжилтэй болон дунд орлоготой улс орнуудын мэдээлэл түлхүү агуулагддаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Ийм учраас үнэлгээнд зарим улс оронд тоон нотолгоог, зарим улс оронд чанарын нотлох баримтыг илүүд үздэг.

# Судалгааны арга зүйн эх сурвалж

Энэхүү баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийн хүрээ нь тоон болон чанарын олон төрлийн эх сурвалж бүхий өргөн хүрээний эх сурвалж, арга зүйг хамардаг. Судлаачдын үнэлгээний үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс судлах ёстой арга зүйн өргөн хүрээний ном бүтээлүүд байдаг. Судлаачдыг дэмжих практик гарын авлага, шалгуур үзүүлэлтийг ашигласан үнэлгээ нь илүү үр дүнтэй байх болно.

Түүнчлэн судлаачид судалгааны арга зүйтэй холбоотой ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой. Өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах нь мэдээлэл олж авах эрх, хувийн нууцыг хамгаалах эрх зэрэг хүний хэд хэдэн эрхэд нөлөөлөх төдийгүй өгөгдөл хамгаалах зэрэг олон улсын хэм хэмжээ болон дотоодын хууль тогтоомжоос хамаардаг. Судлаачид судалгааны арга зүй, холбогдох дотоодын хууль тогтоомжтой холбоотой ёс зүйн стандарт зарчмыг даган мөрдөх ёстой. Тухайлбал:

- Agresti; C. Franklin & Klingenberg, B. (2017). Statistics: The Art and Science of Learning from Data (4th Ed.)[107]
- P.Alasuutari,L.Bickman,J.Brannan&J.Brannen(2008).The SAGE Handbook of Social Research Methods[108]
- R. M. Groves, F. J. Fowler, M. P. Couper, J. M. Lepkowski, E. Singer & R. Tourangeau (2009). Survey Methodology[109]
- НҮБ-ын Хүний эрхийн комисс (2012). Хүний эрхийн үзүүлэлт: Хэмжигдэхүүн ба хэрэгжүүлэх гарын авлага.[110]

# Шалгуур үзүүлэлтийн эх сурвалж

Энэ бүлгийн үлдсэн хэсэг нь ROAMX хүрээний тодорхой асуулт, шалгуур үзүүлэлтийн эх сурвалжийг хамарсан болно.

# Ангилал R • Эрх

**Ерөнхий зүйл**

- Энэхүү сэдвийн оршил хэсэгт тодорхойлсон 6 баримт бичигт хүний эрхийн олон улсын эрх зүйн орчныг тусгасан. Үүнд:
  - Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ);[111]
  - Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП);[112]
  - Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭТОУП);[113]
  - Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (АҮАҮБХУТОУК);[114]
  - Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭЯГБХУТК);[115]
  - Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭТК).[116]

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей “Хүний оффлайн орчинд эдэлдэг эрхийг онлайн орчинд нэгэн адил хамгаалах ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрч, [117] НҮБ-ын Хүний эрхийн хорооноос 2016 онд гаргасан “Интернэт дэх хүний эрхийг хангах, хамгаалах, эдлэх тухай” тогтоолд энэ талаар болон цахим орчин дахь хүний эрхтэй холбоотой бусад асуудлыг тусгасан.[118]

Тодорхой бүс нутагт хамааралтай бүс нутгийн дараах эрхийн гэрээнүүд байдаг. Үүнд:

- Хүний эрхийн тухай Америкийн конвенц;[119]
- Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн харти;[120]
- Хүний эрхийн тухай Арабын тунхаг;[121]
- Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенц.[122]

Интернэт болон эрхийн талаарх ерөнхий асуудлыг тусгасан ЮНЕСКО-гийн дор дурдсан тайлан, баримт бичиг байдаг. Үүнд:

- *CONNECTing the Dots, хурлын үр дүнгийн баримт бичиг, 2015;*[123]
- *Хүртээмжтэй мэдлэгийн нийгмийг дэмжих үндсэн тулгуур, 2015;*[124]
- *Энх тайван, тогтвортой хөгжлийн төлөөх Мэдлэгийн нийгмийн алсын харааг шинэчлэх нь, 2013;*[125]
- *Интернэтийн эрх чөлөөний тухай цуврал тайлан.*[126]

Түүнчлэн ЮНЕСКО-гоос зөвшөөрсөн олон улсын болон бүс нутгийн баримт бичгийг онлайнаар үзэж болно.[127] Олон байгууллага үндэсний эрхийн тогтолцоог үнэлэх шалгуур үзүүлэлтийн хүрээг боловсруулсан. Тухайлбал:

- Европын зөвлөл, *Интернэтийн эрх чөлөөний үзүүлэлт* (бодлогын орчныг бүрдүүлэх);[128]
- Freedom House, *Сүлжээн дэх эрх чөлөө*;[129]
- Дэлхийн эдийн засгийн форум, *Сүлжээний бэлэн байдлын индекс*, 2016 – байгаль орчны дэд индекс.[130]

Улс орнуудын хүний эрхийн үндэсний орчин, хууль эрх зүйн орчны харьцуулсан үнэлгээг хэд хэдэн засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагууд хийсэн. Тухайлбал:

- Freedom House, “*Сүлжээн дэх эрх чөлөө*” улсын үнэлгээ;[131]
- Хил хязгааргүй сэтгүүлчид, *Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс*;[132]
- V-Dem хүрээлэн, *Ардчиллын олон талт байдал* –сонгуулийн ардчиллын индекс болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний өргөтгөсөн үзүүлэлт гэх мэт.[133]
- Дэлхийн эдийн засгийн форум, *Сүлжээний бэлэн байдлын индекс*, – байгаль орчны дэд индекс[134] Онлайн эрхтэй холбоотой хөгжлийн талаарх бусад мэдээллийг дараах баримт бичгүүдээс авах боломжтой. Үүнд:
- Интернэт ба харьяаллын төсөл, Retrospect мэдээллийн сан;[135]
- Хувийн нууцлал, өмч, интернэт засаглалын менежментийн хувилбар, MAPPING бодлогын ажиглалт.[136]

2017-2018 онд дэлхийн нээлттэй, хүртээмжтэй бөгөөд олон талт сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааны хүрээнд ЮНЕСКО-гоос Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлт (ИТБШҮ)-ийн хүрээг боловсруулсан. Энэхүү ажлыг 2018 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-гийн Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөрт танилцуулж, улмаар тус хөтөлбөрийн удирдах зөвлөлөөс оролцогч талыг интернэтийн хөгжлийн үндэсний үнэлгээг хийхэд уг аргачлалыг сайн дурын үндсэн дээр ашиглахыг дэмжсэн шийдвэрийг гаргасан[1].

Энэхүү хүрээ нь засгийн газрын бодлого, зохицуулалтын эрх бүхий байгууллага болон бусад сонирхогч талуудад дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор өргөн хүрээтэй судалгаа, зөвлөлгөөн, дүн шинжилгээ хийх замаар боловсруулсан чухал ач холбогдолтой баримт бичиг юм. Үүнд:

- Үндэсний интернэт орчин, бодлогын талаар тодорхой бөгөөд бодитой ойлголтыг бий болгох;
- ЮНЕСКО-гийн эрх, нээлттэй байдал, хүртээмжтэй байдал, олон талт оролцооны (ROAM) зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой орчин, бодлогыг үнэлэх;
- Интернэт хөгжихийн хэрээр зорилгодоо хүрэх, ЮНЕСКО-гийн зарчимд нийцүүлэх боломжийг олгохуйц бодлогын зөвлөмж, бодитой санаачилгыг гаргах.

Энэхүү бүлэгт Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг улс орнуудын харилцан адилгүй нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд судлаачдад туслах гарын авлагыг оруулав.

## Хэрэгжүүлэх гарын авлага

ИТБШҮ-ийн хүрээний зөвлөлдөх үйл явцын хүрээнд зохион байгуулсан хэлэлцүүлэг, ИТБШҮ-ийн урьдчилсан туршилт ба туршилтын хэрэгжүүлэлтийг хийсэн судлаач, оролцогч талуудын туршлагад тулгуурлан энэхүү гарын авлагыг боловсруулсан. Судалгааны төслийн зохион байгуулалт, удирдлага, хэрэгжүүлэлт болон болзошгүй зарим асуудлыг авч үзсэн энэхүү гарын авлагыг цаашид шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх туршлага, интернэтийн шинэ хөгжилтэй уялдуулан шинэчлэх юм.

## Үндсэн шалгуур үзүүлэлт, хэсэгчилсэн үнэлгээ

ИТБШҮ нь үндэсний интернэт орчныг үнэлэх цогц тогтолцоог бүрдүүлдэг. ЮНЕСКО-гоос ашиглах боломжтой нотлох баримтаас үндэсний интернэт орчны талаарх мэдээллийн санг аль болох бүрэн хөгжүүлэхийн тулд энэхүү хүрээг бүхэлд нь ашиглах зүйтэй хэмээн үзэж байна.

Гэвч цогц хүрээг хэрэгжүүлэхэд судалгааны багагүй цаг хугацаа, ихээхэн туршлага шаардах бөгөөд үүнийг бүх тохиолдолд хангаж чадахгүйг ЮНЕСКО хүлээн зөвшөөрч байна. Иймд иж бүрэн үнэлгээ хийхэд хангалттай нөөц байхгүй тохиолдолд цогц хүрээнд багтсан шалгуур үзүүлэлтүүдээс товч бөгөөд илүү төвлөрсөн багц үндсэн шалгуур үзүүлэлтийг санал болгосон. Уг цогц хүрээнд ROAM-X ангилал тус бүрээс хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг багтаасан[2].

Түүнчлэн ЮНЕСКО зарим улсын засгийн газар, бусад оролцогч талыг ROAM-X ангиллын дагуу хэсэгчилсэн үнэлгээ хийх хүсэлтэй байж болохыг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү хүрээний ROAM-X шалгуур үзүүлэлтийн ихэнх нь судлаачдад онцгой сонирхол татаж буй асуудалд илүү анхаарах боломжийг олгодог учраас "Toolbox” (хэрэгслийн хайрцаг) арга тохиромжтой.

Үндэсний интернэт туршлагын тодорхой хэмжигдэхүүнийг авч үзэх зэргээр бие даасан ангиллыг ашиглаж болно. ЮНЕСКО-гоос шалгуур үзүүлэлтийг дээрх байдлаар ашиглах нь тохиромжтой хэмээн үздэг хэдий ч судалгааны үр дүнд бий болсон төсөөлөл, төлөв байдалд нөлөөлөх салангид шалгуур үзүүлэлтийг сонгон хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.

Эдгээр ROAM-X шалгуур үзүүлэлтийн цаашдын хэрэглээ бол сургалтын үйл ажиллагаа юм. Сургагч багш интернэт засаглалын нийлмэл цогц байдлын талаар суралцагчдад заахдаа энэхүү олон улсын хэрэгслийг ашиглахыг зөвлөж, эдгээр шалгуур үзүүлэлтэд тусгагдсан хэмжигдэхүүний талаар мэдлэгтэй байх шаардлагатай.

[1] Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөрийн хорооны 31 дүгээр чуулганаас гаргасан шийдвэр, 2018 оны 11 дүгээр сарын 21-22, ЮНЕСКО-гийн төв байр. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000266235
[2] Үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн өмнөх хувилбарыг 2018 онд Бразил, Сенегал, Тайланд зэрэг улсад амжилттай туршсан бөгөөд үр дүнг эцсийн хувилбарт оруулсан.

# 2. Шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх

ИТБШҮ-ийн хүрээ нь бодлого боловсруулагч, зохицуулах байгууллага, сонирхогч бусад талд бодит ач холбогдолтой, улмаар шийдвэр гаргах болон практик хэрэглээг сайжруулахад чиглэсэн үндэслэлтэй бөгөөд өргөн хүрээний үр дүнд хүрэх зорилготой олон талт судалгааны аргачлал юм. Тухайн улс оронд шалгуур үзүүлэлтийг хэрэглэхэд төсвийг нарийвчлан тооцоолж, шаардлагатай хөрөнгийг бүрдүүлэх шаардлагатай. ЮНЕСКО энэ талаар дэмжих хэдий ч ихэнх тохиолдолд шаардагдах зардлыг бүрэн санхүүжүүлэх боломжгүй. Иймээс засгийн газар, хувийн хэвшил, сан болон бодит хувь нэмэр (жишээ нь, эрдэм шинжилгээний байгууллагын оролцоо), нөөцийг ашиглах нь энэ үйл ажиллагааны нэг хэсэг болно. Нөөцийг бүрдүүлэгч, хандивлагч талууд тодорхой байх ёстой хэдий ч судалгааны гүйцэтгэл нь тэднээс хараат бус байх ёстой.

Энэхүү хүрээг хэрэгжүүлэхэд нарийн төлөвлөлт, хэрэгцээт мэдээллийг цуглуулах болон дүн шинжилгээ хийх хангалттай хугацаа ба нөөцөөс гадна үр дүн болон зөвлөмжийг хэлэлцэх хэлэлцүүлгийг зохион байгуулах шаардлагатай. Үйл ажиллагааны дор дурдсан үндсэн 8 үе шатыг санал болгож байна болно. Үүнд:

- Үйл ажиллагааны алхам 1: Олон талт сонирхлын бүлгүүдээс бүрдсэн зөвлөх багийг байгуулах;
- Үйл ажиллагааны алхам 2: Судалгааны багийг бүрдүүлэх;
- Үйл ажиллагааны алхам 3: Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;
- Үйл ажиллагааны алхам 4: Мэдээлэл цуглуулах, эх сурвалжийг тодорхойлох;
- Үйл ажиллагааны алхам 5: Өгөгдлийн шинжилгээ хийх;
- Үйл ажиллагааны алхам 6: Тайлан бичих, зөвлөмж өгөх;
- Үйл ажиллагааны алхам 7: Үндэсний баталгаажуулалтын олон талт сонирхлын бүлгийн семинарыг зохион байгуулж, холбогдох нөлөөллийн үйл ажиллагааг явуулах;
- Үйл ажиллагааны алхам 8: Нөлөөллийг үнэлэх, мониторинг хийх.

Эдгээр үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй авч үзье.

## Үйл ажиллагааны алхам 1: Олон талт сонирхлын бүлгүүдээс бүрдсэн зөвлөх багийг байгуулах

ИТБШҮ-ийг ашиглан үндэсний үнэлгээ хийхэд зөвлөх багийг заавал байгуулахыг шаардахгүй ч тухайн нөхцөл байдал нь бие даасан судалгаа хийх боломжийг олгох үед уг багийг байгуулж болно.

ЮНЕСКО ИТБШҮ-ийг амжилттай боловсруулахад төрөл бүрийн мэргэжил, сонирхлын чиглэлээр ажилладаг бие даасан шинжээчдээс бүрдсэн олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх баг (ОТСБЗБ) ихээхэн дэмжсэн. Иймд ЮНЕСКО-гоос хэрэв нөхцөл байдал боломжтой бол үндэсний үнэлгээнд үүнийг нэгэн адил хэрэгжүүлэх боломжтой хэмээн үзэж байна. Иймээс судалгаа хийхийн өмнө өргөн хүрээний олон талт оролцоотой зөвлөх багийг байгуулж, үндэсний хэмжээний үнэлгээний үйл явцыг дэмжих болон үр дүнгийн талаарх бодлогын хэлэлцүүлгийг эхлүүлэхэд тогтмол оролцуулахыг зөвлөж байна. ЮНЕСКО-гийн үндэсний хороод болон оролцогч бусад тал ОТСБЗБ-ийг байгуулахад тодорхой үүрэгтэй оролцож болно. Түүнчлэн МХХТ эсхүл цахим эдийн засгийн бодлогын болон зохицуулагч байгууллагууд төдийгүй үндэсний статистикийн алба, интернэтийн гол оролцогч талуудыг хүртээмжтэй, ил тод байдлаар татан оролцуулахыг зөвлөж байна.

### 1.1 Зөвлөх багийн зорилго

Олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх баг нь үндэсний хэмжээний үнэлгээний чанар, хууль ёсны байдал, ил тод байдлыг баталгаажуулах зорилготой. Түүнчлэн тус баг нь хандив, оролцооны хэлбэрээр үнэлгээг хийх хангалттай нөөцийг бүрдүүлэх замаар үнэлгээг үр дүнтэй нөлөөлж чадахуйц өндөр стандартын дагуу хийхэд тусална.

### 1.2 Зөвлөх багийн бүрэлдэхүүн

Багийн гишүүн бүр интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг ашиглахтай холбоотой судалгааны зарим чиглэлээр мэргэшсэн, туршлагатай мэргэжилтэн байх ёстой.

Олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх багийг засгийн газар (бодлогын болон зохицуулагч байгууллага), эрдэм шинжилгээний байгууллага, техникийн хороо, хувийн хэвшил, сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгэм, интернэт хэрэглэгч хувь хүн, НҮБ-ын агентлаг болон засгийн газар хоорондын бүлгийг хамруулсан төрөл бүрийн оролцогч талын тэргүүлэх мэргэжилтэн, шинжээч нараар бүрдүүлэх нь тохиромжтой. ИТБШҮ-д хийсэн урьдчилсан туршилт, туршилтын хэрэгжүүлэлт нь албан ёсны мэдээллийн эх сурвалжид хандах боломжийг олгоход засгийн газрын оролцоо онцгой чухал болохыг батлан харуулсан.

ОТСБЗБ нь уламжлалт сонирхогч талуудын бүлэг (засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм, интернэтийн техникийн нийгэмлэг)-ээс гадна ийм бүлгийн олон талт байдлыг (жишээ нь, интернэтийн бизнес хэрэглэгч төдийгүй интернэтийн үйлчилгээ эрхэлдэг бизнесмен) тусгасан байх шаардлагатай. ОТСБЗБ-ийн газар зүйн болон жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж, залуучууд ялангуяа жендер болон хүүхэд/залуучуудын асуудлаар ажилладаг мэргэжилтнийг оролцуулах шаардлагатай.

Баг нь 8-18 гишүүнтэй, цомхон байх нь зохимжтой.

Багийн гишүүд тухайн төслийг ямар нэг байгууллагын төлөөллийн хувиар бус, мэргэжлийнхээ түвшинд дэмжиж ажиллах үүрэгтэй. Хамгийн чухал нь гишүүд итгэл үнэмшилтэй, үнэ цэнийг нэмэгдүүлэх чадвартай байхаас гадна төлөөлж буй салбар, бүлгийнхээ төлвийг тодорхойлох чадвартай байх ёстой. Тэдний үүрэг бол хянан засварлах бус, зөвлөх явдал юм.

ОТСБЗБ-ийн гишүүдэд цалин хөлс олгохгүй, гэхдээ эцсийн тайланд тэдний оролцоог дурдаж болно (хэрэв тэд хүсвэл).

### 1.3 Ажлын даалгавар

ОТСБЗБ-ийн гишүүд үнэлгээний нөөц болон мэдээллийн эх сурвалжийг судлаачдад санал болгож, тэдгээрт хандах боломжийг олгоход дэмжин туслах үүрэгтэй.

Гишүүн бүр холбогдох цахим шууданд хариу өгөх, ОТСБЗБ-т ажиллахад шаардлагатай цөөн цагийг 2 сар тутамд зарцуулах боломжтой байж, зөвлөлдөх уулзалт, арга хэмжээнд биечлэн ба/буюу онлайнаар аль болох зардал гаргахгүйгээр оролцохыг эрмэлзэх ёстой.

Гишүүн бүр эцсийн тайланг хэвлэгдэхээс өмнө хамтран хянан засварлахад туслах үүргийг хүлээнэ. Энэ үүргийн хүрээнд судалгааны үр дүнг үгүйсгэх, ашиг сонирхлын үүднээс нөлөөлөх бус, харин судалгааны чанар, дүгнэлт болон зөвлөмжийн уялдаа холбоог, цаашилбал тухайн ажлыг хэрхэн сайжруулах асуудлыг авч үзнэ.

ОТСБЗБ-ийн гишүүд судалгааны төгсгөлд болох үндэсний хэмжээний баталгаажуулах семинарт идэвхтэй оролцож, үнэлгээний үр дүнд тулгуурлан гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд засгийн газар, бизнес эрхлэгч, бодлого боловсруулагчидтай хамтран ажиллах шаардлагатай.

### 1.4 ЮНЕСКО-гийн дэмжлэг

ЮНЕСКО нь Үндэсний комисс ба/буюу үндэсний салбар комиссоороо дамжуулан олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх багийг байгуулахад ерөнхий дэмжлэг, техникийн туслалцаа үзүүлж, төлөөллөө гишүүн эсхүл ажиглагчаар ажиллуулдаг.

Тус байгууллага засгийн газар хоорондын хөтөлбөр, тухайлбал, Бүх нийтийн мэдээллийн хөтөлбөрөөр дамжуулан дэмжлэг үзүүлж болно. Бүх нийтийн мэдээллийн хөтөлбөр нь үндэсний хороодын сүлжээгээр дамжуулан ROAM-X шалгуур үзүүлэлтийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэсний оролцогч талуудтай хамтран ажиллах боломжтой.

## Үйл ажиллагааны алхам 2: Судалгааны багийг бүрдүүлэх

ИТБШҮ-ийн судалгааны ажлыг цомхон бөгөөд өндөр ур чадвартай судалгааны баг гүйцэтгэнэ. Уг багт харилцан адилгүй түвшний мэдлэг, туршлагатай 5-8 судлаачийг оролцуулж болно. Эдгээр судлаачдын нэг нь тухайн судалгааг амжилттай гүйцэтгэхэд бүхэлд нь хариуцлага хүлээх багийн ахлагч байна. Багийн ахлагч нь ОТСБЗБ-ийг байгуулах болон ажиллуулахад хувь нэмрээ оруулж, холбоо барих хүнээр ажиллах үүргийг хүлээнэ.

### 2.1 Судалгааны багийн бүрэлдэхүүн

ИТБШҮ-ийн хүрээг интернэтийн төрөл бүрийн чиглэлээрх өргөн хүрээний туршлагатай судлаачдын багт ашиглах боломжтойгоор боловсруулсан. ЮНЕСКО судалгааны туршлагыг онцлон анхаарч, судалгааны багт судалгаа шинжилгээний туршлагатай судлаачдын зэрэгцээ интернэтийн хөгжил, хүртээмж, эрхийн чиглэлээр ажилладаг төрөл бүрийн оролцогч талын төлөөллийг оролцуулах нь ихээхэн үр дүнтэй хэмээн үзэж байна. Судалгааны багийн үндсэн бүрэлдэхүүн нь судалгааны явцад болон үр дүнгийн баталгаатай байдлыг хангахад, түүний дотор дараагийн зөвлөмжид хамааралтай талуудыг оролцуулан хэтийн төлөвийн бүрэн хүрээг авч үзэхэд тусална. Эдгээр чиглэлийн дагуу судалгааны баг нь зөвлөмжийн илүү хүртээмжтэй бөгөөд төлөөлөхүйц байдлыг хангаж, интернэт нийгмийн бүлэгт үзэл бодлыг давуу эрх олгохоос илүүтэйгээр улс орны ашиг сонирхлыг бүхэлд нь хангахад анхааран ажиллана.

Судалгааны багийг бүрдүүлэхэд дор дурдсан асуудлыг авч үзэх шаардлагатай. Үүнд:

- Баг нь тухайн улсын хүн ам зүйн олон янз байдал, түүний дотор хүйс, төрөл бүрийн насны бүлэг, үндэс угсаа, бүс нутгийн онцлогийг тусгасан байна.
- Баг нь ROAM-X шалгуур үзүүлэлтийн ангилал тус бүрээр мэргэшсэн, доод тал нь нэг гишүүнтэй байж, төрөл бүрийн мэргэжилтнээс бүрдсэн байна.
- Багийн бүрэлдэхүүнд интернэт инсайдер болон мэдлэг туршлага нь интернэттэй холбоогүй боловч түүний эдийн засаг, нийгэм, соёлд үзүүлэх нөлөөллийн талаар голчлон анхаардаг мэргэжилтнийг оруулна.

Судалгааны багийн гишүүд интернэт, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн талаарх төрөл бүрийн үзэл бодолтой байх ёстой. Иймд судалгааны багийг зөвхөн интернэтийн талаар тодорхой үзэл бодолтой хүмүүсээр бүрдүүлэх бус, харин түүний ирээдүйн талаарх олонургалчүзэл бодол болон санааны талаар ярилцах орон зайг бий болгоход анхаарах хэрэгтэй.

Судалгааны багийн олон талт байдлыг хангахаас гадна, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхдээ зөвхөн интернэтийн мэргэжилтний үзэл бодол, туршлагыг тусгах бус, интернэт хэрэглэгчид болон интернэтийн хэрэглэгч бус олон бүлгийн үзэл бодол, туршлагыг тусгахад онцгой хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Энэ нь багийн зүгээс эмэгтэйчүүд, хүүхдүүд, янз бүрийн насны хүмүүс, цагаачид болон дүрвэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бэлгийн цөөнх, янз бүрийн хэлний бүлгийн хүмүүсийн үзэл бодолд мэдрэмжтэй хандах шаардлагатай гэсэн үг.

## Үйл ажиллагааны алхам 3: Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Судалгааны багийг байгуулсны дараа дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

а) Тухайн багийн хүрээнд судалгааны төслийн зорилгын талаар нэгдсэн ойлголтыг бий болгох;

б) Боломжит төсвийн хүрээнд ажлын төлөвлөгөө боловсруулах;

в) Төсөл хэрэгжих явцад багаараа хэрхэн хамтран ажиллах талаар харилцан тохиролцох.

### 3.1 Зорилгоо тодорхойлох

Өмнө дурдсанчлан, ИТБШҮ-ийг засгийн газар болон бусад оролцогч талын дор дурдсан үйл ажиллагаанд туслах зорилгоор боловсруулсан. Үүнд:

- Үндэсний интернэт орчны талаар тодорхой бөгөөд бодитой ойлголтыг бий болгох;
- ЮНЕСКО-гийн ROAM зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн орчныг үнэлэх;
- Интернэт хөгжихийн хэрээр дэвшүүлсэн зорилгодоо ЮНЕСКО-гийн зарчим, олон улсын жишигт нийцүүлэн хүрэх боломжийг олгох бодлогын чиг хандлага болон практик санаачилгыг боловсруулах.

Эдгээр өргөн хүрээний зорилт нь ИТБШҮ-ийн хүрээний бүх хэрэглээнд хэрэгжих магадлалтай ч, шалгуур үзүүлэлтийг улс орнуудад хэрэгжүүлэхэд тухайн улс орны тодорхой асуудал бэрхшээл болон боломжийн талаар хэлэлцэх, бодлогын бусад үйл явц болон үндэсний тэргүүлэх чиглэлд тусгах шаардлагатай. Тухайн улсын хувьд зарим шалгуур үзүүлэлт нь бусдаас илүү ач холбогдолтой байж, улмаар бүх талын судалгааг түлхүү шаардаж болно. Иймд төслийн зорилгыг эхнээс нь тодорхой болгож, тохиролцох нь чухал. Үүнийг дээр дурдсан 3 зүйлд нийцүүлэн боловсруулах, тохируулах, үндэсний хэмжээнд шийдвэрлэх шаардлагатай аливаа тодорхой асуудлыг авч үзэх замаар хийх шаардлагатай.

Төслийн зорилго болон онцгой анхаарал хандуулах шаардлагатай тэргүүлэх чиглэлийг ойлгомжтой тодорхойлох нь судлаачдын цаашдын хамтын ажиллагааг хөнгөвчилдөг. ИТБШҮ-ийн урьдчилсан туршилт, туршилтын хэрэгжүүлэлтээс харахад ийм төслийн зорилго, тэргүүлэх чиглэлийн тодорхойлолт нь засгийн газар болон бизнес эрхлэгчдийн эзэмшдэг мэдээлэл зэрэг эх сурвалжид хандах хүртээмжийг сайжруулахад шаардлагатай хууль ёсны болон найдвартай байдлыг илэрхийлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

## 3.2 Ажлын төлөвлөгөө боловсруулах

Зорилгоо тодорхойлсны дараа судалгааны баг төслийн боломжит хугацаа болон нөөцөд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулахад хангалттай хугацааг төлөвлөн мэдээлэл цуглуулах боломжийг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулна.

Ажлын төлөвлөгөөний нарийвчилсан загвар нь тухайн төслийн нөхцөл байдал, тухайлбал, эцэслэн тодорхойлсон зорилго, оролцогч байгууллага, нотлох баримтын бэлэн байдал, үндэсний нөхцөл байдлын бусад асуудлаас хамаарна. Олон хүн амтай томоохон улсыг судлах нь арлын жижиг мужтай харьцуулахад харилцан адилгүй сорилт, асуудлыг бий болгодог. Судалгаанд гол төлөв доод тал нь 6-8 сарыг зарцуулдаг.

Ажлын төлөвлөгөөг гаргахдаа дор дурдсан асуудлыг онцгой анхаарах шаардлагатай. Үүнд:

- Шаардлагатай бол шалгуур үзүүлэлтийн тайлбар, үзүүлэлт тус бүрийг шалгах арга хэрэгсэл, мэдээллийн эх сурвалж;
- Судалгааны багийн гишүүдийн ажил, үүргийн хуваарилалт;
- Бэлтгэл ажил, судалгаа, дүн шинжилгээ, тайлангийн хуваарь;
- Багийн гишүүдийн ажил үүргийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах арга зүй.

ИТБШҮ-ийн хүрээ нь Creative Commons тусгай зөвшөөрлийн дагуу нээлттэй хандалттай тул ИТБШҮ-ийн хэрэглээний үр дүнгийн тайланг ЮНЕСКО-гоос хараат бусаар нийтэлж болно. Гэвч ЮНЕСКО нь хэвлэн нийтлэгч байх үед тухайн байгууллага нь хэвлүүлэх бичвэрийн чанарын баталгааны эрхийг эзэмших бөгөөд ийм тохиолдолд тухайн байгууллагын хянан шалгах үйл явцад тодорхой хугацааг тогтоож өгөх хэрэгтэй. Энэ талаарх нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл ЮНЕСКО-той холбоо барина уу.

Ажлын төлөвлөгөө нь ИТБШҮ-ийг хэрэгжүүлэх бодитой бөгөөд эрүүл орчинг бүрдүүлсэн, уян хатан байвал зохино. Жишээлбэл, тодорхой хэсэгт нотлох баримтыг олж авахад гарсан гэнэтийн асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх гэх мэт. Ажлын төлөвлөгөөний гол хугацаанд өөрчлөлт оруулах эсэхийг хянан нягтлах шаардлагатай.

Судалгааны баг хэрэгжилтийн явцад судалгаа, дүн шинжилгээг бүртгэх, удирдах зорилгоор төслийн удирдлагын программ хангамжийг ашиглах нь илүү ач холбогдолтой байдаг.

## 3.3 Судалгааны багийн зохицуулалт

ЮНЕСКО-гийн Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтийн туршлагаас харахад судалгааны багийн үр дүнтэй байдал, хамтын ажиллагаа, зохицуулалтыг хангах нь чухал ажээ.

Багийн гишүүд өөр өөр ангилал болон ажлын чиглэлээр (жишээлбэл, тодорхой ангилалд) тэргүүлэх хариуцлагыг хүлээж болох ч тус тусдаа судалгаа, дүгнэлт хийх шаардлагагүй. ЮНЕСКО-гоос багийн хэд хэдэн гишүүн хамтран ажиллагсадтайгаа хамтарч судалгаа хийх, ангилал тус бүрийн хамтарсан үнэлгээнд оролцох шаардлагатай хэмээн зөвлөдөг. Энэ нь аливаа асуудлыг төслийн дараагийн үе шатанд шийдвэрлэхээр үлдээхээс илүүтэйгээр судалгааны явцад гарсан маргаан болон маргаантай асуудалд тохирох төрөл бүрийн туршлага, хэтийн төлөвийг бий болгоход маш чухал.

Ийм нөхцөлд дор дурдсан зүйлийг эхнээс нь тодорхойлох нь илүү ач холбогдолтой байх болно. Үүнд:

- Судалгааны багийн гишүүд ажлын тодорхой чиглэлийг хариуцан ажиллах;
- Тухайн чиглэлээр багийн бусад гишүүд туслан дэмжих үүрэгтэйгээр ажиллах;
- Багийн хүрээнд онлайнаар эсхүл нүүр тулсан хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах;
- Төслийн дүгнэлт, зөвлөмжийн төслийг боловсруулах, хэлэлцэх ажлыг зохицуулах.

# Үйл ажиллагааны алхам 4: Мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох

Тухайн улс оронд ROAM-X шалгуур үзүүлэлтийн хүрээг хэрэгжүүлэхэд хийгдэх гол ажил бол мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох үйл ажиллагаа болно. Энэ үе шат нь нотлох баримтын тоо хэмжээ, чанар, олдоцоос хамааран улс орнуудад ихээхэн ялгаатай байж болно.

Гарын авлагын энэ хэсэгт мэдээлэл цуглуулах ерөнхий цар хүрээ, боломжит эх сурвалж болон нотлох баримтыг олж авах, ашиглахад гарч болзошгүй зарим хүндрэл, асуудлыг авч үзнэ. Нотлох баримтын дүн шинжилгээтэй холбоотой асуудлыг 6 дугаар хэсэгт авч үзэх болно.

## 4.1 Мэдээлэл цуглуулах цар хүрээ

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд мэдээлэл цуглуулах ажлын цар хүрээг тусгах шаардлагатай (дээрх хэсгээс харна уу). Энэ нь шалгуур үзүүлэлтийг тухайн улсын онцлог, нөхцөл байдалд нийцүүлэх, тохируулах талаарх хэлэлцүүлгээс эхлэнэ.

- Ихэнх шалгуур үзүүлэлт маш тодорхой, ойлгомжтой байдаг бол зарим шалгуур үзүүлэлтийг нийцүүлэн тохируулах, тайлбарлах шаардлага гардаг тул энэ тухай судалгааны явцын болон эцсийн тайлангийн аль алинд нь тодорхой тусгах шаардлагатай.
- Хэлэлцүүлгийг тухайн багт холбогдох шалгуур үзүүлэлтийг шалгах аргачлалыг тодорхой байлгахад чиглүүлнэ.
- ROAM-X шалгуур үзүүлэлтийн хүрээний холбогдох бүлэгт тодорхойлсон эх сурвалжаас гадна улсын хэмжээнд нээлттэй эх сурвалжийг тодорхойлохын тулд цогцоор нь үнэлж дүгнэх шаардлагатай.
- ЮНЕСКО-гоос энэхүү тоймд дор дурдсан зүйлийг тусгахыг зөвлөж байна. Үүнд:
- Тоон мэдээллийн албан болон албан бус эх сурвалж, эрдэм шинжилгээний болон бусад судалгааны тайлан, баталгаатай бөгөөд эрх бүхий чанарын эх сурвалжийг тодорхойлох бүтээлийн тойм, хэвлэгдээгүй мэдээллийг авах боломжтой агентлаг, байгууллага;
- Засгийн газрын агентлаг, бизнес эрхлэгч болон бусад байгууллагатай тэдний эзэмшиж болох хэвлэгдээгүй нотлох баримтыг ашиглах талаар цахим шуудангаар болон утсаар харилцах;
- Нотлох баримтын нэмэлт эх сурвалжийг олж тогтоох, харилцаа холбоо тогтоох зорилгоор гол мэдээлэгчтэй (Олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх багийн гишүүдийг оролцуулан) хэлэлцүүлэг хийх.

Бүлгийн хэлэлцүүлэг болон түүвэр асуулгын судалгаа, тухайлбал, жендер болон залуучуудын асуудалтай холбоотой хэрэглэгч, хувь хүний туршлагын талаарх мэдээлэл цуглуулах судалгааг авч үзэж болно.

Эх сурвалжийг тодруулах нь судалгааны багт дараах боломжийг олгодог. Үүнд:

- Мэдээлэл цуглуулах хуваарийг бодитой гаргах (урьдчилсан судалгаа, мэдээлэгчтэй ярилцлага хийх болон бусад эх сурвалжийг оролцуулан);
- Судалгааны ажилд зарцуулах хугацаа, нөөцийн хуваарилалтыг эцэслэх (судалгааны багийн ажил үүргийн хуваарилалтыг оролцуулан);
- Үнэлгээний явцад хийх боломжгүй болон анхан шатны судалгаа хийх шаардлагатай асуудлыг тодруулах.

Эдгээр төлөвлөлттэй холбогдох бүтээлийн тойм судалгаанд боломжит эх сурвалжийн ихэнхийг тодорхойлдог бол бусдыг нь дараагийн судалгааны явцад тодорхойлж болох бөгөөд гагцхүү төсөл хэрэгжих явцад шаардлагатай үед нь нэгтгэх боломжтой байх ёстой.

## 4.2 Эх сурвалж

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд зохион байгуулалт, тоон, чанарын үзүүлэлт гэсэн үндсэн гурван төрлийн эх сурвалжыг тусгаж, энэ хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Судлаачид нотлох баримтын төрөл бүрийн эх сурвалж, шалгах арга хэрэгслийг тодорхойлох бөгөөд тэдгээрийн заримыг олон төрлийн шалгуур үзүүлэлтэд, заримыг нь тодорхой шалгуур үзүүлэлтийн ангилалд ашиглана.

Дээрх 3 төрлийн үзүүлэлт нь судлаачдад ИТБШҮ-ийн хүрээг бүрдүүлдэг ангилал хоорондын уялдаа холбоог баталгаажуулах нотлох баримтуудыг нэгтгэсэн байдлаар гаргах боломжийг олгодог.

Баталгаажуулах эх сурвалж, арга хэрэгслийн талаарх ерөнхий зааварчилгааг энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээний холбогдох бүлэгт ангилал, ангилал тус бүрийн сэдэв тус бүрээрх боломжит эх сурвалжийг санал болгосон. Сэдэвтэй

холбоотой баримт бичгийг ихэвчлэн дараах 2 үндсэн бүлэгт хуваадаг. Үүнд:

- Эхний бүлэгт ашиглах боломжтой, холбогдох сэдвийг авч үзэх үед хэрэг болохуйц ерөнхий эх сурвалжийг (жишээлбэл, "албан ёсны нийтлэл, тайлан", үндэсний хороо, зөвлөлийн тайлан, тухайлбал, "хүний эрхийн үндэсний хороо, зөвлөлийн тайлан", "төрийн үйлчилгээний хэрэглэгчдийн санал асуулга", "домэйн нэрийн бүртгэл", "МХХТ-ийн ажиглалтын байгууллагын тайлан" гэх мэт) тодорхойлдог. Эдгээр нь зарим талаараа улс орон бүрд ялгаатай, өмнө дурдсанчлан бүтээлийн тойм судалгааны явцад тодорхойлогдох тодорхой улс оронд хамаарах эх сурвалж байж болно.
- Хоёр дахь бүлэгт тухайн улсын төдийгүй бусад улстай холбоотой нотлох баримтыг агуулж болох олон улсын гэрээний баримт бичиг, стандарт, НҮБ-ын агентлагууд, Дэлхийн банк болон засгийн газар хоорондын бусад байгууллагаас эмхэтгэн гаргасан олон улсын индекс, олон улсын төрийн бус байгууллагын үнэлгээ зэрэг хэвлэн нийтлэгдсэн эх сурвалжийг тодорхойлдог.
- Албан ёсны мэдээлэл болон бусад нотлох баримтыг олж авах үйл явц улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Мэдээллийн нээлттэй бодлоготой зарим улсын тухайд албан ёсны мэдээлэлд хандахад илүү хялбар байдаг. ИТБШҮ-ийн урьдчилсан туршилт, туршилтын хэрэгжүүлэлтээс харахад мэдээллийн нээлттэй бодлогыг хараахан хэрэгжүүлээгүй (эсхүл хэрэгжүүлдэггүй) улс оронд өгөгдөлд хандахад илүү хүндрэлтэй байдаг аж. ИТБШҮ-ийг хэрэгжүүлэх судалгааны төсөлд засгийн газар уг асуудлыг шийдвэрлэхэд, ялангуяа засгийн газрыг төлөөлж буй оролцогчид судалгааны багийн нэрийн өмнөөс хандах албан ёсны хүсэлт гаргах боломжтой тохиолдолд тусална.

## 4.3 Зөвлөгөөн, мэдээлэгчтэй хийх ярилцлага, бүлгийн хэлэлцүүлэг

ROAM-X шалгуур үзүүлэлтийн хүрээг нотлох баримтад ашиглах боломжит эх сурвалж, ялангуяа бичгийн эх сурвалжийг ашиглахаар боловсруулсан. Судалгааны баг анхан шатны судалгааг заавал хийх шаардлагагүй хэдий ч сайн дураар шаардлагатай тодорхой өгөгдөл мэдээлэл нь өмнө хийгдсэн судалгаа, мэдээллийн санд байхгүй тохиолдолд анхан шатны судалгааг хийж болно.

Судалгааны баг албан ёсны үүрэг хариуцлага хүлээсэн болон тодорхой шалгуур үзүүлэлтийн ангиллаар мэргэшсэн холбогдох талуудтай ярилцлага, хэлэлцүүлэг хийх замаар судалгааны дутууг нөхөж болно.

- ЮНЕСКО-гийн Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтийн туршлагаас харахад нийтлэгдсэн болон хэвлэгдээгүй нэмэлт эх сурвалжийг тодорхойлох, мэдээлэгч/шинжээчийн үзэл бодлыг ойлгох зэргээр илүү тодорхой бөгөөд баттай нотлох баримтын санг бүрдүүлэхэд мэдээлэгчтэй (төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад оролцогчдын зарим нь) хийх ярилцлага чухал ач холбогдолтой байдаг.
- Түүнчлэн гол мэдээлэгчдийг хамруулсан бүлгийн хэлэлцүүлэг үр дүнтэй байдаг нь энэ төрлийн бусад судалгааны төслүүдээс харагддаг. Голлох мэдээлэгчдийг нэгтгэх нь судлаачдад асуудлыг өөр өөр өнцгөөс харах боломжийг олгодог. Ийм хэлэлцүүлгийн бүлэг нь хэлэлцэж буй асуудлын талаар төрөл бүрийн үзэл бодолтой мэргэжилтнүүдээс бүрддэг тул нийгэм, эдийн засгийн тодорхой бүлгийг төлөөлдөг оролцогчдоос бүрддэг фокус бүлгээс ялгаатай.

Бусад шалгуур үзүүлэлтийн хүрээ болон энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээг боловсруулсан туршлагаас харахад нээлттэй бөгөөд ил тод зөвлөлдөх хэлэлцүүлгээр дамжуулан сонирхогч талуудыг оролцуулах нь судалгааны багт чухал ач холбогдолтой аж. Энэ нь төслийг чиглүүлэх бус, харин байгаа судалгаа болон нөөцөд нэмэлт байдлаар хэрэглэгдэх юм. Зөвлөлдөх хэлэлцүүлгийн явцад олж авсан нотлох баримтад хувийн ашиг сонирхлоор хандахаас зайлсхийж, маш болгоомжтой хандах хэрэгтэй. Ил тод байдлыг дэмжих, зүй бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд зөвлөлдөх хэлэлцүүлгийн үр дүнг цахим орчинд нийтлэх нь зүйтэй.

Зөвлөлдөх хэлэлцүүлгийн үр дүнд цуглуулсан нотлох баримтыг тайлбарлах материалын нотолгооноос ялгаж, нэмэлт нотолгооноос тусад нь анхааралтай авч үзэх шаардлагатай. Нэг шинжээч эсхүл хэд хэдэн шинжээчийн хэлсэн ижил зүйл нь тухайн асуудлыг үнэн зөв гэж үзэх эсхүл ерөнхийд нь дүгнэх үндэслэл болж чадахгүй. Ямар ч тохиолдолд эцсийн тайланг гаргахад ийм төрлийн нотлох баримтыг холбогдох ажиглагчаар заавал баталгаажуулсан байхыг анхаарна уу (нотлох баримтыг ерөнхийд нь үнэлэх талаар 5.1 дүгээр хэсгийг үзнэ үү).

## 4.4 Мэдээллийн зөрүүг арилгах

Ихэнх улс орны нотлох баримтын сангийн өгөгдөл мэдээлэл илэрхий зөрүүтэй байх нь бий. Энэ нь бусад багц шалгуур үзүүлэлтийн индекс, урьдчилсан туршилт болон туршилтын хэрэгжүүлэлтээс харахад ялангуяа нэн буурай хөгжилтэй улс орон, жижиг арал, үндэсний статистикийн үйлчилгээний удирдлага болон мэдээлэл цуглуулах нөөц боломж хязгаарлагдмал улс оронд түгээмэл аж. Зарим улс оронд зөвхөн цөөн тооны шалгуур үзүүлэлтийн хүрээнд нотлох баримт цуглуулах боломжтой байдаг.

Иймд энэхүү хүрээг мэдээллийн хомсдолоос үүдэлтэй асуудлыг шийдвэрлэх үүднээс боловсруулсан бөгөөд энэ нь аливаа улс орны ойлголтыг нэмэгдүүлэх, бодлого боловсруулалтын чанарыг сайжруулахын тулд аль болох олон нотлох баримтыг нэгтгэх зорилготой. ЮНЕСКО-гоос үүнийг нотлох баримтын сан хязгаарлагдмал улс оронд илүү чухал гэж үздэг. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд олон тооны шалгуур үзүүлэлтийг оруулсан нь ямар ч улс оронд олж тогтоох боломжтой нотлох баримтын хүрээг нэмэгдүүлэх, улмаар мэдээлэл хязгаарлагдмал байсан ч энэ талаарх ойлголтыг сайжруулах, бодлого боловсруулахад хувь нэмэр оруулах зорилготой. Ангилал тус бүрд хамаарах нотлох баримтын холбогдох эх сурвалжийг "Эх сурвалж" бүлэгт дурдсан бөгөөд ийм нотлох баримтыг төслийн төлөвлөлтийн эхний үе шатанд судалгааны багийн гишүүд тодорхойлдог. Судлаачид бүрэн хэмжээний зураглалыг гаргахын тулд төрөл бүрийн эх сурвалжийг нэгтгэж, аль болох хамгийн их төлөөлөлтэй бөгөөд сүүлийн үеийн өгөгдлийг ашиглахыг чухалчлах шаардлагатай.

Зарим боломжит эх сурвалжийг өмчлөх (төлбөртэй болон захиалгын бүртгэлээр) болон арилжааны зорилгоор хувийн хэвшил, бизнес эрхлэгчдээс цуглуулж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийн эзэмшигч ИТБШҮ-ийн үнэлгээг дэмжих үүднээс зарим мэдээллийг үнэ төлбөргүй ашиглуулах нь бий. Түүнчлэн зарим онлайн үйлчилгээ эрхлэгчийн сурталчилгааны платформ болгон сурталчилгаа хийх замаар олон нийтэд хүртээмжтэй болгодог мэдээлэл зэрэг төлөвлөөгүй болон тодорхойгүй сурвалжаас холбогдох мэдээллийг авах боломжтой.

Өгөгдөл мэдээллийн мөн чанар, хүртээмжтэй холбоотой асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг үндсэн 3 төрлийн үзүүлэлт тус бүрээр авч үзье.

## 4.5 Зохион байгуулалтын нотлох баримт

Энэхүү хүрээний зарим шалгуур үзүүлэлт нь үндсэн хууль болон эрх зүйн тодорхой зохицуулалт, тэдгээрийг хэрэгжүүлэх, мөрдүүлэх засгийн газрын агентлаг болон бусад "эрх бүхий" (өөрөөр хэлбэл, хариуцах) байгууллагын ажлын гүйцэтгэлтэй холбоотой.

Үндсэн хуулийн болон эрх зүйн зохицуулалттай холбоотой нотлох баримтыг албан ёсны хэвлэл, мэдээлэгчээс авахад харьцангуй хялбар байдаг. МХХТ-ийн бодлогын болон зохицуулагч байгууллага зэрэг төрийн байгууллага, бусад эрх бүхий байгууллагын ажлын гүйцэтгэлтэй холбоотой нотлох баримт нь төрөл бүрийн эх сурвалжид суурилсан дүн шинжилгээ хийхийг шаарддаг. Эдгээр эх сурвалж нь улс орнуудад өөр өөр байж болох ч засгийн газрын тайлан мэдээ, хууль эрх зүйн баримт бичиг, хэвлэл мэдээллийн тайлан, эрдэм шинжилгээний болон иргэний нийгмийн эх сурвалжийн дүн шинжилгээг багтаадаг.

Зарим тохиолдолд асуулт, үзүүлэлт нь засгийн газраар хүлээн зөвшөөрөгдсөн болон соёрхон баталсан олон улсын тодорхой баримт бичигт хамаарна. Энэ нь ялангуяа R ангилалд хамааралтай бөгөөд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП/ICCPR), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт (ЭЗНСЭТП/ ICESCR), Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭТК/CRC), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭЯГБХУТК/CEDAW) зэрэг олон улсын эрхийн гэрээ хэлэлцээрт хамаарах хэд хэдэн үзүүлэлт байдаг. Эдгээр баримт бичиг, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулж буй бүс нутгийн хэмжээний гэрээ хэлэлцээр нь хүний эрхийн тухай хууль тогтоомж болон хэрэгжилтийн олон улсын стандартыг тогтоодог.

Тэдгээрийг хэрэгжүүлэх, мөрдүүлэхтэй холбоотой нэмэлт удирдамжийг НҮБ-ын Хүний эрхийн хорооноос хүлээн зөвшөөрсөн баримт бичгүүдээс авах боломжтой. Эдгээрийг "Эх сурвалж" бүлэгт эш татсан болно.

Олон хэл, соёлын өв зэрэг чиглэлээрх ЮНЕСКО-гийн гэрээ хэлэлцээр зэрэг засгийн газар хоорондын олон тооны гэрээ хэлэлцээр нь тодорхой асуулт, үзүүлэлтэд хамаарах бөгөөд "Эх сурвалж" бүлэгт эшлэгдсэн болно. Зарим тохиолдолд, олон улсын хэм хэмжээ болон стандартыг засгийн газар хоорондын хэлэлцээр болон бусад сонирхогч талын хооронд байгуулсан хэлэлцээр үл хамааран албан ёсны төдий эсхүл хууль ёсны үүрэг багатайгаар боловсруулсан байдаг. Олон талт сонирхлын бүлгээр дамжуулан ба/буюу интернэтийн мэргэжилтэн болон бизнес эрхлэгчдийн бүлгээр хэлэлцэн тохиролцсон хэлэлцээр нь О ангилалд (нээлттэй байдал) хамаарна. Эдгээр төрлийг "Эх сурвалж" бүлэгт эш татсан болно.

Өдгөө интернэт засаглалын асуудлыг авч хэлэлцдэг олон улсын олон форум байдаг бөгөөд хязгаарлагдмал нөөцтэй судалгааны төслийн хувьд тэдгээрийг бүгдийг нь судлах боломжгүй. Иймээс зарим тохиолдолд олон улсын тодорхой жишиг гэрээ хэлцэл болонзохицуулалтыг үзүүлэлт болгон сонгодог. Жишээлбэл, М ангиллын зарим үзүүлэлт (олон талт сонирхлын бүлэг), тухайлбал, дэлхий, бүс нутгийн болон үндэсний Интернэт засаглалын форум, Олон улсын цахилгаан холбооны байгууллага, Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага гэсэн олон улсын 3 байгууллагын зохицуулалт дахь олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоонд илүү төвлөрдөг. Эдгээр байгууллага нь олон тооны оролцогч улсыг эгнээндээ нэгтгэсэн, бараг бүх тохиолдолд хамааралтай байх магадлалтай тул сонгосон болно. Судлаачид хэрэв хүсвэл холбогдох бусад олон улсын форумд оролцох боломжтой.

Эдгээр (болон бусад) асуулт, үзүүлэлтийн зарим нэр томьёоны тайлбар нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг. ЮНЕСКО-гоос олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт, стандарт байхгүй тохиолдолд уг хүрээг

хэрэгжүүлэхэд судалгааны багийг тодорхой тодорхойлолтыг гаргахыг хязгаарладаг. Шалгуур үзүүлэлт нь үндсэндээ үндэсний хэмжээний судалгааны хэрэгсэл болдог тул судалгааны баг нэр томьёог үндэсний хэмжээнд ойлгогдохуйц тайлбарлах, тэдгээрийн утга агуулгыг оновчтой тодорхойлох, орон нутгийн онцлогоос хамаарсан боломжит нэмэлт тайлбарыг тусгах нь илүү тохиромжтой.



## 4.6 Тоон нотлох баримт

Энэхүү хүрээний зарим шалгуур үзүүлэлт нь олон янзын эх сурвалжаас авч болох тоон мэдээлэлд тулгуурладаг. Үүнд:

- Үндэсний статистикийн газар, бусад анхдагч эх сурвалжийн тайланд тулгуурласан НҮБ-ын агентлагийн боловсруулсан олон улсын мэдээллийн багц;
- Төрөл бүрийн аргаар боловсруулсан засгийн газрын мэдээллийн багц;
- Засгийн газар, засгийн газар хоорондын агентлагийн цуглуулсан мэдээллээс илүү арилжааны зорилгоор цуглуулсан хамгийн сүүлийн үеийн бизнесийн мэдээлэл (Зарим бизнес эрхлэгч ийм мэдээллийг арилжааны нууц гэж үздэг бол зарим нь өөрийн зар сурталчилгааны платформоор дамжуулан олон нийтэд зориулж нийтэлдэг);
- Төрийн байгууллага, бие даасан судалгааны төв, эрдэмтэн судлаачид болон бусад хүмүүсийн нийт хүн амын дундаас түүврийн аргаар хийсэн өрхийн судалгаа;
- Тоон мэдээллийн бусад эх сурвалж.

Тоон өгөгдөл мэдээллийг тодорхой үзэл баримтлал, хамрах хүрээ, судалгааны аргаар тодорхойлох шаардлагатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй (5.4 дүгээр хэсгийг үзнэ үү). Олон жилийн түүхтэй үндэсний статистикийн албатай улс орнуудад энэхүү хүрээний олон тоон шалгуур үзүүлэлтэд шаардагдах албан ёсны өгөгдөл мэдээлэл байдаг бол ийм албагүй олон улс оронд тоон өгөгдөл хангалтгүй байдаг. Ийм нөхцөлд бизнес эрхлэгчдээс ирүүлсэн мэдээлэл, эрдэм шинжилгээний судалгаа, өрхийн судалгаа зэрэг тоон мэдээллийн бусад боломжит эх сурвалжийг тодорхойлж, ашиглах нь тун чухал.

Бизнес эрхлэгчдийн арилжааны зорилгоор цуглуулж, хадгалдаг өгөгдөл мэдээллийн хэмжээ нь ихэнх засгийн газарт байдаг, ялангуяа хүртээмжтэй байдал гэх мэт асуудлаарх мэдээллээс хангалттай их байдаг. Бизнес эрхлэгчид гол төлөв ийм мэдээллийг олон нийтэд дэлгэх сонирхолгүй байдаг ч зарим мэдээллийг, тухайлбал, интернэтийн талаарх ойлголтыг тайлбарлан түгээх, холбогдох бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бэлтгэн гаргаж болно. Иймд судалгааны баг нь төслийн төлөвлөлт, зохиомжийн эхний үе шатаас эхлэн ийм арга замаар ажиллах шаардлагатай.

*Ангилан задлах нь*

Энэхүү хүрээний зарим тоон шалгуур үзүүлэлт нь ангилсан болон нэгтгэсэн өгөгдлийн үнэлгээ хийхийг шаарддаг. Ангилан задлах гэдэг нь нийт хүн амаас түүвэрлэн авсан хүн амын төрөл бүрийн бүлгээр шалгуур үзүүлэлтийн нийт өгөгдлийг тус тусад нь тоон үзүүлэлтээр задлахыг хэлнэ. Жишээлбэл, эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд, тодорхой насны бүлэг (хүүхэд, өндөр настан гэх мэт), бүс нутаг (жишээ нь, хот ба хөдөө эсхүл холбооны засаглалтай улс орны өөр өөр муж), угсаатны болон хэлний бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт нийгмийн олон янзын бүлгийн интернэтийн хүртээмж, нөлөөллийг авч үзэхэд маш чухал юм.

Түүнчлэн боломжтой бол салбар дамнасан, өөрөөр хэлбэл, хувь хүний үр дүнд нөлөөлөх олон тооны хүчин зүйлс (жишээ нь, хүйс, үндэс угсаа, орлого) болон тэдгээрээс үүдэлтэй бодлогын шаардлага хоорондын хамааралд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Харамсалтай нь, ИТБШҮ-ийн урьдчилсан туршилт, туршилтын хэрэгжүүлэлтийн үр дүнгээс харахад олон улс оронд одоогоор бэлэн байгаа цөөн тооны өгөгдлийн багцыг ангилан задлах боломжтой байдаг аж. Иймд судлаачид боломжтой гаргалгааг эрэлхийлэх шаардлагатай. Өрхийн судалгаа болон түүнтэй адилтгах түүвэр судалгаа нь гол төлөв албан ёсны статистик мэдээллээс илүү дэлгэрэнгүй байдаг. Түүнчлэн бизнес эрхлэгчдээс ихэвчлэн нийтэлж гаргахаар зэхэж байснаас нь илүү дэлгэрэнгүй задлан ангилсан мэдээллийг авч болно. ЮНЕСКО-гоос задлан ангилсан мэдээллийн асар их эрэлт хэрэгцээ нь цаашид засгийн газар болон үндэсний статистикийн байгууллагыг илүү их анхаарахад түлхэц болно хэмээн үзэж байна.

## 4.7 Чанарын нотлох баримт

Энэхүү хүрээний зарим шалгуур үзүүлэлт нь чанарын нотлох баримттай, өөрөөр хэлбэл, үндэсний интернэт орчинд болж буй үйл явдлын статистик бус үнэлгээтэй хамааралтай. Чанарын нотлох баримт нь тоон нотлох баримтаас дутуугүй үнэ цэнтэй, гүнзгий ойлголттой байдаг бөгөөд энэ хоёр төрлийн нотлох баримт нь бие биеэ харилцан нөхөж, аль аль нь интернэтийн түгээмэл байдалд үр дүнтэй шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой.

ИТБШҮ-ийн хүрээнд чанарын нотолгоо маш чухал. Учир нь:

- Олон шалгуур үзүүлэлт нь тоон хэмжилтийн явцад тогтмол байдаг болон хамаардаггүй;
- Тоон хэмжилтийн үр дүнг хүртэгчдэд тоон мэдээлэл байдаггүй.
- Чанарын нотлох баримтыг үнэлэхэд дор дурдсан төрөл бүрийн эх сурвалжаас авсан нотлох баримтыг авч үзнэ. Үүнд:
- Засгийн газар, бизнес эрхлэгч, иргэний нийгмийн болон бусад байгууллагын тайлан;
- Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн судалгаа;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн мэдээ;
- Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, хэлэлцүүлгийн бүлэг.

Чанарын нотлох баримтыг тоон мэдээллийн нэгэн адил тодорхой ойлголт, хамрах хүрээ, судалгааны аргаар гаргаж авдаг бөгөөд тэдгээрт тулгуурлан үнэлдэг.

## 4.8 Ойлголтын талаарх нотолгоо

Энэхүү хүрээний цөөн тооны шалгуур үзүүлэлт нь хүн амын тодорхой бүлэгтэй холбоотой.

МХХТ болон бусад салбарын бодлогыг үр дүнтэй боловсруулахад хэрэглэгчдийн (болон хэрэглэгч бус хүмүүсийн) ойлголт, зан үйлдлээр илрэх хандлагыг тусгахад ихээхэн анхаарч ирсэн. Үүнтэй холбоотой нотлох баримт нь,тухайлбал, эмэгтэйчүүдэд тулгарч буй саад бэрхшээл, хүүхдийн интернэтийн хэрэглээ, интернэтийн хууль эрх зүйн болон ёс зүйн асуудлын талаарх үзэл бодлыг өөрчлөх зэрэгт маш чухал юм. Иймд ойлголтын талаарх асуултыг ихэвчлэн өрхийн судалгаа болон бусад түүвэр тоон судалгаа төдийгүй зөвлөлдөх хэлэлцүүлэг, фокус бүлгийн ярилцлага болон бусад аргаар олж авсан нотлох баримтыг ашигласан чанарын судалгаанд оруулдаг.

## 4.9 Анхан шатны судалгаа

Шалгуур үзүүлэлтийн хүрээг анхан шатны судалгааг шинээр хийхээс илүүтэй бэлэн байгаа нотлох баримтыг ашиглах зорилгоор боловсруулсан.

Гэвч зарим тохиолдолд бэлэн нотлох баримтын санг өргөжүүлж, судалгааны өмнө болон судалгааны явцад илэрсэн зарим зөрүүг нөхөж чадах анхан шатны судалгаа хийх нөөц бололцоотой байх хэрэгтэй. Энэ нь судалгаа шинжилгээний ерөнхий бүтцийг өөрчлөхгүйгээр (жишээ нь санхүүжүүлэгч байгууллагын зорилгод хэт нийцүүлэх гэх мэт) илүү далайцтай дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргахад тусалдаг.

Анхан шатны судалгаа нь тухайн улс оронд нотлох баримтаар нотлогддог салбарт, ялангуяа тоон болон чанарын хувьд хязгаарлагдмал үед онцгой ач холбогдолтой. Энэ нь тодорхой ангилал, сэдэв (жишээлбэл, олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоо болон интернэтийн хүүхдүүдэд үзүүлэх нөлөө), тодорхой шалгуур үзүүлэлтийн төрөлтэй (жишээлбэл, одоо байгаа өгөгдлийн багцыг илүү өргөн хүрээнд задлах боломж) холбоотой байж болно.

Нөөц боломжтой тохиолдолд анхан шатны судалгаанд төрөл бүрийн арга зүйг хэрэглэх нь тохиромжтой. Үүнд:

- Ялангуяа А ангилал (Бүгдэд хүртээмжтэй байх), Х ангилалд (зангилаа асуудлууд) жендер болон хүүхэдтэй холбоотой сэдэвт ач холбогдолтой байж болох илүү өргөн хүрээний бөгөөд илүү задлан ангилсан мэдээлэл цуглуулах боломжийг олгодог өрхийн болон бусад түүвэр судалгаа;
- Энэхүү хүрээнд тусгагдсан байгууллагын зохицуулалтын зорилготой харьцуулсан гүйцэтгэлийн үнэлгээ (үүнийг холбогдох төрийн байгууллага эсхүл эрх бүхий байгууллагатай хамтран хийж болно);
- Интернэт хэрэглэгчдийн төрөл бүрийн бүлгийг оролцуулан мэдээлэгчээс авсан, нийтлэгдсэн мэдээллийн чанарын үнэлгээ, мэдээллийг сайжруулан өргөтгөж чадах фокус бүлэг;
- Аль болох илүү өргөн хүрээний мэдээлэгчтэй хийсэн ярилцлага.

Анхан шатны судалгаа нь мэргэжлийн, ёс зүйн болон нууцлалын өндөр стандартад нийцсэн байх ёстой. Тухайлбал, өрхийн судалгааны загвар ба түүврийн хэмжээ, эсхүл оролцогчдыг сонгох болон фокус бүлгийг чиглүүлэхэд стандарт аргачлалыг ашиглана. Холбогдох эх сурвалжийг энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээний холбогдох бүлэгт тодорхойлсон болно.

# Үйл ажиллагааны алхам 5: Өгөгдлийн шинжилгээ хийх



Энэ хэсэг нь үндсэндээ бие даасан шалгуур үзүүлэлт, холбогдох асуултын үнэлгээтэй холбоотой боловч сэдэв болон ангиллын ерөнхий үнэлгээг хамарна.

Судлаачид төрийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын агентлаг, үндэсний судалгааны хүрээлэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл болон бусад эх сурвалжаас авсан нотлох баримтаа найдвартай бөгөөд эрх бүхий эх сурвалжаас ирсэн эсэхийг баталгаажуулах замаар асуултын баталгаатай байдлыг хангах, боломжтой бол бусад эх сурвалжаар баталгаажуулах хэрэгтэй.

Бие даасан шалгуур үзүүлэлтийг үнэлэх нь зарим тохиолдолд илүү төвөгтэй байх нь бий. Судлаачид бодит аргыг ашиглах ёстой бөгөөд нотлох баримтыг байгаагаар нь ойлгож болохгүй. Зарим ерөнхий асуудлыг авч үзэж, улмаар энэхүү хүрээний шалгуур үзүүлэлтийн үндсэн 3 төрөлтэй холбоотой гол асуудлыг дор тодорхойлов.

## 5.1 Нотлох баримтыг ерөнхийд нь үнэлэх

Энэхүү хүрээний цөөн хэдэн шалгуур үзүүлэлт нь тэдгээртэй холбоотой асуултад бүрэн хариулт өгдөг. Эдгээр нь ердөө л шалгуур үзүүлэлт бөгөөд тэдгээрийн үр дагаврыг тайлбарлах шаардлагатай.

Судлаачдад шаардлагатай бүх нотлох баримтыг тухайн нотлох баримтыг санал болгож буй хувь хүн ба байгууллага нь тодорхой цаг үед тодорхой газарт болон тодорхой нөхцөлд тодорхой аргаар цуглуулна. Албан ёсны буюу баталгаатай эх сурвалж байхаас үл хамааран тэдгээрийг үнэлэхдээ дараах 4 бүлэг асуултыг тусгайлан авч үзэх шаардлагатай. Үүнд:

1. Эх сурвалж нь юу болох? Хэн нотлох баримтыг цуглуулав? Тэдний шалтгаан юу байв? Тэдэнд тодорхой үр дүнд хүрэх сонирхол байгаа эсэх? Тэдний үзэл баримтлал, тодорхойлолт, хамрах хүрээг илэрхийлэх ямар төсөөлөл байж болох вэ?
2. Нотлох баримтыг хэрхэн цуглуулсан бэ? Ямар нэг арга ашигласан эсэх? Тоон үзүүлэлтийн хувьд түүврийн бүлэг нь үнэн зөв эсхүл судалж буй хүн амыг (түүврийн хэмжээг оруулаад) төлөөлөх чадвартай эсэх? Фокус бүлгийн хувьд оролцогчдыг хэрхэн сонгосон, тэдгээрийн төлөөлөх байдал хэр байсан бэ? Чанарын үнэлгээний хувьд шинжээч, боловсруулагч ба тайлан болон бусад баримт бичиг нь хараат бус эсэх?
3. Нотлох баримтыг хэзээ цуглуулсан бэ? Интернэт болон интернэтийн зах зээл хурдацтай өөрчлөгдөж байна. Тухайлбал, хүртээмжтэй холбоотой өгөгдөл харьцангуй богино хугацаанд хуучирдаг. Засгийн газар солигдох ба бусад нөхцөл байдал нь эрх эдлэх ба зөрчигдөхөд гэнэт нөлөөлж болно. Судлаачид тухайн өгөгдөл нь интернэтийн хөгжлийн өнөөгийн байдлыг илэрхийлэхэд цаг хугацааны хувьд хангалттай эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй. Судалгааны эцсийн боловсруулалтыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулж болох байнгын өөрчлөлт, шинэчлэлтээс зайлсхийх үүднээс судлаачид эцэслэх хугацааг тодорхойлж, богино хугацааны дүн шинжилгээ хийхээс илүүтэй үүсэж буй чиг хандлагад анхаарахыг зөвлөж байна.
4. Энэ нь юуг илэрхийлж байна вэ? Цуглуулсан нотлох баримт нь гаргасан дүгнэлттэй нийцэж байгаа эсэх? Эдгээр дүгнэлт хэр баталгаатай вэ?

## 5.2 Олон улсын хэм хэмжээ, стандарт

Дор дурдсан 3 төрлийн хэд хэдэн шалгуур үзүүлэлт нь олон улсын хэм хэмжээ, стандартад нийцдэг. Үүнд:

- Эдгээрийн зарим нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП), Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭТК/CRC) зэрэг олон улсын эрхийн гэрээ хэлцэлд тусгагдсан хүний эрхийг хамгаалах үүрэг зэрэг засгийн газрын байгуулсан олон улсын гэрээ болон хуулиар заавал биелүүлэх бусад гэрээнд тусгагдсан байдаг. Түүнчлэн ТХЗ 9.c “Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хүртээмжийг үлэмж нэмэгдүүлж, 2020 он гэхэд нэн буурай хөгжилтэй орнуудад хямд интернэтийн хэрэглээг нийтийн хүртээл болгох”, ТХЗ 16.10. Олон нийтийг мэдээлэлд хандах болон үндсэн эрх чөлөөгөөр хангах, ТХЗ 5. Жендерийн тэгш байдлыг хангах зэрэг НҮБ-ын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт хамаарна.
- Зарим нь хэл, соёлын өвийг оролцуулан ЮНЕСКО-гийн засгийн газар хоорондын үйл явцын хүрээнд баталсан болон Нэгдсэн Үндэстний Байгууллага, засгийн газар хоорондын агентлагийн бусад хэлэлцээрийг дагаж мөрддөг олон улсын гэрээ хэлэлцээрийг багтаадаг.
- Зарим нь ЮНЕСКО, ОУЦХБ хамтран удирддаг Тогтвортой хөгжлийн өргөн зурвасын хорооноос тодорхойлсон хандалт ба хүртээмжтэй байдлын зорилт, 2003/2005 онд болсон Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалт болон 2015 онд болсон 10 жилийн тойм уулзалтаас гарсан олон талт сонирхлын бүлгүүдийн оролцооны үндэслэл болон зарчмыг засгийн газар, бизнес эрхлэгч, интернэтийн мэргэжилтнүүд өргөн хүрээнд зөвшөөрсөн.
- Үүнтэй төстэй албан бус стандарт, жишиг үзүүлэлт, зорилтыг төрийн бус байгууллага, ялангуяа R ангилалд

(Эрх) болон бизнесийн холбоодоос О ангилалд (Нээлттэй байдал) тогтоож өгсөн.

- Эдгээр аргачлал нь үндэсний интернэт орчныг үнэлэх ач холбогдолтой жишиг үзүүлэлтээр хангаж, тохирох хүрээнд оруулж өгдөг. Зарим тохиолдолд тэдгээрийг "Эх сурвалж" бүлэгт эш татсан харьцуулсан тоон болон чанарын үзүүлэлт дагалддаг. Бүс нутгийн стандарт, жишиг үзүүлэлтийг олон салбарт хүлээн зөвшөөрсөн бөгөөд эдгээрийг мөн адил авч үздэг. Тэдгээрийн тайлбарыг эх баримт бичигт үндэслэн гаргаж, харгалзах хуудасны төгсгөл болон баримт бичгийн төгсгөлд зүүлт хийснээс гадна "Эх сурвалж" бүлэгт оруулсан болно.

## 5.3 Зохион байгуулалтын нотлох баримт

Зохион байгуулалтын нотлох баримт нь дараах зүйлийн аль алинд нь хамаарна. Үүнд:

- Ангилал, шалгуур үзүүлэлттэй холбоотой үндсэн хуулийн болон бусад эрх зүйн зохицуулалт байгаа эсэх,
- Тэдгээрийг хэрэгжүүлэх, соёрхон батлахтай холбоотой төрийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагын ажлын гүйцэтгэл. "Эрх бүхий байгууллага" гэдэг нь энэ хүрээнд интернэтийн засаглал, ашиглалттай холбоотой үүрэг гүйцэтгэдэг төрийн байгууллагаас бусад агентлаг болно.

Албан ёсны үндсэн хуулийн болон эрх зүйн зохицуулалт байгаа эсэхийг тодруулах явц харьцангуй хялбар байх ёстой бөгөөд засгийн газрын бүтэц нь ихээхэн ялгаатай, хамгийн тодорхой салбарт ч зохицуулалт үргэлж байдаггүй гэдгийг санах нь зүйтэй.

Судлаачдад байгууллагын зохицуулалтын ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд илүү төвөгтэй байдаг. Өмнөх 4.5 дугаар хэсэгт дурдсанчлан, үүнтэй холбоотой нотлох баримтыг харилцан адилгүй эрх, хараат бус байдал, цогц байдал, баталгаатай байдлын төрөл бүрийн эх сурвалжаас авах боломжтой. Судалгааны баг нь харилцан адилгүй эх сурвалжаас авсан үзэл бодлын зөрүүтэй байдлыг тусгаж, олон эх сурвалжаас жишээ авч нотлох баримтыг баталгаажуулах, мөн холбогдох байгууллагууд болон тэдэнтэй харилцдаг бусад сонирхлын бүлгийн мэдээлэгчийг оролцуулан гол мэдээлэгчтэй ярилцлага хийх замаар асуудлыг судалж, нотлох баримтын санг сайтар үнэлэх шаардлагатай. Судлаачид байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх явцдаа өөрсдийн гаргасан тодорхойлолтын зөрүүтэй байдлаас үүсэх эрсдэлийг сайтар ойлгосон байх ёстой. Энэ төрлийн хэд хэдэн шалгуур үзүүлэлт нь "эрх бүхий байгууллага"-ын тайланд тусгайлан бичигдсэн байдаг. Энэхүү лавлах мэдээллийг холбогдох шалгуур үзүүлэлтэд дурдсан асуудлын талаар мэдлэгтэй, оновчтой үнэлгээ хийх хангалттай мэдээлэлтэй, мөн ашиг сонирхлын зөрчилгүй этгээдэд зориулсан болно. Энэ хүрээнд “эрх бүхий этгээд” гэдэгт төрийн байгууллагаас илүүтэй шинжээчийн төлөөллийг авч үзнэ.

Байгууллагын болон хууль эрх зүйн зохицуулалтын гүйцэтгэл нь цаг хугацааны явцад, зарим тохиолдолд гэнэт буюу огцом өөрчлөгдөж болзошгүйг анхаарах нь зүйтэй. Чанарын үзүүлэлтийг үнэлэх явцад, ялангуяа тэдгээр нь бодлогын арга барил, хууль эрх зүйн болон бусад үйл ажиллагааны хүрээ, хэрэгжилттэй холбоотой байх үед засгийн газар, хууль тогтоомж, дүрэм журмын сүүлийн үеийн өөрчлөлтийг анхаарах хэрэгтэй. Судлаачид гүйцэтгэлийн явц (жишээ нь, хүссэн үр дүн нь их эсхүл бага ажиглагдаж байгаа эсэх), судалгааны үеийн нөхцөл байдлыг харгалзан үзвэл зохино. Аливаа зөвлөмжийг гаргахдаа байгууллагын стандарт, бодит хэрэгжилт хоорондын зөрүүтэй байдлыг харгалзах нь зүйтэй.

## 5.4 Тоон нотлох баримт

Тоон мэдээллийг зарим тохиолдолд нотлох баримтын бусад хэлбэрээс илүү үнэн зөв, бодитой гэж туйлшрах нь бий. Практикт шаардлагатай дүгнэлтэд хүрэхийн тулд статистик мэдээллийг төрөл бүрийн аргаар ашиглаж болдог. Судлаачид олон төрлийн баримт бичгийг өмнөх 5.1 дүгээр хэсэгт дурдсан 4 асуултыг оролцуулан хамаарал болон баталгаатай байдлыг авч үзнэ. Судлаачдын анхаарвал зохих 4 нэмэлт асуудлыг дор дурдав. Үүнд:

- Тоон өгөгдөл мэдээллийн чанар нь мэдээлэл цуглуулах ажлын чанар, найдвартай байдлаас хамаардаг. Албан ёсны статистик мэдээлэл ч хоорондоо ялгаатай байх нь бий. Зарим илэрхий тоон мэдээллийг (НҮБ-ын зарим мэдээллийн багцад буй үндэсний зарим мэдээллийг оролцуулан) өмнөх туршлага хийгээд харьцуулах боломжтой улс орнуудын мэдээлэлд тулгуурлан тооцоолж гаргадаг. Энэ нь үргэлж ойлгомжтой байдаггүй ч баримт бичгийн төгсгөлийн зүүлт хэсгээс харах боломжтой. Өрхийн судалгаанд түүврийн хэмжээ, түүвэрлэлтийн төлөөлөх шинж чанар, мэдээлэл цуглуулах тогтсон зарчмыг дагаж мөрддөг эсэхээс шалтгаалан чанарын хувьд ихээхэн ялгаатай байдаг. Өгөгдлийн томоохон багц, тухайлбал, хөгжилтэй холбоотой асуудал бэрхшээлийг үнэлэхэд ашигладаг тодорхой бүлгийг (их орлоготой, боловсролын түвшин өндөр, тухайлбал, интернэтийг түлхүү ашигладаг хүмүүс, түүнчлэн эдгээр бүлэгт гол төлөв пропорциональ бус хамааралтай хот суурин газрын эрэгтэй хүн амын бүлгүүд) хэт их төлөөлүүлснээс үр дүнг гажуудуулж болзошгүй.
- Хэмжих боломжтой шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход хэрэглэгддэг нэр томьёо нь улс орон болон мэдээллийн багцад харилцан адилгүй байдаг. Жишээлбэл, "өргөн зурвасын" гэсэн нэр томьёог зарим улс оронд бусад улсаас хамаагүй өндөр хурдын өргөн зурвасын холболтыг тодорхойлоход ашигладаг бол зарим мэдээллийн багцад өнөөг хүртэл ОУЦХБ-ын анхны тодорхойлолтын дагуу 256 кбит/с-ээс дээш хурдаар

тооцон ашиглаж байна. Өрхийн судалгааны асуултууд нь ижил төстэй мэт боловч газар бүрд харилцан адилгүй утгатай байдаг.

- Интернэтийн зах зээлийн хурдацтай өөрчлөлт, хөгжилтэй холбоотойгоор МХХТ, интернэттэй холбоотой өгөгдөл мэдээлэл нь интернэт хэрэглэгчийн тоо, ашиглаж буй технологи, хэрэглэж буй үйлчилгээний аль аль нь эдийн засгийн бусад салбараас илүү хурдан хуучирч байна. Жишээлбэл, 3-аас дээш жилийн насжилттай интернэтийн хүртээмж, ашиглалтын тоон мэдээлэл нь хэдийн үнэ цэнээ алдсан байх магадлалтай. Иймд судалгаанд ашигласан өгөгдөл мэдээллийг аль болох үнэлгээ хийгдэж буй цаг үетэй ойртуулахад анхаарах хэрэгтэй.
- Энэ хүрээнд цөөн тооны өгөгдөл мэдээлэл нь энгийн хариулттай байх бөгөөд ихэнх нь тодорхой хэмжээгээр нөхцөл байдлаас хамаарсан тайлбарыг шаарддаг. Үүрэн холбооны өргөн зурвасын бүртгэлтэй хэрэглэгчийн тоо нь олон улс оронд өөр өөр байдаг нь тухайлбал, олон хүн нэгээс олон сүлжээнд бүртгэлтэй байдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл, улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Олон талт сонирхлын бүлгүүдийн оролцооны үйл явцад "идэвхтэй" оролцоо гэдгийг нөхцөл байдлаас хамааран өөр өөр утгаар авч үзнэ. Судлаачид тоон мэдээллийн чанар, найдвартай байдалд эргэлзэх тохиолдолд энэ талаар үнэлгээний эцсийн тайланд тодорхой тусгах ёстой.

Эцэст нь тоон шинжилгээнд статистикийн хувьд хэмжигдэхүйц зүйлийг үнэлэх нь тоон тодорхойлолт багатай зүйлийг хэт чухалчлах эрсдэл гарах нь бий. Ийм эрсдлээс зайлсхийх, бууруулахын тулд судлаачид нэгдсэн дүгнэлт гаргах шаардлагатай.

## 5.5 Тоон өгөгдлийн чиг хандлага

Тоон өгөгдлийн багц байнга давтагдах нь интервенц хаана хамгийн үнэ цэнтэй болохыг тодорхойлоход туслах чиг хандлагын талаарх нотолгоог харуулж, улмаар бодлогын болон практик зөвлөмж өгөхөд тусалдаг. Судлаачид олж тогтоосон үр дүндээ урт хугацааны хэтийн төлөвийг харуулахын тулд давтагддаг өгөгдлийн багцыг ашиглах хэрэгтэй.

Хэдийгээр шалгуур үзүүлэлтийн хүрээ нь үнэлгээ хийх үеийн туршлагын талаар товч мэдээллийг өгөх зорилготой боловч өөрчлөлтийн цар хүрээ, хурдыг үнэлэхийн тулд өмнөх жилүүдийн мэдээллийг хамгийн сүүлийн үеийн боломжит мэдээллийн хамтаар авч үзэх шаардлагатай.

Зарим улс оронд ИТБШҮ-ийг ашиглан тогтмол давтамжтайгаар, боломжтой бол 3 эсхүл 5 жил тутамд давтан судалгаа хийдэг. Энэ нь цаг хугацааны явцад гарсан өөрчлөлтийг ажиглах, ИТБШҮ-ийн өмнөх тайланд өгсөн зөвлөмжийн үр дүнд бодлого, практикт гарсан өөрчлөлтийн үр нөлөөг үнэлэх боломжийг олгох замаар шалгуур үзүүлэлтийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Анхны гарсан үр дүн, дүн шинжилгээ нь ийм байдлаар өөрчлөлтийг хэмжих үндсэн суурь болдог.

## 5.6 Чанарын нотлох баримт

Судалгааны баг тоон үзүүлэлтийн нэгэн адил чанарын үзүүлэлтэд шинжлэх ухаанчаар хандах шаардлагатай. Тоон үзүүлэлттэй холбоотой дээр дурдсан олон зүйл чанарын үзүүлэлтэд нэгэн адил хамаарна.

Судалгааны баг бусад төрлийн нотлох баримтын нэгэн адил цуглуулсан өгөгдөлд дүн шинжилгээ хийхдээ чанарын эх сурвалжийн чанар, найдвартай байдалд анхаарах хэрэгтэй. Үндсэн 3 төрлийн чанарын үзүүлэлтийг ашиглах боломжтой.

Эдгээр чанарын үзүүлэлтийн эхнийх нь засгийн газрын байгууллага, эрдэмтэн судлаач, судалгааны төв, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг олон янзын оролцогч талын хийсэн судалгаанаас бүрдэх бөгөөд эдгээр өөрсдийн зорилгод нийцсэн нотлох баримтын санг бүрдүүлэх үүднээс гол төлөв тоон аргаас илүү чанарын аргыг ашигласан байдаг. Үүнд, тухайлбал, ерөнхийд нь түүвэрлэхгүйгээр зөвхөн төлөөлүүлэх зорилгоор сонгосон бүлэг ба хувь хүнийг тухайн асуудлаар өөр өөр ойлголттой байгаа эсэхийг судлах фокус бүлэг, ярилцлагын судалгааг хамруулж болно. Ийм бүлгээс олж мэдсэн зүйл нь зөвхөн мэдээллийн шинжтэй байх бөгөөд хүн амын статистикийн түүврийг төлөөлдөггүй. Энэ тохиолдолд судлаачид судалгааны арга зүйн баталгаатай байдал, судалгааг санхүүжүүлж байгаа болонхийж буй этгээдийн ашиг сонирхлыг анхаарах хэрэгтэй.

Чанарын мэдээллийн эх сурвалжийн хоёр дахь төрөл нь тодорхой судалгаанд бус, тухайн асуултад хамаарах асуудлаарх туршлага, ойлголтод үндэслэсэн “эрх бүхий байгууллага”-аас авсан тайлбараас бүрддэг. Ийм мэдээллийн зарим хэсэгт сэдэв болон асуултын (жишээлбэл, арилжааны эсхүл үзэл суртлын) талаарх хэтийн төлөвийг тусгасан байдлаар бичигдсэн байж болно. Судлаачид ийм мэдээллийг анхаарахгүй өнгөрч болохгүй, эсрэгээр анхаарлаа хандуулж, ашиглах хэрэгтэй. Нэгдүгээрт, өмнөх 5.3 дугаарт тодорхойлсон боловсруулагч/хэвлэн нийтлэгч нь “эрх бүхий байгууллага” мөн эсэхийг авч үзэх хэрэгтэй. Нотлох баримтын хүрээнд үзэл бодлын ихээхэн ялгаатай байх тохиолдолд түүний боломжит шалтгаан, үндэсний интернэтийн орчныг ойлгохын тулд өөр өөр үзэл бодлын утга учир, боломжит зөвлөмжийг авч үзэх хэрэгтэй.

Харилцан адилгүй үзэл бодлын талаарх хэлэлцүүлгийг эцсийн тайланд тусгаж болно. Ингэснээр эцсийн тайлангийн үнэ цэн нэмэгдэнэ. Үүний нэгэн адил судалгааны баг чанарын нотлох баримтын чанар, найдвартай байдалд эргэлзэж байвал энэ талаар тайландаа тодорхой тусгах ёстой.

Судалгааны баг гурав дахь төрлийн чанарын нотлох баримтыг мэдээлэл цуглуулах, тухайлбал, гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага, бүлгийн ярилцлагаас олж авах боломжтой. Эдгээр нь эхний төлөвлөсөн цуврал асуултад тулгуурласан хагас бүтэцлэгдсэн хэдий ч үүсэж болзошгүй бусад асуудлыг судлах боломжийг олгох хангалттай уян хатан байх тохиолдолд үр дүнтэй байж болно. Хэрэв боломжтой бол эргэн магадлах үүднээс ярилцлага, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг (зөвхөн бүх оролцогчдын зөвшөөрлөөр) хөтөлнө.

## 5.7 Үр дүнгийн үнэлгээ

Шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу өгөгдлөө 3 хэсэгт хувааж судлахыг судлаачдад зөвлөж байна. Нэгдүгээрт, хэрэв боломжтой бол шалгуур үзүүлэлтийн утгыг тайлбарласан дурын тодорхой мета өгөгдөл; хоёрдугаарт, өгөгдөл мэдээлэл; гуравдугаарт, холбогдох шалгуур үзүүлэлтэд хамаарах асуултын хүрээнд дүн шинжилгээ хийсэн өгөгдлийн ач холбогдлын талаарх товч дүн шинжилгээ. Мета өгөгдөл (хэрэв байгаа бол), өгөгдөл болон дүн шинжилгээ нь хамтдаа үнэлгээний үр дүнг бүрдүүлнэ.

Судалгааны үр дүнгийн үнэлгээ (боломжтой бол мета өгөгдөл, өгөгдлийн шинжилгээ) нь бүхэлдээ судалгааны багийн хариуцах ёстой ажил бөгөөд багийн гишүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр дүгнэлтээ гаргах нь зүйтэй. Судалгааны багийн хэмжээнд зөвшилцөлд хүрэх боломжгүй тохиолдолд зөрүүтэй байдлыг эцсийн тайланд тодорхой тусгаж өгнө (дараагийн хэсгийг үзнэ үү).

ЮНЕСКО-гоос үнэлгээг доороос-дээш аргаар буюу тухайн сэдвийн дагуу 5 ангилал тус бүрээр бичгээр үнэлгээг гаргахаас өмнө бие даасан шалгуур үзүүлэлт, асуултын үр дүнг авч үзэхийг санал болгосон. Улмаар судалгааны баг ангилал тус бүрд зориулсан зөвлөмж, түүнчлэн салбар дамнасан буюу нийтлэг зөвлөмжийг гаргана.

ЮНЕСКО-гоос сэдэв, ангилалд хамаарах асуултыг үнэлэхэд оролцсон багийн гишүүдэд өөрсдийн гаргасан дүгнэлтээ эн тэргүүнд бусадтайгаа хэлэлцэхийг зөвлөдөг. Тухайн ажлын чиглэлийн ахлах судлаач уг хэлэлцүүлгээс гарсан үр дүн, чанарын талаар товч тайлан бэлтгэнэ. Энэхүү тайлангийн төслийг судалгааны багт танилцуулахаас өмнө холбогдох гишүүд хянан нягтална. Зарим мэдээллийг эцсийн тайлангийн арга зүйн бүлэгт оруулж болно.

Судалгааны баг нь ажлын энэ үе шатанд зарим мэдээллийг тодруулах, тэдний ажлын үр дүнг хэлэлцэхийн тулд төслийн явцад ярилцсан зарим гол мэдээлэгч, холбогдох бусад хүнтэй эргэн уулзаж болно. Түүнчлэн олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх багийн гишүүдтэй зөвлөлдөх нь зүйтэй. Энэ нь дүгнэлтийг баталгаажуулах, багийн доторх санал зөрөлдөөнийг шийдвэрлэхэд тусалдаг. Гэвч энэ нь зөвлөлдөх уулзалтад оролцогчдын заримыг лоббидох бус, судалгааг бодитоор хийсэн хүмүүсийн хариуцах ёстой судалгааны үр дүнг өөрчлөхгүй байхад анхаарал хандуулах хэрэгтэй.

## 5.8 Асуулт ба үзүүлэлтийг харьцуулах

Зарим судалгааны багт асуулт болон шалгуур үзүүлэлтийг харьцуулахад бүтэцлэгдсэн болон стандартчилагдсан аргын аль алиныг нь хэрэгжүүлэх нь тустай байж болох юм. Эдгээр 3 төрлийн үзүүлэлтийг (зохион байгуулалтын, тоон, чанарын) үнэлэх нэг арга бол харьцуулах тоон хэмжигдэхүүний арга (Лайкерт шкал/Likert) юм. Энэ аргачлалаар судлаачид холбогдох үзүүлэлт ба үзүүлэлтийн нотлох баримтад үндэслэн асуулт тус бүрийг 1-5 эсхүл 1-10 хүртэлх тоон утгаар харгалзуулан үнэлнэ. Өөр нэг арга бол тухайн шалгуур үзүүлэлт ба асуулттай холбоотойгоор тухайн улс хэр гүйцэтгэлтэй байгааг үнэлэхдээ ногоон, улбар шар, улаан өнгө оноон хуваарилдаг "гэрлэн дохио"-ны арга болно.

Ийм төрлийн үйл ажиллагаа нь давуу талтай боловч эрсдэлтэй байдаг. Тухайлбал:

- Өмнө дурдсан 3 төрөлд багтдаг асуулт/үзүүлэлтийг харьцуулах боломжийг олгодог.
- Судалгааны багийн гишүүдийн үзэл бодлын ялгааг тодорхойлоход тусалж чаддаг (багийн гишүүдээс ихээхэн ялгаатай оноо бүхий асуудалд төвлөрсөн хэлэлцүүлэг хийх замаар).
- Бодлого ба практикийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход тусалж чаддаг (судалгааны баг бүхэлдээ харьцангуй бага оноотой асуулт, дүгнэлтийг тодруулах замаар).
- Бие даасан судлаачдын санаа бодлыг янз бүрийн үзүүлэлтийн харьцангуй чухал байдал, тэдгээрийн интернэтийн орчны харьцангуй гүйцэтгэлд төвлөрүүлж чаддаг.

Эрсдэл талаас авч үзвэл, тухайн ангилалд хамаарах дундаж үзүүлэлтийг тогтоохын тулд зэрэглэлийг механик аргаар нэмэхгүй байхыг ЮНЕСКО-гоос зөвлөдөг. Учир нь үзүүлэлт бүрийг ижил утгатай гэж үздэг учраас ийм аргыг ашигладаг судлаачид өөр өөр оноо өгөхөөс зайлсхийх хэрэгтэй. Энэ нь тухайн улсын хувьд бусдаас илүү үнэ цэнэтэй, бие даасан тодорхой шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг авч үзэхэд саад болж болзошгүй.

Дээрх сануулгын дагуу хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлт болон ИТБШҮ-ийн туршилтын хэрэгжүүлэлтийг хариуцсан зарим судлаач бие даасан үзүүлэлт тус бүрээр зөвшилцөлд хүрэхэд Лайкерт шкал ач холбогдолтойг олж тогтоосон. Бусад нь зөвшилцлийн үнэлгээнд хүрэх жижиг бүтэцтэй аргыг илүүд үздэг.

### 5.9 Олон улсын индексийг хэрэглэх

Өмнө авч үзсэнчлэн, ИТБШҮ-ийн хүрээ нь НҮБХХ-ийн Хүний хөгжлийн индекс, ОУЦХБ-ын МХХТ-ийн хөгжлийн индекс зэрэг индексийн аргаар улс хоорондын харьцуулалт хийх үндэслэлийг тодорхойлдоггүй. ИТБШҮ нь үндэсний интернэтийн өөр өөр орчныг ойлгоход дэмжлэг үзүүлэх, интернэтийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, түүнтэй холбоотой эрсдэл, бэрхшээлийг үндэсний хэмжээнд бууруулахад чиглэсэн бодлогын зохистой хариу арга хэмжээ, бодит санаачилгыг боловсруулах зорилготой.

Гэвч зарим тохиолдолд газар зүйн бүс нутгийн бахарьцуулж болохуйц хөгжлийн туршлага болон статустай улс орны туршлагыг ижил бүлгийн хүрээнд авч үзэх нь ач холбогдолтой байдаг. Жишээлбэл, ОУЦХБ-ын мэдээллээс интернэтийн хүртээмжийн түвшин болон нэг хүнд ногдох ҮНБ нь өөр хоорондоо шууд уялдаа холбоотой нь тодорхой харагдаж байна. Зарим улсын хувьд хүртээмжтэй байдал нь нэг хүнд ногдох ҮНБ нь ойролцоо байдаг бусад улс оронтой харьцуулахад төсөөлж байснаас илүү өндөр байдаг бол зарим нь тэдгээр улсаас доогуур үзүүлэлттэй байдаг.

Иймд нэг хүнд ногдох ҮНБ, МХХТ-ийн хөгжлийн индекс, Жендерийн тэгш бус байдлын индекс зэрэг олон улсын холбогдох индексээр тухайн улс орны зэрэглэлийг тодорхой шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн түвшинд авч үзэх, тухайн улсын нийтлэг индексийг харгалзан ИТБШҮ-ийн тодорхой шалгуур үзүүлэлтийн хувьд тухайн улс төсөөлж байснаас илүү сайн эсхүл хангалтгүй эсэхийг олж тогтооход тустай. Үүний нэг жишээ бол тухайн улсын цахим орчин дахь жендерийн ялгааг харьцуулах боломжтой бусад улс оронтой жендерийн тэгш бус байдлын индексээр харьцуулах явдал юм.

## Үйл ажиллагааны алхам 6: Тайлан бичих, зөвлөмж өгөх

ИТБШҮ-ийг ашиглан хийсэн үнэлгээний эцсийн тайлан нь үндэсний нөхцөл байдал, төслийг эхлүүлэхэд тавьсан зорилтуудаас хамааран улс орнуудад тодорхой хэмжээгээр өөр өөр байна. Ихэнх тохиолдолд тайланд үндэсний интернэтийн орчны талаарх дүгнэлт, засгийн газар болон оролцогч бусад талд өгөх зөвлөмжийг тусгадаг. Дүгнэлт болон зөвлөмж нь үндэсний сонирхогч талууд болон интернэтийн түгээмэл байдлын чиглэлээр ажилладаг олон улсын хамтын нийгэмлэгийн ач холбогдлыг нэмэгдүүлдэг. Тайлан нь хэвлэхэд тохиромжтой байх ба ЮНЕСКО-гоос чанарын баталгаажуулалтыг хийсний дараа (Хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтийг ашиглан бэлтгэсэн ихэнх тайлангийн нэгэн адил) нийтэлж болно.

ЮНЕСКО-гоос ИТБШҮ-ийн үнэлгээний тайлангийн ерөнхий бүтцийг дор дурдсан бүлгүүдтэй байхаар тодорхойлсон. Үүнд:

а. ИТБШҮ-ийн хүрээг тодорхойлж чадах ИТБШҮ-ийн товч танилцуулга (мэдээлэлгүй уншигчдад ойлголт өгөх зорилгоор);

б. Судалгааны үр дүнгийн товч дүгнэлт (бие даасан ангиллаас илүүтэйгээр бүхэлд нь авч үзсэн байдлаар):

- Бодит байдлыг тодорхойлсон арга зүй, оролцоо зэргийг багтаасан судалгааны товч тойм. Үүнд:
  - Нотлох баримт цуглуулах аргачлалын тайлбар;
  - Гүйцэтгэсэн анхан шатны судалгааны тэмдэглэл;
- Ангилал тус бүрийн гол үр дүнгийн товч дүгнэлт;
- Нотлох баримтын сангийн талаарх тайлбар. Үүнд:
  - Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг сайжруулах талаарх зөвлөмж;
  - Үнэлгээний тэргүүлэх ач холбогдол ба/буюу нэн чухал зөвлөмжийн талаарх дүгнэлт.

в. ROAM-X ангилал тус бүрд хамаарах бие даасан бүлгүүд. Үүнд:

- Бүлэг доторх сэдэв бүрийн хэсэг;
- Шалгуур үзүүлэлтийн мета өгөгдөл (боломжтой бол), цуглуулсан өгөгдөл, шалгуур үзүүлэлт тус бүрийн дүн шинжилгээ бүхий сэдэв доторх асуулт бүрийн зүйл/параграф;
- Ангилалтай холбоотой зөвлөмж.

г. Өмнөх бүлгүүдэд тусгагдсан, зорилтот оролцогч талуудын бүлгээр бүтэцлэгдсэн зөвлөмжийн бүрэн эмхэтгэл (6.2 дугаар хэсгийг үзнэ үү).

д. Судалгааны явц, талархал, эх сурвалжийн дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан хавсралт.

Судлаачид тайлан бэлтгэхдээ ЮНЕСКО-гийн төслийн веб сайтаас хэвлэл мэдээллийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний үр дүнгийн тайлан, ИТБШҮ-ийн эхний туршилтын тайлантай танилцах нь илүү үр дүнтэй.

ЮНЕСКО-гоос нийтлэхээр төлөвлөж буй тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн 6 хэлний аль нэгээр нь бичсэн эсхүл орчуулсан байх шаардлагатай.

## 6.1 Тайлан бэлтгэх

Судалгааны баг тайлангийн төслийг боловсруулж, батлахдаа өөр өөр аргачлалаар ажилладаг. Тайлан бичих ерөнхий аргачлалыг ажлын төлөвлөгөөний эхний хэлэлцүүлгээр хэлэлцэн тохиролцох шаардлагатай бөгөөд төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт оруулж болно.

Тайланд тусгасан дүгнэлт, зөвлөмжийг судалгааны багийн гүйцэтгэсэн ажлын үр дүнд тусгана. Тайланд багийн гишүүдийн нэгдсэн байр суурийг тусгах үүднээс тайланг хэвлэн нийтлэхээс өмнө үзэл бодлын зөрүүг арилгах зорилгоор тухайн тайланг бэлтгэх явцад судалгааны багийн дунд тайлангийн төслийг хуваалцаж, хэлэлцүүлэхийг ЮНЕСКО-гоос зөвлөдөг. Үүнийг онлайнаар зохион байгуулах боломжтой ч төслийн дүгнэлтийн чанарын үнэлгээг биечлэн шалгах хамтарсан семинар зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг (5.7 дугаар хэсгийг үзнэ үү).

Ялангуяа эдгээр нь чухал ач холбогдолтой бөгөөд гол асуудлаарх үзэл бодлын зөрүүг худал зөвшилцөх замаар нуух, эсвэл зохих ёсоор шийдвэрлэж чадахгүй байхаас сэргийлжтодорхой тусгах нь зүйтэй. Судалгааны багийн хүрээнд зөвшилцөлд хүрэх боломжгүй тохиолдолд энэ талаар тайланд тодорхой тусгах шаардлагатай бөгөөд энэ нь дүн шинжилгээ болон зөвлөмжийн аль алинд нь хамаарна.

Өмнө дурдсанчлан, судалгааны баг үйл ажиллагааны энэ үе шатанд зарим гол мэдээлэгчтэй эргэн холбогдож, мэдээллийг тодруулж болно. Ийм зөвлөлдөх хэлэлцүүлгийн үеэр зөвлөмжийг тодорхойлох, үг хэллэгийг тогтох, улмаар хэрэгжүүлэх боломжит хамгийн үр дүнтэй аргыг авч хэлэлцэх боломжтой.

Судалгааны төслийн хүрээнд олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх багийн гишүүдийг томилсон тохиолдолд тэдгээр нь эцсийн тайлангийн төслийг авч хэлэлцэх ёстой. Тэдний үзэл бодол судалгааны үр дүнг өөрчлөхгүй хэдий ч нийтлэгдсэний дараа холбогдох оролцогч талууд зөвлөмжийг оновчтой тодорхойлох эсхүл хэрэгжүүлэхэд ач холбогдолтой байж болно.

## 6.2 Зөвлөмж боловсруулах

ИТБШҮ-ийн хүрээ нь үндэсний интернэтийн орчны талаарх ойлголтыг сайжруулах ач холбогдолтой. Үнэлгээ нь Тогтвортой хөгжлийн хөтөлбөр дэх интернэтийн үнэ цэн, ач холбогдлыг нэмэгдүүлэх, эрсдэл болон бэрхшээлийг бууруулахад чиглэсэн илүү үр дүнтэй бодлого, практикийг хэрэгжүүлэхэд түлхэц болно. Иймд судалгааны үр дүнд тодорхой оролцогч талуудад чиглэсэн, тодорхой зөвлөмжийг гаргах ёстой. Судалгааны дүгнэлт бүр зөвлөмж болж чадахгүй юм уу эсвэлболох боломжгүй ч судалгааны хүрээнд тодорхойлсон үр дүн, дүгнэлт, тэдгээрийн багц нь боломжит зөвлөмжийг өгч болно. Гэвч бүх зөвлөмж нь тодорхой дүгнэлттэй холбоотой, үндэслэлтэй байх шаардлагатай. Түүнчлэн зөвлөмжийн жагсаалтыг зохист хэмжээтэй байлгахад анхаарах хэрэгтэй.

Үндэсний интернэтийн орчин харилцан адилгүй байдаг бөгөөд хариуцагч, эрх эзэмшигч, тэдгээрийг төлөөлөгч төдийгүй бусад оролцогч зэрэг тодорхой сонирхогч талтай холбоотой ажил үүрэг өөр өөр байдаг. Төрөл бүрийн ангилал, сэдэв нь эдгээр ялгаанаас үүдэлтэй өөр өөр хариултыг шаарддаг. Зөвлөмжийг дор дурдсан холбогдох хариуцагчид шууд хандсан байдлаар боловсруулах шаардлагатай. Үүнд:

- Засгийн газрын төрөл бүрийн байгууллага, агентлаг;
- Интернэтийн холболт болон үйлчилгээний чиглэлийн бизнес эрхлэгч;
- Тухайн улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг интернэтийн мэргэжилтнүүдийн холбоо, интернэт засаглалын байгууллага (жишээлбэл, домэйн нэрийн удирдлагыг хариуцагч);
- Үндэсний статистикийн тогтолцоо, судалгааны төв, эрдэмтэн судлаач болон өнөөгийн болон хэтийн төлөвийн талаарх холбогдох судалгаа хийдэг болон хийх боломжтой бусад хүмүүс;
- Иргэний нийгмийн байгууллага, түүний дотор хүүхдийн эрх, хүртээмж, хөгжил, жендер болон ахуй амьдралтай холбоотой асуудлаар ажилладаг байгууллага;
- Үндэсний хэмжээний бусад оролцогч;
- Тухайн улсад интернэттэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх сонирхолтой олон улсын хөгжлийн агентлаг.

Үр дүн болон гарах бодлого, практик зөвлөмжийг хэлэлцэх нь энэхүү гарын авлагын хамрах хүрээнд хамаарахгүй хэдий ч ЮНЕСКО-гоос зөвлөмжийн цар хүрээ, танилцуулгатай холбоотой дараах 4 зүйлийг анхаарч үзэхийг санал болгож байна. Үүнд:

- Зөвлөмжид тухайн улс орны оролцогч талууд интернэтийн түгээмэл байдлыг ерөнхийд нь нэмэгдүүлэхийн тулд юу хийж чадахыг тодорхой ангилал, сэдвээр нь авч үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, ROAM-X харилцан хамаарлыг харгалзан үзэж, зөвлөмжийн уялдаа холбоо, нэмэлт өөрчлөлт оруулах боломжоор хангах шаардлагатай.
- Зөвлөмжид интернэтийн цаашдын хөгжлийг үндэсний хөгжлийн стратеги, нээлттэй засаглал, цахим эдийн засгийн стратеги, тогтвортой хөгжлийн зорилтуудын амлалт, жендерийн тэгш байдлын талаарх бодлого зэрэг үндэсний төрийн бодлогын бусад зорилттой уялдуулахад анхаарна.
- Зөвлөмжид интернэтээс үүдэлтэй ойрын болон урт хугацааны боломж, асуудал, сорилтыг харгалзан үзэж, тэдгээрт анхаарал хандуулсан байх шаардлагатай. Энэ нь үндэсний интернэтийн туршлагад чухлаар нөлөөлөх зөвлөмжид тусгагдсан асуудлын эрэмбэ дараалллыг тодорхойлдог.
- Зөвлөмжид мэдээлэл дутмаг газарт анхаарлаа хандуулж, тэдгээрийг шийдвэрлэх аргыг санал болгох замаар тухайн улсын нотлох баримтын санг сайжруулах арга замыг тусгасан байна.

Эцэст нь шалгуур үзүүлэлтийн дараагийн хэрэгжүүлэлтийг хэзээ эхлүүлж болохыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Эхний ээлжинд шалгуур үзүүлэлтийн хүрээг ашиглан иж бүрэн үнэлгээ хийсэн тохиолдолд дараагийн давтан үнэлгээг үндсэн шалгуур үзүүлэлтэд чиглүүлэн хийх нь зохимжтой.

## Үйл ажиллагааны алхам 7: Үндэсний баталгаажуулалтын олон талт сонирхлын бүлгүүдийн семинарыг зохион байгуулж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах

Үндэсний түвшний үнэлгээний үйл явцын төгсгөлд үнэлгээний үр дүн, бодлогод тусгах зөвлөмжийг хэлэлцэх үндэсний баталгаажуулалтын семинарыг зохион байгуулж, олон талт сонирхлын бүлгүүдийн оролцогч, гол бодлого боловсруулагч, судалгаанд хамрагдсан гол зохицуулагч байгууллагыг оролцуулна. Энэ арга хэмжээний үеэр бодлогын хувилбарыг цаашид хэрэгжүүлэх боломжит арга хэмжээний талаар авч хэлэлцэнэ.

Ийм семинар нь зөвлөмжийн дагуу хийгдэх боломжит хэрэгжүүлэлтийн үйл ажиллагааны талаар авч хэлэлцэх боломжийг зөвхөн бодлого боловсруулагчдад төдийгүй өргөн хүрээний оролцогч талуудад олгодог. Түүнчлэн семинараар зөвлөмжийн хэрэгжилт, үр нөлөөг хянах хугацааг тогтоож болно.

Энэхүү арга хэмжээг ЮНЕСКО, олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх баг, судалгааны баг хамтран зохион байгуулах бөгөөд ЮНЕСКО–гийн зүгээс үндэсний үнэлгээний талаарх нэмэлт сурталчилгаа, танин мэдэхүйн үйл ажиллагааг дэмжин ажиллах боломжтой.

Үнэлгээг үндэсний хэмжээний мэдлэг, мэдээллийн нөөц гэж үзвэл, холбогдох салбарын сургалтын хөтөлбөр зэрэг судалгааг тасралтгүй ашиглах үүднээс судалгааны болон эрдэм шинжилгээний нийгэмлэгүүдийг татан оролцуулах хэрэгтэй.

## Үйл ажиллагааны алхам 8: Нөлөөллийг үнэлэх, мониторинг хийх

ЮНЕСКО, зөвлөх баг, судалгааны багаас үндэсний үнэлгээг хийж дууссаны дараа тогтоосон хугацаанд хэрэгжилтийн ахиц дэвшил болон бодлогын сайжруулалтыг хянах, үнэлэх зорилгоор цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ (жишээлбэл, техникийн зөвлөгөө) тодорхойлно. Энд дурдсан цар хүрээ нь зөвхөн зөвлөмж өгөх зорилготой бөгөөд практикийн хувьд дараа нь өөрчлөлтийг хэмжих боломжийг олгохын тулд хангалттай тодорхойлолт, тодорхой байдлыг шаарддаг. Судалгааны баг нь үр дүнг гажуудуулж болохуйц хувийн ашиг сонирхлоос зайлсхийхийн тулд нөлөөллийн хяналт үнэлгээ, мониторингийг хараат бусаар өндөр түвшинд хийх шаардлагатай. Хэрэв боломжтой бол үнэлгээний энэ үе шатыг төслийн анхны баримт бичиг, төсөвт тодорхойлон тусгах хэрэгтэй.

# 3. Ирээдүйг төсөөлөх нь

Интернэт асар хурдацтай өөрчлөгдөж байна. Одоогоос 20 жилийн өмнө интернэтийн хүртээмж хязгаарлагдмал, ашиглах боломжтой үйлчилгээний цар хүрээ одоогийнхоос хамаагүй явцуу байсан билээ. Тухайн үед мобайл интернэт, өргөн зурвасын интернэт нь олон нийтийн хувьд дөнгөж хөгжиж, нийгмийн мэдээллийн хэрэгслээр ач холбогдолтой программ хангамж гараагүй, ирээдүйд видео стриминг болон үүлэн тооцоолол бий болно хэмээн үзэж байсан. Өнөөдөр интернэт нь 5G сүлжээ, юмсын интернэт, их өгөгдлийн шинжилгээ, алгоритмын шийдвэр

гаргалт, виртуал бодит байдал, хиймэл оюун ухаан, дэвшилтэт робот техник зэрэг мэдээллийн технологийн бусад өөрчлөлтийн зэрэгцээ асар хурдацтай хөгжин өөрчлөгдөж байна.

Судлаачид үнэлгээ хийж, цаашдын бодлого болон практикт хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулахдаа эдгээр асар хурдацтай, урьдчилан таамаглах аргагүй хөгжлийн талаар мэддэг байх ёстой. Ирэх 5 жилийн хугацаанд ялангуяа дор дурдсан 4 асуудалд онцгой анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Шалгуур үзүүлэлтэд багтсан зарим асуултын ач холбогдол цаг хугацаа өнгөрөх тусам багасаж, зарим нь илүү чухал болж болно. Жишээлбэл, IPv4 болон IPv6 протоколын нэвтрүүлэлтийн ач холбогдол IPv6 протоколыг бүх нийтээр ашиглах тусам багасах магадлалтай бол цахим худалдааны нөлөөлөл нь их өгөгдөл болон хувийн нууцлалын хоорондын харилцаа холбооны хамтаар илүү ач холбогдолтой болох төлөвтэй байна.
- Зарим шалгуур үзүүлэлтийн үнэ цэн, тодорхойлолтыг нэмж өөрчлөх шаардлага гарч болно. Жишээлбэл, "өргөн зурвас" гэдэг утга ерөнхийдөө боломжит зурвасын давтамжийн хэмжээгээр өөрчлөгдөж байна. Зарим өгөгдлийн багцад үүнийг 256 кбит/с-ээс дээш өгөгдөл дамжуулах хурд хэмээн тодорхойлсон хэвээр байгаа ч энэ нь өдгөө мөрдөгдөж буй стандартад нийцсэн олон цахим үйлчилгээг хүргэх боломжгүй юм. Энэ мэт ухагдахуун, тодорхойлолттой холбоотой нэмэлт өөрчлөлт нь НҮБ-ын системтэй нийцэх ёстой.
- Бодлого боловсруулагчид, үндэсний статистикийн системүүд холбогдох мэдээллийг цуглуулж, олон нийтэд нээлттэй болгоход илүү хариуцлагатай ажилласнаар тоон нотлох баримт зэрэг нотлох баримтын цар хүрээ, чанар сайжирна гэж үздэг. Төрөл бүрийн сонирхлын бүлэг олон улсын шинэ индексийг боловсруулан гаргах нь түгээмэл бөгөөд заримыг нь өдгөө ашиглаж буй индекстэй зохих ёсоор нэгтгэж болно.
- Өдгөө шинээр гарч буй болон ирээдүйд бий болох технологи, зах зээлийн цаашдын шинэ хөгжил нь ROAM зарчим болон ROAM-X ангилалд нөлөөлнө. Одоогийн энэ хүрээнд зөвхөн тэдгээртэй холбоотой бодлогын хүрээний товч үнэлгээг багтаасан болно. Хэдийгээр холбогдох шалгуур үзүүлэлт байхгүй ч цаашид бий болно. Судлаачид нэмэлт нотлох эх сурвалж бэлэн болсон үед одоогийн хүрээнд нэмж оруулах хэрэгтэй.

# 4. ЮНЕСКО-той хамтран ажиллах

ЮНЕСКО хуримтлагдсан туршлага, өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг харгалзан 2024 онд болох Харилцаа холбооны хөгжлийн олон улсын хөтөлбөрийн зөвлөлийн 2 жил тутамд зохион байгуулдаг уулзалтаас өмнө энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээг бүхэлд нь хянан авч үзэхийг эрмэлзэж байна.

Үүнд төслийн завсрын үеийн хэрэгжүүлэлтэд оролцогчдын санал бодол маш чухал. Иймд ЮНЕСКО судалгааны багуудыг цаашдын судалгаанд шалгуур үзүүлэлтийн ач холбогдлыг дээшлүүлэхэд тус дөхөм болох үндэсний онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлсэн туршлагын талаарх санал дүгнэлтээ ЮНЕСКО-д ирүүлэхийг уриалж байна.

Энэхүү гарын авлагын онлайн хувилбарыг хэрэгжүүлэх туршлагаас хамааран шинэчилнэ.

ЮНЕСКО нь олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөх багийг байгуулахаас эхлээд арга хэмжээг хамтран зохион байгуулах, үр нөлөөллийн мониторинг хийх хүртэлх бүх үйл явцыг дэмжихэд бэлэн байдаг. Тус байгууллага үндэсний үнэлгээний дүнг ЮНЕСКО-гийн тусгайлсан цуврал нийтлэлийн нэг хэсэг болгон нийтэлдэг. Түүнчлэн ЮНЕСКО туршлага солилцох, нөлөөллийн үйл ажиллагаа, бодлогын мэтгэлцээнийг дэмжих зорилгоор үндэсний хэмжээний үнэлгээний үйл явцад туслах, үндэсний туршлагыг хуваалцах дэлхийн цахим платформыг байгуулна.

Өөрийн улс оронд ИТБШҮ-ийн үндэсний үнэлгээг хийх сонирхолтой хүмүүс сонирхлоо илэрхийлж, ЮНЕСКО-той дор дурдсан хаягаар холбогдоно уу. Үүнд:

ЮНЕСКО-гийн төслийн зохицуулалт, холбоо барих: internet.indicators@unesco.org

- ЮНЕСКО-гийн төслийн веб сайт: https://en.unesco.org/internetuniversality

Оролцогч талууд Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжүүлэлтийн талаарх мэдээллийг Интернэтийн түгээмэл байдлын холбоонд бүртгүүлж, цахим шуудангаар тогтмол хүлээн авах боломжтой. https://en.unesco.org/feedback/ join-our

# Хавсралт 1. Олон талт сонирхлын бүлгийн зөвлөх багийн гишүүд



ЮНЕСКО-гоос төслийн хэрэгжүүлэлтэд зөвлөгөө өгөх зорилгоор төрөл бүрийн бүс нутаг, сонирхогч талуудын интернэтийн төрөл бүрийн чиглэлээр ажилладаг олон улсын 15 шинжээчээс бүрдсэн олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөл (ОТСБЗБ)-ийг томилсон. ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгээс нэмэлт дэмжлэг, зөвлөгөөг өгч ажилласан. Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зөвлөгөө авсан болно.

| Нэр | Байгууллага | Оролцогч бүлэг | Бүс нутаг |
|---|---|---|---|
| Александрин Пирлот де Корбион | Privacy International | Төрийн бус байгууллага | Олон улсын |
| Андреа Калдераро | Интернэт болон дэлхийн улс төрийн төв, Кардиффын их сургууль | Эрдэм шинжилгээ | Европ |
| Деми Гетчко | Бразилийн интернэтийг удирдах хороо | Техникийн нийгэмлэг, олон талт сонирхлын бүлэг | Латин Америк, Карибын тэнгис |
| Элетра Рончи | Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) | Засгийн газар хоорондын | Олон улсын |
| Грейс Гитайга | KICTANet | Олон талт сонирхлын бүлэг | Африк |
| Жасмина Бирн | НҮБ-ын Хүүхдийн сан | Засгийн газар хоорондын | Олон улсын |
| Жейсон Пилемейер | Дэлхийн сүлжээний санаачилга | Төрийн бус байгууллага | Олон улсын |
| Жанетт Хофман | Берлиний Нийгмийн шинжлэх ухааны судалгааны төв | Эрдэм шинжилгээ | Баруун Европ, Хойд Америк |
| Жулиа Поле | Берлиний Нийгмийн шинжлэх ухааны судалгааны төв | Эрдэм шинжилгээ | Баруун Европ, Хойд Америк |
| Маниша Патак-Шелат | Ахмедабадын Мудра Харилцааны Дээд Сургууль | Эрдэм шинжилгээ | Ази, Номхон далай |
| Миши Чоудхари | Программ хангамжийн эрх чөлөөний хуулийн төв | Хувийн хэвшил | Ази, Номхон далай |
| Нибал Идлеби | НҮБ-ын Баруун Азийн Эдийн Засаг болон Нийгмийн Комисс | Засгийн газрын хоорондын | Олон улсын |
| Соня Ливингстон | Лондонгийн Эдийн Засаг, Улс Төрийн Ухааны Сургууль | Эрдэм шинжилгээ | Европ |
| Стивен Вайбер | Олон улсын номын сан, хүрээлэнгийн холбоо | Төрийн бус байгууллага | Олон улсын |
| Тарек Камел | Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага | Ашгийн бус байгууллага | Олон улсын |

# Хавсралт 2. Зөвлөлдөх арга хэмжээ

ЮНЕСКО-гоос Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулах үндсэн аргачлалын хүрээнд олон улс, бүс нутаг болон үндэсний хэмжээний олон арга хэмжээний үеэр нүүр тулсан уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Эдгээр зөвлөлдөх арга хэмжээ нь төслийг сурталчлах, бүс нутгийн нэр хүндтэй бөгөөд тэргүүлэх шинжээчдийг цуглуулах, гишүүн улс, олон улсын байгууллага, техникийн холбоо, хувийн хэвшил, иргэний нийгэм, ТББ, интернэтийн болон хууль эрх зүйн мэргэжилтэн, эрдэмтэн, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, оюутан зэрэг төрөл бүрийн оролцогчийг хамруулах зорилготой. Эдгээр үйл ажиллагаа нь төсөлд чухал нөлөөлж, ЮНЕСКО-г сонирхогч талуудын үнэ цэнэтэй санал зөвлөгөөгөөр хангах, цахим мэдүүлгийн тоог нэмэгдүүлэх, энэхүү төслийн эзэмшлийг харуулах болон ЮНЕСКО-гийн эрхэмлэх үнэт зүйлс болох хүний эрх, нээлттэй байдал, хүртээмжтэй байдал, олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоо зэргийг сурталчлан таниулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Төслийн эхний үе шатанд (2017 оны 3 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд) Аргентин, Австри, Бельги, Хятад, Колумби, Эстони, Франц, Герман, Индонез, Ямайка, Йордан, Кени, Панам, Перу, Португал, Орос, Өмнөд Африк, Швед, Швейцар, Тайланд, Арабын Нэгдсэн Эмират Улс, Вьетнам зэрэг 22 улсад 26 зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулсан.

Төслийн хоёр дахь үе шатанд (2017 оны 12 дугаар сараас 2018 оны 5 дугаар сарын хооронд) Бразил, Канад, Египет, Франц, Гана, Итали, Перу, Шри Ланка, Швейцар, Тайланд, Тунис, Их Британи, АНУ зэрэг 13 оронд 15 зөвлөлдөх арга хэмжээг (4 бүс нутгийн зөвлөлдөх форум багтсан) зохион байгуулсан.

Төслийн гурав дахь үе шатанд (2018 оны 6 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд) Франц, Гүрж, Герман, Гана, АНУ зэрэг 5 улсад 5 зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулсан.

Эдгээр 3 үе шатны зөвлөлдөх арга хэмжээнд бүх оролцогч тал, бүс нутгийн 2000 гаруй мэргэжилтэн оролцсон.

## Эхний шатны зөвлөлдөх арга хэмжээ

| Арга хэмжээ | Огноо | Байршил | ЮНЕСКО-гийн веб сайтад тавигдсан мэдээ |
|---|---|---|---|
| RightsCon хурал | 2017 оны 3 дугаар сарын 29-31 | Брюссель, Бельги | ЮНЕСКО Брюсселийн хурлаар Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн талаар мэргэжилтнүүдтэй зөвлөлдөв. |
| GIG-Arts Paris | 2017 оны 3 дугаар сарын 30-31 | Парис, Франц | ЮНЕСКО GIG-Arts хурлаар интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох шинэ төслөө хэлэлцүүлэв. |
| BILETA (Британи болон Ирландын хуулийн боловсрол, технологийн нийгэмлэг) жил тутмын зөвлөгөөн | 2017 оны 4 дүгээр сарын 10-11 | Брага, Португал | ЮНЕСКО BILETA хурал дээр интернэтийн түгээмэл байдал болон цахим эрх чөлөөг дэмжив. |
| Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр | 2017 оны 5 дугаар сарын 1-4 | Жакарта, Индонез | Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр ЮНЕСКО Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулах талаар зөвлөлдөв. |
| Стокхольмын интернэт форум | 2017 оны 5 дугаар сарын 22 | Стокхольм, Швед | ЮНЕСКО Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн талаар зөвлөлдөв. |
| Африкийн дээд хэмжээний уулзалт | 2017 оны 5 дугаар сарын 30 | Найроби, Кени | Кени: Интернэт засаглалын форумын хурал 2017 |
| Интернэт засаглалын талаарх Европын яриа хэлцэл (EuroDIG) | 2017 оны 6 дугаар сарын 6-7 | Таллин, Эстони | ЮНЕСКО EuroDIG бага хурлын үеэр интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн талаар олон талт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. |

| | | | |
|---|---|---|---|
| Дэлхийн хэвлэл мэдээллийн их хурал | 2017 оны 6 дугаар сарын 7-9 | Дурбан, Өмнөд Африк | ЮНЕСКО-гоос редакторуудад эх сурвалжийн нууцлалын судалгааг танилцуулав. |
| Мэдээллийн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалт | 2017 оны 6 дугаар сарын 12-16 | Женев, Швейцар | Мэдээллийн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтын үеэр ЮНЕСКО-гоос интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох хэлэлцүүлгийн веб сайтаа нээв. |
| Дэлхийн хэвлэл мэдээллийн форум | 2017 оны 6 дугаар сарын 19-21 | Бонн, Герман | Deutsche Welle Дэлхийн хэвлэл мэдээллийн форум дээр интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн талаар зөвлөлдөв. |
| Олон улсын хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны судалгааны нийгэмлэг 2017 | 2017 оны 7 дугаар сарын 16-20 | Картагена, Колумби | ЮНЕСКО интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн талаар эрдэмтэн судлаачидтай зөвлөлдөв. |
| Ази, Номхон Далайн интернэт засаглалын форум | 2017 оны 7 дугаар сарын 26-29 | Бангкок, Тайланд | Интернэт засаглалын 8 дахь удаагийн Ази, Номхон далайн бүс нутгийн форумын үеэр ЮНЕСКО-гийн интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг авч хэлэлцлээ. |
| Латин Америк, Карибын Тэнгисийн интернэт засаглалын форум | 2017 оны 8 дугаар сарын 2-4 | Панам хот, Панам | ЮНЕСКО-гоос Латин Америкт интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн цуврал зөвлөлдөх уулзалтыг эцэслэв. |
| Дэвшилтэт харилцаа холбооны гишүүдийн уулзалт | 2017 оны 8 дугаар сарын 16-18 | Йоханнесбург, Өмнөд Африк | |
| Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах асуудлыг судлах төв (CELE17) | 2017 оны 9 дүгээр сарын 6-8 | Буэнос-Айрэс, Аргентин | ЮНЕСКО-гоос Латин Америкт интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн цуврал зөвлөлдөх уулзалтыг эцэслэв. |
| Африкийн интернэтийн эрх чөлөөний форум (FIFAfrica) | 2017 оны 9 дүгээр сарын 27-29 | Йоханнесбург, Өмнөд Африк | |
| Харилцаа холбоог хөгжүүлэх олон улсын хөтөлбөрийн зөвлөлийн албан бус уулзалт | 2017 оны 9 дүгээр сарын 28 | Парис, Франц | Харилцаа холбоог хөгжүүлэх олон улсын хөтөлбөрийн уулзалтын үеэр интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулахад ЮНЕСКО-гийн гишүүн орнуудыг оролцохыг уриалав. |
| Нууцлал, өгөгдөл хамгаалах дэлхийн хурал | 2017 оны 9 дүгээр сарын 28-29 | Хонг Конг, Хятад | ЮНЕСКО-гийн интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг Хонг Конгт болсон мэдээлэл хамгаалах, нууцлалын асуудал эрхэлсэн комиссаруудын олон улсын 39 дүгээр хуралд хэлэлцүүлэв. |
| Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүүхдийн эрх, хэвлэл мэдээллийн талаарх олон улсын семинар | 2017 оны 10 дугаар сарын 2-4 | Лима, Перу | ЮНЕСКО-гоос Латин Америкт интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн цуврал зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж дуусав. |
| Интернэтийн эрх чөлөөний хурал | 2017 оны 10 дугаар сарын 13 | Вена, Австри | ЮНЕСКО нь Вена хотноо зохиогдож буй Интернэтийн эрх чөлөөний хурал дээр интернэтийн түгээмэл байдал, олон улсын хүний эрхийн стандартыг дэмжив. |

| | | | |
|---|---|---|---|
| Дэлхийн цахилгаан холбооны хөгжлийн хурал (WTDC-17) | 2017 оны 10 дугаар сарын 9-20 | Буэнос-Айрэс, Аргентин | ЮНЕСКО-гоос Латин Америкт интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн цуврал зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж дуусав. |
| Москва: Европын сэтгүүл зүйн сургалтын холбоо | 2017 оны 10 дугаар сарын 18-20 | Москва, ОХУ | Оросын сэтгүүл зүйн холбоо, боловсрол, судалгааны байгууллагууд ЮНЕСКО-гийн интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулах төсөлд оролцов. |
| Йорданы Хэвлэл мэдээллийн хүрээлэн | 2017 оны 10 дугаар сарын 24 | Амман, Йордан | интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулав. |
| Дэлхийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын долоо хоног | 2017 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 1 | Кингстон, Ямайка | Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол, соёл хоорондын яриа хэлэлцээний VII бага хурал |
| Интернэтийн нэр, хаягийн байгууллага | 2017 оны 10 дугаар сарын 28-наас 11 дүгээр сарын 3 | Абу Даби, Арабын Нэгдсэн Эмират Улс | ЮНЕСКО-гоос ICANN дээр интернэтийн шалгуур үзүүлэлтийн талаар зөвлөлдөв. |
| Вьетнамын интернэт форум | 2017 оны 11 дүгээр сарын 27-28 | Ханой, Вьетнам | Вьетнамын интернэт форумаар интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг ашиглан кибер хуулиудыг үнэлэх талаар авч хэлэлцэв. |

# Хоёр дахь шатны зөвлөлдөх арга хэмжээ

| Арга хэмжээ | Огноо | Байршил | ЮНЕСКО-гийн веб сайтад тавигдсан мэдээ |
|---|---|---|---|
| Хойд Африк, Африкийн интернэт засаглалын форум | 2017 оны 11 дүгээр сарын 28-наас 12 дугаар сарын 6 | Шарм Эл Шейх, Египет | ЮНЕСКО нь Египетэд болсон Хойд Африк, Африкийн интернэт засаглалын форумд интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн төслийн талаар хэлэлцүүлэв. |
| Дэлхийн дуу хоолой дээд хэмжээний уулзалт 2017 | 2017 оны 12 дугаар сарын 3 | Коломбо, Шри Ланка | Дэлхийн дуу хоолой дээд хэмжээний уулзалтын оролцогчид ЮНЕСКО-гийн интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтэд хувь нэмрээ оруулав. |
| Интернэт засаглалын форум 2017 | 2017 оны 12 дугаар сарын 17-21 | Женев, Швейцар | ЮНЕСКО-гоос Интернэт засаглалын форумд оролцогчидтой интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн талаар авч хэлэлцэв. |
| Дэлхийн сүлжээний санаачилгын мэдээлэл | 2018 оны 2 дугаар сарын 9 | Парисын төв байр, Франц | ЮНЕСКО-гоос Дэлхийн сүлжээний санаачилгад интернэтийн шалгуур үзүүлэлтийн талаар мэдээлэл өгөв. |
| Интернэт ба эрх зүйн бодлогын сүлжээний 2 дугаар хурал | 2018 оны 2 дугаар сарын 26-28 | Оттава, Канад | Эрх зүйн мэргэжилтнүүдийг ЮНЕСКО-гийн интернэтийн шалгуур үзүүлэлтийг сайжруулахад урьж оролцуулав. |
| Латин Америкийн бүс нутгийн зөвлөлдөх форум | 2018 оны 3 дугаар сарын 5 | Сан-Паул, Бразил | ЮНЕСКО-гоос Латин Америкт интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн цуврал зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж дуусав. |

| | | | |
|---|---|---|---|
| Холбоотой дэлхийн засаглалын инновац сэдэвт олон улсын ажлын уулзалт | 2018 оны 3 дугаар сарын 8-9 | Стенфорд, Калифорн, АНУ | |
| Арабын орнуудын бүсийн зөвлөлдөх форум | 2018 оны 3 дугаар сарын 12-13 | Тунис, Тунис | Арабын орнуудын тэргүүлэх мэргэжилтнүүд интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн ач холбогдлыг онцлов. |
| Мэдээллийн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалт 2018 | 2018 оны 3 дугаар сарын 21 | Женев, Швейцар | ЮНЕСКО-гоос Мэдээллийн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалтад интернэтийн шалгуур үзүүлэлт нь ТХЗ-д хүрэхэд хэрхэн хувь нэмэр оруулж чадах талаар танилцуулав. |
| Олон улсын сэтгүүл зүйн их наадам | 2018 оны 4 дүгээр сарын 14 | Перужа, Итали | Олон улсын сэтгүүл зүйн наадмын үеэр сэтгүүл зүйн холбоод интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг авч хэлэлцэв. |
| GIG-ARTS хурал | 2018 оны 4 дүгээр сарын 27 | Кардифф, Их Британи | Хурлын үеэр эрдэм шинжилгээний нийгэмлэг ЮНЕСКО-гийн интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлт боловсруулах төслийг сайшаан хүлээн авлаа. |
| Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр | 2018 оны 5 дугаар сарын 3 | Аккра, Гана | Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр 2018 |
| Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн талаарх ЮНЕСКО-гийн жишиг семинар | 2018 оны 5 дугаар сарын 3-5 | Бангкок, Тайланд | Үгээр илэрхийлэхийн аргагүй интернэтийн эрх чөлөө: Уран бүтээлч, бүтээгчид интернэтийн түгээмэл байдлын болон түүний ROAM зарчмыг илэрхийлэв. |
| Орбиком олон улсын симпозиум | 2018 оны 5 дугаар сарын 8-9 | Лима, Перу | Хотууд тогтвортой хөгжихийн тулд ТХЗ-ын 16.10 зорилтыг интернэтийн түгээмэл байдалтай нийцүүлж чадна. |
| RightsCon Toronto | 2018 оны 5 дугаар сарын 16-18 | Торонто, Канад | ЮНЕСКО интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх талаар оролцогч талуудтай зөвлөлдөв. |

# Гурав дахь шатны зөвлөлдөх арга хэмжээ

| Арга хэмжээ | Огноо | Байршил | ЮНЕСКО-гийн веб сайтад тавигдсан мэдээ |
|---|---|---|---|
| EuroDIG 2018 | 2018 оны 6 дугаар сарын 4 | Тбилис, Гүрж | ЮНЕСКО EuroDIG-2018 дээр интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн хоёр дахь хувилбарыг танилцуулав. |
| Дэлхийн хэвлэл мэдээллийн форум | 2018 оны 6 дугаар сарын 11-13 | Бонн, Герман | ЮНЕСКО-гоос Дэлхийн хэвлэл мэдээллийн форум дээр интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтээ танилцуулав. |
| Олон улсын хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны судалгааны нийгэмлэг, 2018 | 2018 оны 6 дугаар сарын 21 | Южин, Орегон, АНУ | ЮНЕСКО-гийн интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтээр практик бодит байдлыг үнэлэх хэрэгтэй гэж эрдэмтэн судлаачид дүгнэв. |
| Forum sur la gouvernance de l'Internet | 2018 оны 7 дугаар сарын 5 | Парис, Франц | ЮНЕСКО-гоос Францын интернэт засаглалын форумд нээлттэй, хүртээмжтэй интернэтийг дэвшүүлэв. |
| Африк дахь интернэтийн эрх чөлөөний форум, 2018 | 2018 оны 9 дүгээр сарын 28 | Аккра, Гана | 2018 оны Африк дахь интернэтийн эрх чөлөөний форумаар ЮНЕСКО-гийн интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлт, мэдээллийн нээлттэй байдлыг дэмжив. |

# 1, 2, 3 ДАХЬ ШАТАНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗӨВЛӨЛДӨХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГЛАЛ



### 1 дэх шат

Хот, улс: Брюссель, Бельги; Парис, Франц; Брага, Португал; Жакарта, Индонез; Стокхольм, Швед; Найроби, Кени; Таллин, Эстони; Дурбан, Өмнөд Африк; Женев, Швейцар; Бонн, Герман; Картахена, Колумби; Бангкок, Тайланд; Панам хот, Панам; Йоханнесбург, Өмнөд Африк; Буэнос-Айрес, Аргентин; Хонг Конг, Хятад; Лима, Перу; Вена, Австри; Москва, ОХУ; Кингстон, Ямайка; Абу Даби, АНЭУ; Ханой, Вьетнам.

### 2 дахь шат

Хот, улс: Шарм Эль-Шейх, Египет; Коломбо, Шри Ланка; Женев, Швейцар; Парис, Франц; Оттава, Канад; Сан Пауло, Бразил; Стэнфорд, Калифорн, АНУ; Тунис, Тунис; Перуджа, Итали; Кардифф, Их Британи; Аккра, Гана; Бангкок, Тайланд; Торонто, Канад

### 3 дахь шат

Хот, улс: Тбилис, Гүрж; Бонн, Герман; Южин, Орегон, АНУ; Парис, Франц; Брюссель, Бельги.

### Урьдчилсан туршилт

2018 оны 5 дугаар сард Бразил, Эквадор, Нигери, Пакистан зэрэг улсад боломжит байдлын үнэлгээ хийсэн.

2018 оны 7 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд Бразил, Сенегал, Тайланд зэрэг улсад туршилтыг зохион байгуулсан.



# ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН 1 ДЭХ ШАТНЫ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХУВААРИЛАЛТ




Нэг дэх үе шатны зөвлөлдөх арга хэмжээгээр интернэтийн түгээмэл байдлын өргөн хүрээний сэдвүүд, тэдгээрийг шалгуур үзүүлэлтийн хүрээнд нэгтгэх арга замыг авч хэлэлцсэн. 2017 оны 6 дугаар сарын 14-нд Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалтаар НҮБ-ын албан ёсны 6 хэлээрх цахим платформыг нээж, 2017 оны 10 дугаар сарын 31 хүртэл нээлттэй ажиллуулж, 198 оролцогчоос санал, зөвлөгөө авсан. Үйл ажиллагааны эхний шатанд шалгуур үзүүлэлтийн хүрээний төслийн хувилбарыг бэлтгэж, 2017 оны 12 дугаар сард цахим болон хэвлэмэл байдлаар нийтлэгдсэн интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох судалгааны баримт бичигт орох багц шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон.

# Хавсралт 3. Цахимаар өгсөн санал зөвлөгөө

Интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийг 2 шаттай зөвлөлдөх арга хэмжээний хүрээнд боловсруулсан.

Хэлэлцүүлгийн 1 дэх үе шатны зөвлөлдөх арга хэмжээ нь интернэтийн түгээмэл байдлын өргөн хүрээний сэдвүүд, тэдгээрийг шалгуур үзүүлэлтийн хүрээнд нэгтгэх арга замыг авч хэлэлцсэн. 2017 оны 6 дугаар сарын 14-нд Мэдээллийн нийгэмлэгийн дэлхийн дээд хэмжээний уулзалт дээр НҮБ-ын албан ёсны 6 хэлээр цахим зөвлөгөө өгөх платформыг нээж, 2017 оны 10 дугаар сарын 31 хүртэл нээлттэй ажиллуулж, 198 оролцогчоос санал, зөвлөгөө авсан. Үйл ажиллагааны эхний үе шатанд шалгуур үзүүлэлтийн хүрээний төслийн хувилбарыг бэлтгэж, 2017 оны 12 дугаар сард цахим болон хэвлэмэл байдлаар нийтлэгдсэн интернэтийн түгээмэл байдлын үзүүлэлтийг тодорхойлох судалгааны баримт бичигт орох шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон.

Хоёр дахь шатны зөвлөлдөх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 1-нээс 2018 оны 3 дугаар сарын 15 хүртэл зохион байгуулж, оролцогч талуудад энэхүү хүрээ болон шалгуур үзүүлэлтийн төсөлд санал өгөх боломжийг олгосон. Нэг дэх шатны нэгэн адил энэ шатанд 6 хэлээр цахим санал зөвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгуулж, нийт 138 санал, интерактив платформоор 136 санал хүлээн авсан.

Бүх санал зөвлөгөөг http://en.unesco.org/internetuniversality хаягаар хандан үзэх боломжтой.

## Нэг дэх шатанд хүлээн авсан санал зөвлөгөө, 2017 оны 6 дугаар сараас 10 дугаар сар

### Засгийн газар

| | |
|---|---|
| Албани Улсын Засгийн Газар | Албани |
| Болгар Улсын Тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбооны яам | Болгар |
| Commission nationale burkinabй pour l'UNESCO | Буркина Фасо |
| ЮНЕСКО дахь Дани улсын төлөөлөгч | Дани |
| Fundaciуn Museos de la Ciudad - Municipio de Quito | Эквадор |
| ЮНЕСКО-гийн Германы үндэсний комисс | Герман |
| Их Британийн Мэдээллийн комиссарын алба | Их Британи |
| Бүгд Найрамдах Доминикан Улсын Харилцаа холбооны хүрээлэн | Бүгд Найрамдах Доминикан Улс |
| Үндэсний статистик, газар зүйн хүрээлэн | Мексик |
| ЮНЕСКО-гийн Кени Улсын үндэсний комисс | Кени |
| Бүгд Найрамдах Доминикан Улсын Боловсролын яам | Бүгд Найрамдах Доминикан Улс |
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Экваторын Гвиней |
| Колумбын Мэдээллийн технологи, харилцаа холбооны яам | Колумби |
| Шинжлэх ухаан, технологи, дээд боловсрол, хүн ам, эрчим хүчний яам | Венесуэл |
| Харилцаа холбоо, технологийн яам | Сири |
| Хөгжлийн төлөвлөлт, статистикийн яам | Катар |
| Боловсрол, судалгааны яам | Швед |
| Шинжлэх ухаан, боловсролын яам | Болгар |
| ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яам | ОХУ |
| Боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацын яам | Барбадос |
| Бүгд Найрамдах Болгар Улсын Гадаад хэргийн яам | Болгар |
| Мэдээллийн технологи, харилцаа холбооны яам | Руандагийн Бүгд Найрамдах Улс |

| | |
|---|---|
| Дотоод хэргийн яам | Сомали |
| Зам тээврийн яам | Австри |
| Зам тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбооны яам | Болгар |
| Эрчим хүч, аялал жуулчлал, дижитал төслийн яам | Испани |
| Вануатугийн Цагдаагийн алба | Вануату |

## Олон нийтийн бусад салбар

| | | |
|---|---|---|
| Мансур Д. Лиман | Нигерийн холбооны радио корпорац | Нигери |
| | Instituto Federal de Telecomunicaciones | Мексик |
| | Consejo para la Transparencia | Чили |
| Ханна Маккаусланд | Мэдээллийн комиссарын алба | Их Британи |

## Засгийн газар хоорондын

| | | |
|---|---|---|
| Алехандро Патино | Латин Америк, Карибын тэнгисийн эдийн засгийн комисс | Чили |
| Ашвини Сатнур | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр | Энэтхэг |
| Маделин Салва | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) | Өмнөд Номхон Далай |
| Татиана Мурована | ЮНЕСКО-гийн Боловсролын мэдээлэл технологийн хүрээлэн | ОХУ |
| Эрх чөлөөний цахим эвсэл (Аргентин, Австрали, Австри, Канад, Коста Рика, Чех, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Гана, Ирланд, Япон, Кени, Латви, Литва, Мальдив, Мексик, Молдав, Монгол, Нидерланд, Шинэ Зеланд, Норвеги, Польш, Испани, Швед, Тунис, Их Британи, Америкийн Нэгдсэн Улс) | | |

## Интернэтийн техникийн болон мэргэжлийн нийгэмлэг

| | | |
|---|---|---|
| Абдурахамана Али Сумана | Association Nigйrienne pour l'Emergence des TIC | Нигери |
| Констанс Боммелаер де Леуссе болон Николас Зайдлер | Интернэтийн нийгэмлэг | Швейцар |
| Даниел Чонг | | Малайз |
| Габриэла Рамирез | | Аргентин |
| Гидеон | DotConnectAfrica | Кени |
| Горла Правен | Swecha | Энэтхэг |
| Малиса Ричардс | Интернэтийн нийгэмлэгийн Гайана дахь бүлэг | Гайана |
| Мойсес Роберто Эскобар | Бие даасан зөвлөх | Эл Салвадор |
| Омар Заккарди | FULL SYSTEM | Аргентин |
| Солана Ларсэн | Мозилла Сан | Герман |
| Тао Жин | Хубэй мужийн эмэгтэйчүүд, хүүхдийн эмнэлэг | Хятад |
| Том | eQualit.ie | Австрали |
| Татиана Жерейссати | NIC.br/Cetic.br | Бразил |
| Том Маккензи | ITEMS International | Франц |

### Хувийн хэвшил

| | | |
|---|---|---|
| Александрс Саулевикс | Latvijas Vega | Латви |
| Азам Шири Еганэ | | Иран |
| Бенжамин Увайгбе | VOGUISH Wifi | Нигери |
| Димитри Мартинис | ЭмСиЭм Дижитал Медиа | Грек |
| Хичем Резгүй | И-Энерги сэтгүүл | Алжир |
| Жимсон Олуфуеэ | Африкийн Мэдээлэл, харилцаа холбооны технологийн холбоо | Африк |
| Жон Акирэ | Нил Мэдээлэл, харилцаа холбооны технологийн институт ХХК | Уганда |
| Лорена Виллада | Mastterss G&R | Колумби |
| Рубен Кайседо | Ninguna | Колумби |
| Сам Бахоур | Хэрэглээний мэдээллийн менежмент | Палестин |
| Саид Абдулла Али Ал Ажми | Оманы Цахилгаан холбооны компани | Оман |

### Иргэний нийгэм

| | | |
|---|---|---|
| Абделкерим Оусман Тоуджани | Action Citoyenne pour l'Information et l'Education au Developpement Durable -ACIEDD | Чад |
| Абденоур Тоубринет | Алжирын мусульман скаутууд | Алжир |
| Аджитжату Барри Баут | ACSIS | Швейцар |
| Баудоуйн Шомбе | Centre Africain d'Echange Culturel | Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс |
| Карлос Герман Герреро Арготе | Hiperderecho | Перу |
| Клемент Чигбо | Анамбра мужийн Орон нутгийн усан хангамж, ариутгалын газар | Нигери |
| Деница Кожухарова | Эрх зүй болон интернэтийн сан | Болгар |
| Эсмералда Москателли | Номын сан, хүрээлэнгийн олон улсын холбоо | Нидерланд |
| Федерико Жиордано | Centro de Estudios para la Go-bernanza (CEG) | Аргентин |
| Идову Адэвале | Хэвлэл мэдээллийн эрхийн хөтөлбөр | Нигери |
| Жереми Малколм | Electronic Frontier Foundation | АНУ |
| Хосе Эдуардо Рохас | Fundaciyn REDES | Боливи |
| Жулиан Касасбуэнас Г | Colnodo | Колумби |
| Махендранаф Бусгопаул | Мавритусын Интернэт засаглалын форум болон Халлигийн хөдөлгөөн | Мавритус |
| Махеешвара Кириндигода | Шри Ланкын Интернэтийн нийгэмлэг | Шри Ланка |
| Маркос Урупа | Интервозес- Бразилын нийгмийн харилцааны хамтын нийгэмлэг | Бразил |
| Мариа Флоренсиа Ровери | Nodo TAU | Аргентин |
| Мариа Паз Каналес | Derechos Digitales | Чили |
| Марие Жанн Абега Энжи | Apeda-c | Камерун |
| Мариенграсиа Чиринос болон Скарлет Клементэ | IPYS Venezuela | Венесуэл |
| Марван Абдаллах Амиш | Sirte homeland for stability and social peace | Ливи |
| Марянт Фернандез Перез | Европын Дижитал Эрх | Европын Холбоо |
| Матилдэ Карлота Кампусмана Диаз | РОТАРИ | Перу |
| Мэй Лин Фанг | Хүн төвтэй интернэт | АНУ |
| Минна Килмалахти | Хүүхдийг ивээх сан | Финланд |

| | | |
|---|---|---|
| Мохамад | Janzour Association for Voluntee- rism and Development | Ливи |
| Мохаммед Сайяд | Африкийн мэдээлэл харилцаа холбооны технологийн нийгэмлэг | Египет |
| Авис Момени | Protйgй QV | Камерун |
| Мухаммад Шаббир | Интернэтийн нийгэмлэг, Исламабад Пакистан бүлэг | Пакистан |
| Надим Нашиф | 7amleh- Арабын нийгмийн сүлжээг хөгжүүлэх төв | Израил/Палестин |
| Нассер Юусфи | | Алжир |
| Нигат Дад | Дижитал эрхийн сан | Пакистан |
| Нжояа Даоуда | Centre d'entraonement aux Njoya Daouda mйthodes d'йducation active du Cameroun (CEMEA-C) | Камерун |
| Омар Лозано В | Responde Diversidad Ac. | Мексик |
| Петер Мичек | Access Now | АНУ |
| Понселет Илележи | Гамби улсын YMCA компьютер сургалтын төв болон Дижитал студи | Гамби |
| Рэймонд Матлала | Олон улсын дипломат харилцааны төлөөх Өмнөд Африкийн залуус | Өмнөд Африк |
| Рейналдо Алонсо | Кубын Мэдээлэл зүйн холбоо | Куба |
| Ричард Хилл | Интернэтийн зөв засаглалын холбоо | Швейцар |
| Роман Чуков | Олон улсын санаачилгыг дэмжих төв | ОХУ |
| Сандра Чахер | Asociaciyn Civil Comunicaciyn para la Igualdad | Аргентин |
| Шийтал Кумар | Глобал Партнерс Дижитал | Их Британи |
| Шу Луо | Бээжин хотын ЮНЕСКО-гийн клубуудын холбоо | Хятад |
| Сильви Сиам | Protйgй QV | Камерун |
| Уира Пора | Instituto Brazileiro de Politicas Digitais | Бразил |
| Владимир Чорни | Red en defensa de los derechos digitales (R3D) | Мексик |
| Зайнаб Нийкзад Акбари | Энхтайван, ардчилллын төлөөх тэгш байдал | Афганистан |

**Эрдэм шинжилгээ**

| | | |
|---|---|---|
| Адриан Шофилд | Жобургийн Программ хангамжийн инженерийн төв | Өмнөд Африк |
| Али Ал. Шуаили | Султан Кабусын Их Сургууль | Оман |
| Анжела Жакуэз | Universidad Autynoma de San- to Domingo, Recinto Santiago. (UASD) | Бүгд Найрамдах Доминикан Улс |
| Анна Мариа Сганга Фореро | IIS Campus Leonardo da Vinci Umbertide | Итали |
| Бачир Шахи | Ан-Нажахын Үндэсний Их Сургууль | Палестин |
| Бэн Акох | Манитобагийн Их Сургууль | Канад |
| Карисса Велиз | Оксфордын Их Сургууль, Практик ёс зүйн Уэхиро төв | Их Британи |
| Крис Зиелински | Винчестерийн Их Сургууль, Эрүүл мэндийн мэдээллийн түншлэлийн хөтөлбөр | Их Британи |
| Клаудиа Падовани | Падовагийн Их Сургууль | Итали |
| Клаудио Лусена | Парайба Мужийн Их Сургууль | Бразил |
| Кристобал Суарес Гуэрреро | Universidad de Valencia | Испани |
| Дэвид А. Брей | Харвардын Гэрээт гүйцэтгэх ммэргэжилтэн | АНУ |
| Экатерина Сорокова | Москвагийн Олон Улсын Харилцааны Дээд Сургууль | ОХУ |
| Элагина Мариа | Эдийн Засгийн Дээд Сургууль | ОХУ |
| Эммануэл Ангода | Лира Таун Коллеж | Уганда |

| | | |
|---|---|---|
| Фридрих Кроц | Бременийн Их Сургуулийн Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, интернэт судалгааны төв | Герман |
| Гуадалупе Вадилло | Universidad Nacional Autynom de Mйxico | Мексик |
| Хамад Мохаммед Салем Аль-Азри | Султан Кабусын Их Сургууль | Оман |
| Исмаел Пена-Лопез | Каталоны Нээлттэй Их Сургууль | Испани |
| Жон Самуэл | Мэдээлэл өгөөгүй. | |
| Хосе Луис Мендоза | Centro Latinoamericano de Investigaciones Sobre Internet | Венесуэл |
| Хосе Мануэл Гомез | Fundacion Metropolitana | Эквадор |
| Дмитри Кочегуров | Inion Ran | ОХУ |
| Лукас Коста дос Анжос | Instituto de Referкncia em Internet e Sociedade | Бразил |
| Луз Силвиа Роман Куэто | I.E. Cap Fap Jose Quicones Lima Peru | Перу |
| Мигуэл Фадул | Sociedad de Profesionales de las Miguel Fadul Telecomunicaciones de la Repu- Repъblica Dominicana | Бүгд Найрамдах Доминикан улс |
| Муратова Нозим | Узбекистаны Үндэсний Их Сургууль | Узбекистан |
| Нассер Хамдан аль Риями | Султан Кабусын Их Сургууль | Оман |
| Оба Абдулкадир ЛА'АРО | Илорины Их Сургууль | Нигери |
| Олуфеми Самсон Адетунжи | Акурегийн Технологийн Холбооны Их Сургууль | Нигери |
| Освалдо И. Ларанкуэнт Куэто | Instituto Tecnolygico de Santo Domingo (INTEC) | Бүгд Найрамдах Доминикан Улс |
| Паоло Баррон | Мексикийн Үндэсний Автономит Их Сургууль | Мексик |
| Пауло Роберто дэ Лима Лопез | Телемедицин академик сүлжээ - RUTE/RNP | Бразил |
| Рашид бин Хамад бин Хумайд Аль Балуши | Султан Кабусын Их Сургууль | Оман |
| Ренато Версейс Мадер | ESPM | Бразил |
| Роза М. Марино Месиас | Universidad de Andorra | Андорра |
| Рубен Арока Яакоме | Universidad Catylica de Santiago de Guayaquil | Эквадор |

### Сэтгүүл зүй/хэвлэл мэдээлэл

| | | |
|---|---|---|
| Аль Абдул Самед Хайдер Алжабри | | Ирак |
| Фредерико Линкс | ACTION эвсэл | Намиби |
| Фархад Ибрагимов | Нийтлэл мэдээллийн агентлаг | ОХУ |
| Кассем Хашан аль Рикаби | Арабын редакторуудын сүлжээ /Шомоос Хэвлэл мэдээллийн сан/ Үндэсний сэтгүүл зүйн төв | Ирак |
| Нашилонго Гервасиус | Интернэтийн нийгэмлэгийн Намиби дахь бүлэг | Намиби |
| Шрийдийп Раямажи | RayZnews | Непал |
| Сивуилэ Свигги Сэси | Internative Digital | Өмнөд Африк |

### Хувь хүмүүс

| | | |
|---|---|---|
| Александр С. | LATVIJAS VEGA | Латви |
| Амали Дэ Силва-Мичелл | | Шри Ланка |
| Кортни Радш | | АНУ |
| Эанг Сианхонг | Хааны Хууль зүй, Эдийн Засгийн Их Сургууль | Камбож |
| Эмилиа Корреа | Proyecto riquezas en latinoamerica | Аргентин |
| Эрика | | Аргентин |
| Горла Правийн | Swecha | Энэтхэг |
| Гүнтер Сайранек | Бие даасан зөвлөх | Герман |

| | | |
|---|---|---|
| Ич | | Хятад |
| Локеш Гужжараппа | | Энэтхэг |
| Луэл Рас Месфин Хайлэ Селассие | Дебре Зейтийн Вант Улс, Шинэ Өргүй, Далайд Гарцгүй Бүрэн Эрхт Улс | Ямайка |
| Принзессин Регин "Пеги" Хохэнцоллер | | АНУ |
| Тереса Лопез | Нийгмийн оновчтой шийдэл | Бүгд Найрамдах Доминикан улс |
| Силвиа Марсела Бласко | | Аргентин |
| Закир Бин Рехман | | Пакистан |

# ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН 2 ДАХЬ ШАТНЫ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХУВААРИЛАЛТ




2017 оны 12 дугаар сарын 1-нээс 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд 2 дахь шатны хэлэлцүүлгийг зохион байгуулж, сонирхогч бүх талд энэхүү хүрээ болон шалгуур үзүүлэлтийн төсөлд санал өгөх боломжийг олгосон. Хэлэлцүүлгийн 1 дэх шатны нэгэн адил 2 дахь шатанд 6 хэлээр явуулсан онлайн зөвлөгөөнөөр 138 санал хүсэлт, интерактив платформоор 136 санал хүсэлтийг хүлээн авсан.

## Хэлэлцүүлгийн 2 дахь шатанд хүлээн авсан санал. 2017 оны 12 дугаар сараас 2018 оны 3 дугаар сарын хооронд

### Засгийн газар

| | |
|---|---|
| Үндэсний цахим гэрчилгээ олгох газар | Тунис |
| Мэдээллийн технологийн аюулгүй байдлын үндэсний агентлаг | Тунис |
| Бахрейны Боловсрол, соёл, шинжлэх ухааны үндэсний комисс | Бахрейн |
| Цахилгаан холбооны үндэсний комисс | Гондурас |
| Цахилгаан холбооны үндэсний комисс | Гаити |
| Франц Улсаас ЮНЕСКО-д суугаа байнгын төлөөлөгч | Франц |
| Глобал Аффайрс Канад | Канад |
| Мэдээллийн технологийн газар | Оман |
| Хятадын Шинжлэх ухаан, техникийн мэдээллийн хүрээлэн | Хятад |
| Лаосын Үндэсний интернэтийн төв | Лаос |
| ЮНЕСКО-гийн Латвийн үндэсний комисс | Латви |
| ЮНЕСКО-гийн Мавритусын үндэсний комисс | Мавритус |
| Шуудан, харилцаа холбооны яам | Камерун |
| Шинжлэх ухаан, технологи, харилцаа холбооны яам | Коста Рика |
| Испани Улсын Дижитал хөтөлбөр, эрчим хүч, аялал жуулчлалын яам | Испани |
| Мэдээллийн технологи, харилцаа холбооны яам | Колумби |
| Харилцаа холбооны технологи, дижитал эдийн засгийн яам | Тунис |
| Харилцаа холбоо, мэдээллийн яам | Сингапур |
| Боловсролын яам | Тринидад ба Тобаго |
| Боловсрол, дээд боловсролын яам | Катар |
| Боловсрол, судалгааны яам | Швед |
| Бүгд Найрамдах Латви Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам | Латви |
| Боловсрол, шинжлэх ухаан, технологийн  яам | Танзани |
| Боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацын яам | Барбадос |
| Сангийн яам, Мэдээллийн системийн алба | Болгар |
| Төрийн захиргаа, харилцаа холбооны яам | Тринидад ба Тобаго |
| Зам тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбооны яам | Болгар |
| Польш Улсын Үндэсний өргөн нэвтрүүлгийн зөвлөл | Польш |
| Navodaya Vidyalaya Samiti | Энэтхэг |
| ЮНЕСКО-гийн Оманы үндэсний комисс | Оман |
| ЮНЕСКО-гийн Пакистаны үндэсний комисс | Пакистан |
| Палестин Улсын Хууль тогтоох зөвлөл | Палестин |
| Финланд Улсаас ЮНЕСКО-д суугаа байнгын төлөөлөгч | Финланд |
| Мексик Улсаас ЮНЕСКО-д суугаа байнгын төлөөлөгч | Мексик |
| Румын Улсаас ЮНЕСКО-д суугаа байнгын төлөөлөгч | Румын |
| Данийн Вант Улсаас ЮНЕСКО-д суугаа байнгын төлөөлөгч | Дани |
| Саудын Арабын Вант Улсаас ЮНЕСКО-д суугаа байнгын төлөөлөгч | Саудын Араб |
| Турк Улсаас ЮНЕСКО-д суугаа тайнгын Төлөөлөгч | Турк |

| | |
|---|---|
| Бразилийн нээлттэй Мэдээллийн портал | Бразил |
| Эль Сальвадорын Ерөнхийлөгчийн алба | Эль Сальвадор |
| ЮНЕСКО-гийн Шри Ланка улсын үндэсний комисс | Шри Ланка |
| ЮНЕСКО-гийн Шведийн үндэсний комисс | Швед |
| Нийтийн номын сан | Саудын Араб |
| АНУ-ын Тэнгисийн явган цэргийн корпус | АНУ |

**Засгийн газар хоорондын**

| | | |
|---|---|---|
| Аббас Үзүлмез | ЮНЕСКО | Олон улсын |
| Александру Фрунза-Николеску | Европын Зөвлөлийн Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Мэдээллийн нийгэм болон гэмт хэрэгтэй тэмцэх газар | Европ |
| Дина Юсеф Салиб | Александрины номын сан | Египет |
| Ито Мисако | ЮНЕСКО | Олон улсын |
| Жасмина Бирн | ЮНИСЕФ | Олон улсын |
| Мирна Барбар | Баруун Азийн орнуудын эдийн засаг, нийгмийн комисс | Ливан |
| Омар Салим Аль-Шанфари | ЮНЕСКО, Бүх нийтийн мэдээллийн хөтөлбөрийн зөвлөлийн Оман улсын төлөөлөгч | Оман |
| | Европын Зөвлөл, Мэдээлэл хамгаалах алба | Европ |
| | Европын Зөвлөлийн Хэвлэл Мэдээлэл, Интернэтийн хэлтэс, Мэдээлэл хамгаалах алба | Европ |
| Эрх чөлөөний цахим эвслийн гишүүд (Канад, Коста Рика, Эстони, Финлянд, Герман, Нидерланд, Норвег, Их Британи, Америкийн Нэгдсэн Улс) | | |

**Интернэтийн техникийн болон мэргэжлийн нийгэмлэг**

| | | |
|---|---|---|
| Ахмад Бахлак | Инженерийн оюутан | Ливан |
| Камила Трентаду | Сүлжээний мэдээллийн төв | Аргентин |
| Эрик Муссет | Азийн Хөгжлийн Банк | Камбож |
| Хафед Г.Яхмади | Арабын интернэтийн засаглалын форум, Сонирхогч талуудын зөвлөгөөний бүлгийн гишүүн | Тунис |
| Жон Мангар Риичдит | Өмнөд Суданы Залуусын интернэтийн засаглалын форум, Залуусын интернэтийн засаглалын форумын элч | Өмнөд Судан |
| Том МакКензи | ITEMS International | Франц |

**Хувийн хэвшил**

| | | |
|---|---|---|
| Алисия Паз | Гондурасын Олон улсын технологийн товчоо BIT-HN | Гондурас |
| Эндрю О'Коннор | Усны төлөө пенни | Их Британи |
| Лаурен Давес | Олон улсын үүрэн утасны операторуудын холбоо (GSMA) | Их Британи |
| Леонардо Сабоиа Гоес де Азеведо | Gestro Transversal | Бразил |
| Ма Давей | Kongxi | Куба |
| Мохаммед Тимоулали | GTOPIC | Марокко |

**Иргэний нийгэм**

| | | |
|---|---|---|
| Бабатунде Окуноеэ | Парадигмын санаачилга | Нигер |
| Бренда Итзел Паласиос | Los nicos no se divorcian | Мексик |
| Клэре Милн | Антелоп зөвлөгөө өгөх газар | Их Британи |
| Дебора Браун | Дэвшилтэт харилцаа холбооны нийгэмлэг | АНУ |

| | | |
|---|---|---|
| Елена Шерстобожева | Хэвлэл мэдээллийн хуульч | ОХУ |
| Эрика Смит | Дэвшилтэт харилцаа холбооны нийгэмлэг, Эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх хөтөлбөр | Мексик |
| Гаятри Хандхадай | Дэвшилтэт харилцаа холбооны нийгэмлэг, Харилцаа мэдээллийн бодлогын хөтөлбөр | Энэтхэг |
| Густаво Гомез | OBSERVACOM | Уругвай |
| Жейсон Пиелемейер | Дэлхийн сүлжээний санаачилга | АНУ |
| Жереми Малколм | Цахим хязгаар сан | АНУ |
| Жессика Диир | Сошиал Медиа Эксченж | Ливан |
| Жорж Варгас | Викимедиа сан | АНУ |
| Лиз Вүүлэри | Ардчилал болон технологийн төв | АНУ |
| Лужайн Альхатлоул | Хүний эрхийн төлөө тэмцэгч | Саудын Араб |
| Маркос Урупа | Интервозес - Бразилын хамтын нийгмийн харилцаа холбоо | Бразил |
| Марта Жиралдо | Колумбын системийн инженерүүдийн холбоо | Колумби |
| Мэриант Фернандес Перез | Европын цахим эрх | Европын Холбоо |
| Майк Женсен | Дэвшилтэт харилцаа холбооны нийгэмлэг | Өмнөд Африк |
| Мириам Кристина Рохас | REDES Сан | Боливи |
| Рожер Робертс | TITAN | Бельги |
| Шиитал Кумар | Global Partners Digital | Их Британи |
| Стевен Вайбер | Номын сангийн холбоо болон хүрээлэнгийн олон улсын холбоо | Нидерланд |
| Санни Канг | Цахим нууцлалын мэдээллийн төв | АНУ |
| Валерия Бетанкурт | Дэвшилтэт харилцааны нийгэмлэг | Эквадор |
| Владимир Кортес Рощдественский | Artнculo 19 | Мексик |
| Зотан Мави | Дижитал эрх мэдэл сан | Энэтхэг |
| | netCommons | Европ |

**Эрдэм шинжилгээ**

| | | |
|---|---|---|
| Бузиан Зейд | Шаржа дахь Америкийн Их Сургууль | Арабын Нэгдсэн Эмират Улс |
| Крис Зиелински | Винчестерийн Их Сургууль | Их Британи |
| Даг Пинар | Кадир Хасын Их Сургууль | Турк |
| Дан Свантессон | Бондын Их Сургууль | Австрали |
| Деннис Редекер | Бременийн Их Сургууль, Арлын арк төсөл | Герман |
| Эйлиин Донахо | Стэнфордын Дэлхийн Дижитал Бодлогын Инкубатор | АНУ |
| Елена Вартанова | Москвагийн Улсын Их Сургууль | ОХУ |
| Фред Мудхай | Ковентрийн Их Сургууль | Их Британи |
| Иван Сзекели | Төв Европын Их Сургууль | Унгар |
| Жое Каннатачи | Гронингений Их Сургуулийн хувийн нууцлалын эрхийн асуудлаарх тусгай илтгэгч | Нидерланд |
| Жорж Балладарес | Эквадорын Пап Ламын Католик Их Сургууль | Эквадор |
| Мария Михалис | Вестминстерийн Их Сургууль | Их Британи |
| Марлин Тадрос | Виртуаль Активизм | АНУ |
| Мауро Сантаниэло | Салерногийн Их Сургууль | Итали |
| Нермине Махмуд-Рифаат Абдель Азиз | Каир дахь Америкийн Их Сургууль | Египет |

| | | |
|---|---|---|
| Патрисия Моралес | Лёвены Их Сургууль | Бельги |
| Пьер Гедеон | Ливаны Канад Их Сургууль | Ливан |
| Рольф Х Вебер | Цюрихийн Их Сургууль | Швейцар |
| Рори МакГреал | Атабаскагийн Их Сургууль | Канад |
| Сана эл Харби | Жэдда Их Сургууль | Тунис |
| | Тураны Их Сургуулийн Сэтгүүл зүй, орчуулгын тэнхим | Казахстан |

**Сэтгүүл зүй/хэвлэл мэдээлэл**

| | | |
|---|---|---|
| Ияад Алрифай | Кампанит ажлын төв - Сада нийгмийн төв | Палестин |
| Надежда Ажгихина | Европын сэтгүүлчдийн холбоо | ОХУ |
| Радхакришнан Сивараман | Ниш Медиа Зөвлөх | Энэтхэг |

**Хувь хүмүүс**

| | | |
|---|---|---|
| Элке Томпсон | Шинэ Зеландын үндэсний номын сан | Шинэ Зеланд |
| Эмилиа Корреа | Сантиаго дель Эстеро мужийн Эмэгтэйчүүдийн зөвлөл | Аргентин |
| Гюнтер Сайранек | Зөвлөх | Герман |
| Жереми Миллард | Технологи, харилцаа холбооны салбарын мэргэжилтэн | Их Британи |
| Ласло Дротос | Үндэсний Сеченийн номын сан | Унгар |
| Пол Уэст | Үндэсний нээлттэй сургалтын систем | Өмнөд Африк |
| Радхакришнан Сивараман | МД Ниш Медиа Зөвлөх | Энэтхэг |
| Реви Пиллай | | Их Британи |
| Ригоберт Кенмагне | | Франц |
| Стивен Стилвелл | | АНУ |

# Хавсралт 4. Интернэтийн түгээмэл байдлын гол шалгуур үзүүлэлт

Энэхүү хавсралтад интернэтийн түгээмэл байдлын шалгуур үзүүлэлтийн 4-өөс 8 дугаар бүлгийн иж бүрэн багцаас сонгон авсан шалгуур үзүүлэлтийн дэд багцыг тодорхойлов. Шалгуур үзүүлэлтийн энэхүү дэд багц нь иж бүрэн үнэлгээ хийхэд хангалттай нөөцгүй тохиолдолд үнэлгээг хийхэд ашиглаж болох үндсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлдог.

“Нэгтгэсэн болон ангилсан” гэсэн хэллэг бүхий шалгуур үзүүлэлтийн тухайд ангилан задлахдаа хүйс, нас, үндэс угсаа, нутаг дэвсгэр, хөгжлийн бэрхшээл зэрэгт онцгойлон анхаарах хэрэгтэй.

# Ангилал R • Эрх

### RA.1 Эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлэлцээр, хууль тогтоомж, стандарт, хууль ёсны зарчимд нийцсэн хүний эрхийг хангах, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бий эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ, хууль тогтоомж, стандартад нийцсэн үндсэн хууль, эрх зүйн орчин, түүний дотор хяналтын зохицуулалт бий эсэх, тэдгээрийг засгийн газар болон эрх бүхий байгууллага даган мөрдүүлж байгааг нотлох баримт.

### RA.2 Хүний оффлайн орчинд эдэлдэг эрхийг онлайн орчинд нэгэн адил хамгаалсан байх ёстойг зөвшөөрсөн хууль эрх зүйн орчин бий эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хувь хүн онлайн/оффлайн горимд ижил эрхтэй байх зарчмыг хууль болон практикт хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж байгаагийн нотолгоо.

### RB.2 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан аливаа хязгаарлалтыг дэлгэрэнгүй тодорхойлж, эрхийн талаарх олон улсын гэрээ, хууль, стандартын дагуу ил тод хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцүүлэн тогтоосон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн хязгаарлалт, тэдгээрийг засгийн газар болон эрх бүхий бусад байгууллага хүлээн зөвшөөрдөг тухай нотолгоо.

### RB.4 Хуулиар ямар нөхцөлд платформ, онлайн үйлчилгээ эрхлэгчийн нийтэлсэн болон тэдний хэрэглэгчдийн хуваалцсан контентын төлөө хариуцлага хүлээдэг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Зуучлалын хариуцлага, агуулга/контент зохицуулалтын эрх зүйн орчин нь эрхийн талаарх олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцдэг эсэх, хэрэгжилтийг нотлох баримт.

### RC.2. Засгийн газар интернэтийг бүхэлд нь болон тодорхой онлайн үйлчилгээ, програм хангамж, веб сайтад нэвтрэх эрхийг хаадаг, хяналт тавьдаг эсэх, үүнийг ямар үндэслэлээр, хэр ил тод байдлаар хэрэгжүүлдэг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Ил тод байдал, хяналтын зохицуулалтыг оролцуулан интернэт хандалтыг хаадаг, хяналт тавьдаг эрх зүйн орчин;
- Хандалтыг хаах, хяналт тавихтай холбоотой засгийн газар, шүүхийн шийдвэр, бусад баталгаатай, эрх мэдэл бүхий эх сурвалжаас авсан нотолгоо;
- Интернэт холболтыг салгах эсхүл бусад хязгаарлалт хийх тохиолдол, шинж үндэслэл;

- Сүүлийн 3 жилийн хугацаанд контентод хандах эрхэд тавьсан хязгаарлалт, домэйн нэрийг хүчингүй болгосон тохиолдол, бусад хөндлөнгийн оролцооны тоо, чиг хандлага.

### RC.4 Хувь хүн, сэтгүүлч, бусад онлайн/хэвлэл мэдээллийн хэрэгслийн этгээд цахим мэдээлэлд онлайнаар нэвтэрснийхээ төлөө баривчлагдах, яллагдах, сүрдүүлгэд өртөж байсан эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хуулийн заалт, практикийн хамрах хүрээ, мөн чанар;
- Зөвшөөрөгдөх хязгаарлалтын нөхцөл байдал, шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор олон улсын гэрээний дагуу хууль бус контентыг олж авсан үндэслэлээр дур мэдэн саатуулж, мөрдсөн хэргийн тоо.

### RD.2 Төрийн бус байгууллага онлайнаар чөлөөтэй зохион байгуулагдаж чаддаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Онлайн зохион байгуулалтыг нотлох баримт, ийм байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс зүй бусаар оролцоогүйг нотлох баримт.

### RD.3 Төрийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцохыг дэмжсэн цахим засаглал ба/буюу цахим оролцооны талаарх төрийн бодлого байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Цахим засаглал, цахим оролцооны талаар төрөөс баримталж буй бодлого, тухайлбал, интернэтийг олон нийтийн хэлэлцүүлэгт ашиглах байдал;
- НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газраас гаргадаг цахим оролцооны индекс дэх байр/зэрэглэл.

### RE.2 Засгийн газар, хувийн хэвшил болон бусад байгууллагын мэдээлэл олж авах, хохирол барагдуулах эрхийг оролцуулан хувь хүний мэдээллийн хамгаалалтыг хуулиар баталгаажуулж, практикт хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хяналтын механизм, хохирол барагдуулах арга хэрэгсэл зэрэг мэдээлэл хамгаалах хууль эрх зүйн орчин, засгийн газар болон эрх бүхий бүхий байгууллага тэдгээрийг хүлээн зөвшөөрч, мөрдүүлж байгааг нотлох баримт;
- Хувийн мэдээллийг арилжааны зорилгоор ашиглах, хяналтын механизм, хохирол барагдуулах арга хэрэгсэл болон олон улсын мэдээлэл дамжуулалт/аюулгүй байдлын талаарх хууль эрх зүйн орчин;
- Мэдээлэл хамгаалах бие даасан байгууллага ба түүнтэй адилтгах байгууллага байдаг эсэх, түүний эрх мэдэл.

### RE.3 Хэрэглэгчийн мэдээллийг хууль ёсны дагуу авах хууль сахиулах болон бусад байгууллагын эрх мэдлийг зайлшгүй шаардлагатай, зохистой бөгөөд эрхийн тухай олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлцэл, хууль тогтоомж, стандартад нийцсэн нөхцөл байдлаар хязгаарладаг эсэх?[341]

**Шалгуур үзүүлэлт:**

- Бие даасан хяналт, ил тод байдал зэрэг мэдээллийг хуулийн дагуу саатуулах эрх зүйн орчин байгаа эсэх, засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагын хэрэгжилттэй холбоотой нотлох баримт.

### RF.1 Засгийн газрын бодлогод интернэтийг хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролтой[1] холбоотой стратеги, ялангуяа Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт (ЭЗНСЭТП/ICESCR)-ын эрхийг тусгасан эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролын салбарын стратегид а) интернэт, б) ЭЗНСЭТП-ын эрхийг хүлээн зөвшөөрснийг нотлох баримт;
- Интернэтийн ажил эрхлэлт, эрүүл мэнд, боловсролд үзүүлэх нөлөөллийн талаар засгийн газраас хийсэн судалгааны баримт.

### RF.2 Нийт иргэд, бусад хувь хүн интернэтийн давуу талыг ашиглан соёлын үйл ажиллагаанд оролцох боломжтой эсэх?

[1] Эдгээрийг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг төлөөлөх бүлгүүдээр сонгосон болно.

**Шалгуур үзүүлэлт:**

- Янз бүрийн нийгэм/үндэстний хоорондын интернэтийн хүртээмж, ашиглалтын ялгааны цар хүрээ, мөн чанар;
- Цахим орчинд буй соёлын өвийн талаарх төрийн бодлого байдаг эсэх;
- Бүтээлээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн хуулийн болон бусад хууль ёсны баталгаа.

# Ангилал O • Нээлттэй байдал

### OA.2 Бизнес, шинжлэх ухаан, иргэний нийгмийн хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин нь интернэтийн инновацыг дэмждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн шинэ бизнес, инновацыг бий болгоход хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчныг нотлох баримт;
- Хувийн хэвшил, МХХТ-ийн бизнесийн зохицуулалтын орчин, тэр дундаа интернэтэд суурилсан бизнесийн туршлагын талаарх ойлголт.

### OB.3 Төрөөс чөлөөт болон нээлттэй эхийн программ хангамжийг оролцуулан оюуны өмчийн лицензийн\ олон төрлийг дэмждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Чөлөөт болон нээлттэй эхийн программ хангамж болон бусад төрлийн лицензийн талаарх төрийн бодлого;
- Төрийн байгууллагад төрөл бүрийн лицензийн сонголттой программ хангамжийг ашиглаж буй байдал.

### OB.4 Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд интернэт болон төрийн цахим үйлчилгээг хэрэглэхэд хялбар байлгах стандартыг сурталчилж, хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрэглэхэд хялбар байдлыг хангах талаарх төрийн бодлого, үйл ажиллагаа;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжтэй байдлын бодлого, үйл ажиллагааны талаарх ойлголт.

### OC.1 Харилцаа холбооны зах зээлд олон улсын хэм хэмжээ, стандартад нийцсэн бие даасан зохицуулалт байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Бие даасан зохицуулах байгууллага болон эрх бүхий байгууллага байдаг эсэх;
- Харилцаа холбооны бизнес эрхлэгч, хэрэглэгчдийн холбоо болон бусад байгууллагын зохицуулалтын чанарын талаарх ойлголт зэрэг зохицуулалтын гүйцэтгэлийг нотлох баримт.

### OC.4 Харилцаа холбооны хандалтын сүлжээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хангалттай үр дүнтэй өрсөлдөөнтэй эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Суурин болон хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо;
- Суурин болон хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь.

### OD.4 Төрөөс боловсролын нээлттэй нөөцийг ашиглахыг дэмжиж, эрдэм шинжилгээний болон судалгааны эх сурвалжийг нээлттэй ашиглах боломжийг олгодог эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Боловсролын нээлттэй нөөцийн талаарх боловсролын бодлого;
- Дээд боловсролын байгууллага, суралцагч нь эрдэм шинжилгээний болон судалгааны эх сурвалжийг ашиглах талаарх зохицуулалт.

### CD.5 Төрөөс интернэтийн үйлчилгээ эрхлэгчээс сүлжээний урсгалыг тодорхой төрлийн контент болон эх сурвалжийн агуулгаар ялгахгүйгээр ил тод, шударга, төвийг сахисан байдлаар удирдахыг шаарддаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Сүлжээний ялгаваргүй байдал, онлайн ба сүлжээний үйлчилгээний өрсөлдөөнтэй холбоотой хуулийн зохицуулалт, арга хэмжээ.

### CE.1 Олон нийтийн болон олон нийтээс санхүүжүүлсэн мэдээлэлд нээлттэй хандах зохих нууцлалын хамгаалалт бүхий хууль тогтоомжийг баталж, хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Олон улсын хэм хэмжээ[243], нууцлалын шаардлагад нийцсэн нээлттэй мэдээлэлд нэвтрэх хууль эрх зүйн орчин бий эсэх;
- Нээлттэй мэдээллийг ашиглах боломжтой нөөц, онлайнаар ашиглаж байгаа нотолгоо.

### CE.2 Төрийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага нь албан ёсны бүх хэлээр, голлох бүх веб хөтчөөр хандах боломжтой веб сайттай эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Веб сайтыг зохих хэл, веб хөтчийн хандалтаар хангах төрийн бодлого, үр дүнтэй хэрэгжилтийг нотлох баримт;
- Веб сайттай төрийн үйлчилгээний эзлэх хувь (НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн газраас гаргадаг онлайн үйлчилгээний индекс дэх зэрэглэл).

# Ангилал А • Бүх нийтэд хүртээмжтэй байх

### AA.1 Интернэтийн хандалт, ашиглалтын талаарх статистик мэдээллийг үндэсний статистикийн систем ба/буюу эрх бүхий бусад байгууллагаас тогтмол системтэйгээр тогтмол цуглуулдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Өрхийн судалгаа зэрэг олон эх сурвалжаас нэгтгэсэн болон ангилсан статистикийн мэдээллийг цуглуулах зохицуулалт;
- Өрхийн бие даасан судалгаа болон интернэтийн нэгдсэн хандалт, ашиглалттай холбоотой бусад нотолгоо.

### AA.4 Төрөөс бүх нийтийг найдвартай, хямд өргөн зурвасын сүлжээгээр хангах бодлого, хөтөлбөртэй эсэх, энэ нь үр дүнтэй хэрэгждэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Бүх нийтийн хүртээмжийн талаарх стратеги, түүний хэрэгжилтийг нотлох баримт;
- Бүх нийтийн хүртээмжид чиглэсэн ахиц дэвшлийг нотлох статистик баримт, нэгтгэсэн болон ангилсан байдлаар[2].

*Цахилгаан эрчим хүчний боломжтой хамааралтайгаар нөхцөл байдлаас хамаарах 3.D шалгуур үзүүлэлтийн өгөгдөл/нотолгоог авч үзэх шаардлагатай.*

### AB.1 Хүн амын хэдэн хувь нь интернэтийг ямар давтамжтай ашигладаг вэ? Энэ хувь нэмэгдэж байгаа эсэх?[3]

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтэд нэвтэрсэн хүмүүсийн эзлэх хувь, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- Интернэтэд холбогдсон айл өрхийн эзлэх хувь;[343]

[2] Нас, хүйс, газар нутаг, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдал зэрэг тодорхой хамаарлыг авч үзнэ.
[3] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.

- 100 хүнд ногдох интернэт хэрэглэгчийн тоо, хэрэглээний давтамжаар нэгтгэсэн болон ангилсан байдлаар;[344]
- 100 хүнд ногдох олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тоо (нийгмийн сүлжээ, бичил блог, мессеж, хэрэглэгчийн үүсгэсэн видео урсгал)[4], нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- 100 хүнд ногдох олон нийтийн хэвлэл мэдээллийн веб сайтад (өмнө тодорхойлсон) хандсан тоо.

### AB.3 Хүн амын хэдэн хувь нь харилцаа холбоо/өргөн зурвасын үйлчилгээг ашигладаг вэ? Энэ нь нэмэгдэж байгаа эсэх[5]?

**Шалгуур үзүүлэлт:**

- Гар утас эзэмшдэг хувь хүмүүсийн эзлэх хувь, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;[345]
- 100 хүнд ногдох өргөн зурвасын суурин сүлжээний хэрэглэгчийн тоо, нэгтгэсэн болон ангилсан байдлаар;[346]
- 100 хүнд ногдох үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээний хэрэглэгчийн тоо, зурвасын өргөн, нэгтгэсэн болон ангилсан байдлаар.[347]

### AB.4 Интернэт хэрэглэгч болон хэрэглэгч бус хүмүүст интернэтэд нэвтрэхэд ямар саад бэрхшээл тулгардаг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- Өрхийн судалгаа ба/буюу бусад эх үүсвэрээс авсан интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгардаг саад бэрхшээлийн талаарх ойлголт (хэрэглэгч болон хэрэглэгч бус хүмүүс), нэгтгэсэн болон ангилсан байдлаар[6].

### AC.1 Хүн амын бүх хэсэг нь интернэтэд холбогдох боломжтой гар утсыг хямд үнээр авах боломжтой эсэх[7]?

**Шалгуур үзүүлэлт:**

- Зардал: а) хямд[348] гар утас, б) ухаалаг гар утас, в) нэг хүнд ногдох сарын үндэсний нийт орлого (ҮНО)-д эзлэх хувь;
- Интернэт хэрэглэгч болон хэрэглэгч бус хүмүүсийн хямд үнийн талаарх ойлголт, нэгтгэсэн болон ангилсан байдлаар.

### AC.2 Хүн амын бүх хэсэгт өргөн зурвасын[349] интернэт, хэрэглээ нь зохистой үнэтэй эсэх[8]?

**Шалгуур үзүүлэлт:**

- Анхан шатны[350] суурин өргөн зурвасын холболт ба ашиглалтын сарын зардал, нэг хүнд ногдох сарын ҮНО-д эзлэх хувь;
- Анхан шатны[351] хөдөлгөөнт өргөн зурвасын холболт ба ашиглалтын сарын зардал, нэг хүнд ногдох сарын ҮНО-д эзлэх хувь;
- Боломжтой эсхүл бусад тохиолдолд тэг-үнэлгээтэй эсхүл хямд өртөгтэй хандалт.

### AD.1 Бүс нутаг хооронд болон хот хөдөөгийн хооронд өргөн зурвасын хүртээмж, ашиглалтын хувьд мэдэгдэхүйц ялгаатай эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Хот, хөдөөгийн өргөн зурвасын сүлжээний газар зүйн хамрах хүрээ, зурвасын өргөнөөр;
- Холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч болон интернэт хэрэглэгчийн тоо, боломжтой бол хот ба хөдөө, бүс нутгаар ангилсан байдлаар.

### AD.5 Бүх насны бүлгийн насанд хүрэгчид интернэтийг ижил хэмжээгээр ашигладаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэт ашигладаг янз бүрийн насны бүлгийн насанд хүрэгчдийн эзлэх хувь, хэрэглээний давтамж ба төрлийг[9] хүйсээр ангилсан байдлаар;

[4] Олон нийтийн хэвлэл мэдээллийн нөлөөлөл, хамрах хүрээ нь улс орнуудад харилцан адилгүй байдгийг анхаарна уу.
[5] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.
[6] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.
[7] Төгсгөлийн зүүлтийг харна уу. Үнэлгээнд улс орнуудын болон цаг хугацааны хувьд "суурь түвшин"-ий тодорхойлолт өөр өөр байдгийг анхаарах шаардлагатай. Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.
[8] Төгсгөлийн зүүлтийг харна уу. Үнэлгээнд улс орнуудын болон цаг хугацааны хувьд "өргөн зурвасын" болон "суурь түвшин" гэсэн тодорхойлолт нь өөр өөр байдгийг анхаарах хэрэгтэй.
[9] "Ашиглалтын төрөл" гэж интернэт хэрэглэгчдийн нийгмийн сүлжээ ашиглах, веб мэдээ үзэх, тоглоом тоглох, цахим шуудан шалгах зэрэг олон төрлийн онлайн үйл ажиллагааг хэлнэ.

- Интернэтэд нэвтрэх, ашиглахад тулгардаг саад бэрхшээлийн талаарх ойлголт, эцсийн хэрэглэгчдийн интернэтэд нэвтрэх, ашиглах үнэ цэнийн талаарх ойлголтыг (боломжтой бол) нас, хүйсээр ангилсан байдлаар.

### AE.1 Улсын хэмжээнд хэдэн интернэт домэйн нэр, сервер байдаг вэ?

**Шалгуур үзүүлэлт:**

- 1000 хүнд ногдох бүртгэгдсэн домэйн нэрийн тоо (ccTLDs. gTLDs[352] болон IDNccTLDs нэрийг оролцуулан) болон боломжтой бол чиг хандлага;
- Нэг сая хүнд ногдох аюулгүй веб серверийн тоо, боломжтой бол чиг хандлага.

### AE.4 Орон нутагт бүтээсэн контентыг оролцуулан орон нутгийн болон уугуул иргэдийн хэлээрх интернэт контентын хэмжээ[10] ихсэж, өсөн нэмэгдэж байгаа эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Голлох онлайн үйлчилгээнд үндсэн хэл, бичгийг ашиглах боломжтой хүн амын эзлэх хувь;
- Хүн амын дунд томоохон хэрэглэгчийн бүлэгтэй бүх хэлээрх төрийн веб сайтын агуулгын хүртээмж.

### AF.1 ЕБС, боловсролын сургалтын хөтөлбөрт МХХТ, хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын сургалтыг оруулж, үр дүнтэй бөгөөд аюулгүй хэрэглээнд чиглүүлж, хөтөлбөрийг практикт хэрэгжүүлдэг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Сургуулийн сургалтын хөтөлбөр, тэр дундаа хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол, соёл хоорондын яриа, МХХТ-ийн ур чадвар олгох сургалтын талаарх бодлого;
- Бага, дунд, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн баримт бичгүүд;
- МХХТ-ийн сургалттай эсхүл сургалтад МХХТ-ийг ашигладаг бага, дунд сургуулийн багш нарын эзлэх хувь;
- Интернэтэд холбогдсон сургуулиудын эзлэх хувь;
- Сургууль дээрээсээ интернэтэд холбогдох боломжтой суралцагчдын эзлэх хувь.

### AF.3 Хүн амын болон ажиллах хүчний хэдэн хувь нь МХХТ–ийг ашиглах чадвартай вэ?[11]

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтийн тодорхой ур чадвартай хэрэглэгчдийн эзлэх хувь, ур чадварын түвшингээр (анхан, дунд, ахисан), нэгтгэсэн болон ангилсан байдлаар;[353]
- Ажлын байранд МХХТ ашигладаг боловсон хүчний эзлэх хувь, ур чадварын түвшин ба төрлөөр (үндсэн, дунд, ахисан), нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (ШУТИМ/STEM)[12] болон МХХТ-ийн сургалтад хамрагдсан их дээд сургуулийн оюутнуудын эзлэх хувь, хүйсээр ангилж, дэлхийн дундажтай харьцуулсан байдлаар.

---

[10] Үүнд бичвэр, аудио, видео контентыг авч үзэх шаардлагатай.
[11] Ангилахдаа хүйс, нас, нутаг дэвсгэр, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй байдалд онцгой анхаарах хэрэгтэй.
[12] Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик

# Ангилал M • Олон талт сонирхлын бүлгүүдийн оролцоо

### MA.1 Интернэтийн хөгжүүлэлт болон бодлого боловсруулалтын бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо нь олон улсын жишигт нийцсэн эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Холбогдох олон улсын жишигт нийцсэн зохицуулалт, орчинтой эсэх;[354]
- Цахим худалдаа, тоон гарын үсэг, кибер аюулгүй байдал, өгөгдлийн хамгаалалт, хэрэглэгчийг хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин.

### MB.2 Төрөөс үндэсний интернэтийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулахад сонирхлын бүлгүүдийг идэвхтэй оролцуулдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэтийн хөгжил, ашиглалттай холбоотой үндэсний бодлого боловсруулах институц, үйл явцад олон талт сонирхлын бүлгүүдийн зөвлөлдөх уулзалт болон оролцооны зохицуулалт байдаг эсэх;
- Идэвхтэй оролцож буй төрийн бус сонирхогч талын тоо, сонирхогч талыг бүлгээр, хүйсээр ангилсан байдлаар

### MB.3 Интернэт засаглалын үндэсний форум ба/буюу бусад олон талт сонирхлын бүлгийн форум нь идэвхтэй оролцоотой сонирхлын бүх бүлэгт нээлттэй байдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Интернэт засаглалтай холбоотой үндэсний интернэт засаглалын форум (ИЗФ) ба/буюу бусад олон талт сонирхлын бүлгийн форум байдаг эсэх;
- Үндэсний ИЗФ болон бусад форумын оролцогчдын өгөгдөл, хүйс ба сонирхлын бүлгээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар, ялангуяа алсын зайнаас оролцох зохицуулалтыг оролцуулан сонгосон бүлгийн (жишээлбэл, боловсролын яам, ЖДҮ, хүүхдийн асуудлаар ажилладаг ТББ, үйлдвэрчний эвлэл гэх мэт) оролцоо.

### MC.2 Тухайн улсын засгийн газар, бусад сонирхлын бүлгүүд МХХТ болон интернэттэй холбоотой олон улсын томоохон форумд идэвхтэй оролцдог эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Дэлхийн болон бүс нутгийн ИЗФ-д оролцсон төрөл бүрийн сонирхлын бүлгийн оролцогчийн тоо, нэг сая хүн амд ногдох тоо, сонирхлын бүлэг ба хүйсээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар;
- ОУЦХБ-д оролцох албан ёсны төлөөлөгчдийн бүрэлдэхүүн дэх төрийн бус сонирхлын бүлгүүдийн оролцоо, сонирхлын бүлэг ба хүйсээр нэгтгэсэн болон ангилсан байдлаар.

### MI.3 Засгийн газар, бусад сонирхогч талууд ОУИНХБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- ОУИНХБ-ын Засгийн газрын зөвлөх хорооны гишүүнчлэл, идэвхтэй оролцоо;
- ОУИНХБ-ын сонгуулийн хэсэг, ажлын хэсэг болон бусад форумын гишүүнчлэл, идэвхтэй оролцоо.

# Ангилал X • Зангилаа асуудлуудын шалгуур үзүүлэлт

## XA.1 Интернэтийг хөгжүүлэх үндэсний бодлого, стратегид эмэгтэйчүүд, охидын эрх ашиг сонирхол, хэрэгцээг тодорхой тусгаж, үр дүнтэй хяналт тавьдаг эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

- Үндэсний стратегид тусгасан, а) Эмэгтэйчүүдийн интернэтийн хэрэгцээ шаардлага, б) Эмэгтэйчүүдийн эрх мэдэл, жендерийн тэгш байдлыг дэмжих интернэтийн боломж;
- МХХТ/Интернэттэй холбоотой бодлого боловсруулах төрийн удирдах албан тушаалд ажилладаг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо;
- МХХТ-ийн хүртээмж, ашиглалтын талаарх боломжит өгөгдөл, хүйсээр ангилсан байдлаар
- Интернэтийн хандалт, ашиглалтын талаарх стратегид тусгагдсан эмэгтэйчүүдийн оролцоог хянах үндэсний тогтолцоо.

## XA.2 Интернэтэд нэвтрэх, ашиглахад жендерийн цахим ялгаа байдаг эсэх, хэрэв байдаг бол энэ ялгаа нэмэгдэж байгаа, тогтвортой эсхүл буурч байгаа эсэх?

**Шалгуур үзүүлэлт:**

